

НИЙГМИЙН АРДЧИЛЛЫН СУРАХ БИЧИГ 3-Р ДЭВТЭР

Алексадр Петринг болон бусад зохиогчид

Нийгмийн баримжаат төр ба нийгмийн ардчилал



AKADEMIE
FÜR
SOZIALE
DEMOKRATIE

FRIEDRICH
EBERT
STIFTUNG



ISBN 978-3-86872-128-7 1-дэх хэвлэл (Дигитал хувилбарыг 2009 оны 10-р сард шинэчилсэн.)



Фридрих-Эбертийн сан ФЭС-гийн
улс төрийн академийн хэлтсээс
эрхлэн гаргав.
2009 оны 8-р сар, Бонн хот

Редакци: Ёоахен Даам, Товиас Гомберт, Христиан
Крелл, Александр Петринг, Томас Риксен,
Хэвлэл: Брандт ХХК хэвлэлийн газар
Хэвлэлийн эх ба өрөлт: DIE.PROJEKTORIN, Berlin
Хавтасны зураг: Юүри Аркурс

Агуулгын хариуцлагыг бүлэг тус бүрийн зохиогчид хүлээнэ. Зохиогчдоод илэрхийлж буй санаа бүрээ ФЭС-гийн байр суурьтай нийцүүлэх шаардлага тавих боломжгүй юм.

Герман хэлнээс орчуулсан:	Фридрих-Эбертийн сангийн Монгол дахь Төлөөлөгчийн газрын захирал Чогдонгийн Оюунгэрэл
Редакторласан:	Нийгмийн хамгааллын сайдын зөвлөх, Доктор Горчинсүрэнгийн Адъяа
Хэвлэлийн эхийг бэлтгэсэн:	Фридрих-Эбертийн сангийн ажилтан Ёндонренчингийн Батболд

НИЙГМИЙН АРДЧИЛЛЫН СУРАХ БИЧИГ 3-Р ДЭВТЭР

Алексадр Петринг болон бусад зохиогчид

Нийгмийн баримжаат төр ба
нийгмийн ардчилал

АГУУЛГА

Өмнөх үг	7
Орчуулагчийн зурвас	10
1. Удиртгал	11
2. Нийгмийн баримжаат төр ба нийгмийн ардчилал	14
3. Нийгмийн баримжаат төрийн шударга ёс	21
3.1 Тэгш байдал	25
3.2 Бүтээмжийн шударга ёс	28
3.3 Хэрэгцээний шударга ёс	31
3.4 Боломжийн тэгш байдал	33
3.5 Нэгдсэн дүгнэлт	36
3.6 Тойрон аялал: Эрхард Эпплер “Шударга ёс”-ны ойлголтын талаар юуг өгүүлэв?	37
4. Нийгмийн баримжаат төрийн материал, хийц, архитектур	41
4.1 Нийгмийн баримжаат төрийн барилгын материал ба багаж хэрэгслүүд	42
4.2 Нийгмийн баримжаат төрийн архитектур	45
4.3 Нийгмийн баримжаат төрийн архитектурын бүтцээс үүдэлтэй үр дагаврууд	52
5. Нийгмийн баримжаат төрийн өмнө тулгарч буй сорилтууд	57
5.1 Даяаршил	60
5.2 Эдийн засаг ба хөдөлмөрийн салбарын бүтцийн хувьсал	66

5.3 Хүн ам зүйн хувьсал	69
5.4 Нийгмийн хувьсал	72
6. Улс төрийн намуудын нийгмийн бодлогын талаар баримталж буй байр суурь	76
6.1 Германы ерөнхий зарчмууд-Христосын Ардчилсан Холбоо Намын хөтөлбөр (ХАХН)	77
6.2 Чөлөөт Ардчилсан Намын (ЧАН) хөтөлбөр- “Виесбадены ерөнхий зарчмууд”	80
6.3 Хамбургийн хөтөлбөр-Германы Социалдемократ Намын (ГСДН)-ын мөрийн хөтөлбөр	83
6.4 “Ногоон Ирээдүй”-Холбоотон90/Ногоонтнууд намын мөрийн хөтөлбөр	87
6.5 “Хөтөлбөрийн чиг хандлагыг тодорхойлогч үнэт зүйлс”-“Зүүний нам”-ын хөтөлбөр	91
6.6 Нэгдсэн дүгнэлт	93
7. Нийгмийн баримжаат төрийн үндсэн салбарууд	95
7.1 Татвар	96
7.2 Хөдөлмөр	112
7.3 Тэтгэвэр	125
7.4 Эрүүл мэнд	142
7.5 Боловсрол	159
8. Эргэцүүлэл	175
Эх сурвалжийн зөвлөмж	177
Зохиогчдын тухай	182

Нийгмийн баримжаат төр нь нийгмийн ардчиллын зүгээр нэг дагалдах хэрэгсэл биш юм. Нийгмийн баримжаат төр нь ардчиллын үндэс бөгөөд тэгш эрх чөлөө-бүтэн эрх чөлөөний баталгаа юм.

Нийгмийн ардчиллын эрх чөлөөний тухай ойлголт нь нийгмийн баримжаат төрд илүү тодорхой, ойлгомжтой болдог. Нийгмийн баримжаат төр дэх эрх чөлөөний ойлголт нь хувь хүний эрх чөлөөг төр эсхүл нийгмийн дур зоргоороо хөндлөнгийн оролцооноос хамгаалах хамгаалалт төдийгүй үзэл бодол, сэтгэл бодролын эрх чөлөөний тухай ойлголтыг агуулж байдаг. Бүтэн эрх чөлөөний ойлголтод айдас, зовлонгоос ангид байх эрх чөлөө төдийгүй нийгмийн баримжаат төрөөс бүх хүмүүст өөрийн хүссэнээр амьдрах материаллаг нөхцөлийг бүрдүүлж өгөх шаардлагыг агуулж байдаг.

Тэгш эрх чөлөөг хангах асуудал бол нийгмийн ардчиллын нийгмийн бодлогод байнга тавигдаж байдаг эрхэд суурилсан шаардлага юм. Чиглэл, зорилго нь тодорхой. Уг зорилгод хүрэх алхмуудыг эрин цаг үе бүрийн өндөрлөг дээрээс байнга шинэчлэн тодорхойлж өөрсдийн замнаж буй зам мөрийг дахин дахин нягтлан үзэж шинэчлэн баталгаажуулж байх ёстой. Энэхүү баталгаажуулах, шинэчлэх үйлст тань дэм болох зорилгоор энэхүү сурах бичгийг бид хэвлүүллээ.

Уг сурах бичигт нийгмийн баримжаат төр ба ардчиллын суурь-үндсэн хамаарлыг тодорхойлж шударга ёсны ямар ямар ойлголтууд нийгмийн баримжаат төрийг илэрхийлдэгийг харуулахын зэрэгцээ дэлхийн улс орнууд нийгмийн баримжаат төрийн аль хэв шинжээр нийгмийнхээ эв санааны нэгдэлийг зохион байгуулдаг бэ? гэдгийг тайлбарлах болно. Түүнчлэн нийгмийн баримжаат төрийн талаар сүүлийн үед гарч буй шүүмжлэлүүдийг судалж бодит байдал дээр ямар сорилтууд тулгараад байгааг харуулж улс төрийн намуудын нийгмийн бодлогын хөтөлбөрүүдийг ерөнхийд нь танилцуулж нийгмийн баримжаат төрийн хөдөлмөр, тэтгэвэр, эрүүл мэнд, боловсрол, татварын салбаруудын тухай нарийвчлан хэлэлцэнэ. Сурах бичгийн энэхүү дэвтэр нь бусад дэвтрүүдийн нэгэн адилаар эрин цаг үеийн эргэлтэд хөдөлшгүй үнэн байж чадах хариултыг өгөх зорилтыг агуулаагүй агаад уншиж судлах цаашид эргэцүүлэн бодоход уншигч та бүхнийг урьж буй урилга болой.

Нийгмийн баримжаат төр ба нийгмийн ардчилал сурах бичиг нь нийгмийн ардчиллын цуврал сурах бичгүүдийн гуравдугаар дэвтэр юм. Энэхүү дэвтэр нь нийгмийн ардчиллын үндсүүд сурах бичиг дээр суурилсан. Нийгмийн ардчиллын үндсүүд сурах бичигт нийгмийн ардчиллын үнэт зүйлсийг тайлбарлаж либерал, консерватив, нийгмийн ардчиллын нийгмийн загваруудыг хооронд нь харьцуулж либертар ардчилал ба нийгмийн ардчиллын ялгааг харуулсан билээ. Эл сурах бичиг нь нийгмийн ардчиллын орчин үеийн, үнэлэмж дээр суурилсан нийгмийн ардчиллын эдийн засгийн бодлогыг хэрхэн хэрэгжүүлэх бэ? гэдэг асуултын хариултыг хайх явцад эдийн засаг ба нийгмийн ардчилал дэвтэртэй зарим талаараа холбогдож эрлийн замууд нь огтлолцох болно.

Европын болон дэлхийн түвшинд нийгмийн бодлогын салбарт тулгарч буй асуудлууд улам илүү ач холбогдолтой болсоор байна. Энэхүү дэвтэрт германы нийгмийн баримжаат төрийн загвар чухал байр суурийг эзэлж буй.

Олон улсын хэтийн чиг хандлагаас авч үзвэл Европ ба нийгмийн ардчилал, даяаршил ба нийгмийн ардчилал сэдвүүд нийгмийн ардчиллын сурах бичгүүдэд онцгой чухал байрыг эзэлдэг.

Сүүлийн жилүүдэд тохиолдоод байгаа санхүүгийн зах зээл- ба эдийн засгийн хямрал нь нийгмийн баримжаат төртэй байх нь ямар чухал ач холбогдолтой юм бэ? гэдгийг онцгой арга хэлбэрээр улам тодорхой харуулсаар байна. Нэн ялангуяа хямралын үед нийгмийн баримжаат төрийн хүч ба ач холбогдол улам тодорхой болж байна. Нийгмийн баримжаат төр нь автомат тогтворжуулагчийн үүрэг гүйцэтгэн дотоодын эрэлтийг дэмжиж иргэдээ ядууралд өртүүлэхгүй байх, ажлын байруудыг баталгаажуулахад чухал үүрэг гүйцэтгэдэг.

Төгсгөлд нь бид Александр Петринг, Товиас Гомберт, Томас Риксен нарт чин сэтгэлийн талархал илэрхийлж байна. Александр Петринг нь энэ сурах бичгийн үндсэн зохиогч юм. Товиас Гомберт, Томас Риксен нар тодорхой бүлгүүдийг зохиосноос гадна редакцийн болон сурганы арга барилыг сайжруулах, баяжуулахад хувь нэмрээ оруулсан юм. Мөн бидний зүгээс Диана Огнянова, Мариус Вүземайер нарт эрүүл мэнд ба боловсрол бүлгийг бичихэд гол тулгуур болсонд, Михаел Даудерштадт, Клаудиа Богедан нарт сурах бичгийн концепцийг боловсруулахад зөвлөгөө өгсөнд, Эва Флекен,

Кнут Ламбертин болон энэ сурах бичгийг бүтээхэд хувь нэмрээ оруулсан бүх хүмүүст талархал илэрхийлье. Та бүхний хичээл зүтгэл, идэвх санаачилга, гар нийлсэн хамтын ажиллагаанд чин сэтгэлийн талархал илэрхийлье. Та бүхэн гар, сэтгэл нийлж хамтарч ажиллаж чадаагүй бол бидэнд өчнөөн нэмэлт хүндрэл учрах байлаа.

Нийгмийн ардчиллын академийн бэлэг тэмдэг бол луужин. Фридрих-Эбертийн сан та бүхэнд нийгмийн ардчиллын академийн сургалтууд, сурах бичгүүдээрээ дамжуулан өөрсдийн байр суурь, чиг хандлагаа тодорхойлоход тань ерөнхий хүрээг тогтоож өгөхийг зорьж байна. Хэрэв та бүхэн бидний саналуудаас улс төрийн зам мөрөө тодорхойлоход ашиглах аваас бид баярлах болно. Иргэдийн хичээл зүтгэл, харилцан ярилцлага, хэлэлцүүлэг мэтгэлцээн нь нийгмийн ардчиллыг тэтгэгч ундарга нь билээ.



Кристиан Крелл

Нийгмийн ардчиллын
академийн захирал



Ёохон Даам

Нийгмийн ардчиллын цуврал
сурах бичгүүд төслийн
удирдагч

Эрхэм уншигчид та бүхэндээ Фридрих-Эбертийн Сангийн Нийгмийн Ардчиллын Академийн сурах бичгийн 2-р дэвтэр “Нийгмийн баримжаат төр ба нийгмийн ардчилал” сурах бичгийг герман хэлнээс орчуулан хүргэж байгаадаа баяртай байна. Асар их байгалийн баялагтай, цөөхөн хүн амтай монгол орон иргэдийнхээ нийгмийн баталгаат байдал, цаашилбал улс орны тогтвортой хөгжлийг хангахад нийгмийн хамгаалал, нийгмийн үйлчилгээний үүрэг асар их билээ. Сурах бичигт консерватив, либерал, социалдемократ хэв шинжит нийгмийн баримжаат төртэй орнуудын төлөөлөл болгон өндөр хөгжилтэй, аж үйлдвэржсэн орнуудыг сонгон авчээ. Монгол улсын нийгмийн баримжаат төрийн байгууламж, нийгмийн хамгааллын бодлого, нийгмийн үйлчилгээ нь манай орны өв уламжлал, сэтгэлгээний онцлог, хүн ам зүйн хөгжлийн онцлог, улс орны эдийн засаг, нийгмийн бүтэц, хөгжлийн түвшин зэрэг олон зүйлээс хамаарах нь ойлгомжтой. Эл сурах бичгийн гол санаа нь:

- Ардчилал, нийгмийн баримжаат төр хоёр хоорондоо салшгүй холбоотой.
- Материаллаг үндсэн баталгаа нь хангагдсан нөхцөлд хүмүүс оролцоо, эрх чөлөөний эрхүүдээ эдэлж чаддаг.
- Нийгмийн ардчилалд нийгэмд нийгмийн бодлого нь бусад бодлогын салбаруудын адил энгийн нэг бодлогын салбар биш. Харин хамгийн чухал бодлогын салбар юм.
- Ард иргэдийнхээ нийгмийн баталгааг хангая гэвэл нийгмийн баримжаат төрөө бэхжүүл. Нийгмийн баримжаат төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулж бүх хүмүүст нээлттэй байлгая гэвэл санхүүжилтийн баталгааг хангах хэрэгтэй.
- Даяаршил, эдийн засаг, хөдөлмөрийн салбар дахь бүтцийн өөрчлөлт, хүн ам зүйн хөгжлийн улмаас нийгмийн баримжаат төрд шинэ сорилтууд тулгараад байна. Эдгээр нь хүнд сорилтууд боловч даван туулах боломжтой.

Харин монгол орны хувьд нийгмийн баримжаат төртэй, нийгмийн үйлчилгээ бүгдэд хүртээмжтэй, нээлттэй байх ёстой гэдэгт нийгмийн зөвшилд хүрсэн гэж үзэж болох боловч бүхнийг төрд даатгах, төрөөс бүх зардлыг нь гаргуулна гэдэг популист амлалтууд улам газар авч байна. Энэ нь нийгмийн баримжаат төрийг эсэргүүцэгчидтэй адилхан хор уршгыг авчирдаг аж. Нийгмийн баримжаат төрийн санхүүжилтийн даах хэмжээгээр нийгмийн үйлчилгээний чанар хүртээмж хэмжигддэг. Эх орны хишиг гэх мэт тооцоо үндэслэл муутай популист амлалтууд нийгмийн хамгааллын тогтолцооны суурийг ганхуулах аюултай гэдэг сургамжийг нэн шинэ түүхээсээ бид авсан билээ. Монгол хүн бүр нийгмийн баталгаатай хамгаалалд зовлон зүдүүр, айх аюулаас ангид, ирээдүйдээ итгэлтэй байж ардчилалыг жинхэнэ утгаар нь хэрэгжүүлэхэд хувь нэмэр болоосой гэдэг чин хүсэл минь уг сурах бичгийг орчуулан гаргах эрч хүчийг надад өгсөн юм. Энэ номыг орчуулахад туслалцаа үзүүлсэн редактор, эх бэлтгэгч, ажлын хамт олондоо чин сэтгэлийн талархал илэрхийлье. 2014 он.

Улаанбаатар хот

1. УДИРТГАЛ

Нийгмийн баримжаат төр бол нийгмийн ардчиллын үндсэн элементүүдийн нэг мөн. Нийгмийн баримжаат төр бол үндсэн эрхүүд хэлбэр төдий хэрэгжих бус харин идэвхтэй хэрэгжиж байх баталгаа нь юм. (үндсэн эрхүүдийн хэлбэр төдийн хэрэгжилт гэдэг нь зөвхөн хуулиар олгогдсон буюу тунхаглагдсан гэсэн санаа-Орч)

Нийгмийн баримжаат төрийн тухай хэлэлцүүлэг, мэтгэлцээнүүд улс төрийн бүхий л урсгалуудын дунд нэхэл хатуутай өрнөж байдаг. Учир нь нийгмийн баримжаат төрийн тухай ойлголтод ардчилал болон үнэт зүйлсийн тухай ойлголт багтаж байдаг учраас нэхэл хатуутай байх нь аргагүй юм. Энэхүү сурах бичиг нь уншигч таньд эдгээр хэлэлцүүлгийн дундаас өөрийн баримталж буй байр суурийг олох, түүнийг тайлбарлах, хамгаалахад нь туслах зорилготой.

Нийгмийн ардчиллын үнэт зүйлс нь эрх чөлөө, шударга ёс, эв нэгдэл юм. Эдгээр гурван үнэт зүйлс нь энэхүү номын гол агуулга болох нийгмийн ардчиллын тухай ойлголтын үндэс суурийг бүрдүүлдэг. Нийгмийн баримжаат төр ба нийгмийн ардчиллын суурь буюу үндсэн харилцан хамаарлын тухай уг сурах бичгийн эхэнд өгүүлсэн. (2-р Бүлэг)

Энэ бүлэгт дараахи зүйлс тодорхой болно: Нийгмийн бодлогын талаар ярьж буй хүн бүр хувиарлалтын асуудлын талаар зайлшгүй ярих хэрэгтэй болдог. Учир нь боловсрол, мэргэжил эзэмших боломж, орлого, эрх мэдэл, аюулгүй байдал, эрх ба үүрэг ямар зарчмуудын дагуу хувиарлагдаж байна бэ? гэдэг асуудал нь өөрөө нийгмийн бодлого юм. Эдгээр нь амьдралын үндсэн асуудлууд учраас хувиарлалт нь шударга байхыг шаарддаг. Тэгэхлээр ямар байвал шударга хувиарлагдлаа гэж үзэх бэ? гэдэг асуулт урган гарч ирнэ. Амьдралын дээрх чухал салбаруудад шударга ёсны зарчмуудыг хэрхэн хэрэгжүүлэх бэ? Ажилгүйдлийн даатгал, боловсрол, эрүүл мэндийн тогтолцоонд бүгдэд нь нэгэн зэрэг мөрдөгддөг шударга ёсны зарчим байна уу? Шударга ёсны эдгээр асуудлуудыг 3-р бүлэгт авч үзэх болно.

Нийгмийн баримжаат төрийн олон хэлбэр үүсэж хөгжсөнийг олон улсын харьцуулсан судалгаа харуулж байна. Хэрэв нийгмийн

2-р бүлэг:
Нийгмийн
баримжаат төр
ба нийгмийн
ардчилал

3-р бүлэг:
Нийгмийн
баримжаат төр
дэх шударга ёс

4-р бүлэг:
Нийгмийн
баримжаат
төрийн барилгын
материал, хийц,
архитектур

баримжаат төрийг барилга байгууламж гэж жишиж үзэх юм бол бүгдээрэнг нь ижил материалаар, ижил хийцээр барьсан. (Номын зохиогчид нийгмийн баримжаат төрийн байгууллыг уншигчдад ойлгомжтой болгохын тулд барилга байгууламжтай зүйрлэн тайлбарлажээ. Иймээс номд барилгын материал, хийц, архитектур зэрэг үгсийг олонтаа хэрэглэжээ. Эдгээр үг хэллэг Монгол уншигчдад төдийлөн ойлгомжтой бус, болхи орчуулга мэт санагдаж болох талтай ч зохиогчдын санааг эвдэж эс зүрхлэв.-Орч) Харин тэдгээрийн архитектурын бүтэц, ард иргэддээ хүрэх үр дагавар нь хоорондоо ихээхэн ялгаатай. Барилгын хийцийн ялгаатай байдлын талаар 4-р бүлэгт авч үзэх болно.

5-р бүлэг:
Нийгмийн
баримжаат төрийн
өмнө тулгарч буй
сорилтууд

Нийгмийн баримжаат төр нь нэр алдарт хүрэхийн тулд ор үндэсгүй шүүмжлэлийг гүүрээ болгон ашигладаг популистуудын золиос болох нь олонтаа. 5-р бүлэгт эдгээр шүүмжлэлүүдийг эрэмбэлэн цэгцэлж германы нийгмийн баримжаат төрийн өмнө ямар бодит сорилтууд тулгараад байгааг тайлбарлаж эдгээр сорилтуудыг хэрхэн даван туулах арга замын талаар эхний зааварчилгаануудыг өгөх болно.

6-р бүлэг:
Улс төрийн
намуудын
нийгмийн
бодлогод
баримталж буй
байр суурь

Ойлголт болон сорилтуудыг тайлбарлаж зохих ойлголттой болсны дараагаар 6-р бүлэг Бундестагт суудалтай улс төрийн намууд нийгмийн бодлогын салбарт ямар байр суурийг баримталдаг, нийгмийн баримжаат төрийн эрхэм зорилгыг хэрхэн тодорхойлдог, шинэчлэлийн ямар санааг дэвшүүлдэг талаар авч үзнэ.

7-р бүлэг:
Нийгмийн
баримжаат төрийн
үндсэн салбарууд

Тэгш эрх чөлөөг хангахыг нийгмийн ардчиллын эрхэд суурилсан шаардлагууд зүй ёсоор шаардаж байдаг. Ингэснээр зорилго нь тодорхой болж байна. Гэхдээ нийгмийн баримжаат төрийн салбар тус бүр ямар тодорхой хэлбэртэй байх ёстой бэ? гэдэг асуултад үүгээр бүрэн хариулчихна гэсэн үг биш.

Хөдөлмөр,
Тэтгэвэр, Эрүүл
мэнд

Орчин үеийн нийгмийн баримжаат төрийн дараахи таван үндсэн салбарыг тодорхойлох боломжтой. Учир нь: Нийгмийн баримжаат төр нь амьдралд учирч болох томоохон эрсдэлүүдээс хамгаалж ард иргэдийнхээ хүний ёсоор амьдрах нөхцөлийг хангах үүрэгтэй тул эрүүл мэнд-ажилгүйдэл-тэтгэврийн даатгал нь нийгмийн баримжаат төрийн анхдагч бүрэлдэхүүн хэсгүүд мөн.

Боловсрол

Нийгмийн баримжаат төр бүх иргэдийнхээ¹ оролцоог хангах

зорилготой тул нийгмийн баримжаат төрийн тухай орчин үеийн ойлголтод боловсролын бодлого зайлшгүй хамаарна. Боловсрол нь ардчилсан эрхүүдийг хангах анхдагч нөхцөл учраас материаллаг нөөцийн хувиарлалтанд шийдвэрлэх үүргийг гүйцэтгэдэг. Боловсрол нь оролцоо ба боломжтой утга нэг ойлголт юм.

Татвар

Нийгмийн баримжаат төрийн тухай орчин үеийн ойлголтын өөр нэгэн чухал элемент бол татварын бодлого юм. Зөвхөн нийгмийн баримжаат төрийн зарлага ба үйлчилгээг татвар, хураамжаас санхүүжүүлдэг гэдэг утгаараа ч биш татвар нь нийгмийн орлого ба хөрөнгийн хувиарлалтад нөлөөлдөг үндсэн чухал элемент гэдэг утгаараа нийгмийн бодлогын үндсэн шаардлагуудын хүрээнд зайлшгүй авч үзэх ёстой ойлголт юм.

1 Номонд эр ба эм хүйсийг тус бүрээр нь илэрхийлдэг үгсийг өргөн хэрэглэсэн. Зарим хэсэгт хэл зүйн шаардлагын үүднээс зөвхөн нэг хүйсийг илэрхийлдэг үгийг хэрэглэсэн ч цаана нь хоёр хүйсийг хамруулсан. (Харин монгол хэлний орчуулгад хоёр хүйсийг тусгайлан илэрхийлсэн үгс хэрэглэдэггүй тул зөвхөн нэг үгээр илэрхийлэгдсэн байгаа.-Орч)

2. НИЙГМИЙН БАРИМЖААТ ТӨР БА НИЙГМИЙН АРДЧИЛАЛ ²

Энэхүү бүлэгт:

- Нийгмийн баримжаат төр ба нийгмийн ардчиллын харьцааны талаар ярилцана.
- Эрх чөлөө, тэгш байдал, эв санааны нэгдэлийн үнэт зүйлс дээр суурилсан нийгмийн ардчиллын нийгмийн баримжаат төрийн тухай ойлголтыг тайлбарлана.
- Улс төрийн, иргэний, эдийн засгийн, нийгмийн, соёлын үндсэн эрхүүдийг хангахад нийгмийн баримжаат төр ямар үүрэг гүйцэтгэдэг бэ? гэдгийг авч үзнэ.

*Герман нь
нийгмийн
баримжаат
холбооны улс
мөн.*

“ХБНГУ бол ардчилсан, нийгмийн баримжаатай холбооны улс мөн.” Энэ бол Германы үндсэн хуулийн 20-р зүйлийн эхний өгүүлбэр бөгөөд уг өгүүлбэрт ардчиллын зарчим, нийгмийн баримжаат төрийн зарчим, эрх зүйт төрийн зарчмууд агуулагдаж байгаа бөгөөд уг үзэл санаа нь үндсэн хуулийн эцгүүдийн хүслээр үеийн үед үүрд мөнх мөрдөгдөж байх ёстой билээ

*Нийгмийн
баримжаат төрийн
байгууламж нь
шударга ёсыг
хэрхэн хангах бэ?
гэдэг асуултын
хариулт юм.*

Үндсэн хуулийн олон зүйл заалтад ардчиллын зарчим ба эрх зүйт төрт ёсны тухай ойлголтыг илүү тодорхой тайлбарладаг бол нийгмийн баримжаат төрийн зарчмын талаар тодорхой тайлбар байдаггүй. Нийгмийн баримжаат төрийн байгууламжийн хамгийн чухал шалгуур үзүүлэлт нь шударга ёс учраас үндсэн хуульд тодорхой тайлбар байхгүй байгаа нь гайхаад байх зүйл биш юм.

*Юуг шударга гэх
бэ? – мөнхийн
маргаан*

Юуг шударга гэх бэ? гэдэг асуулт нь өөрөө хүн төрөлхтөн үүсэн бий болсон цагаас өнөөг хүртэл маргааны мөнхийн сэдэв байсаар иржээ. Ямар нийгмийн баримжаат төрийг шударга нийгмийн баримжаат төр гэх бэ? гэдэг эргэцүүлэл, өдгөө оршин буй нийгмийн баримжаат төрийн давуу бөгөөд сул талууд нь юу бэ?, Уг байгууламжийн бүтцийн бусад боломжит хувилбаруудын эрэл хайгуул уг сурах бичгийн ихээхэн хэсгийг эзэлж буй. Нийгмийн бодлогын төрөл бүрийн салбар, хүчин зүйлсийн талаар нарийвчлан авч үзэхээсээ өмнө эхлээд ардчилал ба нийгмийн баримжаат төрийн үндсэн харьцааг авч үзэх нь зүйтэй.

2 Тус бүлгийг боловсруулахдаа Кнайп (2003), Прус (1990), Скенлон (2005), Кауфманн (2003), Риттер (1991) санаан дээр суурилсан.

Нийгмийн баримжаат төр бол үндсэн хуулиараа үндсэн эрхүүд, хувь хүмүүсийн болон эдийн засгийн эрх чөлөөг баталгаажуулаад зогсохгүй (эрх зүйт төр) нийгмийн эсрэг тэсрэг байдал, зөрчлийг (тодорхой хэмжээнд хүртэл) тэнцвэржүүлэхэд шаардагдах эрхзүйн, санхүүгийн болон материаллаг арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлдэг ардчилсан төр юм. Нийгмийн баримжаат төрийн зарчим нь ийнхүү эрх зүйт төрийн шударга ёсны зорилтуудыг багтааж байдаг бөгөөд эдгээр зорилтуудыг германы үндсэн хуулийн 20 ба 28-р зүйлд тодорхойлсон байдаг.

(Улс төрийн тайлбар толь, 2006 он, 282-р тал)

Нийгмийн бодлого нь өнгөцхөн харахад ердийн нэг бодлогын салбар шиг санагддаг. Гэтэл холбооны төсөвт хамгийн их хувийг эзэлдэг төсөвтэй салбар, нийгмийн бодлогын шийдвэр бүх иргэдэд шууд (нийгмийн үйлчилгээ үзүүлэх), эсхүл шууд бус (татвар, шимтгэлээс санхүүждэг) байдлаар хамаатай зэрэг онцлогтой тул бусад салбаруудаас онцгой ялгаатай. Иймэрхүү байдлаар хуумгай хандаж болохгүй гэдгийг үндсэн хууль тодотгож өгсөн. Тэгэхлээр ардчилал ба нийгмийн баримжаат төрийн онцгой харьцаа юунд оршиж байна бэ?

Нийгмийн бодлого нь бодлогын бусад салбаруудтай адилхан уу?

Бүх иргэд нь эрх чөлөөний тэгш эрхийг эдэлдэг, улс төрийн шийдвэр гаргалтанд оролцох тэгш боломжоор хангагдсан байхыг ардчилал гэнэ. Бүх хүмүүс адил тэгш нэр хүндтэй, тэгш хүндэтгэл хүлээх эрхтэй. Дээрх шаардлагуудыг өнгөцхөн харахад байдаг л, байх ёстой улиг домог болсон зүйлс мэт сонсогдоно. Санаанууд нь олон талаараа өнөөг хүртэл нөлөөтэй хэвээрээ байгаа Аристотель эхээс төрөхдөө эрх чөлөөгүй амьдрахаар заяагдсан хүмүүс байдаг гэдэгт бат итгэлтэй байсан юм. Тэрбээр боолчлогдох заяанд төрсөн хүмүүс байдаг гэдэгт итгэдэг байжээ. Мөн тэрбээр эмэгтэйчүүдэд эрэгтэйчүүдтэй ижил байр суурь, нэр хүнд эдлүүлэх шаардлагагүй гэж үздэг байж. Түүний энэ санааг эсэргүүцсэн эсэргүүцэл дээр улс төрийн тэгш эрхийн тухай санаа хөгжиж улмаар эмэгтэйчүүдэд сонгох, сонгогдох эрхийг олгосон юм. Германд эмэгтэйчүүд 1919 оноос сонгох, сонгогдох эрхтэй болсон бол Швейцарт эмэгтэйчүүдийн сонгох сонгогдох эрхийн төлөө тэмцэл 1971 оныг хүртэл үргэлжилжээ. Улс төрийн тэгш байдлын тухай санаа нь улиг домог төдий болсон зүйл огтхон ч биш бөгөөд зарим талаараа харьцангуй шинэлэг хөгжил юм.

Ардчилал бол: Улиг домог болсон зүйл биш

Нийгмийн баримжаат төр нь: бодит эрх чөлөө ба ардчиллыг хэрэгжүүлэх үндэс мөн.

Алдар нэр, Хүндэтгэлийн тэгш байдал, өөрийн хүслээр амьдрах тэгш эрх чөлөө нь ардчиллын урьдчилсан шаардлага ба нөхцөл юм. Алдар нэр ба хүндэтгэл хүн бүрд эхээс төрөхөд нь тэгшхэн заяадаг

зүйл биш гэдгийг дээрх жишээнүүд харуулж байна. Тэгш байдлыг хангахын тулд бусад арга хэрэгслүүдээр баяжуулах шаардлагатай. Зөвхөн материаллаг үндсэн хангамж хангагдсан нөхцөлд хүмүүс өөрийгөө хүндэтгэх, өөрийн хүссэнээр амьдрах эрхээ эдэлж чаддаг. Идэх хоолгүй, орох оронгүй нэгэнд хэлбэр төдий эрх чөлөө хичнээн их байгаад ч ямар ч үнэ цэнэгүй зүйл. Тэгэхлээр эрх чөлөө ба ардчилал хэрэгжих нөхцөлүүдийг бүрдүүлэхийн тулд нийгмийн баримжаат төрийг байгуулсан.

Ардчилсан
төрд нийгмийн
баримжаат төр
хэрэгтэй.

Хоол хүнс, орон байр зэрэг үндсэн хэрэгцээнүүдээс гадна ардчиллыг хоосон зүйлсийн үгэн халхавч болгон ашиглах биш, харин жинхэнэ утгаар нь хэрэгжүүлэхийн тулд нийгэмд бусад нийгмийн үйлчилгээ, нөөц бүрдсэн байх ёстой: Эдгээр нь боловсрол ба мэдээлэл юм. Ядууралд өртөх эрсдэлээс хамгаалах, боловсролтой байх баталгаа нь сайн дурынхны буяны үйлс эсхүл нийгмийн эв санааны нэгдэлээс хамаардаг байж таарахгүй. Нийгмийн бодлогогүйгээр бодит ардчилал оршин тогтнох боломжгүй учраас ардчилсан төрд нийгмийн баримжаат төр хэрэгтэй.

Нийгмийн
ардчилал:
нийгмийн болон
улс төрийн
асуудлыг хооронд
нь эрт холбож
өгсөн.

Нийгмийн ардчилалд ардчилал ба нийгмийн хамгааллын уялдаа холбоо ямагт онцгой чухал ач холбогдолтой байсаар ирсэн. Аль дээр 1868 онд "Германы ажилчдын нийгэмлэгүүдийн нэгдэлийн өдөр"-өөр тухайн цаг үеийнхээ хэллэгээр "Улс төрийн эрх чөлөө нь ... ажилчин ангийг эдийн засгийн чөлөөлөлтөд хүргэхэд зайлшгүй хангагдсан байх ёстой урьдчилсан нөхцөл юм. Нийгмийн асуудал нь улс төртэй салшгүй холбоотой бөгөөд нийгмийн асуудлын шийдэл нь улс төрийн шийдвэрээс хамааралтай, зөвхөн ардчилсан төрийн үед шийдвэрлэгдэх боломжтой." хэмээн бичиж байжээ. 150-иад жилийн туршид нийгмийн ардчилал ба нийгмийн хамгааллын уялдаа холбоо ямар байх ёстойг дахин дахин тунгаан бодсоор ирсэн бөгөөд уг холбоос ГСДН-ын мөрийн хөтөлбөрт зохих тусгалаа олсон байдаг:

Нийгмийн баримжаат төр нь 20-р зууны иргэншлийн томоохон ололт амжилт юм. Нийгмийн баримжаат төр нь иргэний эрх чөлөөний эрхүүдийг иргэдийн нийгмийн эрхүүдээр баяжуулж өгсөн. Иймээс бид ардчилал ба нийгмийн баримжаат төрийг хоорондоо салшгүй холбоотой гэж үздэг. Нийгмийн баримжаат төр нь олон сая хүнийг нийгмийн гарал үүслээс үүдэлтэй хавчлагаас чөлөөлж зах зээлийн хатуу хүтүүгээс хамгаалж өөрийн хүссэнээр амьдрах боломжийг нээж өгсөн. Нийгмийн баримжаат төр нь бидний хангалуун чинээлэг амьдралыг бүрдүүлэгч эдийн засгийн динамикийн үндэс юм. [...] өнөөгийн эрин үед аюулгүй байдлыг хангах, өөдлөн дэвших талаар өгсөн амлалтаа шинэчлэхийн төлөө бид нийгмийн баримжаат төрийг ирээдүйд нийгмийн асуудал үүсэхээс урьдчилан сэргийлэх чадамжтай нийгмийн баримжаат төр болгон цаашид хөгжүүлсээр байх болно.

(Хамбургийн хөтөлбөр 2007 он 55,56-р тал)

Дээр дурьдсан асуудлаас урьдчилан сэргийлэх чадамжтай нийгмийн баримжаат төрийн тухай санаа нь Скандинавын орнуудын нийгмийн баримжаат төрийн амжилттай бодлого, тэдгээрийн социалдемократ хэв шинжит нийгмийн баримжаат төрөөс эхтэй бөгөөд нийгмийн баримжаат төрийн барилгын материал, хийц, архитектур сэдэвт 4-р бүлэгт нарийвчлан тайлбарлах болно.


Нийгмийн асуудлаас урьдчилан сэргийлэх чадамжтай нийгмийн баримжаат төрийн санаа- 4-р бүлгийн социалдемократ загвартай харьцуулна уу.

Ардчиллын материаллаг болон материаллаг бус нөхцөлүүд нь зөвхөн амьжиргааны баталгааг хангаснаар сэтгэл ханах ёсгүй гэдгийг өнгөрсөн зуунд хийгдсэн ардчиллын судалгаанууд дахин давтан баталсан юм. Ингэснээр улс төрийн оролцооны хэмжээ нь жишээлбэл: сонгуулийн оролцоо, улс төрийн намууд дахь идэвх санаачилга, болон улс төрийн үйл ажиллагааны бусад хэлбэрүүд дээр дурьдсан материаллаг болон материаллаг бус нөөцийн хүртээмжтэй нягт холбоотой.

Нийгмийн баримжаат төр: Амьжиргааны баталгааг хангаад зогсохгүй...

Амьдрал дээр ажилгүйдэлд өртөж ажилгүй болсон, эсхүл маш бага орлоготой, боловсрол нимгэнтэй хүмүүс улс төрийн эрхүүдээсээ тун бага хэсгийг нь эдэлдэг. Эрх чөлөөний эрхүүд ба улс төрийн эрхүүдээ тэгш эдлэх нь ардчиллын үндсэн нөхцөл бөгөөд харьцуулж болохуйц нийгэм болон эдийн засгийн амьдралын нөхцөлүүд хангагдсан нөхцөлд л хэрэгжих боломжтой.

Идэвхтэй (улс төрийн) оролцооны нөхцөл



Зураг1: Нийгмийн баримжаат төр ба ардчиллын уялдаа холбоо

Нийгмийн
баримжаат
төр" хэтэрхий
өндөр" өртөгтэй
юу? Ардчилал
"хэтэрхий өндөр"
үнэтэй байж
болох уу?

Нийгмийн баримжаат төрийн талаархи олон хэлэлцүүлэг нийгмийн баримжаат төрийн үүргээ биелүүлэхтэй холбоотой гардаг зардлын эргэн тойронд өрнөдөг. Тэр ч байтугай нийгмийн бодлого нь эдийн засгийн өсөлтөд саад болдог хэмээн нотолдог. Ардчилал ба нийгмийн баримжаат төр нь хоорондоо салшгүй холбоотой тул зарим нотолгоо нь үнэхээр учир утгагүй зүйлс. Ардчилал үнэ өртгөөс хамаардаг байж таарахгүй. Эрх чөлөө ба ардчиллыг эдийн засгийн өсөлттэй харьцуулшгүй.

Хүчирхэг
нийгмийн
баримжаат төртэй
орнуудын эдийн
засаг ихэнхдээ
амжилттай байдаг:

Нийгмийн баримжаат төрийн эсрэг чиглэсэн, байнга давтагдаж байдаг шүүмжлэлүүдийг нарийвчлан магадлаад үзэхэд үндэслэлгүй гэдэг нь нотлогддог. Хамгийн баян ардчилсан орнуудын дунд хамгийн том нийгмийн баримжаат төртэй орон олон байгаа нь дээрх шүүмжлэлүүд үндэслэлгүй гэдгийг давхар нотолж байгаа юм.

Нийгмийн үйлчилгээний өндөр зардалтай нийгмийн баримжаат төрийг тогтвортой санхүүжүүлэх боломжгүй, иймээс нийгмийн баримжаат төрийн зардал ихсэх тусам төрийн өр зайлшгүй нэмэгддэг гэдэг шүүмжлэлийг нотлох ямар ч нотолгоо өнөөдрийг хүртэл олдоогүй байна. Том хэмжээний нийгмийн баримжаат төртэй, төр нь өр ихтэй улс орнууд байхын зэрэгцээ нийгмийн үйлчилгээний зардал өндөртэй ч төрийн өр багатай улс орнууд ч байна.

Нийгмийн
баримжаат
төр бол дахин
хувиарлалт гэсэн
үг.

Нийгмийн баримжаат төрийн санхүүжилтийн асуудал нийгмийн баримжаат төрийг шүүмжлэх бас нэгэн бай нь болдог. Нийгмийн бодлого бол дахин хувиарлалт гэсэн үг. Тэгэхлээр дахин хувиарлалт гэдэг бол их орлоготой хүмүүс орлогынхоо багаахан хэсгийг өгч харин бага орлоготой хүмүүс нь орлого дээрээ багаахан зүйлийг нэмж авна гэсэн үг юм. Дахин хувиарлалтын энэхүү үйл явцыг зарим хүмүүс бусдыг эрхэндээ оруулж буй эсхүл бусдын олсныг булааж буй зөвтгөх ямар ч үндэслэлгүй акт гэж үздэг.

Нотолгоо: Эрх
зүйт төр эхлээд
өмчийн баталгааг
хангадаг.

Төр иргэдийнхээ орлогын хувиарлалтанд хөндлөнгөөс оролцдог нь бодит үнэн. Энд ямар үнэлэмж илүү давуу байр суурь эзэлдэг нь харьцангуй тодорхой. Ардчилсан эрх зүйт төргүй бол өмчлөх эрх төдийлөн үнэ цэнэгүй. Учир нь эрх зүйт төр нь өмчлөх эрхийг баталгаажуулдаг. Нөгөөтэйгүүр ардчилсан эрх зүйт төр нь өөрөө иргэдийнхээ өөрийн хүссэнээр хүний дайтай амьдрах нөхцөл нь болдог.

Татвар, шимтгэлээр дамжуулан зах зээлээс бий болгосон өмчийн хувиарлалтанд төр хөндлөнгөөс оролцож бүх хүмүүсийн эрх чөлөө, аюулгүй байдал, өмчийн баталгаат байдлыг хангахад татвар, шимтгэл нь чухал хэрэгслүүд мөн. Ингэхдээ өмчлөх эрхийг бүхэлд нь үгүй хийхгүйгээр харин бусад эрхүүдээр үл хязгаарлагдах давуу эрхийг нь хязгаарлаж өгдөг.

Нийгмийн ардчиллын хэтийн чиг хандлагын үүднээс хувь хүмүүсийн эрх чөлөөг хамтын нийгэмлэгийн (нийгмийн) хөндлөнгийн оролцооноос хамгаалах (сөрөг эрх чөлөөний эрхүүд) болон өөрийн хүсэл, зорилгыг бодитойгоор биелүүлэх эрх чөлөөг тэгш хангах нь (эерэг эрх чөлөөний эрхүүд) эрмэлзэх ёстой, биелүүлэх ёстой зорилтууд гэж үздэг.³ Нийгмийн бодлого ба дахин хувиарлалтыг бусдыг эрхшээлдээ оруулах арга, эсхүл бусдын өмчийг булааж байгаа хэрэг гэж ярьдаг хүн бүр хэн ч халдашгүй дархан байдлаар хамгаалах гээд байгаа эрх чөлөөг нь хүн бүр эдэлж чаддаггүй гэдгийг мэдвэл зохилтой.

Эрх чөлөөг өөрийн хүссэнээр амьдрах боломж хэмээн ойлговол зохилтой. Хүн бүр эрх чөлөөтэй байх, эрхээ эдлэх чадвартай. Хүн бүр эрх чөлөөгөө эдэлж чадах эсэхийг тухайн нийгэм нь шийддэг. Хүн бүр басамжлагдан доромжлогдох хараат байдал, зовлон зүдгүүр, айдсаас ангид байгаад зогсохгүй өөрийн авъяас чадварыг хөгжүүлэх, нийгэм болон улс төрд хариуцлагатайгаар оролцох боломжоор хангагдсан байх ёстой. Нийгмийн баталгаатай хамгаалалд байгаа хүмүүс л эрх чөлөөгөө ашиглаж чаддаг.

(Хамбургийн хөтөлбөр 2007 он, 15-р тал)

Аливаа ардчилсан оронд нийгмийн бодлого нь бусад бодлогын салбаруудын нэгэн адил ердийн нэг салбар биш харин ардчилалтай салшгүй холбоотой салбар байдаг. Эрх чөлөөний эрхүүд, сонгууль, хараат бус шүүх нь хэлбэр төдий оршдог хуурамч ардчилал байхад л хангалттай гэж үздэггүй, харин бүх иргэдийн хувьд нийгмийн болон улс төрийн амьдралаас хувь хүртэх, оролцооны эрхүүд нь бодитойгоор хангагдсан жинхэнэ ардчиллын төлөө оронд бол нийгмийн бодлого ба ардчилал нь хоорондоо салшгүй холбоотой байдаг. Уг холбоос нь нийгмийн ардчиллын цөм юм. Нийгмийн ардчилал бол үндсэн эрхүүдийг хэрэгжүүлэх тухай концепци юм. Нийгмийн ардчиллын үндэс хэмээх 1-р дэвтэрт:


3 Эрэг ба сөрөг эрх чөлөөний харьцааны тухай Нийгмийн ардчиллын үндсүүд хэмээх 1-р дэвтрийн 102-104-р хуудаснаас дэлгэрүүлэн уншина уу.

*Нийгмийн
ардчилал: Сөрөг
ба эерэг эрх
чөлөө*

*Салшгүй
холбоотой:
Нийгмийн
баримжаат төр ба
ардчилал*

Сөрөг эрх чөлөөний эрхүүдийг хэлбэр төдий хэрэгждэг байх нь хангалтгүй, харин бүх хүмүүсийн хувьд бодитойгоор нөлөөлдөг байх ёстой гэж үзвэл сөрөг эрх чөлөөний эрхүүдийг бодит нөлөөтэй болгохын тулд эерэг эрх чөлөөний эрхүүд хангагдсан байх ёстой. Энэ нь юу гэсэн үг бэ? гэхлээр аливаа нийгэм дэх хөрөнөтэй хүмүүс дахин хувиарлалтыг хүлээн зөвшөөрөх ёстой гэсэн үг. [...] Нийгмийн, ерөнхийдөө төрийн зохион байгуулалтын дор нийгмийн үйлчилгээ, нөөцийн дахин хувиарлалтыг хийхгүйгээр бүх хүмүүсийн эрх чөлөөний эрхүүдийг хэрэгжүүлэх боломжгүй юм.”

(Нийгмийн ардчиллын үндсүүд, 1-р дэвтэр, 104-р тал)



Зураг 2: Сөрөг ба эерэг эрх чөлөөний эрхүүд

3. НИЙГМИЙН БАРИМЖААТ ТӨР ДЭХ ШУДАРГА ЁС ⁴

Энэхүү бүлэгт:

- Хувиарлалтын шударга ёсны үндсэн дөрвөн зарчим болох тэгш байдал, бүтээмжийн шударга ёс, хэрэгцээний шударга ёс, боломжийн тэгш байдал ба тэдгээрийн хоорондын харьцааг авч үзнэ.
- Хувиарлалтын шударга ёсны зарчмуудад бүгдэд нь агуулагдаж байдаг хүйсийн болон үе хоорондын шударга ёсны зарчмуудыг нарийвчлан судална.
- Эрхард Эпплерийн улс төрийн өдөр тутмын амьдралын хэл зүйн хэрэглээнд "шударга ёс"-ны ойлголтыг хэрхэн ашиглаж байгаа талаар хийсэн судалгааг танилцуулна.

Шударга ёс бол хэн нэгнийг бусадтай харьцуулсан харьцааг тодорхойлж үнэлдэг шалгуур үзүүлэлт юм. Нийгмийн шударга ёс нь үүний нэгэн адил хэн нэгнийг бусадтай харьцуулсан харьцаа бөгөөд энэ тохиолдолд үйл ажиллагааг гардан гүйцэтгэгч төр буюу нийгмийн иргэдтэйгээ харьцаж буй харьцаа юм. Өөрөөр хэлбэл: төр бүх иргэдтэйгээ шударга харьцаж буй эсэхээр нийгмийн шударга ёс хэмжигдэнэ. Тэгэхлээр төр бүх иргэдтэйгээ шударга харьцахын тулд хувиарлалтын ямар масштабыг хэрэглэх ёстой бэ? гэдэг асуулт гарч ирнэ.

Төрийн хувиарлалтын (дахин хувиарлалтын) үндсийг дээр тайлбарласан. Хүн бүрийн ижил нэр хүндтэй байх тэгш эрхээс үүдэн иргэн бүр өөрийн хүссэнээр амьдрах, улс төрд оролцоотой байх тэгш боломжоор хангагдах ёстой.

Хүн бүрийн нэр хүндтэй байх тэгш эрх дээр шударга ёс суурилдаг. Шударга ёс нь хүн бүр нийгмийн гарал үүсэл, эсхүл хүйсээсээ үл хамааран тэгш эрх чөлөө, амьдралын тэгш боломжоор хангагдах ёстой гэдэг шаардлага юм.

(Хамбургийн хөтөлбөр 2007 он, 15-р хуудас)

Ингэхийн тулд яах ёстой бэ? Бүх иргэд бүгдээрээ тэгш хувь хүртэнэ гэсэн үг үү? Эсхүл дахин хувиарлалтын үр дүнд бүх иргэн тэнцүү хэмжээний өмчтэй болно гэсэн үг үү? Эсхүл бүх иргэдийн хувийн

4 Номын энэ бүлгийг бичихдээ Векер/Наузер (2004 он), Гозепат (2004 он), Керстинг (2000 он), Лессиних (2003 он) бүтээлүүдээс санаа авлаа.

*Хэр шударгаар
хувиарлах бэ?*

**Гүнзгийрүүлэн
унших эх
сурвалжууд:**
Нийгмийн
ардчиллын үндсүүд
1-р дэвтэр
(2008 он), 19-36-р
хуудас


*Бүх хүнд тэгш
хувиарлана гэсэн
үг үү?*

хэрэгцээг ижил хэмжээгээр хангана гэсэн үг үү? Эсхүл бүтээмж ба байгуулсан гавъяаг нь үндэслэж хувиарлах уу? Эсхүл нийгмийн үйлчилгээнээс илүү боломжийг тэгш хувиарлана гэсэн үг үү?

Тэгш байдал, бүтээмжийн шударга ёс, хэрэгцээний шударга ёс, боломжийн тэгш байдлын эдгээр дөрвөн зарчмыг юугаар дамжуулан хэрэгжүүлэх ёстой юм бэ? Эдгээр зарчмуудын алиныг нь нийгмийн баримжаат төрийн ямар салбарт хэрэгжүүлбэл нь зүйтэй бэ? гэдгийг дараахи хэсэгт илүү нарийвчлан авч үзэх болно. Дээр дурьдсан зарчмууд нь хувиарлалтын шударга ёсны үндсэн зарчмууд юм.

Шударга ёсны дараахи хоёр зарчмыг зарчмын хувьд авч үзэх учиртай. Эдгээр нь хүйсийн шударга ёс ба үеүд хоорондын шударга ёсны зарчмууд юм. Хувиарлалтын шударга ёсыг хангахын тулд төр иргэдийнхээ ялгаатай байдлыг дахин хувиарлалтад харгалзан үзэх ёстой юу? Харгалзан үзэх ёстой юм бол аль хэр хэмжээнд харгалзан үзэх ёстой бэ? гэдэг зарчмын асуулт зайлшгүй гарч ирнэ. Иргэдийнхээ ялгаатай байдлыг дахин хувиарлалтанд харгалзан үзэхийн тулд салбар тус бүрт өөр өөр зарчмуудыг хэрэглэх шаардлагатай болдог.

Дөрвөн зарчим:
Тэгш байдал,
боломжийн тэгш
байдал, бүтээмж
ба хэрэгцээ



Зураг 3: Шударга ёсны дөрвөн ойлголтууд

Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн тэгш байдлыг хангах болон өнөөгийн үйл ажиллагаагаар ирээдүйд хойч үеийн оршихуйн үндсийг хамгаалах зарчмуудыг бодлогын аль нэгэн салбараар хязгаарлах боломжгүй юм. Эдгээр зарчмууд нь (нийгмийн)-бодлогын үндсэн чиг хандлагыг тодорхойлогч нь байх ёстой.

Хүйсийн шударга ёс

Зохиогч Эва Флекен

Хөдөлмөрийн харилцаанд ээжүүд аавуудаас бага оролцоотой байгаа нь шударга ёсонд нийцэж байна уу? Эмэгтэй ажилтнууд эрэгтэй ажилтнуудаас бага цалин авч байгаа нь шударга явдал уу? Эрэгтэй сурагчдын сурлагын амжилт охидынхоос доогуур байгаа нь шударга гэж үү?

Эдгээр нь хүйсийн шударга ёстой холбоотойгоор тавигдаж буй олон асуултуудын зөвхөн өчүүхэн хэсэг нь. Хүйсийн шударга ёс нь эмэгтэйчүүд, ба эрэгтэйчүүдийн амьдралын бодит байдлыг бодлогын бүх салбарт системтэйгээр харгалзан үзэхийг шаарддаг. Хүйсийн шударга ёс нь хувиарлалтын шударга ёсны суурь дөрвөн зарчимтай, нэн ялангуяа бүтээмжийн болон боломжийн тэгш байдалтай тодорхой хэмжээнд зөрчилдөж байдаг.

Хүйсийн шударга бус байдал байна гэдгийг олж тогтоосоор удсан ч хүйс хоорондын ялгаатай байдал дорвитой буураагүй л байна. Сайн дураараа хүүхдийн живх солигчид, үр хүүхдээ бусдаар өсгүүлдэг хөхөө шувуу шиг эцэг эхчүүдийн тухай хэлэлцүүлэг, маргаан нийгэмд намжих нь байтугай улам эрчимжсээр байгаа тул нийгмийн бодлогын талбарт эдгээр сэдвүүд нь шинэлэг хэвээр байсаар байна. Уг сэдвүүд ахин дахин хурцдаж нэр нөлөөтэй хүмүүсээр дамжин олны анхаарлын төвд байсаар байна.

Феминист агуулгууд өнгөрсөн хэдэн арван жилд өөрчлөгдөж үндсэн шаардлагууд нь өөр асуудлууд дээр төвлөрсөн байна. Феминист бодлогын фокус нь 1970-аад оны эрс шаардлагуудаас илүүтэйгээр хүйсийн тэгш байдлыг түншлэлийн зарчмаар хангахад төвлөрчээ. Феминизмийн бүтэц өөрчлөгдөж улам боловсронгуй болсон ч феминист шаардлагууд нь урьдын адил улс төрийн шаардлагууд хэвээр байна.

Германы нийгмийн баримжаат төрд тавигдаж буй шаардлагууд нь үндэслэлтэй, зөвтгөхөөс өөр аргагүй байдаг. Үүнд: Өндөр насны ядууралд ихэвчлэн эмэгтэйчүүд өртөж эхнэр нөхрийн орлогод татварын давхар ачаалал үүрүүлж байгаа нь эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтэд сөргөөр нөлөөлж байгаа нь үнэн. Үүнээс гадна хүйсийн тэгш бус байдалд зөвхөн эмэгтэйчүүд бус эрэгтэйчүүд өртөх хандлага нэмэгдэж байна. Жишээлбэл:

Хүйсийн болон үеүд хоорондын шударга ёс: бодлогын аль нэг салбараар хязгаарлагдахгүй.

Гүнзгийрүүлэн унших эх сурвалжууд:

*Фридрих-Эбертийн сан, (2009а он)
Эмэгтэйчүүд-Эрэгтэйчүүд-Жендерийн сэдвүүдийн портал
www.fes.de/gender*

Фридрих-Эбертийн Сан (2009б он) өндөр нас, өдөлмөр, Ядуурал? Эмэгтэйчүүдийг өндөр насны ядуурлаас хамгаалъя! Берлин 2009 он

Кристине Фербер, Ульрике Шпангенберг, Барвара Стиеглер (2008) он Жолоодлогыг эргүүл: Эхнэр, нөхрийн орлогод нэмэгдэл татвар ногдуулдагийг зогсоох хангалттай үндэслэлүүд Фридрих-Эбертийн Сан Бонн хот 2009 он

Бид энэ хооронд зарим салбарт жишээлбэл: боловсролын тогтолцоонд эр хүйсийн ялгаварлан гадуурхалт нэмэгдэж буйг харж байна.

Хоёр хүйс хоёулаа шударга бус байдалтай тэмцэж байна. Хоёр хүйсийн аль нь илүү ялгаварлан гадуурхалтад өртөж буйг харьцуулан дэнслэх нь эдийн засгийн болон нийгмийн бодлогын хувьд ухаалаг бус хэрэг. Учир нь аль нэг салбарт ялгаварлан гадуурхалтад өртсөн бол нөгөө салбарт онцгой эрх олгох байдлаар нөхнө гэдэг ойлголт байхгүй. Үүний оронд орчин үеийн нийгэмд хүйсийн шударга бус байдлыг олон хэмжээст хавтгай дээр авч үзэх шаардлагатай болжээ гэдэг талаас нь харах хэрэгтэй. Өрх толгойлсон эцгүүд хүүхдийн асаргааны асуудлыг өрх толгойлсон эхээс дутуу мэднэ гэж үгүй. Өвчтөнийг асарч буй асрагчид эмнэлэгт ажиллаж буй сувилагчидтай адилхан хүмүүн бусын бага цалин авч байна. Эдгээр жишээнээс харахад хүйсийн шударга ёсны асуудал улам олон талтай болсоор байна, тэр хэмжээгээрээ улам бүр ач холбогдолтой болсоор байна.

Олон ургальч нийгэм хувиарлалтын шударга ёсны илүү цогц стратеги шаардаад зогсохгүй шударга ёсны зарчим тус бүрийг онцгойлон авч үзэхийг шаардаж байна. Уг шаардлага хүйсийн шударга ёсонд нэгэн адил тавигдаж байгаа юм.

Гүнзгийрүүлэн униших эх сурвалжууд:

Фридрих-Эбертийн сан (2006 он) үеүд хоорондын шударга ёс. ФЭС-гийн онлайн академийн сэдвийн модулууд www.fes-online-akademie.de

Петер Воффингер (2009 он) үеүд хоорондын шударга ёсыг хангах нь. Эдийн засгийн хэтийн төлөв, Фридрих-Эбертийн сан (2004 он)

Вжорн Военинг, Кай Бурмайстер (2004 он) үе ба шударга ёс Хамбург

Үеүд хоорондын шударга ёс: нь нэг талаас хөгшин ба залуу хүмүүсийн хооронд, нөгөө талаас өнөөгийн болон ирээдүй хойч үе хоорондын баялгийн хувиарлалтын асуудлыг авч үзэхийг шаарддаг. Үеүд хоорондын шударга ёсны зарчим хэрхэн алдагдаж байгааг харуулж буй нэгэн сонгодог жишээ бол байгаль орчны сүйрэл юм. Сүүлийн үед үеүд хоорондын шударга ёсны тухай ойлголтыг нийгмийн баримжаат төрийн санхүүжилт болон төрийн өрийн асуудалтай холбон тайлбарлах боллоо. Үүнээс гадна уг ойлголтыг боловсролын болон нийгмийн хамгааллын системд төрийн үйлчилгээний зардлыг бууруулах зорилгодоо халхавч болгон ашиглах хандлага байгааг анхаарлын гадна орхиж болохгүй. Ийм ч учраас ГСДН-ын Хамбургийн хөтөлбөрт үеүд хоорондын шударга ёсны тухай ойлголтыг илүү өргөн хүрээтэйгээр томъёолсон юм. “Тогтвортой санхүүгийн бодлого гэдэг ойлголтыг “өнөөдөр тавьсан өрөө ирээдүй хойч үеийнхэндээ үүрүүлж болохгүй” гэсэн үг гэж бид ойлгодог. Төсвийг тогтворжуулж байна гээд бид хойч үедээ элэгдэж хэмхэрсэн дэд бүтцийг үлдээж болохгүй. Иймээс бид хойч үеийнхээ өмнө дараахи үүргийг хүлээх учиртай. Үүнд: “Бид төсвийн алдагдлыг бууруулахын зэрэгцээ боловсрол, судалгаа, дэд бүтцэд одоогийнхоосоо илүү хөрөнгө оруулалтыг хийх ёстой.”

(Хамбургийн хөтөлбөр 2007 он, 46-р тал)

3.1. Тэгш байдал

Тэгш байдал нь хувиарлалтын нэгэн зарчмын хувьд нийгмийн гишүүдийн хооронд эрх зүй, улс төр, нийгэм, эдийн засгийн байр сууриас үүдэлтэй ямар нэгэн ялгаварлалгүй байхыг шаарддаг. 1789 оны Францын хувьсгалын үндсэн уриа нь “Эрх чөлөө, тэгш байдал, эв санааны нэгдэл”-ийг хангах шаардлага байсан юм. 19-р зууны үеэс ажилчны хөдөлгөөн бүх иргэдийн эрх зүй болон улс төрийн тэгш байдлыг хангахын төлөө тэмцсээр иржээ. Ажилчны хөдөлгөөн зөвхөн ажилчин ангийн тэгш эрхийг хангахыг шаардаад зогсохгүй бүх хүнд тэгш эрх чөлөө олгохын төлөө тэмцэж байлаа.

Ажиллагч ангийн тэгш эрхийг хангахын төлөөх тэмцэл нь ажилчин ангийн эрх мэдэл, монополийн төлөөх тэмцэл биш харин тэгш эрх ба тэгш үүргийн төлөөх тэмцэл байлаа.”

(Германы ажилчдын холбооны нэгдэлийн өдрийн хөтөлбөр, Нюрнберг 1868, Довел/Клотцбахын ишлэлээс 2004 он, 157-158-р хуудас)

Эрх зүйн болон улс төрийн тэгш байдал (эрх тэгш байдал)-ын хүрээнд томоохон дэвшил гарсан байна. Тэгш байдалд тэгш, тэгш бус байдалд тэгш бус байдлаар хандах хамгийн дээд түвшнийг суурь болгон авч үзвэл зөвтгөх шалтгааныг холоос хайгаад байхын хэрэггүй бөгөөд: “Бүх хүнд улс төрийн оролцоо ба өөрийн хүссэнээр шийдэх боломжийг тэгш хэмжээгээр олгох ёстой.” гээд хэлчихэд л болно. Иймээс ямар нэгэн шалтгаанаар жишээлбэл хүйсээс хамааран хүмүүст ялгавартай хандахыг зөвтгөх үндэслэл байхгүй, учир нь тухайн хүний хүйс нь нэр хүнд, улс төрийн оролцоо, өөрийн хүссэнээр шийдвэр гаргахад ямар нэгэн ялгавартай хандах үндэслэл болохгүй.

Тэгш бус хандах нь нэгэн хэрэгсэл тул эцсийн дүнд гарч буй тэгш бус байдлаас ялгаж салгаж авч үзэх шаардлагатай. Чухам иймээс л хүнд байдалд байгаа хүмүүсийг онцгойлон харж үзэх шаардлагатай. Иймээс тэгш байдлыг юуны өмнө эрх зүйн орчинд хэрэгжүүлдэг. Бодит байдал дээр тэгш байдлын үндсэн зарчмаас олон тохиолдолд гажиж байгааг ажиглаж болно.

Эрх зүйн тэгш байдлыг хангачихвал тэгш байдал бүрэн утгаараа хангагдчихна гэсэн үг биш юм. Ялангуяа ажил мэргэжил, хөдөлмөрийн харилцаанд уламжлагдан ирсэн тэгш бус байдал оршсоор байна. Хөдөлмөр эрхлэлт болон гэр бүлийн амьдралын

19-р зуунд эрх зүйн болон улс төрийн тэгш байдлыг хангахыг шаардаж байлаа.

Хэлбэр төдий тэгш байдал өргөн хүрээнд хэрэгжиж эхэллээ.

Арга хэрэгсэл ба үр дүнг хооронд нь ялгаж салгаж авч үзэх ёстой.

зохистой тэнцвэрийг хангах асуудал ихэвчлэн эхчүүдийн тулгамдсан асуудал хэвээр байна. Эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс бага цалин авч, эмэгтэйчүүдийг ажлаас халах нь эрэгтэйчүүдийг ажлаас халахаас илүү хялбар, эмэгтэйчүүд ихэвчлэн ядууралд өртөмтгий байсаар байна.

(Хамбургийн хөтөлбөр 2007 он, 10-р тал)

Тэгш бус байдал
байгаа газарт
зөвтгөх шалтгаан
байх ёстой.

Хэрэв бид тэгш бус байдалтай нүүр тулж байгаа бол тэнд зөвтгөх шалтгаан байж л таараа гэж боддог. Хүн бүр хүний дайтай амьдрах, өөрийн хүссэнээр эрх чөлөөтэй амьдрах, улс төрийн шийдвэр гаргалтанд оролцох, санал бодлоо илэрхийлэх эрхтэй учраас тэгш бус байдал байгаа бол түүнийг зөвтгөх шалтгаан байх ёстой.

Тэгш байдлыг ямар
цар хүрээнд авч
үзэх ёстой бэ?

Тэгш байдлыг хангах шаардлага зөвхөн улс төрийн болон нийгмийн эрхүүдэд тавигдаад зогсохгүй орлогын болон нийгмийн үйлчилгээний хувиарлалтанд нэгэн адил тавигдах ёстой биш үү? өнгөцхөн харахад хэрэглэхэд хялбархан мэт санагдах тэгш байдлын зарчимтай холбоотой дараахи хоёр асуулт юуны өмнө гарч ирнэ. Үүнд: Тэгш байдлыг хангах асуудлыг айл өрхийн хүрээнд авч үзэх үү? Эсхүл хүн тус бүрээр авч үзэх үү? Тэгш орлогын тухай асуудал уу? Эсхүл амьдралын тэгш нөхцөлөөр хангах тухай асуудал уу? Тэгш байдлыг хангах асуудлыг цаг хугацааны ямар цар хүрээнд авч үзэх ёстой юм бэ? (Тодорхой цаг хугацаанд, амьдралын тодорхой үед, эсхүл насан туршид нь уу?)

Амьдралын бололцоонд тулгуурласан шийдэл

Кнут Ламвертин, Кристиан Крелл

Герхард Вайссер ядуурал ба эд баялгийн асуудлыг олон хэмжээст хавтгай дээр судалсныхаа дараагаар амьдралын бололцоонд тулгуурласан концепцийг боловсруулсан юм. Герхард Вайснер нь (1898-1989) сайд, нийгмийн шинжлэх ухааны эрдэмтэн, Коелний их сургуулийн профессор, протестантын шашны зүтгэлтэн, идэвх зүтгэлтэй социалдемократ байсан юм. 1954-1970 онд Фридрих-Эбертийн сангийн удирдах зөвлөлийн даргын албыг хашиж байжээ.

Түүний “Амьдралын бололцоо хувиарлагддаг” гэдэг үг хэллэг нь хувиарлалтын бодлогын шийдлийн гол цөм нь байлаа. Тэрбээр хувиарлалтын бодлого боловсруулалтанд зөвхөн материаллаг хэмжээг бус хүний хэрэгцээний бүх хүчин зүйлс, түүнчлэн үйл ажиллагаа явуулах

боломжийн орон зай, нийгмийн сүлжээ, эсхүл соёлын ололт зэргийг харгалзан үзэх ёстой гэдэг үндэслэл дэвшүүлжээ. Тэгэхлээр хувиарлалт нь зөвхөн нийгэм, эдийн засгийн цар хүрээний асуудал биш харин эдгээртэй холбоотой хангалуун аж төрөх бүх боломжийн хувиарлалттай холбоотой асуудал бөгөөд энэ утгаараа материаллаг хүрээнээс давсан асуудал юм. Герхард Вайснер нь ийнхүү амьдралын бололцоог хувиарлах асуудлыг дэвшүүлснээрээ онолын судалгааны ажлыг практик амьдралтай холбож чадсан юм. Түүний энэ санаа ГСДН-ын Годесбергийн хөтөлбөрийн амин сүнс нь болоод зогсоогүй бүтээл, үзэл санаа нь Холбооны нийгмийн халамжийн тухай хууль, Холбооны засгийн газрын ядуурал-ба эд баялгийн тухай илтгэлд чухал нөлөө үзүүлсэн юм.

Түүний “Орлого, хөрөнгө ба эрх мэдлийн хувиарлалтад тэгш байдлыг хангах” тухай шаардлага, оролцоо ба амьдралын тэгш боломжийн тухай сануулга нь 2007 онд боловсруулагдсан ГСДН-ын Хамбургийн хөтөлбөрт тусгалаа олсон байдаг.

Тэгш байдлыг материаллаг үр дүнг тэгш байлгах зорилт хэмээн тайлбарлах нэгэн боломж байж болох юм. Тухайн хүн юуг, хэр хэмжээгээр бүтээснээс үл шалтгаалан бүх хүн төрөөс тэгш хэмжээний материаллаг туслалцааг авна гэсэн санаа.

Уг загварын дагуу хувиарлалтыг хийнэ гэвэл хэрэгсэхгүй байх боломжгүй эсрэг үндэслэлүүд гарч ирнэ. Зах зээлийн эдийн засагтай нийгэмд тэгш байдлын зорилтыг тууштайгаар хэрэгжүүлэх боломжгүй. Учир нь материаллаг тэгш байдлыг хангах зорилт тэр даруйдаа хувь хүний эрхүүдтэй зөрчилдөж (жишээлбэл өмчлөх эрх) байгаа жишээ орчин үеийн ардчилсан нийгэмд элбэг тохиолддог. Тэгш байдлыг дангаар нь хувиарлалтын зарчим болгон хэрэгжүүлэх нь шударга ёсонд нийцдэггүй гэдгийг эдгээр жишээнээс ойлгож авах нь чухал.

Бүтээмж ба хэрэгцээ нь хувиарлалтын бусад хоёр чухал зарчим бөгөөд нийгмийн үйлчилгээ, нөөцийн хувиарлалтыг эдгээр хоёр зарчим дээр тулгуурлан хийх бололцоотой юм. Тэгвэл эдгээр хоёр зарчим нь тэгш бус байдлыг зөвтгөх үндэслэл болж чадах уу?

Материаллаг үр дүнгийн тэгш байдал...

.... энэ нь дангаараа масштаб болж чадахгүй .

3.2. Бүтээмжийн шударга ёс

Жишээ: Ижил
хөдөлмөрт ижил
хөлс

Шударга ёсны олон зарчмуудын дотроос тэгш бус хувиарлалтыг зөвтгөх үндэслэл болж чадах ихэнх хүмүүсийн нүдний өмнө ил байдаг зарчим бол бүтээмжийн шударга ёс. Бүтээмжийн шударга ёс нь (хийснийхээ хэрээр авах зарчим) ижил бүтээмжийг ижил, ижил бус бүтээмжийг ижил бусаар үнэлэхийг шаарддаг. Бүтээмжийн шударга ёсны дээд илэрхийлэл болсон нэгэн жишээ бол: “Ижил хөдөлмөрт ижил хөлс олгох” шаардлага юм.

Социалдемократууд нийгмийн үйлчилгээ ба нөөцийн хувиарлалтын ялгаатай байдлыг хууль ёсных хэмээн ямагт зөвтгөж байдаг хэмээн биднийг мохоох үндэслэл болгосоор ирсэн. Тэгш бус байдал нь онцлог хэрэгцээ эсхүл орлогын мэдрэгдэхүйц, танигдахуйц, үнэлж болохуйц бүтээмжийн зөрүүн дээр суурилсан бол зөвтгөж болох үндэслэл гэж бид үздэг.

(Тийрзе 2005:14-р тал)

Бүтээмжийг яаж
хэмжих бэ?

Гэхдээ бүтээмж болон орлогыг хэр хэмжээнд нарийвчлан тогтоох ёстой юм бэ? гэдгийг хэлэх тийм ч амархан биш. Үйл ажиллагааны үр дүнг бүтээмж гэж үзэх үү? Эсхүл тухайн үйл ажиллагааг хийж гүйцэтгэхэд гаргасан чармайлтыг (хичээл зүтгэл ба идэвх чармайлт) үнэлэх үү? Тэгвэл: Бүтээмжийн үнэлгээнд хүн тус бүрт харилцан адилгүй заяадаг авъяас чадварыг оруулан тооцох ёстой юу? өлгийдөө үнэгчилж байхдаа эцэг эхээс өвлөн авчихсан ч хожим түүнийгээ юунд ч ашиглаагүй бол тухайн хүний авъяасыг авъяастай төрчихсөнийх нь төлөө үнэлэх ёстой юу? үгүй юу?

Хүмүүсийн зүрх сэтгэлд ямархан нууц агуулагдаж байгааг зөвхөн бурхан л мэдэх хойно, тиймээс шаардлагатай хувиарлалтыг зөвхөн бурхан л хүмүүсийн хүсэл, шаардлагад бүрэн нийцүүлэн хийж чадахсан. Харин бурхны оронд хүн гэдэг бодьгалд бүтээмж, хичээл зүтгэл, илэрсэн болоод далд байгаа авъяас чадварыг үндэслэн хувиарлалтыг гардан хийх үүрэг ногддог учраас өөрсдийгөө сайн, илүү сайн, хамгийн сайн болон онцгой хичээл зүтгэл гарган хийсэн гэдгийг маш сайн мэддэг гэж боддог аристократуудын гарт (тэд өөрсдийгөө аристократууд гэж нэрлэх байсан байх) бүхэл бүтэн хувиарлалтын аппарат тэр даруйдаа шилжиж харин тэд нийгмийн бусад үлдсэн гишүүдийн олон талт давуу байдал, гавъяаны талаар сохортой адилхан сууж байх нь ойлгомжтой.

(Вальцер 2006:56)

Олон санал асуулга, туршилтын үр дүнгээс авч үзвэл хүмүүс бүтээмжийг үр дүн, хичээл зүтгэл, авъяас чадвар гэдэг гурван хүчин зүйлсийн нэгдэл гэж үздэгийг харуулж байна. Үр дүн ба чармайлтыг авъяасаас илүү чухалд үздэг.

Бүтээмж: Үр дүн, хичээл зүтгэл ба авъяас чадвар?

Хүмүүсийн олонхи нь хувь хүний авъяас чадвар хичээл зүтгэлтэй хосолсон нөхцөлд үнэлгээний чухал хүчин зүйл болж чаддаг гэж үздэг.⁵ Чармайлт, хичээл зүтгэл, идэвх-эдгээр хүчин зүйлсийг хэн нэгэн гаднаас нь үнэлэхэд туйлын хүндрэлтэй.

Бүтээмжийн зах зээлийн үнэлгээ.

Бүтээмжийн зарчмыг тууштайгаар хэрэглэнэ гэдэг санасан зоргоор амархан зүйл биш. Хамгийн хялбархан шийдэл бол бүтээсэн бүтээмжийн үнэлгээг зах зээлд даатган орхих. Гэхдээ энэ шийдлээс тодорхой үр дагавар гарах нь зайлшгүй. Учир нь зах зээл бүтээмжийн хэрээр хөлс олгохдоо хувь хүмүүсийн хичээл зүтгэл, үүрэг даалгавар биелүүлэхэд бэлэн байдлыг заавал харгалзан үзэх албагүй.

...Юуны өмнө үр дүнд чиглэдэг.

Зах зээл хувь хүний хичээл зүтгэл, бэлэн байдал гэхээсээ илүүтэй зарчмын хувьд үр дүн дээр суурилсан үнэлгээг хийдэг. Гэхдээ бодит байдал дээр иргэдэд шударга хэмээн хүлээн зөвшөөрөгдөж буй орлогын ялгаа болон бодит байдал дээрх орлогын ялгаа хоёр хоорондоо санаснаас хамаагүй илүү зөрүүтэй байдаг. (Миллер 2008 он, 112-р тал)

Дээр дурьдсан асуудлууд дээр илүү зарчмын шинжтэй нэгэн хүндрэл нэмэгддэг: Олон бүтээмж, нэн ялангуяа гэр бүлийн хүрээнд үнэ төлбөргүй, ямар нэгэн үнэлгээгүй хийгдэж байдаг. (Хангамж, хүмүүжил, асрамж) Дээр дурьдсан бүтээмжийн дийлэнхийг эмэгтэйчүүд бүтээж байдаг тул хүйсийн шударга ёсны зарчим давхар зөрчигдөж байгаа юм. Үүнд:

Асуудал: Зах зээл бүх бүтээмжийг бүрэн үнэлдэггүй.

1. Олон хүмүүсийн бүтээж буй бүтээмжийг огт үнэлдэггүй тул хөлсгүй хөдөлмөр юм.
2. Энэхүү шударга бус байдалд ихэнхдээ эмэгтэйчүүд нэрвэгдэж байдаг.

5 Шударга ёсны талаар баримталж буй байр суурийн талаар сонирхолтой судалгааг Миллерийн 4-р бүлгээс уншина уу. (2008 он)

Шударга ёсны зарчмыг амьдралд хэрхэн хэрэглэж байгааг ажилгүйдэл болон тэтгэврийн даатгал дээр илүү тодорхой харж болно. Ажилгүйдэл ба тэтгэврийн даатгалд хоёуланд нь даатгуулагчийн төлсөн шимтгэлийн хэмжээнээс даатгуулагчийн авч буй тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээ хамаардаг. Тэтгэврийн хэмжээ ажил мэргэжил эрхэлж байх нийт хугацааныхаа туршид төлсөн шимтгэлийн хэмжээнээс хамаардаг бол ажилгүйдлийн тэтгэмжийн хэмжээ даатгуулагчийн сүүлийн жилд авч байсан дундаж цалингийн хэмжээнээс хамаардаг.

Харин эрүүл мэндийн даатгалын системд бүтээмжийн шударга ёсыг зөвхөн хязгаарлагдмал хүрээнд хэрэглэдэг. Эрүүл мэндийн даатгалын тогтолцоо даатгуулагчийн цалингийн хэмжээнээс хамааран хууль ёсны болон хувийн даатгал гэсэн хоёр үндсэн хэсэгт хуваагддаг бөгөөд эрүүл мэндийн даатгалын үйлчилгээ бүтээмжээс шууд бус хамааралтайгаар хувиарлагддаг.⁶

Бид бүтээмжийн шударга ёсны зарчмыг боловсролын системд мөн хэрэглэж байгааг харж болно. Боловсролын системд мөнгө, үйлчилгээг бус харин боловсролыг хувиарладаг. Бүх нийтээрээ суурь боловсрол эзэмшсэний дараагаар бүтээмжийн тодорхой шалгуурыг хангасан хүн бүр дараагийн шатны төрийн боловсролын тогтолцоонд дэвшин суралцах боломжоор хангагддаг. Дээр дурьдсан салбаруудад (өмнө нь авч байсан) орлого нь бүтээмжийн шалгуур үзүүлэлт болдог бол боловсролын салбарт дүн, төгсөлтийн үнэмлэх дараагийн шатны сургуульд дэвшин суралцах эсэхийг шийдэх шалгуур үзүүлэлт болдог.

6 Нийгмийн баримжаат төрийн төрөл бүрийн салбаруудад хэрэглэж буй шударга ёсны зарчмуудын талаархи хэлэлцүүлгийн дэлгэрэнгүйг энэ номын 7-р бүлгээс уншина уу.

3.3. Хэрэгцээний шударга ёс

Карл Маркс тэртээ дээр үед германы ажилчны намын Готхаерын хөтөлбөрийг шүүмжилсэн шүүмжлэлдээ “Хүн бүр чадлынхаа хэрээр бүтээж, хүн бүрт хэрэгцээнийх нь хэрээр хүртээх”-ийг шаардсан ч уг шаардлагыг биелүүлэх нь улс төрийн үүрэг гэж үзэхгүй байлаа. Тэрбээр дээрх шаардлага коммунист нийгэм хөгжлийнхөө дээд шатанд ороод ирэхээр өөрөө аяндаа хэрэгжчих тул тэр үед шударга ёсны тухай ойлголт илүүц болох юм” хэмээн үзэж байлаа.

“Хүн бүр чадлынхаа хэрээр бүтээж, хүн бүрт хэрэгцээнийх нь хэрээр хүртээх”

Орчин үеийн нийгэмд нийгмийн үйлчилгээний хувиарлалтын үндэслэл болгоход хэрэгцээ ба хэрэглээний ямар ойлголт хамгийн тохиромжтой бэ? Хувь хүмүүсийн хүслийг хэрэглээ ба хэрэгцээтэй адилтган ойлгож болох мэт. Гэтэл эргэн тойрондоо том цэцэрлэгтэй виллад амьдрах нь зарим хүмүүсийн хэрэгцээ байж болно. Дээрхтэй төстэй хэрэгцээний ойлголтыг хувиарлалтын үндэслэл болгох юм бол нөөц хязгаарлагдмал тул тэр даруйдаа хэрэгцээний шударга ёсыг хэрэглэх хэрэглээний боломжийн дээд хязгаарт тулчихна.

Хувь хүмүүсийн хүслийг хувиарлалтын масштаб болгох уу?

Тухайн нийгэмд хүний дайтай амьдрахад шаардагдах нөхцөлийг хэрэгцээ гэж ойлгох бас нэгэн хувилбар байж болох юм. Хэрэгцээт зүйлсийн талаар дээрхтэй төстэй ойлголтыг Адам Смит тодорхойлсон байдаг. Тэрээр:

Хэрэгцээ: Хүний дайтай амьдрахад юу хэрэгтэй бэ?

Миний ойлголтоор хүний амьдралд чухал шаардлагатай зүйлс бол амьд явахад зайлшгүй шаардлагатай зүйлс биш юм. Харин тухайн улс орны дадал заншлын дагуу зөвхөн нэр хүндтэй хүмүүс төдийгүй нийгмийн доод давхаргынхны амьдралыг мөчиг тачиг гэж хэлэхээргүй хэмжээнд хүрэлцээтэй байх ёстой зүйлс хэмээн би үздэг.

(Смит 1978 1776: 747-р тал)

Тэгэхлээр хэрэгцээний шударга ёсны зорилго нь үндсэн хэрэгцээний зохистой, дундаж эсхүл хамгийн доод түвшинг буюу амьжиргааны баталгаажих доод түвшнийг хангахад чиглэгдэх ёстой. Дээр дурьдсан том эдлэн газартай виллаг үндсэн хэрэгцээ хэмээн хүлээн зөвшөөрөх боломжгүй нь ойлгомжтой ч хэрэгцээний түвшнийг хооронд нь яв цав хязгаарлаж улаан шугам татах боломжгүй юм.

Хүний дайтай амьдрахад чухам хэр хэмжээний бараа болон үйлчилгээ шаардагдах бэ? Энэ асуултад тухайн нийгмийн нөхцөл

Эхний бэрхшээл: Материаллаг улаан шугам

байдлаас хамааран өөр өөр хариулт гарч ирэх байх. 1960-аад оныг хүртэл харилцуур утас, зурагтыг үндсэн хэрэгцээ гэж үздэггүй байсан бол өнөөгийн нийгэмд харилцуур утас, зурагт, интернетийн сүлжээг үндсэн хэрэгцээнд тооцох байх.

Хоёрдох бэрхшээл:
Төрийн хариуцлага
хаа хүрээд зогсох
бэ?

ЗЗөвхөн техникийн болон амьдрах орчны өөрчлөлтүүдээс болоод шинэ бэрхшээлүүд ба дасан зохицох шаардлага гараад байгаа юм биш. Тэгвэл хувь хүмүүсийн хариуцлагагүй байдлаас огтхон ч шалтгаалаагүй бүтэлгүйтэл, санамсаргүй тохиолдол эсхүл бусад нөхцөл шалтгааны улмаас хүмүүс эмзэг байдалд орсон бол тухайн хүмүүсийн эрхэд суурилсан шаардлагыг хэрхэн хангах бэ? Мөн өөрийн буруутай үйл ажиллагааны улмаас амьдралын хүнд нөхцөлд орсон хүмүүсийг яах бэ? Төр өөрийн зуун хувь буруутай үйл ажиллагаанаас болж хүнд байдалд орсон нэгэнд эмзэг байдалд орохгүйн тулд хамаг чадлаараа тэмцсэн нэгэнтэй ижил хэмжээний үйлчилгээ, халамжийг үзүүлэх үүргийг хүлээх ёстой юу?

Гуравдах
бэрхшээл:
Хуваагдашгүй
үйлчилгээг хэрхэн
хуваах бэ?

Хэрэгцээний шударга ёсны зарчмыг хуваагдашгүй буюу хуваах боломжгүй үйлчилгээний хувиарлалтанд хэрхэн хэрэглэх бэ? гэдэг нь өөрөө иргэний хувийн хариуцлагыг тооцох эсэхээс ч хүнд асуудал юм. Энэ нь жишээлбэл: Хүний эд эрхтэн хандивлахтай холбоотой асуудал. Нэгээс дээш тооны хүмүүсийн үхэл амьдралыг шийдэх эрхтэн шилжүүлэн суулгах хэрэгцээ байхад байгаа ганцхан эрхтэнийг чухам хэнд нь өгөх бэ? гэдгийг яаж шийдэх бэ?

Хэрэгцээний
шударга ёс
нь нийгмийн
баримжаат төрийн
зарчмын нэгэн
илэрхийлэл болох
нь

Хэрэгцээний шударга ёсны үндсэн үзэл санаа хүний дайтай амьдрах амьдралын үзэлтэй онцгой арга хэлбэрээр холбогддог нь ойлгомжтой бөгөөд уг холбоос нь нийгмийн баримжаат төрийн үзэл санааг үндсэн хуульд тусгах үндэслэл нь болжээ. Хэрэгцээний шударга ёсны зарчмыг нийгмийн баримжаат төрийн зарчим болгон хэрэглэх нь амаргүй гэдгийг дээрх жишээнүүд харуулж байна.

Эрүүл мэндийн
системд хэрэглэх
нь

Хэрэгцээний шударга ёсны зарчмыг германы нийгмийн баримжаат төрийн зарим нэг үндсэн салбарт хэрэглэдэг. Эрүүл мэндийн системд уг зарчмын хэрэглээ харьцангуй тодорхой байдаг. Хэдийгээр зарим нэгэн салбарт бүтээмжийн шударга ёсны зарчмаас үүдэлтэй зарим нэгэн хязгаарлалтууд байдаг ч гэсэн өвчнийг анагаахдаа ерөнхийдөө эдгэрэх хүртэл нь буюу хэрэгцээнийх нь дагуу эмчилдэг.

Хэрэгцээний шударга ёсны зарчмыг хэрэглэж буй хамгийн тодорхой жишээ бол: Ажилгүйдлийн мөнгө 2. Энэ мөнгийг өмнө нь нийгмийн халамжийн сангаас олгодог байсан юм. Ажилгүйдлийн мөнгө 2-т бүх иргэдийнхээ хүний дайтай амьдрах амьдралын доод түвшний стандартыг баталгаажуулах тухай үндсэн санаа тодорхой харагддаг.

Ажилгүйдлийн тэтгэмжийн мөнгө 2: Үндсэн хангамжийн зарчим

Энд хэрэгцээний шударга ёсны зарчмын хэрэглээний бэрхшээл илүү тод харагддаг. Ажилгүйдлийн тэтгэмжийн хэмжээ халуун маргааны байнгын сэдэв байдаг. Зарим нь ажилгүйдлийн тэтгэмжийн мөнгөний хэмжээ хүний дайтай амьдрахад хүрэлцэхгүй хэтэрхий бага байна гэж үздэг бол зарим нэг нь мөнгөний хэмжээ хэтэрхий өндөр байгаа учраас хүмүүс дахин ажилд орох, ажил хайхыг урьдал болгохгүй байна гэж үздэг.

Маргаантай асуудал: Хэрэглээний хэмжээ

Ажилгүйдлийн мөнгөний хэмжээ хэт их үү? эсхүл хэт бага уу? гэдэг маргаан эхний ээлжинд шударга ёсны тухай биш харин үр өгөөжийн нотолгоо юм. Үр өгөөжийн нотолгоог ямар хэлбэрээр гаргаж болох ч хүний алдар хүнд харьцуулж болдог ойлголт биш. (Энэ хүнээс дор амьдарч байгаа хүмүүс байгаа учраас тухайн хүнийг хүний дайтай амьдарч байна гэж үзнэ гэдэг ойлголт байхгүй.) Энд зөвхөн ажилгүйдлийн тэтгэмжийн мөнгө нийгмийн болон улс төрийн амьдралын оролцоог хангах хэмжээнд хүрэлцэж байна уу? үгүй юу? гэдэг асуудлын хүрээнд л маргаан өрнөх учиртай.

Хүний алдар хүнд бол харьцуулагдах ойлголт биш.

3.4. Боломжийн тэгш байдал

Шударга ёсны дөрөвдэх зарчим болох боломжийн шударга ёс нь бусад гурван зарчмуудаас үндсэндээ нэгэн онцлог ялгаатай. Үр дүнгийн тэгш байдал, бүтээмжийн шударга ёс, хэрэгцээний шударга ёсны зарчмууд нь олон тохиолдолд хоорондоо зөрчилддөг. Боломжийн тэгш байдал нь зөвхөн бүтээмжийн болон үр дүнгийн тэгш байдлыг хооронд нь нэгтгээд зогсохгүй зарим талаар дээрх хоёр зарчмуудыг хэрэглэх нөхцөл нь болдог. Тэр ч байтугай дэс дараатайгаар.

Боломжийн тэгш байдал: Зөвхөн нэг бус хэд хэдэн зарчмуудад зэрэг агуулагдаж байдаг.

Боломжийн тэгш байдал нь бүтээмжийн-болон үр дүнгийн тэгш байдлыг зөвхөн хооронд нь холбож өгөөд зогсохгүй онцлог арга хэлбэрээр бүтээмжийн болон үр дүнгийн тэгш байдлыг хэрэглэх нөхцөлийг бүрдүүлж өгдөг. Гэхдээ дэс дараагаар нь.

Боломжийн тэгш байдал: Бүтээмжийн зарчмыг хэрэглэх нөхцөлийг бүрдүүлж өгдөг.

Харьцуулах
цэг: Гарааны
нөхцөлүүд

Өмнө үзсэн ойлголтууд нийгмийн үйлчилгээний тодорхой төрлүүдтэй холбогддог бол боломжийн тэгш байдлын тухай ойлголт нийгмийн үйлчилгээний тодорхой төрөлтэй холбогддоггүй гэдгээрээ ялгаатай. Боломжийн тэгш байдлын зарчим нь нийгмийн баялаг, нөөцийн ерөнхий хувиарлалттай шууд холбоогүй, зөвхөн боломжийн тэгш хувиарлалттай холбогддог. Өөрөөр хэлбэл: гарааны тэгш нөхцөл бүрдүүлэхийг шаарддаг.

Гарааны тэгш
байдал юу
нөлөөлдөг бэ?

Хэрвээ гарааны тэгш нөхцөл хангагдсан бол гараанаас гарснаас хойш бий болсон орлого, статус, бусад зүйлсийн хувиарлалтын тэгш бус байдлыг зүйд нийцсэн буюу шударга тэгш бус байдал гэж үздэг. Гарааны тэгш нөхцөл хангагдсан нөхцөлд бүтээмжийн шударга ёсны зарчмыг хэрэглэх боломжтой. Хүмүүс хооронд болон хүмүүсийн амьдралын үе бүхэнд маш их тэгш бус байдлаар хувиарлагдсан байдаг өөрийн хүссэнээр амьдрахад шаардагдах нөхцөлүүдээс чухам алиныг нь гарааны нөхцөлүүд гэж үзэх бэ? Хүмүүст байгалаас заяасан авъяас чадвар, эцэг эхийн харилцан адилгүй боломж бололцоо, хүйсээс үүдэлтэй үүрэг ролийн хувиарлалт, боловсролын ялгаатай байдал зэрэг олон нөхцөлөөс боломжийн тэгш бус байдал үүсдэг.

Амьдралын
боломжийн тэгш
байдал

Нэгэн цагт бүрдүүлж өгсөн гарааны тэгш нөхцөл дээр тулгуурласан тэгш боломжит харьцаа харьцангуй богино хугацаанд дахин тэгш бус байдал болон өөрчлөгдөх боломжтой байдаг нь боломжийн тэгш байдалд тулгардаг гол асуудал юм. Иймээс боломжийн тэгш байдлын тухай орчин үеийн онол нь “Амьдралын тэгш боломж” дээр суурилдаг. Энэхүү концепцийн дагуу шударга ёс нь төрийн хариуцлага зөвхөн нэг удаагийн хөндлөнгийн оролцоогоор тэгш боломжийг бүрдүүлээд зогсохгүй, тэгш боломжийг хадгалж байхын тулд байнгын засвар хийж байхыг төрөөс шаарддаг.

Учир шалтгааных
нь улмаас
ялгавартай хандах:
Хувь хүмүүсийн
хандлагын дагуу

Чухам энд боломжийн тэгш байдлыг хангахын тулд чухам юуг тэгш хувиарлах ёстой юм бэ? гэдэг асуулт гарч ирнэ. Жишээлбэл: тэгш бус байдлыг үүсгээд байгаа үр дагавартай нь холбох асуудал гарч ирж байна. Хувь хүмүүсийн хандлагаас үүдэлтэй амьдралын тэгш бус байдалд төрийн хөндлөнгийн оролцоо тус болохгүй.

... эсхүл
“байгалиасаа
сугалааны
шинжтэй байх
ёстой юм уу?”

Хувь хүмүүст байгалаас заяасан авъяас чадвараас үүдэлтэй (сугалааны шинжтэй) тэгш бус байдлыг төр нөхөн төлбөр олгох замаар

тэгшитгэж болно. Ингэж зааг тогтоох нь сонсоход ойлгомжтой, хялбар мэт боловч бодит амьдрал дээр шударга болон шударга бус шалтгааныг хооронд нь тэр бүр нарийн зааглах боломжгүй.

Нэг талаас бид тэгш байх шаардлагыг зөрчин байж хүмүүсийн харилцан адилгүй ажилч хичээнгүй байдал, идэвх санаачилга, амбицаас үүдэлтэй тэгш бус байдлыг арилгахын тулд нийгмийн нөөцийг тэгш бусаар хувиарлахыг зөвшөөрөх ёстой. Нөгөө талаас бид хүн бүрт харилцан адилгүй авъяас чадвар заяасны улмаас Лайссер-фейр-бодлогын дүрэмд заасан шиг тэгш бус хувиарлалтыг хэрхэвч хийж болохгүй. (өөрөөр хэлбэл авъяастайд нь шлүүг хувиарлаж болохгүй.)

(Дворкин 1981:381, А.П. Орчуулга)

Зарим хүмүүс “мэдлэг, чадвар” нь хувиарлалтын хамгийн чухал үзүүлэлт байх ёстой гэж үздэг. Бүх хүмүүст амьдралаа төлөвлөсөн төлөвлөгөөнийхөө дагуу босгох мэдлэг, чадварыг олгох ёстой. Иргэн бүрийн амьдралын боломжийг баталгаажуулахын тулд нийгмийн бодлого тэгш бус байдал үүссэнийх нь дараа тэгш бус байдлыг бууруулахад чиглэх ёсгүй. Харин иргэдээ хүсээгүй, урт хугацааны нийгмийн хохиролтой байдалд өртөхгүй байх боломжоор хангах, тэр ч байтугай хохиролтой байдлыг үүсгэхгүй байх нь нийгмийн баримжаат төрийн үндсэн үүрэг юм.

Мэдлэг, чадварын зөрүүг тогтоох

Шударга ёсны боломжийн тэгш байдлын зарчимд гарааны шударга нөхцөл асуудлын гол зангилаа нь юм бол боловсролын салбар нь уг зарчмыг хэрэглэх үндсэн талбар мөн гэдэг нь ойлгомжтой. Төрийн өмчийн сургалтын байгууллагууд болох хүүхдийн өдөр өнжүүлэхээс авахуулаад мэргэжил сургалтын үндэсний төвүүд нь бүх иргэддээ боловсрол олох боломжийг бүрдүүлж өгөхийг төр үүргээ гэж үздэгийг тодорхой харуулж байна.

Боломжийн тэгш байдлыг хэрэглэх үндсэн талбар: Боловсролын бодлого

Сүүлийн арван жилд хийгдсэн ПИСА-судалгааны үр дүнгээр германы боловсролын тогтолцоонд боломжийн тэгш байдал зөвхөн хязгаарлагдмал хүрээнд хангагддаг гэдгийг харуулжээ.

Герман улс: боломжийн тэгш байдал хангагдаагүй. 7.5-р бүлэг Боловсрол сэдвийг унших

3.5. Нэгдсэн дүгнэлт

Эпплер: Нийгмийн туйлын шударга ёс гэж байдаггүй.

Улс төрд чигийг заагч луужин хэрэгтэй.

Нийгмийн шударга ёсыг хангах нь улс төрийн үндсэн үүрэг

Эрхард Эпплер “Улс төрийн бодлогод нийгмийн шударга туйлын ёсыг хэрхэн хангах бэ? гэж тархиа гашилгах хэрэггүй. Туйлын шударга ёс гэж байдаггүй юм.” хэмээн тодорхой хэлсэн байдаг. (3.6-р бүлэг: Тойрон аялал: Эрхард Эпплер Шударга ёсны тухай юуг өгүүлэв?)

Нийгмийн болон бодлогын бүх салбарт нэгэн зэрэг мөрдөгдөх шударга ёсны нэгдсэн концепцитай байх эрмэлзэл бол зүгээр л бүтэшгүй санаа. Иймэрхүү санаа ардчилсан зарчимд огт нийцэхгүй. Учир нь ард иргэдийн шударга ёсны тухай ойлголт хоорондоо асар зөрүүтэй байдаг.

Шударга ёсны өөр өөр зарчмуудын талаархи хэлэлцүүлэг улс төрийн салбар тус бүрт шударга ёсны дээд хязгаар буюу максимумыг харилцан адилгүй үнэлдэг гэдгийг харууллаа. Гэсэн хэдий ч шийдвэр гаргахдаа чиг баримжаагаа зөв тодорхойлохын тулд улс төрд луужин хэрэгтэй.

Энэ нь нийгмийн ардчилалд юу гэсэн үг бэ?

- Хүн бүрт хүний дайтай, өөрийн хүссэнээр амьдрах , улс төрд оролцох тэгш боломжийг бүрдүүлэхийн тулд нийгмийн нөөцийг тэгш хувиарлах хэрэгтэй.
- Шударга хувиарлалтын асуудлыг тэгш байдал, бүтээмжийн шударга ёс, хэрэгцээний шударга ёс, боломжийн тэгш байдал гэдэг дөрвөн зарчмын дагуу хэлэлцэх хэрэгтэй.
- Эдгээр зарчмууд салбар тус бүрт өөр өөр үнэлэмжтэй байдаг. Тэгш байдал, бүтээмжийн шударга ёс, хэрэгцээний шударга ёс нь харилцан бие биенээ хязгаарлаж байдаг. Харин боломжийн тэгш байдал нь дээрх гурван зарчимд гурвууланд нь агуулагдаж байдаг зарчим юм. Боломжийн тэгш байдал нь бусад зарчмуудыг, нэн ялангуяа бүтээмжийн шударга ёсны зарчмыг хэрэглэх нөхцөлийг бүрдүүлж өгдөг.

3.6. Тойрон аялал: Эрхард Эпплер “Шударга ёсны зарчим”-ын талаар юуг өгүүлэв?

Эрхард Эпплер нь 1926 онд төрсөн. Бундестагийн гишүүн, Холбооны засгийн газрын гишүүн, сайд мөн 1973-1992 онд Германы социалдемократ намын үнэт зүйлсийн комиссын даргаар ажиллаж байсан.

Шударгаёсыг тодорхойлох, баталгаажуулах, хэмжих, нэн ялангуяа албадан хэрэгжүүлэх боломжгүй гэж олон хүн индэр дээрээс ярьдаг нь үнэн ч байж болох юм. Хэн нэгний амийг бүрэлгэх оролдлого

хийснийх нь төлөө хэрэгтэнд шүүгчийн ногдуулсан шийтгэл шударга мөн эсэхийг прокурор, өмгөөлөгч хоёр өөр өөрөөр тайлбарладаг. Тэр ч байтугай үнэхээр бусдын амь насыг нь бүрэлгэхийг оролдсон эсэх асуудлаар өөр өөр үндэслэл гарган маргалддаг. Дараагийн шатны шүүхийн шийдвэр илүү шударга байж чадах уу? Харин жилийн тайлан баланс үнэн зөв эсэхийг бол тооцож гаргаад хяналт хийгээд тогтоох боломжтой. Харин туйлын шударга эсэхийг бол тогтоох боломжгүй. Тайлан баланс үнэн зөв эсэхийг тогтоохын тулд тооцож чаддаг, юу тайланд хамаарах ёстой, юу хамаарах ёсгүйг мэддэг мэргэжлийн хүмүүс байхад болно. Туйлын бөгөөд эргэлзээ бүрийг тайлж чадах үнэнд хүмүүс хүрэх боломжгүй.

“Нийгмийн шударга ёс” хэмээн бидний нэрлээд байгаа тэр зүйлд бол бүр ч туйлын шударга ёс гэж байдаггүй. Нийгмийн шударга ёс юугаар илэрхийлэгдэж байх ёстой бэ? гэдэг талаар бид хэзээ ч нэгдсэн ойлголцолд хүрч чадахгүй учраас нийгмийн туйлын шударга ёсыг тогтоох боломжгүй. Орлогын шударга хувиарлалтыг хувиараа хөдөлмөр эрхлэгч барилгачин, HARTZ-4 хөтөлбөрийн дагуу нийгмийн халамж хүртэгчээс өөрөөр, хадгаламжийн банкны захирал, сайд нарын зөвлөлийн гишүүнээс өөрөөр ойлгодог.

Бүрэн дүүрэн тэгш байдлыг тогтоож байна гээд ажил хийсэн л бол ижил хөлс олгоод байвал энэ нь өөрөө шударга бус хэрэг болох бөгөөд эдийн засагт ч муугаар нөлөөлнө гэдэг дээр нийгэм зөвшилцөлд хүрсэн гэж ойлгож болно. Харин концернуудын удирдах зөвлөлийн гишүүд жирийн мэргэжилтэй ажилчнаас тав дахин, зуу дахин эсхүл хорь дахин их цалин авах ёстой юу? 30 жилийн өмнө бол хорь дахин илүү цалин авахад хангалттай гэж үздэг байсан бол

Гүнзгийрүүлэн унших
эх сурвалжууд:

Эрхард Эпплер
(2009 он) Улс
төрийг цээжний
бангаар Ж.Х.У.Диетц
Хэвлэлийн газар, Бонн
хот

энэ хооронд зуу дахин илүү цалинг ч бага гэж үзэх болж. Үндэслэлээ “хүлээж буй хариуцлага хамаагүй өндөр” гэж тайлбарладаг. Гэтэл холбооны герман улсын канцлер буюу ерөнхий сайд банкны захирлын авч байгаа цалингийн тэг бүхэл.. зууны хэдэн хувийг авдаг. Холбооны канцлерийн хариуцлага банкны захирлынхаас тийм бага гэж үү? Тэгэхлээр ухаантай эдийн засагчдын хэлээд байгаа “Та нар шударга ёсны тухай эцэс төгсгөлгүй маргаанаа дуусгаа, зах зээл хүн бүрт юуг ногдуулнав? Түүнийг л дуугүй ав” гэж хэлээд байгааг гайхах хэрэггүй юм. Хэрэв бэлтгэгдэн гарч буй мэргэжилтэй ажилтнуудын тоо зах зээлд хэрэгтэй байгаа мэргэжилтэй ажилтны тооноос илүү бол тэдний цалин буурч таарна. Хэрэв ухаалаг менежерүүд цөөхөн бол тэдний цалин өсөж таарна. Зах зээлээр шийдэгдэж буй асуудлууд илүү тодорхой, нарийн, тэр талаар удаан маргалдаад байхын ч хэрэггүй. Гэхдээ: Зах зээл зөвхөн ажилч хичээнгүй, ухаалаг хүмүүсийг урамшуулж залхуу, биеийн амрыг харагчдыг шийтгэдэг. Шинжлэх ухааны нотолгоотой, тодорхойлж, хэмжиж болох хүчин чадамжтай зүйлд л итгэдэг хүмүүс хүртэл зах зээлийн зохицуулалтыг хүлээн зөвшөөрдөг. Гэхдээ зах зээл юу гэнэв? түүнийг хүлээн зөвшөөр гэсэн үг биш. Хүмүүст мэдрэмж, итгэл найдвар, хэрэгцээ бий. Эдгээр хэрэгцээнд хоол хүнс, уух ундаанаас гадна анхаарал, хүндлэл, хайр халамж, шударга ёс хамаардаг. Хүмүүс шударга ёсоор цангаж байдаг. Шударга ёсны цангаа нь: Юуг шударга гэж үзэх бэ? гэдэг цэцэн маргаан дээр биш харин юуг шударга бус гэх бэ? гэдэг нарийн мэдрэмж дээр илүү илэрдэг. Юуг шударга бус гэх бэ? гэдэг тал дээр ч хүмүүсийн үзэл өөр өөр, мэдрэмж нь субьектив байх нь ойлгомжтой. Хүмүүс шударга ёсны талаар хатуу тогтсон үзэлтэй байдаг бөгөөд хэн нэгний хэлсний зоргоор үзлээ өөрчилдөггүй. Уг үзэл нь зөрчигдвөл хүмүүс өөрсдөө ч зөрчилд ордог. Үүнийг хүүхдийн цэцэрлэг болон дунд сургуульд ажиглаж болно. Нэг хүүхдэд сайн, нөгөөд нь муу хандсанаасаа болоод шударга бус гэдэг нэрийг зүүсэн багш нэрээ сэргээхийн төлөө хичээх хэрэгтэй болдог. Гэхдээ сэтгэл татсан, даруухан, дээрээс нь хичээл зүтгэл сайтай жаал хүү залхуу, илүүдэл жинтэй, дээрээс нь аливаа зүйлд сонирхолгүй жаал хүүгээс илүү хайр татах нь хүнд байдаг л асуудал боловч багш хүн бүх хүүхдэд ижил хандах ёстой. Хүүхдүүд нас нь нэмэгдэхийн хэрээр энэ хорвоо тэдний санадаг шиг шударга бус юм гэдгийг мэдэрдэг. Эгчид нь цэцэрлэгийн ажилд ээждээ туслахгүй байх түмэн шалтаг байдаг. Ном унших хэрэгтэй, эсхүл дугуй унах хэрэгтэй гэх мэт. Оройтож унтахад хүртэл шалтаг мундахгүй.

Дунд сургуулийн сурагч охин найз охиных нь аав ганган мерседес унаж байхад өөрийнх нь аав дээр үеийн гольф машин унах ёстой гэдэгтэй эвлэрэх л хэрэгтэй болдог. Найз охин нь морь унаж сурч байхад өөрөө морины улаан фен мөртлөө морь унаж сурах боломжгүй байх. Энэ нь сургуулийн сурагч охины хувьд шударга бус ч гэлээ найз охинтойгоо найрсаг харьцахад нь саад болохгүй. Хэрвээ найз охиных нь ээж нийгмийн давхарга гэдэг хаалгыг түүний өмнүүр хааж доод давхаргынхан доод давхаргадаа байх ёстой гэдэг шаардлагыг тавьж “чи найз охиноо гэрт бүү оруул” гэсэн бол тэр гомдож уурлах байсан. Хүүхдүүд жаахан байхаасаа тодорхой хэмжээний шударга бус байдалтай эвлэрч сурдаг. Гэхдээ тодорхой хязгаар хүртэл шүү.

Нийгэм бүхэлдээ дээрхийн адил бүтэцтэй байдаг. Хүүхдүүд нийгэмд олон мянган, жижиг болон дунд зэргийн шударга бус байдлын дунд амьдарч сурдаг. Хүн бүрийн хүсэл тэр бүр биелдэггүй. Мэдээж саятан эцэг эхэд хогийн тэрэгний ачигчтай харьцуулахад дээд сургуулийн элсэлтийн шалгалтанд охиноо бэлтгэх түмэн боломж бий. Багш нь саятан эцгийг уурлуулахгүйн тулд охиныг нь шалгалтанд унагалгүй тэнцүүлчихсэн гэдгийг мэдэх юм бол харин охин эсэргүүцэх болно. Энэ бол хүлээн зөвшөөрч боломгүй шударга бус явдал. Иймээс улс төрийн хүрээнд нийгмийн туйлын шударга ёсны төлөө толгойгоо гашилгах хэрэггүй юм. Нийгмийн туйлын шударга ёс гэж байдаггүй. Улс төрийн хувьд хүлээн зөвшөөрч болох, хүлээн зөвшөөрч үл болох шударга бус байдлын хоорондох ялгаа заагийг мэдрэх нь чухал. Ийм учраас менежер нь мэргэжилтэй ажилчнаас хорь дахин илүү цалин авахыг хэн ч эсэргүүцээгүй. Харин 200 дахин их цалин авахыг хүмүүсийн дийлэнх нь байж болшгүй гэж үздэг. Тухайн менежер ногдол ашгаа өсгөхийн тулд ажилтнуудаа халж байгаа бол бүр ч хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үздэг. Нарийн бичгийн дарга дарга нь өөрөөс нь 4 дахин илүү цалин авдаг бол байж болох зүйл гэж үздэг. Харин дөрөв дахин их цалинтай мөртлөө татвараас зайлсхийх бүх боломжийг сайн мэддэгийгээ ашиглаад өөрөөс нь бага татвар төлдөг гэдгийг мэдэх юм бол бухимдаж таарна.

Хэрвээ германчуудын дөрөвний гурав нь энэ улс оронд шударга бус байдал тогтлоо гэж үзэж байвал, мөн энэ шударга бус байдал хэзээ нэгэн цагт өөрчлөгдөнө гэдэгт эргэлзэж байвал хүлээн зөвшөөрч болох шударга бус байдал, хүлээн зөвшөөрч үл болох шударга бус

байдал хоорондын хил зөрчигджээ гэсэн үг. Олон нийтийг санаа бодлыг судлаачид 2008 онд буюу зах зээлийн радикал эрин үеийн төгсгөлд уг хязгаарыг давлаа хэмээн тогтоосон нь гайхаад байх зүйл биш. Хэрэв зөвхөн ядуус, нийгмийн хувьд сул дорой хүмүүс шударга бус байна гэж шүүмжлээд зогсохгүй, бараг бүгдээрээ буюу өөрийгөө баян гэж үздэггүй бүх хүмүүс шударга бус байдал хэрээс хэтэрлээ хэмээн гомдоллож байгаа бол аюул ойртож буйн дохио юм. Ямар ч нийгэм ийм байдлаар удаан оршин тогтнож чадахгүй. Хүн нэг бүрийн сэтгэлд хүрсэн шударга ёсыг тогтоох нь хэзээ ч бүрэн шийдэгдэх боломжгүй мөнхийн сэдэв боловч нийгмийн шударга ёсыг тогтоох нь зөвхөн нийгмийн романтикуудын дуртай сэдэв биш, харин нийгмийн шударга ёсыг хангах нь улс төрийн үндсэн үүрэг юм.(Эпплер 2009 он: 47-50-р тал)

4. НИЙГМИЙН БАРИМЖААТ ТӨРИЙН БАРИЛГЫН МАТЕРИАЛ, ХИЙЦ, АРХИТЕКТУР

Энэхүү бүлэгт:

- Нийгмийн баримжаат төрийн барилгын материалууд (мөнгө, нийгмийн үйлчилгээ болон материаллаг туслалцаа) ба тэдгээрийн ач холбогдлыг нийгмийн баримжаат төрийн төрөл бүрийн салбарт тодорхойлох
- Нийгмийн баримжаат төрийн үндсэн хэв шинжүүд болох либерал, консерватив, социалдемократ хэв шинжит нийгмийн баримжаат төрийн архитектурын бүтцийг танилцуулна.
- Нийгмийн баримжаат төрийн архитектурын бүтэц тухайн улсын оршин суугчдад ямар үр дагавар авчирдагийг харуулна.

Германы нийгмийн баримжаат төрийн үндсэн бүрэлдэхүүн хэсгүүд болох тэтгэврийн болон ажилгүйдлийн даатгал 100 гаруй жилийн настай. Зарим зохицуулалтууд үүсэн байгуулагдсан цагаас хойш огт өөрчлөгдөөгүй эсхүл ялимгүй өөрчлөгдсөн байдаг. Энэ нь зарим зохицуулалт, онцлог шинжийг хувиршгүй хэмээн үзэж болно гэсэн үг юм.

Германы нийгмийн баримжаат төр: Хувиршгүй.

Хөрш орнуудынхаа нийгмийн баримжаат төрийн барилгын материал, хийц, архитектурын бүтцийг судалснаар нийгмийн баталгаат байдлыг хангах өөр боломж, хувилбарууд байдаг гэдгийг хялбархан олж мэдэх боломжтой. Харин хэрэглэж буй арга хэрэгслүүдийн хувьд: мөнгө, нийгмийн үйлчилгээ, материаллаг туслалцаа бүгд адилхан. Нийгмийн баримжаат төрийн байгууламжийг барилгатай зүйрлэсэн зүйрлэлээ цааш нь үргэлжлүүлэн тайлбарлахад: Барилгын зураг, төсөв, төлөвлөгөөнөөс хамааран барилгын материалын орц нормыг өөр өөр харьцаагаар хольж зуурмагаа бэлтгэж болно.

Олон улсын харьцуулалт тустай.

Өөр өөр материал ашиглаж өөр өөр зураг төлөвлөгөөний дагуу барьдаг учраас байшин бүр өөр хэлбэртэй байдаг. Харин байшингийн хэлбэр, хийцээс хамааран дотор нь амьдарч буй оршин суугчдад өөр өөр нөлөө үзүүлдэг. Дараагийн хуудсуудад барилгын төрөл бүрийн архитектурыг тодорхойлохын тулд эхлээд барилгын материалуудыг танилцуулна. Дараа нь барилгын өөр өөр хэлбэрээс гарах үр дагавруудын талаар 4.3.-р бүлэгт хэлэлцэнэ.

Уг бүлэгт барилгын материал, хийц, архитектурын бүтцээс хамааран ямар ямар үр дагавар гардаг бэ? гэдгийг харуулна.

4.1. Нийгмийн баримжаат төрийн “барилгын материал ба багаж хэрэгсэл”

Анхдагч хэрэгсэл:
Мөнгө

Нийгмийн бодлогод олон төрлийн материал, багаж хэрэгслүүдийг ашигладаг. Төрийн нийгмийн бодлогын гарын доорхи хэрэгсэл бол мөнгө. Ажилгүйдлийн тэтгэмж, тэтгэвэр, хүүхдийн мөнгө зэргийг олгодог бөгөөд ажилгүйдлийн мөнгийг ажилгүй болсон хүний, тэтгэврийн мөнгийг тэтгэвэр авагчийн, хүүхдийн мөнгийг эцэг эхийнх нь дансанд шилжүүлдэг.

Хоёрдогч хэрэгсэл:
Төрийн үйлчилгээ

Дээрх мөнгө буюу мөнгөн шилжүүлгээс гадна нийгмийн баримжаат төр бусад хэрэгслүүдийг ашигладаг. Жишээлбэл: Эрүүл мэндийн бодлогод эрүүл мэндийн үйлчилгээг даатгуулагчиддаа үзүүлдэг. Эмч, асрагч нар оношлогоо, эмчилгээ хийдэг. Түүнчлэн боловсролын болон гэр бүлийн бодлогод үйлчилгээ үзүүлдэг. Сургуульд багш нар хүүхдүүдэд боловсрол олгож хүмүүжүүлэгч нар бага насны хүүхдүүдийг өдөр өнжүүлэх болон цэцэрлэгт асран хүмүүжүүлдэг.

Гуравдагч хэрэгсэл: Мөнгөн бус үйлчилгээ буюу материаллаг тусалцаа

Мөнгөн тэтгэмж, төрийн үйлчилгээнээс гадна мөнгөн бус үйлчилгээ буюу материаллаг тусалцаа нь нийгмийн баримжаат төрийн гуравдагч үндсэн “барилгын материал” юм. Мөнгөн бус үйлчилгээний жишээ бол эрүүл мэндийн бодлогын хүрээнд үнэгүй тараагддаг эм юм.

Багаж хэрэгслийн хайрцагт байж байдаг бусад хэрэгслүүд: Татвар ба шимтгэл

Татвар болон шимтгэл нь нийгмийн баримжаат төрийн багаж хэрэгслийн хайрцагт байж байдаг хэрэгслүүд юм. Эдгээр нь санхүүжүүлэх үүрэгтэйгээс гадна дахин хувиарлалт болон удирдлагын чухал үүрэг бүхий хэрэгслүүд юм. Тэгэхлээр нийгмийн баримжаат төрийн төрөл бүрийн салбарт ямар ямар барилгын материалыг ашигладаг бэ?

Ажилгүйдлийн даатгалд ашиглагддаг “барилгын материалууд”

Сонгодог мөнгөн тэтгэмж

Ажилгүйдлийн даатгал нь цалинг орлох мөнгөн тэтгэмжийн сонгодог жишээ юм. Ажилгүйдлийн тэтгэмж орлогыг орлох үүрэгтэй тул бүх оронд мөнгөн хэлбэрээр олгогддог.

Дээрээс нь нэмээд: Хөдөлмөр хэмээх бүлгийн 7.2.-р хэсэгт төрийн үйлчилгээний талаар дэлгэрэнгүй тайлбарласан.

Даатгуулагчийн дахин ажилд орох, ажилтай болох боломжийг нэмэгдүүлэхийн тулд цалинг орлох мөнгөн тэтгэмжийг олгохын зэрэгцээ төрийн бусад үйлчилгээг үзүүлэх нь илүү ач холбогдолтой

юу? гэдэг асуулт гарч ирнэ. Ажилгүйчүүдийг мэргэшүүлэх болон мэргэжил дээшлүүлэх сургалтанд хамруулах нь олон оронд хөдөлмөрийн биржүүдийн үйлчилгээний бүрэлдэхүүн хэсэг болон хэвшсэн байна. Мэргэшүүлэх болон мэргэжил дээшлүүлэх сургалтын чанар, эдгээрт ажилгүйдлийн даатгалын сангаас зарцуулж буй мөнгөний хэмжээ улс орон бүрт харилцан адилгүй байдаг. Ажилгүйдлийн даатгалын үйлчилгээг зөвхөн мөнгөн тэтгэмжээр хязгаарлахгүй байх, харин мэргэшүүлэх болон мэргэжил дээшлүүлэх сургалтыг биржийн үйлчилгээнд хамруулах олон шалтгаан бий. Хөдөлмөр сэдэвт 7.2-р бүлгээс дэлгэрүүлэн уншина уу.

Тэтгэврийн даатгалын “барилгын материалууд”

Тэтгэврийн даатгал нь үндсэн үйлчилгээгээ ихэвчлэн мөнгөн хэлбэрээр олгодог нийгмийн баримжаат төрийн нэгэн салбар юм. Нас ахихын хэрээр эрүүл мэнд болон асрамжийн даатгалын үйлчилгээнээс хараат болох магадлал өндөр ч эдгээр үйлчилгээ нь тэтгэврийн даатгалын үйлчилгээний бүрэлдэхүүн хэсэг биш юм.

Сонгодог мөнгөн тэтгэмж

Ямар замаар санхүүжилтийг ямар замаар бүрдүүлэх бэ? гэдэг нь тэтгэврийн даатгалын үндсэн асуудал юм. Хувь хүмүүсийн төлж буй шимтгэл татвартай харьцуулахад ямар үүрэгтэй бэ? өндөр насны хувийн даатгал ямар ач холбогдолтой байх ёстой юм бэ? Эдгээр асуултын хариулт тухайн оронд тэтгэвэр авагчдын тэтгэврийн зөрүү болон өндөр насны ядуурлын хамрах хүрээ ямар байх бэ? гэдэгт онцгой ач холбогдолтой. Бусад мэдлэг мэдээллийг 7.3-р бүлгээс авна уу.

*Үндсэн асуудал:
Хэрхэн яаж санхүүжүүлэх бэ?
Тэтгэврийн талаар 7.3-р бүлгээс дэлгэрэнгүй уншаарай.*

Эрүүл мэндийн бодлогын “барилгын материал”

Эрүүл мэндийн системд хэрэглэгдэж буй “багаж хэрэгслүүд”-ийг тэтгэврийн даатгалын толинд туссан урвуу тусгал гэж хэлж болно. Тэтгэврийн даатгалд мөнгө үндсэн үүргийг гүйцэтгэдэг бол эрүүл мэндийн бодлогод эрүүл мэндийн үйлчилгээ болон мөнгөн бус үйлчилгээ үндсэн үүрэгтэй. Эрүүл мэндийг худалдаж авдаг байж таарахгүй.

Мөнгөн бус болон эрүүл мэндийн үйлчилгээ: Эрүүл мэндийг худалдаж авдаг байж таарахгүй

Ийм ч учраас эрүүл мэндийн үйлчилгээг хэрхэн санхүүжүүлэх бэ? Хэн төлөх бэ? гэдэг асуудал зайлшгүй гарч ирдэг. Нийтийн эрүүл мэндийн даатгалын системүүд үр ашиг муутай гэдэг шүүмжлэлд байнга өртдөг.

*Үндсэн асуудал:
Хэрхэн санхүүжүүлэх бэ? Хэн төлөх бэ? (Эрүүл мэнд хэмээх 7.4-р бүлгээс дэлгэрүүлэн уншина уу.)*

Эрүүл мэндийн даатгалын системийг хувийн ба төрийн эрүүл мэндийг хамгаалах систем хэмээн хоёр хуваах нь хоёр ангит эрүүл мэндийн системийг бий болгох аюултай. Дэлгэрэнгүйг 7.4-р бүлгээс уншина уу.

Боловсролын тогтолцооны “барилгын материалууд”

Боловсролын салбар нь мөн мөнгөн тэтгэмж төдийлөн чухал үүрэг гүйцэтгэдэггүй, харин үйлчилгээ чухал үүрэгтэй салбар юм.

Энд юуны өмнө боловсролын үйлчилгээг хэрхэн зохион байгуулах бэ? гэдэг асуулт гарч ирдэг. Төрийн буюу нийтийн бага насны хүүхдийг асран хүмүүжүүлэх байгууллага байна уу? Дунд сургуулийн ямар хэлбэрүүд байна? Дунд сургууль болон мэргэжлийн боловсролын сургуулиуд хооронд дэвшин суралцах боломж нь хэр байна? Дэлгэрэнгүйг боловсрол сэдэвт 7.5-р бүлгээс уншина уу?

Татварын бодлогын “барилгын материалууд” (хэрэгслүүд гэсэн үг-Орч)

Төрийн орлого нь татвар, хураамжаас бүрддэг. Энэ орлогоос нийгмийн хамгааллын системийг санхүүжүүлдэг. Сайн бэхэжсэн, чанартай үйлчилгээ, өндөр тэтгэвэр тэтгэмж олгох чадамжтай нийгмийн баримжаат төртэй байхын тулд төсвийн орлого өндөр байх ёстой. Өөрөөр хэлбэл татвар, хураамжийн хувь хэмжээг өндрөөр тогтоох ёстой. Татварыг доогуур тогтоох юм бол тэр хэмжээгээр нийгмийн баримжаат төрийн тэтгэмж, үйлчилгээний хүрээ хязгаарлагдмал байдаг. Орлогын хэмжээнээс гадна татварыг хураах арга хэлбэр нь нийгмийн баримжаат төрийн хэв шинжид чухал үүрэгтэй байдаг. Татварын төрөл бүрийн систем нь хувиарлалтад харилцан адилгүй нөлөөг үзүүлдэг. Дэлгэрэнгүйг Татвар сэдэвт 7.1-р бүлгээс уншина уу.

Нийгмийн бодлогыг тодорхойлох өргөн боломж байдаг. Ихэнхдээ дээр дурьдсан бүх багаж хэрэгсэл ба барилгын материалыг ашигладаг. Улс орон бүр өөр өөр архитектурын зургаар барилгаа барьдаг учраас зарим барилгын материалыг олонтаа, заримыг нь бараг ашиглалгүйгээр барилгаа барьдаг. Номын 7-р бүлэгт нийгмийн бодлогын салбар бүрийг нарийвчлан судалж улс орнуудын нийгмийн бодлогыг хооронд нь харьцуулах тул энэ бүлэгт зарчмын болон ерөнхий ялгаануудыг тодорхойлох болно. Архитектурын ямар төрлүүд байдаг бэ?

Үйлчилгээг
хангах нь

Үндсэн асуудал:
Хэрхэн зохион
байгуулах бэ?
дэлгэрэнгүйг 7.5-р
бүлгээс уншина уу.

Нийгмийн
баримжаат төрийн
санхүүжилт ба
хувиарлалтанд
үзүүлэх нөлөө-
Дэлгэрэнгүйг
Татвар сэдэвт 7.1-р
бүлгээс уншина уу.

Архитектурын
ямар зургаар
байшингаа
барих бэ?
Барилгын ямар
материалуудыг
ашиглах бэ?

4.2. Нийгмийн баримжаат төрийн архитектур

Нийгмийн баримжаат төрийн төрөл бүрийн хэв шинжүүдийн талаар олон судалгаа хийгдсэнээс хамгийн алдартай, олноо хүрсэн нь Гесте Эспринг Андерсений “Нийтийн сайн сайхны төлөөх капитализмын гурван өөр ертөнц” хэмээх бүтээл юм. Тэрбээр уг номоо 1990 онд нийтлүүлсэн бөгөөд бүтээлдээ барууны аж үйлдвэржсэн орнуудыг капитализмын гурван өөр ертөнцөд хуваасан юм.

Тэрээр гурван ертөнц буюу архитектурын бүтцийг нийгмийн баримжаат төрийн тухайн хэв шинжид гол үүрэг гүйцэтгэсэн архитекторын нэрээр нэрлэсэн байдаг. Архитекторын нэр нь нийгмийн баримжаат төрийн тодорхой хэв шинж бүрдэхэд голлох үүргийг гүйцэтгэсэн улс төрийн намууд болон хөдөлгөөний нэрс юм.

Гесте Эспринг Андерсен нь 1947 онд Дани улсад мэндэлжээ. Тэрбээр Копенгаген хотноо дээд боловсрол олж докторын зэргээ АНУ-ын Висконсины их сургуульд хамгаалжээ. Дараа нь Харвард, Берлин хотын шинжлэх ухааны төв, Флоренцын Их Сургууль, Триентийн их сургуульд тус тус багшилж судалгааны ажлаа хийж байгаад 2000 оноос Барселоны их сургуульд ажиллаж байна. Түүний зохиол бүтээлүүдээс 1990 онд хэвлэгдсэн “Нийтийн сайн сайхны төлөөх капитализмын гурван өөр ертөнц бүтээл”, 1998 онд хэвлэгдсэн “Аж үйлдвэржилтийн эрин үеийн дараахи эдийн засаг”, 2000 онд хэвлэгдсэн “Бидэнд яагаад нийтийн сайн сайхны төлөөх шинэ төр хэрэгтэй бэ?” бүтээлүүд нь хамгийн их алдаршсан юм.

Тэрбээр капитализмын либерал, консерватив, социалдемократ гурван өөр ертөнцийг тодорхойлсон байдаг. Мөн дээрх гурван үндсэн зарчмын дагуу баригдсан барилгуудыг газарзүйн тодорхой байршилд хуваах боломжтой тул газарзүйн байршлынх нь дагуу нэрлэж заншсан байдаг. Либерал ертөнцийг англосаксоний, консерватив ертөнцийг эх газрын, социалдемократ ертөнцийг скандинавын ертөнц хэмээн тус тус нэрлэж заншжээ. Тэгэхлээр эдгээр гурван өөр ертөнц буюу гурван өөр архитекторын бүтцийг хооронд нь хэрхэн харьцуулах бэ?

Харьцуулалт хийхийн тулд харьцуулалтын масштаб хэрэгтэй. Эспринг Андерсен декомодификаци-ийн зэрэг стратификаци-ийн хэмжээ гэдэг хоёр шалгуур үзүүлэлтийг ашигласан.

Гесте Эспринг Андерсен:
“Нийтийн сайн сайхны төлөөх капитализмын гурван өөр ертөнц” ном

“Барилгын архитектор” –ын нэрээр нэрлэсэн.

Нийгмийн баримжаат төрийн гурван үндсэн хэв шинж: либерал, консерватив, социалдемократ

Харьцуулалтыг ямар масштабын дагуу хийх бэ?

Dekommodifizierung гэдэг үг нь англи хэлнээс гаралтай, үгийн язгуур нь “commodity” буюу “бараа” гэдэг ойлголтыг агуулдаг. Энд хөдөлмөрийг бараа хэмээн ойлгож буй. Тэгэхлээр хүмүүсийн амьжиргааны хөдөлмөрийн зах зээлээс заавал хараат байх албагүй баталгаажиж байх хэмжээг декомодификаци гэнэ.

Хэрэв хөдөлмөрийн зах зээл нь амьжиргааны эх үүсвэрээ бүрдүүлэх цорын ганц боломж байх нөхцөлд ажил хийгээд авч байгаа цалин хөлс нь хичнээн бага байсан ч ямар нэгэн ажил эрхлэх хэрэгтэй болдог. Энэ тохиолдолд декомодифици нь тун доогуур түвшинд байна гэсэн үг. Хэрэв эсрэгээрээ төр иргэдийнхээ өргөн хүрээтэй нийгмийн хамгаалалд байх эрхийг хуулиар баталгаажуулж өгсөн нөхцөлд ажил эрхлээгүй байсан ч эсхүл ажил олдохгүй байсан ч (эдийн засгийн байдал дордсон) хүний дайтай амьдрах боломжтой бол (жишээлбэл: өвчилсөн эсхүл өндөр настай болсон) декомодификаци-ийн өндөр байна гэсэн үг.

Стратификаци: “Strafikation” хэмээх үг нь латин хэлний “stratum” гэдэг ойлголтоос эхтэй, энэ нь “дээвэр” гэсэн утгатай үг юм. “Stratum” буюу дээвэр гэдэг үг нь нийгмийн давхаргыг тодорхойлдог. Уг ойлголтыг нийгмийн шинжлэх ухаанд аливаа нийгмийн төрөл бүрийн бүлгүүдийг тодорхойлох, судлахад ашигладаг. Судалгаанд юуг нь илүү түлхүү судлах гэж байгаагаас хамааран нийгмийн давхарга (доод, дунд, дээд давхарга), анги (ажилчин анги, хөрөнгөтнүүд) эсхүл орчин (либерал- простант орчин, социалдемократ орчин, католик орчин) гэх мэт торхойлолтуудыг хэрэглэдэг байна.

Эспринг Андерсений хувьд нийгмийн төрөл бүрийн давхаргыг тодорхойлохоос илүүтэйгээр нийгмийн баримжаат төр нь нийгмийн давхаргуудтайгаа хэрхэн харьцаж байна? Нийгмийн баримжаат төрийн барилгын хийц нь өөрөө нийгэмд онцгой давхраажилт үүсэхэд нөлөөлж байна уу? гэдгийг судалсан юм. Тэгэхлээр эдгээр гурван ертөнцийг декомодификаци ба стратификаци-тай уялдуулан авч үзвэл ямар онцлог шинжүүд байна?

Либерал хэв шинжит нийгмийн баримжаат төр

Либерал хэв шинжит нийгмийн баримжаат төртэй орнуудад зах зээл онцгой чухал байр суурь эзэлдэг. Нийгмийн эрхүүд ба нийгмийн

үйлчилгээ нь харьцангуй сул хөгжсөн байдаг. Үүнээс гадна нийгмийн үйлчилгээ нь аргагүй ядуу зүдүү хүмүүст чиглэдэг бөгөөд байсхийгээд үзлэг шалгалт явуулж үнэхээр эмзэг байдалд байгаа эсэхийг магадлах шалгалт явуулдаг учраас нийгмийн халамж хүртэгсэд нь содон тэмдэгтэй хүмүүс шиг олны харцнаас дөлж явахад хүрч нийгмийн дунд нэр хүнд нь мууддаг.

Төр нь зөвхөн аргагүй байдалд орсон хүмүүсийн нийгмийн баталгаат байдлыг хангах хамгийн эцсийн сүлжээ бөгөөд зарчмын хувьд иргэд нь хөдөлмөрийн зах зээл дээрээс орлого олж чадахгүйд хүрвэл туйлын хүнд байдалд ордог. Декомодификаци-ийн зэрэг нь доогуур. Нийгмийн үйлчилгээг татвараас санхүүжүүлдэг. Либерал хэв шинжит нийгмийн баримжаат төртэй орнуудад хувь хүмүүсийн эрхэд суурилсан шаардлагыг хангахын тулд шимтгэл хураах, шимтгэлээр санхүүжүүлдэг тогтолцоо ховор ажиглагддаг. Шимтгэлийн хувь хэмжээнээс буюу орлогоос хамаардаг үйлчилгээ байхгүй тул тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээ харьцангуй нэгэн жигд. (Ижил хэмжээтэй.)

Нийгмийн баримжаат төрийн хувьд иргэд өмнө нь ямар мэргэжилтэй, хэр хэмжээний орлоготой байсан нь хамаагүй. Нийгмийн даатгалын сангаас олгож буй мөнгөн тэтгэмж, төрийн үйлчилгээ нь зөвхөн баталгаажих доод түвшнийг хангах, юуны өмнө ядуурлаас хамгаалахад чиглэгддэг учраас төлбөрийн чадвартай иргэд нь хувийн даатгалд ханддаг. (Жишээлбэл: тэтгэврийн хувийн даатгал, хувийн сургууль гэх мэт). Либерал хэв шинжит нийгмийн баримжаат төр нь тойруу замаар нийгмийн давхраажилт-страфикаци буюу баян ядуугийн давхаргат нийгмийг бүрдүүлэхэд түлхэц болж байдаг. Либерал хэв шинжит нийгмийн баримжаат төртэй орнуудын төлөөллөөр юуны өмнө АНУ, Их Британи, Австрали зэрэг орнуудыг нэрлэж болно.

Либерал хэв шинжит нийгмийн баримжаат төрийн онцлог үндсэн шинжүүд:

- Нийгмийн даатгалын сангаас олгодог мөнгөн тэтгэмжийн хэмжээ нь нийгмийн баримжаат төрийн бусад хэв шинжүүдтэй харьцуулахад харьцангуй доогуур.
- Татвараас санхүүждэг.
- Декомодификаци буюу хөдөлмөрийн зах зээлээс хараат байдал өндөр

Төр нь: Зөвхөн аргагүй байдалд орсон хүмүүсийн баталгаат байдлыг хангах эцсийн сүлжээ

Төрийн нийгмийн хамгаалалд орлого болон мэргэжлийн ялгааг харгалздаггүй тул –Хувийн даатгалын олон хэлбэр байдаг.

- Хувийн даатгал ба хувийн үйлчилгээ нь нийгмийн давхарга хоорондын ялгааг эрс нэмэгдүүлдэг.

Консерватив хэв шинжит нийгмийн баримжаат төр

Нийгмийн статусын дагуу нийгмийн баримжаат төрийг байгуулдаг.

Эспринг-Андерсен консерватив хэв шинжит нийгмийн баримжаат төрийг зарим хэсэгт корпорати 7 буюу нийгмийн бүлгүүдийг улс төрийн шийдвэр гаргалтанд оролцуулдаг нийгмийн баримжаат төр хэмээн нэрлэсэн байдаг. Корпоратизм нь нийгмийн гишүүд нь мэргэжлийнхээ дагуу тодорхой эрх, статус бүхий бүлгүүдэд хуваагддаг уламжлал дээр суурилдаг тул консерватив хэв шинжит нийгмийн баримжаат төр нь төрөл бүрийн мэргэжил, орлогын бүлгүүдэд ялгавартай ханддаг.

Жишээ: Германы төрийн албан хаагчдын онцгой эрх

Германы төрийн албан хаагчид зарим нэгэн онцгой эрх ямбыг эдлэх эрхтэй тул онцгой эрх, статус бүхий мэргэжлийн бүлгийн хамгийн сайн жишээ юм. Өнөөг хүртэл мэргэжлийн зарим бүлгүүдэд энэхүү зарчим хадгалагдсан хэвээр байгааг харж болно. Жишээлбэл: Татварын зөвлөх, прокурор, нотариат, малын эмч, эмийн санч, эдийн засгийн хянагчид онцгой эрх, статус бүхий мэргэжлийн хангамжийн сүлжээтэй бөгөөд эдгээр сүлжээ нь жишээлбэл: зөвхөн дээрх мэргэжлийн бүлгүүдийн тэтгэврийн даатгалын тогтолцоо байдаг. Тухайн мэргэжлийн танхимын гишүүн хүн бүр автоматаар тухайн мэргэжлийн хангамжийн сүлжээний гишүүн болдог.

Иймээс бие даагчид буюу хувиараа хөдөлмөр эрхлэгчид болон дээр дурьдсан мэргэжлийн бүлгүүдэд албан хаагчийн хөдөлмөрийн харилцаанд хөдөлмөр эрхэлж буй хүмүүс хууль ёсны заавал даатгуулах тэтгэврийн даатгалд хамрагддаггүй. Консерватив хэв шинжит нийгмийн баримжаат төртэй Итали, Франц зэрэг орнуудад мэргэжлийн онцлогоор ялгаатай нийгмийн хамгааллын систем байдаг. Жишээлбэл: ажилгүйдлийн даатгалд

Шимтгэлээс санхүүждэг.

Нийгмийн баримжаат төрийн зардлын дийлэнх хувийг шимтгэлээр санхүүжүүлдэг учраас мэргэжлийн бүлгүүдийг хооронд нь ялгадаггүй хууль ёсны даатгалд ч консерватив зарчим тодорхой

7. Корпоратизм гэдэг үг нь латин хэлний "corporatio" гэдэг үгнээс гаралтай, хуулийн этгээд гэдэг утгатай үг. Эспринг-Андерсен үүгээр нийгмийн төрөл бүрийн бүлгүүд хоорондын хэлэлцээр үндсэн үүрэг гүйцэтгэдэг нийгмийн загварыг тодорхойлдог.

харагддаг. Эквивалент буюу ижил тэгш байх зарчмаас үүдэлтэйгээр (Даатгалаас олгох мөнгөн тэтгэмжийн хэмжээ хувь хүмүүсийн төлсөн шимтгэлийн хэмжээнээс хамаардаг тул) нийгмийн даатгалаас авч буй мөнгөн тэтгэмжийн хэмжээ даатгуулагчийн өмнө нь авч байсан орлогын хэмжээнээс хамаардаг.(Ажилгүйдлийн даатгал, тэтгэвэр)

Нийгмийн даатгалаас олгож буй мөнгөн тэтгэмжийн хэмжээ нь өмнөх статусыг нь хадгалахад “консервлоход” чиглэдэг. Консерватив хэв шинжит нийгмийн баримжаат төрийн нийгмийн даатгалаас олгож буй мөнгөн тэтгэмжийн дундаж хэмжээ нь либерал хэв шинжит нийгмийн баримжаат төртэй орнуудынхаас өндөр байдаг. Мөн бүх иргэддээ нэгдсэн буюу ижил хэмжээний мөнгөн тэтгэмж олгодоггүй.

Шимтгэлээр санхүүждэг зарчим нь консерватив хэв шинжит нийгмийн баримжаат төртэй бараг бүх оронд шимтгэл төлөх орлогын дээд хязгаар (орон бүрт харилцан адилгүй) буюу шимтгэл төлөх ёстой орлогын хязгаарыг тогтоож өгдөг. Уг хэмжээ нь тэгш бус хандах бас нэгэн эх сурвалж болдог. Учир нь олон тохиолдолд хууль ёсны даатгал ба хувийн даатгалын байгууллагуудын шимтгэл төлөх орлогын дээд хязгаар зөрүүтэй байдаг. (Германд уг зөрүү эрүүл мэндийн даатгалд хамгийн тод харагддаг. Татвар хэмээх 7.1-р бүлгээс дэлгэрэнгүйг уншина уу.)

Консерватив хэв шинжит нийгмийн баримжаат төрд сүүлийн арван жилд бараг зэрэг суларсан ч ул мөр нь тодорхой ажиглагдсаар байгаа өөр нэгэн онцлог шинж байдаг. Нийгмийн баримжаат төрийн бусад хоёр хэв шинжтэй нэгэн адил консерватив хэв шинжит нийгмийн баримжаат төрийн загвар нь эрэгтэй, ганц бие орлого ологчид чиглэсэн байдаг.

Татварын хувьд эхнэр, нөхөр хоёр хоёулаа хөдөлмөр эрхэлж буй тохиолдолд ямар нэгэн хөнгөлөлт болон давуу тал байхгүй. Гэрлэсэн эхнэр, нөхөр хоёр хоёулаа хөдөлмөр эрхэлж буй тохиолдолд эхнэр, нөхрийн орлогын нийлбэрийг тооцоод орлогын тавин хувьд нь тодорхой хэмжээний нэмэгдэл татвар ногдуулдаг систем германд үйлчилдэг. Дээрээс нь бүтэн өдрийн буюу өдөр өнжүүлэхтэй хүүхэд асран хүмүүжүүлэх цэцэрлэг, сургууль, хагас өдрөөр хөдөлмөр эрхлэх ажлын байр харьцангуй дутмаг, гэр бүлийн хөдөлмөрийн хувиарт ажил эрхэлдэг ээжийн тухай ойлголт хэвшээгүй зэрэг шалтгаануудын

Мөнгөн тэтгэмжийн хэмжээ өмнөх статусыг нь хадгалааг (консервлодог).

Шимтгэл төлөх орлогын дээд хязгаарыг тогтоох аргачлалаас хамааран тэгш бус байдал үүсдэг.

Эрэгтэй, ганц бие орлого ологчид чиглэсэн даатгал

Үр дагавар: Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхэлт доогуур

улмаас консерватив хэв шинжит нийгмийн баримжаат төртэй орнуудад эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийн квот либерал болон социалдемократ хэв шинжит нийгмийн баримжаат төртэй орнуудынхаас доогуур байдаг.

*Олон давхаргат
бүтэцтэй-(
стратификаци)*

Консерватив хэв шинжит нийгмийн баримжаат төртэй орнуудад стратификаци буюу давхраажилт маш эрчимтэйгээр мэргэжлийн бүлэг, орлого, хүйс. тусгаарлалтын олон шугамын дагуу явагддаг. Консерватив хэв шинжит нийгмийн баримжаат төртэй орнуудын онцлог шинжүүдийг хамгийн ихээр агуулсан орнуудын төлөөллөөр Герман, Франц, Австри, Бельги зэрэг орнуудыг нэрлэж болно.

Консерватив хэв шинжит нийгмийн баримжаат төрийн онцлог үндсэн шинжүүд:

- Мөнгөн тэтгэмж, тэтгэврийн хэмжээ нь өмнөх орлогоос хүчтэй хамааралтай.
- Төрийн үйлчилгээ төдийлөн хөгжөөгүй.
- Санхүүжилтийн дийлэнх хэсэг нь шимтгэлээс бүрддэг.
- Мэргэжлийн бүлэг, орлого, хүйсээс үүдэлтэй стратификаци нь хүчтэй.

Социалдемократ хэв шинжит нийгмийн баримжаат төр

Социалдемократ хэв шинжит нийгмийн баримжаат төрийн архитектурын бүтэц нь либерал хэв шинжит нийгмийн баримжаат төрийн архитектуртай санхүүжилтийн хувьд адилхан. Либерал хэв шинжит нийгмийн баримжаат төртэй нэгэн адил санхүүжилтийн дийлэнх хэсэг нь шимтгэлээс биш харин ердийн татвараас бүрддэг. Гэхдээ бүтээмжийн тал дээр гурван ялгаа байгааг тодорхойлж болно.

Нэгдүгээрт социалдемократ хэв шинжит нийгмийн баримжаат төртэй орнуудад либерал хэв шинжит нийгмийн баримжаат төртэй орнуудтай харьцуулахад нийгмийн даатгалын сангаас олгодог мөнгөн тэтгэмж, тэтгэвэр болон үйлчилгээний хэмжээ ерөнхийдөө өндөр байдаг.

Хоёрдугаарт: мөнгөн тэтгэмж, тэтгэвэр төрийн үйлчилгээний хэмжээ нь консерватив хэв шинжит нийгмийн баримжаат төртэй

*Нэгэн адил
татвараас
санхүүждэг.*

*Илүү өндөр
бүтээмжтэй.*

*Мөнгөн тэтгэмж,
тэтгэвэр, төрийн
үйлчилгээ
илүү тэгш
хувиарлагдааг.*

орнуудтай харьцуулахад харилцан адилгүй хэмжээний орлоготой хүмүүсийн авч буй мөнгөн тэтгэмж, тэтгэвэр, үйлчилгээний хэмжээ ерөнхийдөө их ойролцоо байдаг. Нийгмийн үйлчилгээний олон төрөлд (жишээлбэл: ажилгүйдлийн мөнгө) татвар ногдуулдаг учраас мөнгөн тэтгэмж ба үйлчилгээний хэмжээ ойролцоо байдаг.

Гуравдугаарт: бүх хүнд нээлттэй, уг үйлчилгээнд хамрагдахын тулд зөвхөн бага хэмжээний шимтгэл төлдөг эсхүл огт шимтгэл төлөх шаардлагагүй үйлчилгээг түгээмэл төрийн үйлчилгээ гэдэг бөгөөд уг үйлчилгээ нь социалдемократ хэв шинжит нийгмийн баримжаат төрийн барилгын хийцийн чухал онцлог шинж юм. Юуны өмнө хүүхдийн асаргаа халамж, өндөр настны асрамжийн салбарт өргөн хүрээтэй төрийн (орон нутгийн) үйлчилгээний сүлжээ тогтсон байдаг.

Түгээмэл, нийтийн буюу төрийн үйлчилгээ

Хүүхдийн асаргаа халамж, өндөр настны асрамжийн тогтолцоог бэхжүүлж чадсан учраас дараахи эерэг үр дүнд хүрсэн. Эхний ээлжинд хүүхдийн асаргаа халамж болон өндөр настны асрамжийн салбарт өндөр чанартай, нэр хүнд сайтай, найдвартай дэд бүтцийг байгуулснаар нэн ялангуяа эмэгтэйчүүдэд гэр бүл ба хөдөлмөр эрхлэлтийг хослуулах боломж бүрдсэн. Хүүхдийн асаргаа халамж, өндөр настнуудын асрамжийн салбарт өндөр стандартуудыг тогтоож чадсан тул эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийн квот өндөр байдаг.

Гэр бүл ба хөдөлмөр эрхлэлтийг хослуулах боломж илүү сайн, эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийн квот нь илүү өндөр.

Төр нь өргөн хүрээнд ажил олгогчийн үүрэг гүйцэтгэдэг. Социалдемократ хэв шинжит нийгмийн баримжаат төртэй орнуудад төрийн албанд ажиллагсдын тоо харьцангуй өндөр байдаг тул төр нь хөдөлмөр эрхлэлтийн байдал болон хүүхдийн асаргаа халамж, өндөр настнуудын асрамжийн чанарт шууд нөлөөлөх боломжтой байдаг. Төрийн нөлөөллийн чадамж ийм өндөр учраас төрийн үйлчилгээ нь бүх хүнд нээлттэй, өрх толгойлсон ганц бие эцэг-эхчүүдийн ядуурлын квот эрс доогуур байдаг.

Төр ажил олгогчийн үүрэг гүйцэтгэх нь эерэг үр нөлөөг авчирдаг.

Социалдемократ хэв шинжит нийгмийн баримжаат төртэй орнуудын нийгмийн үйлчилгээ өргөн хүрээтэй, мөнгөн тэтгэмж, тэтгэврийн хэмжээ нь харьцангуй ижил байдаг тул хөдөлмөрийн зах зээлээс хараат бус байдлын зэрэг хамгийн өндөр, страфикаци буюу нийгмийн давхраажилт нь харьцангуй сул байдаг. Социалдемократ хэв шинжит нийгмийн баримжаат төрийг цогцлоон байгуулсан,

Скандинавын орнууд: Хөдөлмөрийн зах зээлээс хараат бус байдал өндөр, давхраажилт сул байдаг.

архитектурын уг зарчмыг ашигласан орнуудын төлөөлөл жишээлбэл: Швед, Дани, Норвеги зэрэг Скандинавын орнууд юм.

Социалдемократ хэв шинжит нийгмийн баримжаат төрийн онцлог үндсэн шинжүүд.

- Төрийн үйлчилгээ нь нийгмийн бодлогын чухал бүрэлдэхүүн хэсэг.
- Мөнгөн тэтгэмж, тэтгэврийн хэмжээ нь харьцангуй жигд
- Өндөр татвараас санхүүждэг
- Декомодификаци буюу хөдөлмөрийн зах зээлээс хараат бус байдал өндөр
- Орлогын тэгш байдал өндөр хэмжээнд хангагдсан, нийгмийн давхраажилт сул

4.3. Нийгмийн баримжаат төрийн архитектурын зарчмуудаас гарах үр дагавар

Хэдийгээр дэлхийн аль ч орон дээр дурьдсан хэв шинжүүдийн аль нэгийг 100 хувь агуулах боломжгүй ч ихэнх орнуудыг дээр дурьдсан архитектурын зарчмуудын аль нэгэнд хамруулах бүрэн боломжтой. Нийгмийн баримжаат төрийн барилгыг ямар хийцээр, ямар бүтцээр барьсан бэ? гэдгээс хамааран тодорхой үр дагаврууд урган гардаг гэдгийг тодорхойлолтын зарим нэг хэсгээс тодорхой харж болно.

Нийгмийн баримжаат төрийн архитектурын гурван өөр хийцийн онцлог шинжүүд:

	Либерал	Консерватив	Социалдемократ
Декомодификаци буюу хөдөлмөрийн зах зээлээс хараат бус байдлын зэрэг	доогуур	Дунд зэрэг	хүчтэй
Стратификаци буюу нийгмийн давхраажилт	Дунд зэрэг	хүчтэй	сул
Ядуурлын квот	өндөр	Дунд зэрэг	сул
Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийн квот	Дунд зэрэг	доогуур	өндөр
Төрийн албанд ажиллагсдын тоо	бага	Дунд зэрэг	их
Татвар	доогуур	Дунд зэрэг	өндөр
Шимтгэл	бага	өндөр	бага

Нийгмийн баримжаат төрийн архитектурын бүтцээс ямар үр дагаврууд гардаг бэ? гэдгийг тодорхой харахын тулд тэдгээрийг хооронд нь харьцуулах хэрэгтэй. Жишээлбэл: социалдемократ хэв шинжийг хамгийн ихээр агуулсан нийгмийн баримжаат төртэй скандинавын орнуудад либерал болон консерватив хэв шинжит нийгмийн баримжаат төртэй орнуудтай харьцуулахад ядуурлын квот хамгийн доогуур байна. Харин эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийн квот социалдемократ хэв шинжит нийгмийн баримжаат төртэй орнуудад хамгийн өндөр байна. Эдгээр орнууд юуны өмнө нийгмийн үйлчилгээгээр дамжуулан дээрх үр дүнд хүрсэн. Зарим салбарт төрийн үйлчилгээний хэлбэрээр, зарим салбарт мөнгөн тэтгэмжийн хэлбэрээр нийгмийн үйлчилгээг хүргэдэг. Ийм ч учраас дээр дурьдсан орнуудад төсвийн санхүүжилттэй салбарт ажиллагсдын тоо эх газрын европын орнуудынхаас өндөр байдаг.


Социалдемократ хэв шинжит нийгмийн баримжаат төрийг өмнөх хэв шинжүүдтэй харьцуулах нь

Мэдээжийн хэрэг, дээр дурьдсан нийгмийн хамгааллын бүтцийг өртөг зардалгүйгээр байгуулах боломжгүй. Санхүүжилтийн дийлэнх хувийг татвараас бүрдүүлдэг бөгөөд нийгмийн даатгалын шимтгэл энд төдийлөн чухал үүрэг гүйцэтгэдэггүй. Либерал болон консерватив хэв шинжит нийгмийн баримжаат төртэй орнуудтай харьцуулахад социалдемократ хэв шинжит нийгмийн баримжаат төртэй орнуудад цалингийн нэмэлт зардал өндөр байдаг. Гэхдээ либерал болон консерватив байр суурийг баримтлагсдын амны уншлага болсон "Цалингийн нэмэлт зардал, татварын ачаалал өндөр байх нь эдийн засгийн бүтээмжийг бууруулдаг" гэдэг нотолгоо батлагддаггүй.

Татвараас санхүүждэг.

Улс орнуудын эдийн засгийн өсөлт ба цалингийн нэмэлт зардал, татварын ачааллын хооронд нийтэд танигдсан сөрөг нөлөө буюу урвуу хамаарал байдаггүй. Юуны өмнө хүүхдийн асаргаа, халамж, боловсролын үйлчилгээний зардал, мөн ажилгүйчүүдэд зориулсан мэргэшүүлэх болон мэргэжил дээшлүүлэх эрчимтэй сургалтын зардлыг дунд ба урт хугацаанд авч үзвэл татвар бууруулахаас хамаагүй өндөр ашиг авчирдаг. Өндөр чанартай, нийтэд нээлттэй нийгмийн үйлчилгээний үрээр зөвхөн цөөн тооны хүмүүс төрийн туслалцааг урт хугацаанд авахаас өөр аргагүй хүнд байдалд ордог. Социалдемократ хэв шинжит нийгмийн баримжаат төр нь тэгэхлээр нийгмийн асуудал үүсэхээс урьдчилан сэргийлэх чадамжтай төр юм.

Нийгмийн үйлчилгээний зардал урт хугацаанд өндөр ашиг авчирдаг.



■ Нийгмийн асуудал үүсэхээс урьдчилан сэргийлэх чадамжтай төр нь

Сайн боловсрол, эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүд, хөдөлмөрийн зах зээлийн идэвхтэй боллогоор дамжуулан хүмүүсийг хүнд байдалд оруулахгүй байх, урьдчилан сэргийлэх аргыг эрэлхийлдэг.

■ Нийгмийн асуудал үүссэний дараа шийдлийг хайдаг төр нь

Хүмүүсийг амьдралд тохиолдож болзошгүй эрсдэлээс хамгаалах, зовлон зүдгүүрт өртүүлэхгүй байх дасгал бөгөөд нийгмийн асуудал үүсэхээс урьдчилан сэргийлэх чадамжтай төрийг нөхөж байдаг.

Зураг 4: Нийгмийн асуудал үүсэхээс урьдчилан сэргийлэх чадамжтай нийгмийн баримжаат төр болон нийгмийн асуудал үүссэний дараа шийдлийг хайдаг нийгмийн баримжаат төр хоорондын уялдаа холбоо

Нийгмийн давхарга хоорондын шилжилт буюу доод давхаргаас дээд давхарга руу шилжих шилжилт хялбар

Социалдемократ хэв шинжит нийгмийн баримжаат төртэй орнуудад нийгмийн давхарга хоорондын шилжилт илүү хялбар байдаг. Ингэснээр амьдралын нөхцөл төдийлөн сайнгүй гэр бүлээс гаралтай хүүхдүүдэд сайн боловсролтой болох боломж нээлттэй тул Скандинавын орнууд бусад орнуудтай харьцуулахад хүний нөөцөө илүү сайн ашиглаж чаддаг.

Нийгмийн асуудал үүсэхээс урьдчилан сэргийлэх чадамжтай нийгмийн баримжаат төр хэрэгжүүлдэг.

Дээрээс нь боловсрол багатай байх тусмаа ажилгүйдэлд өртөх эрсдэл хамгийн өндөр учраас боловсрол багатай хүмүүсийн тэтгэврийн хэмжээ нь мөн доогуур тогтоогддог. Өргөн хүрээтэй нийгмийн үйлчилгээг үзүүлж чаддаг социалдемократ хэв шинжийг түлхүү агуулсан нийгмийн баримжаат төр улсынхаа эдийн засгийн байдлыг дээшлүүлж чаддаг. Бүх хүнд боломж олгодог, үндсэн үйлчилгээ, хангамжийг баталгаажуулсан, орлогын эрс зөрүүтэй байдлыг бууруулж чадсан, эдийн засгийн динамик өндөртэй нийгмийг байгуулахын тулд төрийн үүрэг хүчтэй байх ёстой.

Энэ нь нийгмийн ардчилалд юу гэсэн үг бэ?

- Либерал болон консерватив хэв шинжит нийгмийн баримжаат төртэй орнууд бүх оршин суугчдынхаа тэгш эрх чөлөө, оролцоог

хангалттай хэмжээнд хангаж чаддаггүй.

- Харин социалдемократ хэв шинжит нийгмийн баримжаат төртэй орнууд маш сайн бэхэжсэн нийтийн дэд бүтцийнхээ ачаар бүх оршин суугчдынхаа тэгш эрх чөлөө, оролцоог хангалттай хэмжээнд илүү сайн, илүү найдвартай хангаж чаддаг.
- Социалдемократ хэв шинжит нийгмийн баримжаат төртэй орнуудад нийгмийн үйлчилгээний зардлыг төсвөөс санхүүжүүлсний улмаас эдийн засагт нь сөрөг нөлөө үзүүлдэггүй. Харин ч эсрэгээрээ эдгээр орнуудын эдийн засгийн динамик өндөр байдаг.

Нийгмийн баримжаат төрийн төрөл бүрийн архитектурын бүтэцтэй төстөйгөөр капитализмын төрөл бүрийн хэв шинжүүд бий болсон. Капитализмыг [зохицуулалттай](#) ба [зохицуулалтгүй](#) капитализм хэмээн хоёр хуваадаг. Капитализмын хэв шинжүүдийг компаниудын санхүүжилт, хөдөлмөрийн харилцаа, дунд сургууль-ба мэргэжлийн боловсролын тогтолцооны зохион байгуулалт, компани хоорондын харилцаа зэрэг үзүүлэлтүүдийн дагуу хуваадаг. (Нийгмийн ардчиллын сурах бичиг 2-р дэвтэр: Эдийн засаг ба нийгмийн ардчилал 44-49-р хуудас)

Нийгмийн асуудал үүсэхээс урьдчилан сэргийлэх чадамжтай нийгмийн баримжаат төр
Маттиас Платцэк

Орчин үед ядуурал, ажилгүйдэл гэх мэт “хуучны” нийгмийн асуудлууд өнөөгийн алдаатай хөгжлийн явцад улам бүр аюултай харьцаагаар холилдож нийлмэл шинжтэй болж байна. Боловсрол, мэргэжлийн сургалтын орон тоо улам хомсдож хүмүүс буруу хооллолт иргэншлийн үр дагаварт давхар нэрвэгдсэнээс хэт таргалалт, сахарын өвчин элбэгшиж байна. Мөн ямар нэгэн зүйлд донтох, хараат болох, хүний бие махбодь цагаасаа эрт доройтох, цагаачдын тодорхой бүлгүүд нийгэмшихгүй байх хандлага, мэргэжлээрээ ахиж дэвших хүсэл санаачилга буурах, зориг мохох, итгэл найдвараа гээх зэрэг иргэншлийн хүндрэлүүд ихсэх хандлагатай байна. Дайран дээр давс гэгчээр алдаатай хөгжлийн үр дагаврууд хоорондоо уялдаатай бөгөөд харилцан бие биенээ идэвхжүүлж байдаг.

Ийнхүү ядуурал, нимгэн боловсрол, эд хөрөнгө өвлөх боломж байхгүйтэй адил хумигдсан, нийгмийн давхарга хооронд шилжих боломж бараг байхгүй болсон, урам зориг мохох зэрэг олон хүндрэл нийлээд чөтгөрийн тойрог үүсгэж өөрийн хүчээр хөл дээрээ босож амьдралаа өөрийн гараар босгох боломжийг улам хязгаарладаг. Германд олон хүн байсхийгээд мөнгөний гачаалд орж байсхийгээд ажилгүй болдог. Түр зуур мөнгөний гачаалд орсон болохоос тэр чигээрээ ядуураагүй, нэг л удаа ажилгүй болсон болохоос насан туршдаа ажилгүй болоогүй гэдэг итгэл байхгүй учраас энэ нь асар том заналхийлэл болдог. Германд дээрх айдас олон хүнийг түгшээж нийгэмд гүнзгий тархсан байдаг.

Өнөөгийн нийгмийн асуудал үүссэн хойно шийдлийг нь хайдаг нийгмийн баримжаат төр энэ айдсаас хүмүүсээ чөлөөлж чадахгүй нь тодорхой байна. Чухам энэ сул тал нь германы нийгмийн баримжаат төрийн сайн нэрийг хугалдаг юм. Иймээс нийгмийн асуудал үүсэхээс урьдчилан сэргийлэх чадамжтай нийгмийн баримжаат төр чанартай боловсрол, эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх арга хэмжээг эхнээс нь эрчимтэй дэмждэг. Урьдчилан сэргийлэх чадамжтай төр хүмүүсийн хөдөлмөр эрхлэх чадамжийг дээшлүүлж ядуурлаас иргэдээ хамгаалдаг. Ойрын жилүүдэд германд тэтгэвэрт гарах хүмүүс нийгмийн асуудал үүсэхээс урьдчилан сэргийлэх чадамжтай нийгмийн баримжаат төрийн эрхэм зорилгыг хэрэгжүүлэхийн төлөө байх ёстой. Нийгмийн асуудал үүсэхээс урьдчилан сэргийлэх чадамжтай төр, сайн эдийн засаг хоёр нь нэг зоосны хоёр тал юм. Хангалуун чинээлэг байдлыг бүрдүүлэх чадамжтай эдийн засагтай байхыг хүсэгч хүн бүр 21-р зууны нөхцөлд хүмүүс болон нийгмийн дэд бүтцэд системтэйгээр хөрөнгө оруулалт хийж байдаг нийгмийн баримжаат төрийг дэмждэг байвал зохино. /.../ Нийгмийн асуудал үүсэхээс урьдчилан сэргийлэх чадамжтай нийгмийн баримжаат төр нь аюулгүй байдал, оролцооноос ухарна гэсэн үг биш харин эхлээд хүн бүрийн аюулгүй байдал, оролцоо ирээдүйд хангагдах нөхцөлийг бүрдүүлнэ гэсэн үг. Нийгмийн асуудал үүсэхээс урьдчилан сэргийлэх чадамжтай төрийг байгуулах нь өндөр шаардлагатай зорилт. Уг зорилтод гарын алга эргүүлэхийн дайтай хурдан хүрэх боломжгүй гэдэг нь ойлгомжтой. Гэхдээ зарчмын энэ чиглэлийг шийдмэгээр сонгох нь 21-р зууны социалдемократуудын хамгийн чухал үүргийн нэг юм. (Платцэк 2007 он, 229-232-р хуудас)

5. НИЙГМИЙН БАРИМЖААТ ТӨРИЙН ӨМНӨ ТУЛГАМДАЖ БУЙ СОРИЛТУУД

Энэхүү бүлэгт:

- Нийгмийн баримжаат төрийн талаар өрнөж буй эрс шүүмжлэлийг танилцуулж эрэмбэлнэ.
- Даяаршил, эдийн засаг, хөдөлмөрийн бүтцийн хувьсал, хүн ам зүй, нийгмийн хувьслын салбаруудад тулгамдаж буй бодит сорилтуудын талаар ярилцана.
- Эдгээр сорилтуудыг нийгмийн баримжаат төрийн үйлчилгээний цар хүрээг хумих бус харин архитектурын бүтцийг өөрчлөх замаар даван туулах боломжтой гэдгийг харуулна.

Дээр үеийн Бүгд Найрамдах Улсад өсөлтийн явцад хувиарлах нөөц нэмэгдэх эсэх нь ойрын ирээдүйд баталгаатай бус байсан ч эцэст нь өсөлтөөс бий болсон нэмэгдлийг ямар нэгэн аргаар хувиарлах байдлаар хувиарлалтын зөрчлийг энх тайван замаар шийдвэрлэх боломжгүй болоод ирэхийн цагт шударга ёс, тэгш байдлын асуудал гэнэт нэгэн шинэ хэлбэрийн, магадгүй өөр хэлбэрийн шаардлага болон хувирсан юм. (Тийрзе 2005 он, 13-р тал)

Хэрвээ Вольфганг Тийрзе-гийн хэлсэн үг үнэн юм бол “Хуучны амар жимэр Холбооны улсаас” өнөөдрийн Холбооны Улс юугаараа өөр болчихсон хэрэг бэ? гэдэг асуулт гарч ирнэ. Хувиарлалтын асуудал өсөлтийн үр дүнд бий болсон нэмэгдэлийг хувиарлах асуудлын хүрээнд эргэлдэхээ больсон шалтгаан нь юу юм бэ? Ямар нөхцөл шалтгаануудын улмаас нийгмийн бодлого хэдэн арван жилийн өмнөхтэй харьцуулахад өөр үүрэгтэй болсон юм бэ?

Даяаршил, хөдөлмөр, эдийн засгийн салбарт гарсан бүтцийн хувьсал, хүн ам зүйн хувьсал, нийгмийн хувьсал зэрэг хөгжлийн шинэ хандлагуудын улмаас дараахи чухал өөрчлөлтүүд гарсан байна. Хөгжлийн эдгээр өөрчлөлтүүд нь заримдаа нийгмийн баримжаат төрийн зарим нэг дүрмийг бус харин бүхэлд нь шүүмжлэх шалтгаан болж байна.

Дээрх хувьслуудын улмаас гарч буй өөрчлөлтүүд германы нийгмийн баримжаат төрийг хэтэрхий данхар, хэтэрхий өглөгч хэмээн

Хувиарлалтын шинэ асуудлууд гараад ирсэн үү? Юу өөрчлөгдчихсөн хэрэг бэ?

Хөгжлийн дөрвөн хандлага: Даяаршил, хүн ам зүй, нийгэм, бүтцийн хувьсал

Нийгмийн баримжаат төрийн шүүмжлэл моданд орж байна. Гэхдээ...

шүүмжлэх үндэслэл нь болж байна. Холбооны ерөнхийлөгч асан Роман Херцог металлын аж үйлдвэрийн салбарын ажил олгогчдын холбооноос санхүүжүүлсэн Нийгмийн баримжаат зах зээлийн шинэ санаачилга⁸ арга хэмжээнд оролцохдоо ажил олгогчдыг дэмжсэн үг хэлэх нь зүйтэй гэж бодсон юм байлгүй “Олон хүмүүсийн хувьд биеэ зовоож ажил хийхийн оронд төрөөр тэжээлгээд хэвтэж байхыг илүүд үзэж байна. Энэ нь ажил хөдөлмөр эрхэлж буй хүмүүсийн хувьд дээшээ тэнгэр хол мэт санагдах шударга бус явдал” юм гэжээ. (Франктурын Аллгемайн сонины 2001 оны 11-р сарын 25-ны дугаарт нийтлэгдсэн.)

Ерөнхийдөө ямар
ч ялгаагүй...

Филисофич Петер Слотердиджик шинэ либерал аргументад хүч нэмэх хэрэгтэй гэж бодсон юм байлгүй, “Либерал ажиглагчдын нүдээр харахад хүмүүсийн оршихуйн системийн нуруун дээр дээр зайдалсан улам бүр өсөн томорч буй авах идэхийн мангаст өнөөгийн харьцааны өөрийнх нь бүтээл болох тосон ирж буй аюулын талаар нийгэмд сануулсан гавъяа ногдож байна. Эдгээр аюул нь компаниудын гарыг хүлсэн хэтэдсэн зохицуулалт, амжилттай ажилласных нь төлөө шийтгэл ногдуулдаг хэтэдсэн татвар, хувийн болон төсвийн салбарт хомхойн сэтгэлгээгээр төсөвт хандсанаас үүдэлтэй хэтэдсэн өр юм.” хэмээжээ.

Эсхүл бодит
байдалтай
уялдаагүй...

Түүний төрийн мангасыг дарахад санал болгож байгаа жор нь нийгмийн байгууллыг “шинэчлэх” санаа юм. “Энэхүү шинэчлэл нь сунгадаг өглөгч гарын хувьд (төрийг өглөгч гар гэжээ.-Орч) хувьсгалаас багагүй үр дүнг авчирна. Ийнхүү шинэчлэн байгуулснаар албадлагын татварыг устгаж албадан авсан татвараа нийтэд бэлэг болгон тараадгийг болиулна, тэглээ гээд төсвийн салбар ядуурахгүй” гэжээ. (Франкфуртын Аллгемайн сонины 2009 оны 6-р сарын 10-ны дугаар)

Эдийн засаг
ба нийгмийн
баримжаат төрийн
хооронд ямар
нэгэн сөрөг
хамаарал байхгүй.

Татварын бодлого хэмээх 7.1-р бүлэг, Нийгмийн баримжаат төрийн байгууламжийн материал, барилгын хийц ба архитектур” хэмээх 4-р бүлэгт харуулсны дагуу дээрх шүүмжлэлүүдийг судлаад үзэхэд батлагдах магадлал туйлын хомс гэдэг нь харагддаг. Үүнд: Нэгдүгээрт, Германы татвараас санхүүждэг нийгмийн баримжаат төр нь олон улсын түвшинд харьцуулахад хэмжээгээрээ дунд зэрэгт ордог. Хоёрдугаарт: Аливаа улсын нийгмийн баримжаат төрийн хэмжээ ба эдийн засгийн бүтээмжийн чадавхи хоёрын хооронд сөрөг хамаарал байдаггүй.

8 Цаад учир шалтгааны талаар Шпет (2004 он) уншина уу.

2004 онд татвар төлөгчдийн дөрөвний нэгээс дээш (26,8%) хувь нь (жилийн орлогын доод хэмжээ 37,500 евро) германы нийт цалин ба орлогын татварын 79,6%-ийг төлж байсан нь түүний хэлсэнтэй нийцэж байгаа юм. үүний шалтгааныг холоос хайгаад байхын хэрэггүй. 2004 онд татвар төлөгчдийн дөрөвний нэгээс илүү хувийн (28,8%) жилийн нийт орлогын дээд хэмжээ нь 10,000 евротой тэнцэж байсантай холбоотой. Татвар төлөгчдийн тал хувийн жилийн орлого нь 23,000 еврогоос доогуур байсан бөгөөд тэд орлогын албан татварын 4,3%-ийг төлжээ. (*Холбооны статистикийн газрын 2008 оны мэдээ)

Тэгш бус санхүүжилт нь тэгш бус хувиарлалтаас эхтэй.

Философич Слотердижикийн итгэл үнэмшлээ болгосон нөхцөл байдал нь Германд сүүлийн жилүүдэд өмч хөрөнгийн тэгш бус байдал эрчимтэй нэмэгдсэнтэй холбоотой. 2007 оны байдлаар бүх насанд хүрэгчдийн дөрөвний нэг (27%) хувь нь хувийн өмч хөрөнгөгүй, тэр ч байтугай өр ширтэй байсан бол хүн амын хамгийн баян 10 хүн тутамд хамгийн багаар бодоход 222.000 еврогийн цэвэр хөрөнгө ногдож байжээ.

Өмч хөрөнгийн тэгш бус байдал эрс нэмэгдсэн

Германы иргэдийн хамгийн баян 10% нь нийт хөрөнгийн 60%-ийг эзэмшдэг. Хүн амын хамгийн ядуу 70% нийт өмчийн дөнгөж 9% -ийг эзэмшдэг. (Фрик ба Гравка 2009 он). Германы нийгмийн баялгийн хувиарлалт ийм тэгш бус байхад татварын хэтэдсэн аюулын тухай ярьж ирээдүйн нийгмийн бодлогыг өглөг, бэлгийн хэлбэрт шилжүүлэхийг хүсэгч хүн бүр бодит байдлыг нэг удаа ч гэсэн тогтож хараасай. Мэдэж байсан ч мэдээгүй дүр эсгэдэг ч байж мэдэх юм.

10% нь 60 хувийг, 70% нь 9%-ийг тус тус эзэмшдэг.

Дээрх нийтэд нь шүүмжилсэн шүүмжлэлээс гадна дэргэдүүр нь нүдээ аниад өнгөрөхийн аргагүй бодит шаардлагууд бас байна. Иймэрхүү шүүмжлэлүүд нь сүүлийн хэдэн арван жилд нийгэм, эдийн засаг, амьдралын хүрээнд гарсан өөрчлөлтүүд, эдгээрийн улмаас нийгмийн баримжаат төрийн өнөөгийн бүтцэд бодитойгоор тулгараад байгаа сорилтуудтай холбоотой. Эдгээр сорилтууд тулгармагц яаран тэвдэн нийгмийн баримжаат төрийн үйлчилгээний хүрээг хумихыг шаардахаасаа өмнө эдгээр сорилтуудын улмаас ерөнхий нөхцөлүүд хэрхэн өөрчлөгдөж буйг анхааралтай судлах шаардлагатай. Нийгмийн баримжаат төрийн үндсэн салбарууд хэмээх 7-р бүлэгт дээр дурьдсан өөрчлөлтүүдэд нийтлэг бус харин тус бүрд нь тохирсон өөр өөр хариултыг өгөх шаардлагатай гэдгийг харуулж байна.

Нүдээ аниад өнгөрөхийн аргагүй үнэн.

Нийгмийн баримжаат төрийг бүхэлд нь золигт гаргаж төрийн үйлчилгээний хүрээг хумих замаар бус харин шинэ сорилтуудыг өөрчлөн байгуулалт ба шинэчлэл хийх замаар давах туулах хэрэгтэй гэдэг хариулт гарч ирж байна. Энэхүү салаа замын уулзвар дээр германы төрөл бүрийн урсгалууд ба хүчнүүд хоорондын саналын зөрүүтэй байдал, ямар байр суурь хэлэлцүүлэгт давамгайлж байгааг төвөггүй харж болохоор байна. Барууны хүчнийхэн, консерватичууд болон неолибералчууд энэ эгзэгтэй эгшинйг нийгмийн баримжаат төрийг эрс сулруулахад ашиглах гэж улайран нийгмийн баримжаат төрийг өмгөөлөгчдийн эмзэг газрыг олж түүн дээрээ дөрвөлөн дахиж өндийлгөхгүй болтол цохилт өгөх боломжийг эрэлхийлж байна. Шинэчлэл бүрийг эсэргүүцэгч хэт зүүний үзэлтнүүд нийгмийн баримжаат төрийг шинэчлэх оролдлогуудын эсрэг популист ял тулгаж байгаа нь нийгмийн баримжаат төрийг сууриар нь ганхуулахад хүргэж болзошгүй өөр нэг хэлбэрийн аюул юм. Хэрэв хүсэл, зорилго байх юм бол бүхнийг хуучин хэвээр нь үлдээж болно гэдэг бүтэмшгүй санааг тэд өдөөн дэвэргэж байна. (Тавриелл 2008 он 305-р тал)

5.1. Даяаршил

Томас Риксен

Олон нийтийн хэлэлцүүлэгт эдийн засгийн даяаршлыг нийгмийн баримжаат төрийн нийгмийн үйлчилгээний өнөөгийн хүрсэн түвшнийг бууруулахгүй, хэвээр нь хадгалахад тулгарч буй хамгийн чухал сорилтуудын нэг хэмээх үзэл давамгайлдаг. Олон улсын түвшинд өрсөлдөх чадварыг бууруулж байна гэдэг шалтгаанаар нийгмийн бодлогын цар хүрээг хумих шаардлагыг олонтаа тавьж өнөөг хүртэл эдгээр шаардлагыг биелүүлсээр иржээ.

Сонирхогч талын байнга давтах дуртай популист үндэслэлүүд уншигч авхай нарт хэдүйн танил болсон зүйлс. Харин илүү гүнзгийрүүлэн судлаад үзэхэд даяаршил үнэхээр нийгмийн баримжаат төрд аюул учруулаад байна уу? гэдэг асуултын хариулт олон талтай. Улам бүр өсөн нэмэгдэж буй олон улсын эдийн засгийн харилцааны сүлжилдсэн байдал болон нийгмийн баримжаат төр хоёрын хоорондын уялдаа холбооны талаар онолын төрөл

Даяаршил нь олон талт ойлголт бөгөөд уг ойлголтод олон улсын түвшинд явагдаж буй олон улсын оролцоотой төрөл бүрийн үйл явцыг хамруулан ойлгож болно. Бид соёлын, нийгмийн, улс төрийн нэн ялангуяа эдийн засгийн даяаршлын талаар ярьцгаадаг... Худалдааны саад хоригийг бууруулах, босго буюу эрчимтэй хөгжиж буй орнуудын хөгжил болон техникийн инноваци гурав нь эдийн засгийн даяаршлыг урагшлуулагч хөдөлгөгч хүчин буюу мотор нь юм.

Гүнзгийрүүлэн унших
сурах бичиг, номын нэрс
Нийгмийн ардчиллын
академийн сурах бичгийн
2-р дэвтэр: Эдийн засаг
ба нийгмийн ардчилал
(2009 он) 19-36-р хуудас

Марианне Вайсхайм
болон бусад зохиогчид
(1999 он), Даяаршлын
эрин үед? Нийгэм ба
улс төрийн бодлого
улс үндэстнүүдийн хил
хязгаарт захирагдахгүй
болсныг илтгэх
нотолгоо ба тоо
баримтууд, Баден Баден

Германы Бундестаг
(2002 он), Бундестагаас
томилогдсон Дэлхийн
эдийн засгийн
даяаршлыг судлах
онцгой комиссын
тайлан, 2002 оны 6-р
сарын 12-нд Берлин
хотноо хэвлэгдсэн
14/9200 тоот хэвлэмэл
материал

бүрийн хандлагууд хөгжсөн байдаг. Онолын олон төрлийн хандлагыг хялбарчлахын тулд даяаршлын талаар өөдрөг ба гутранги үзлийг баримтлагсад хэмээн номонд хоёр бүлэгт хуваалаа. Эдгээр хоёр бүлгийг дараахи хэсэгт танилцуулах болно. Танилцуулгын дараагаар өнөөг хүртэл олонхи орнуудын засгийн газрууд даяаршлын үйл явцын эсрэг ямар хариу арга хэмжээ авч ирснийг схемчлэн харуулах болно. Эцэст нь бодлогын өөр нэгэн хувилбар болох нэгдсэн европын нийгмийн бодлогыг даяарчлах оролдлогын талаар хэлэлцэх болно.

Даяаршлын талаар өөдрөг үзэл баримтлагсад

өөдрөг үзэлтнүүд даяаршлын улмаас нийгмийн баримжаат төрд ямар нэгэн дарамт учрахгүй хэмээн нотолдог. Тэд нийгмийн баримжаат төрийн бүтэц, үйлчилгээний тухай шийдэл нь улс үндэстнүүдийн үндэсний түвшинд гарах шийдвэр бөгөөд уг шийдвэр нь зөвхөн тухайн үндэстний улс төрийн байгуулал ба олонхийн харьцаанаас хамаарна гэж үздэг. Олон улсын өрсөлдөөний улмаас нийгмийн баримжаат төрийн үйлчилгээг хумих чиглэлд дарамт ирлээ ч гэсэн тухайн улсын иргэдийн дийлэнх нь өргөн хүрээтэй үйлчилгээ үзүүлэх чадамжтай нийгмийн баримжаат төртэй байхыг дэмжиж буй нөхцөлд төрийн үйлчилгээний хүрээг заавал хумих албагүй. (Сванк 2002 он)

Нийгмийн баримжаат төр бол улс төрийн шийдвэр болохоос эдийн засгийн шийдвэр биш

Хохирлыг нөхөн олгох тухай нотолгоо

Өөдрөг үзэлтнүүдийн зарим нь бүр цаашилж даяаршил нийгмийн баримжаат төрийн бэхжилтийг дэмжих боломжтой гэж нотолцгоодог. Тэд олон улсын худалдаа хангалуун чинээлэг амьдралын түвшинг дээшлүүлж улмаар нийгмийн баримжаат төрийн хувиарлалтын орон зайг нэмэгдүүлнэ хэмээн нотолдог. Түүнээс гадна өөдрөг үзэлтнүүд үүргээ сайн гүйцэтгэх чадамжтай нийгмийн баримжаат төр нь зах зээлийг либералчлах улс төрийн шийдвэрийг хэрэгжүүлэх нэгэн нөхцөл юм гэж нотолцгоодог. Иргэд олон улсын зах зээлийн эрсдэлүүдээс нийгмийн хувьд найдвартай хамгаалагдсан гэдэгтээ итгэлтэй байсан нөхцөлд либералчлах тухай улс төрийн шийдвэрийг дэмждэг. Ингэсэн нөхцөлд л даяарших үйл явц ба нийгмийн баримжаат төрийн үйлчилгээний хүрээг өргөтгөх буюу бэхжүүлэх үйл явц харилцан эерэг үйлчлэл үзүүлж чадна. (харьцуулж үзнэ үү. Родрик 1998)

Даяаршил нийгмийн баримжаат төрийг бэхжүүлдэг.

Нийгмийн баримжаат төрийн байгуулал нь өгөгдмөл давуу талыг бэхжүүлдэг.

Капитализмын
тодорхой
хэв шинжүүд
нийгмийн
баримжаат төр
дээр суурилдаг.

Нийгмийн
баримжаат төр аж
үйлдвэржилтийн
төрөлжилтийг
дэмждэг.

“Капитализмын тоглоомын төрлүүд”⁹ үзлийг баримтлагсдын төлөөлөл дээрхээс өөр нотолгоог гаргаж ирдэг. Тэд олон улсын худалдаа нь олон улсын хөдөлмөрийн хувиарлалтыг эрчимжүүлж ингэснээр аж үйлдвэржилтийн төрөлжилтийг дэмждэг гэж үздэг.

“Капитализмын тоглоомын төрлүүд” үзлийг баримтлагсад улс ардын аж ахуйн байгууллын бүтцүүд (уг бүтцэд нийгмийн баримжаат төр мөн багтдаг) хоорондоо зохицол сайтай, харилцан бие биенээ хүчирхэгжүүлж байх тохиолдолд өгөгдмөл давуу талууд дээрээ суурилан аж үйлдвэржилтийг төрөлжүүлэн хөгжүүлэх боломжтой гэж үздэг. Үүний цаана нийгмийн баримжаат төрөө бэхжүүлж чадсан орнууд олон улсын худалдааг эрчимтэй хөгжүүлсний үрээр нийгмийн баримжаат төрөө улам бэхжүүлэх боломжтой гэдэг хүлээлт байна.

Өгөгдмөл давуу талын сонгодог жишээ бол дарс ба ноосны үйлдвэрлэл юм. Португалийн байгалийн өгөгдмөл давуу тал буюу нөхцөл нь илүү сайн чанарын дарс үйлдвэрлэхэд тохиромжтой бол Шотландын байгалийн өгөгдөл ноосыг илүү хямдаар үйлдвэрлэхэд тохиромжтой. Хэрэв эдгээр орнууд дарс болон ноосыг хоёуланг нь үйлдвэрлэхийн оронд өгөгдмөл давуу тал дээрээ тулгуурлан бүтээгдэхүүн үйлдвэрлээд худалдаалбал хоёр орон хоёулаа хожих болно.

Харин англосаксоний орнуудад нийгмийн баримжаат төрийн үйлчилгээ хумигдаж болзошгүй юм. Энэ талаас нь харвал даяаршил нь зарчмын хувьд нийгмийн баримжаат төрд аюул учруулах хүчин зүйл биш аж.

Даяаршлын талаар гутранги үзлийг баримтлагсад

Гутранги үзэлтнүүд харин эсрэгээрээ нийгмийн бодлогын арга хэмжээнүүдийг олон улсад үйл ажиллагаа явуулдаг компаниудын өртөг зардлыг нэмэгдүүлэгч хүчин зүйл хэмээн онцлон тэмдэглэдэг. Эдгээр компаниуд сонголт хийх боломжтой тул нийгмийн баримжаат төрийг санхүүжүүлдэг цалингийн нэмэлт зардал, татвар, бусад нэмэлт зардлууд нь хамгийн доод хэмжээнд байх бусад орнуудыг сонгон авч үйлдвэрлэлээ явуулдаг. Үүнтэй нэгэн адил хөрөнгө эзэмшигчид татварын ачаалал багатай оронд хөрөнгө оруулалт хийх сонголтыг илүүд үздэг. (Шарп 2000 он)

Нийгмийн бодлого
нь өртөг зардлыг
нэмэгдүүлэгч
хүчин зүйл

9 Нийгмийн ардчиллын академийн сурах бичгийн 2-р дэвтэр: Эдийн засаг ба нийгмийн ардчилал (2009 он) 44-49-р хуудас.

Компаниуд, хөрөнгө, мөн өндөр мэргэжлийн ажиллах хүч нь олон улсын хэмжээнд мовил буюу шилжих боломжтой тул улс орнуудын засгийн газрууд хоорондоо “Хэн нь татварын хувь хэмжээг хамгийн багаар тогтоох бэ? Хэн нь нийгмийн стандартуудыг хамгийн доогуур тогтоох бэ?” гэдэг шалгуураар хоорондоо өрсөлдөх хэрэгтэй болдог. Энэ өрсөлдөөний үр дүнд хаа сайгүй нийгмийн баримжаат төрийн үйлчилгээ хумигдах болно гэж гутранги үзэлтнүүд үздэг. (race to the bottom) Засгийн газруудад дарамт үзүүлэхийн тулд хөрөнгө ба компани тухайн орныг орхин гарах шаардлагагүй, харин гарлаа шүү гэж дарамтлахад л хангалттай гэнэ.

Хэн нь нийгмийн бодлогын хамгийн доод стандартыг амлах бэ? гэдэг өрсөлдөөн

Өрсөлдөөний дарамтыг үүсгэгч нь эдийн засгийн интернационалчлал биш, харин хөрөнгийн шилжилтийн либералчлал юм гэж гутранги үзэлтнүүд үздэг. Өөдрөг үзэлтнүүдийн баримталдаг байр суурь зөвхөн таваарын худалдаа эрхлэлтэд утга учиртай боловч системийн өрсөлдөөний динамик юуны өмнө хөрөнгийн шилжилтийн либералчлалын үр дүнд хөгждөг хэмээн гутранги үзэлтнүүд үздэг.

Хөрөнгийн шилжилтийг либералчлах нь шийдвэрлэх үүрэгтэй.

Даяаршлын талаар гутранги үзлийг баримтлагсад даяаршлын нөлөө бодитойгоор харагдах хүртэл тодорхой хугацаа өнгөрөх боломжтой гэдгийг урьдчилан хэлдэг. Хөдөлгөөнт буюу шилжих хүчин зүйлс болох компани ба хөрөнгө татвараас зайлсхийх боломжтой тул эхний ээлжинд нийгмийн баримжаат төрийн зардлыг үйлдвэрлэлийн суурин хүчин зүйлс буюу ажилтнуудад үүрүүлж орхидог. Хөрөнгөнөөс олж буй орлогод ногдуулдаг татвар нь хөдөлмөрөөр олж буй орлогод ногдуулдаг татвараас доогуур байдаг. (Хөрөнгийн татвар хөдөлмөрийн хөлсөнд ногдуулж байгаа татвараас доогуур байдаг.) Баячуудын хөрөнгөнөөсөө олж буй орлого ихэвчлэн ядуусынхаас илүү өндөр байдаг тул прогрессив аргачлалаар ногдуулж буй татварын үр нөлөө буурдаг. (Татвар хэмээх 7.1.-р бүлэгтэй харьцуулж үзнэ үү.) Санхүүжилт нь улам бүр шударга бус болж нийгмийн баримжаат төр зорилгодоо хүрч чадахгүйд хүрдэг. Энэ нь алсдаа нийгмийн баримжаат төрийн үйлчилгээний хүрээг хумихад хүргэж болзошгүй.

Өртөг зардлыг хөдөлгөөнгүй буюу шилждэггүй хүчин зүйлст үүрүүлж орхидог.

Өнөөг хүртэл ямар хариу арга хэмжээг авч хэрэгжүүлсэн бэ?

Шинжлэх ухааны бүтээлүүдэд “Даяаршил нийгмийн баримжаат төрийн үйлчилгээний хүрээг бодитойгоор хумихад хүргэв үү?” гэдэг талаар нэгдмэл дүгнэлт, нэгдсэн байр суурьт хүрээгүй байна. Тоон

Нийгмийн баримжаат төрийн үйлчилгээний хүрээг хумьсан уу? нэгдмэл дүр зураг харагдахгүй байна.

*Гүнзгийрүүлэн унших
сурах бичиг, номын нэрс
Филипп Генишел (2003
он), Даяаршлыг асуудал,
асуудлыг шийдвэрлэгч,
өнгөлөн дэлдалсан
чимэглэл хэмээн үзэхийн
учир*

*Гюнтер Хеллман, Клаус
Диетер Вольф, Михаел
Цюрн нарын бүтээл
“Олон улсын шинэ
харилцааны талаархи
германы судалгааны
хүрсэн түвшин, хэтийн
төлөв” Баден, Баден
429-464-р хуудас*

*Херверт Овингер ба
Петер Штарке (2007
он) OECD-ийн орнуудын
1980-2001 оны нийгмийн
бодлогын чиг хандлага
Нэг нэгэндээ ойртох, нэг
нэгнээсээ алсрах ба нэгэн
хэвээр удаан орших
тухай Улс төрийн
улирал тутмын сэтгүүл
(38-р тусгай дугаар) 470-
495-р хуудас*

үзүүлэлтүүдийг харьцуулсан судалгаанд 1990-ээд оны дунд үеийг хүртэл нийгмийн баримжаат төрийн зардал, татварын орлого буураагүй гэдгийг тогтоосон байдаг. Гэхдээ эдгээр судалгааны шалгуур үзүүлэлтүүдийг буруу сонгосон гэдэг шүүмжлэл байдаг. Нийгмийн баримжаат төрийн зардлыг нэгтгэсэн байдлаар тооцсон учраас хувь хүмүүст хүрч буй үйлчилгээ, олгож буй тэтгэвэр тэтгэмжид ямар өөрчлөлт гарав? гэдгийг тодорхойлох боломжгүй. Нийт зардлын хэмжээ тогтвортой хэвээр байсан ч үйлчилгээ хүртэгсдийн тоо өссөний улмаас тэдний хүртэж буй үйлчилгээний хэмжээ буурсан байх боломжтой. Харин чанарын судалгаагаар судалгаанд хамрагдсан хугацаанд үйлчилгээний хэмжээг бууруулсан, үйлчилгээ хүртэх эрх нь үүссэн даатгуулагчдын, хамрах хүрээг хязгаарласныг нотлох нотолгоо олон байлаа. Орлогын тал дээр ч ижил төстэй байдал үүсчээ. Орлогын нийт хэмжээнээс татварын орлогын бүтцийн өөрчлөлтийн талаар мэдээлэл авах боломжгүй. Бодит байдал дээр татварын ачаалал хөрөнгөнөөс хөдөлмөр лүү шилжсэнийг нотлох эмпирик нотолгоо олонтаа тохиолддог. Үүнээс гадна судалгаа зөвхөн 1990-ээд оны дунд үеийг хүртэлх хугацааг хамарсан, сүүлийн үед хийгдсэн судалгаа байхгүй хэмээн шүүмжилжээ.

Өрсөлдөөний дарамт практик дээр нөлөөлж байна.

Сүүлийн үеийн, урт хугацааг хамарсан судалгаануудын үр дүн даяаршлын улмаас нийгмийн баримжаат төрийн үйлчилгээний зардал хумигдаж байгааг тогтоосон байна. (Буземайер 2009 он) Нийтэд нь авч үзвэл улс орнуудын засгийн газрууд практик дээр даяаршлын улмаас тулгарсан сорилтуудад нийгмийн баримжаат төрийн үйлчилгээний зардлыг хумих замаар хариу үйлдэл үзүүлжээ. Энэ нь даяаршлын улмаас тулгараад байгаа сорилтуудыг төрийн үйлчилгээний зардлыг хумихаас өөр ямар ч аргаар даван туулах боломжгүй гэсэн үг огтоос биш. Өнөөг хүртэл баримталж ирсэн бодлогоос өөр, нийгмийн баримжаат төрийг даяаршлын сорилтуудад ажрахгүй болгоход чиглэсэн бодлогын олон хувилбарууд байгаа нь ойлгомжтой. Энэ асуудлын хүрээнд ямар хэлэлцүүлгүүд өрнөж байгааг дараагийн хэсэгт товч танилцуулъя.

Гарах гарц: нь Дэлхийн ба европын нийгмийн бодлого мөн үү?

Нийгмийн баримжаат төрийн зардал өрсөлдөх чадварт муугаар нөлөөлж байна, иймээс зардлыг хумих хэрэгтэй гэдэг дарамт байнга ирдэг. Уг дарамтын улмаас тулгарч буй сорилтуудыг хэрхэн даван туулах бэ? Ямар хариу арга хэмжээ авах бэ? гэдэг асуулт гарч ирнэ. Зөн совингоо дагавал нийгмийн баримжаат төрийн байгууллагуудыг хөрөнгийн нэгэн

адил олон улсын түвшинд шилжүүлэх шийдвэр гаргаж болно. Эдийн засгийн даяаршилд нийгмийн бодлогыг даяаршуулах замаар хариу барих ёстой. Ийм хариу барьчихвал үйлдвэрлэлийн хөдөлгөөнт хүчин зүйлсийг бусад орон луу шилжүүлэх замаар нийгмийн баримжаат төрийн зардлаас зайлсхийх боломжийг хаачихна гэсэн үг. Гэхдээ улс орнуудын нийгмийн баримжаат төрийн хөгжил хоорондоо асар их зөрүүтэй учраас уг шийдвэр бодлогын түвшинд хэрэгжих боломжгүй юм. Түүнээс гадна нийгмийн бодлогыг олон улсын түвшинд гаргах нь өнөөгийн нөхцөлд нормативын хувьд хүсээд байх зүйл мөн үү? гэдэг нь эргэлзээтэй. Нийгмийн баримжаат төр ба ардчилал нь хоорондоо нягт холбоотой тул олон улсын шийдвэр гаргалтын түвшнийг ардчилах үйл явцтай хөл нийлүүлэх шаардлагатай болно. Энэ нь нийгмийн бодлогыг даяарчлахтай адил үл гүйцэлдэх санаа юм.

Европын холбооны түвшинд¹⁰ нөхцөл байдал арай өөр байна. Европын Холбоонд нэгдсэн нийгмийн баримжаат төр байгуулах чадамж байхгүй нь үнэн. Олон үндэстний байгууллагууд дотоодын нэгдсэн зах зээлийг байгуулж заавал дагаж мөрдөх дүрэм журмуудыг батлах чадамжтай ч (сөрөг интеграци) “эерэг интеграцийн салбарт буюу зах зээлд нийгмийн бодлогын зохицуулалт хийх тал дээр гар нь хүлээстэй гэсэн үг. (Шарп 1999 он)

Гэсэн хэдий ч олон төрлийн нийгмийн бодлогын зохицуулалт сайн дурын үндсэн дээр хийгдсээр байна. Үүнээс гадна Европын Холбоонд заавал дагаж мөрдөх дүрэм журмыг тогтоох хэмжээнд цаашид хөгжүүлэх боломж бүхий нэгэн байгууллага байдаг. Үүний тулд гишүүн орнуудын нийгмийн бодлогыг нийтэд нь эв зохицолд хүргэх зорилт тавих шаардлагагүй. Европын орнуудын нийгмийн бодлогын уламжлал харилцан адилгүй учраас нэгдсэн зохицуулалтад оруулах зорилт тавьлаа ч биелэх боломжгүй. Нэгдсэн зохицуулалтад оруулна гэхээсээ илүү европын түвшинд заавал дагаж мөрдөх доод стандартуудыг тогтоох нь илүү бодитой зорилт юм. ГСДН доод стандартуудыг тогтоох чадамжтай нийгмийн холбоо байгуулахын төлөө байна гэдгээ зарласан.

Европын Нэгдсэн Холбоо бол даяаршилд өгөх бидний хариулт болох ёстой. Европын нийгмийн холбоо нь эдийн засаг ба валютын холбоотой ижил түвшинд байгуулагдах ёстой. /.../ Бид гишүүн орнуудын нийгмийн системүүдийг нэгтгэх, жигдрүүлэх зорилтыг тавиагүй, харин гишүүн орнуудтай нийгмийн тогтвортой байдлыг хангах пактын хүрээнд нэгдсэн ойлголтод хүрэхийн төлөө байна.” (Хамбургийн хөтөлбөр 2007 он, 26,28-р хуудас)

10 “Европын нийгмийн бодлого” сэдвийг Нийгмийн ардчиллын сурах бичгийн 4-р дэвтэр “Европ ба нийгмийн ардчилал” номоос дэлгэрэнгүйг уншина уу.

5.2. Эдийн засаг ба хөдөлмөрийн салбарын бүтцийн хувьсал

ХБНГУ байгуулагдсаны дараах эхний арван жил: Аж үйлдвэрийн салбар тогтмол өсөлттэй байсан.

1960-аад он: Чахилгаан хэрэгслүүдийн анхны худалдан авалтын үе


Гүнзгийрүүлэн унших эх сурвалжууд:

Буркарт Лутц (1989 он), Улам л баян чинээлэг болох тухай богинохон зүүд. 20-р зууны европын аж үйлдвэрийн капитализмын хөгжлийн нэгэн шинэ тайлбар. Франкфурт ам Майн/ Нью Йорк

ХБНГУ байгуулагдсаны дараах эхний арван жилийн онцлог бол аж үйлдвэрийн салбарын тогтмол өсөлт байлаа. 1970-аад оны сүүлчийг хүртэл тус салбарт ажиллагсдын тоо, ажиллагсдын цалин хөлс ч тогтмол өсөлттэй байлаа. Цалин хөлс тогтмол өссөний үр дүнд хүн ам орлогынхоо тун бага хувийг орон байр, хоол хүнс зэрэг үндсэн хэрэгцээндээ зарцуулж хэрэглээндээ илүү их мөнгө зарах боломжтой болж байлаа.

1960-аад онд германы (мөн Европын) ихэнх айл өрхүүд анхны хөргөгч, угаалгын машин, талх шарагч, авто машин зэргийг худалдан авсан үе байлаа. Орлого нэмэгдэхийн хэрээр аж үйлдвэрийн секторт үйлдвэрлэгдсэн бүтээгдэхүүнүүдийн эрэлт нэмэгдэж байлаа. Эдгээр салбарын бүтээмж эрс дээшилснээр үнэ буурч, үнийн бууралт эрэлтийг улам нэмэгдүүлж байлаа. Үр дүнд нь бүтээмжийн өсөлт ашгийг нэмэгдүүлж, эрэлт ба үйлдвэрлэл нэмэгдэж дахиад л бүтээмжийн ашгийг нэмэгдүүлэх шинэ циклийг эхлүүлж байлаа. Аж үйлдвэрийн салбарт ажиллагсдын тоо нэмэгдэж орлого, эрэлт ч нэмэгдсээр байлаа.

Дээрээс нь уламжлалт секторууд (хөдөө аяж ахуй, гар урлал) ба орчин үеийн аж үйлдвэрийн секторуудын хооронд эерэг харилцан үйлчлэл бий болсон юм. Орчин үеийн аж үйлдвэрлэлийн салбарт дутагдаж байсан ажиллах хүчнүүдийг уламжлалт секторуудаас нөхөж уламжлалт секторууд орчин үеийн секторын инновациас ашиг хүртэж байлаа.



5-р зураг: Дотоодын хөдөлмөр эрхлэгсэдийг Германы эдийн засгийн салбаруудын дагуу харуулсан байдал

1970-аад он, 1980-аад онд нөхцөл байдал өөрчлөгдөж эхэлсэн юм. Цахилгаан хэрэгсэл, авто машин анхлан худалдан авалтын үе төгсгөл болж хэрэглэгчид тооноос илүү чанарыг эрхэмлэх болсон юм. Хэдийгээр бүтээмжийг нэмэгдсэний үрээр үнэ буурсаар байсан ч эрэлт нэмэгдэхээ больсон юм. Эдгээр хөгжилтэй холбоотойгоор тус салбарт хөдөлмөр эрхлэлт нэмэгдэхээ больж эхлээд зогсонги байдалд орсноо улмаар буурч эхэлсэн юм.

1970-аад он: Аж үйлдвэрлэлийн салбарт хөдөлмөр эрхлэгсдийн тоо буурч эхэллээ.

Харин ахуй үйлчилгээний салбарын эрэлт нэмэгдэж эхэлсэн юм. 1970-аад оны үеэс ахуй үйлчилгээний салбарын ач холбогдол дээшилж эхэлснийг тус салбарын ажиллагсдын тоо нэмэгдсэн нь давхар нотолж байгаа юм. Германд тус ахуй үйлчилгээний салбарын өсөлт аж үйлдвэрийн салбарын бууралтын ард анзаарагдалгүй үлдэж байна. Иймээс ахуй үйлчилгээний салбарын хөгжлийг нухацтай авч үзэх шаардлагатай. Эцэст нь хэлэхэд 20-р зууны эхний хагаст дээрхтэй төстэй шилжилт явагдсан билээ: Хөдөө аж ахуйн салбараас аж үйлдвэрийн салбарт шилжих шилжилт. Тэгвэл эдгээр өөрчлөлтийн үйл явц хоорондоо юугаараа ялгаатай юм бэ?

Ахуй үйлчилгээний салбарын ач холбогдол дээшилж эхлэв.

Ахуй үйлчилгээ олон янз. Зарим ахуй үйлчилгээ зөвхөн компаниудад зориулагддаг бол зарим нь зөвхөн айл өрхүүдэд зориулагддаг. Зарим ахуй үйлчилгээнд өндөр мэргэжлийн ажиллагсад шаардагддаг бол заримд нь мэргэжлийн ур чадвар төдийлөн шаарддаггүй энгийн үйлчилгээ байдаг. Ажиллах хүчнийг ихээр шингээдэг ахуй үйлчилгээний бүх төрөлд бүтээмжийг нэмэгдүүлэх боломж нь хязгаарлагдмал байдаг нэгэн нийтлэг шинж байдаг. Хэдийгээр үйлчлэгч, эмч, асрагч, эсхүл багш нар нэгэн зэрэг олон зочид, өвчтөн, сурагчдад үйлчлэх боломжтой ч ахуй үйлчилгээний чанарын асуудал тэр даруйдаа тавигдаж эхэлдэг.

Ажиллах хүчнийг олноор нь шингээдэг ахуй үйлчилгээний салбарын бүтээмжийг зөвхөн хязгаарлагдмал хэмжээгээр нэмэгдүүлэх боломжтой.

Ажиллах хүчнийг олноор нь шингээдэг ахуй үйлчилгээний бүтээмжийг боловсруулах аж үйлдвэрийн салбартай ижил хэмжээнд дээшлүүлэх боломжгүй. Цалин нэмэгдэхтэй зэрэгцээд үнэ буурдаг “алтан үе” өнөө дахин давтагдахгүй. Аж үйлдвэрийн салбарт ажиллагсдын цалин

11 1990 оныг хүртэл Холбооны герман улсын газар нутаг дээр, 1950-1959 он хүртэл Берлин, Саарландыг оруулалгүйгээр тооцсон.

нэмэгдэхэд төдийлөн мэргэжлийн ур чадвар шаардаад байдаггүй ахуй үйлчилгээний салбарт ажиллагсдын тоо буурдаг.

*Цалингийн тэгш
бус байдал
нэмэгдсээр:
Ажлын байр үгүй
болох уу?*

Сүүлийн жилүүдэд эрчимтэй ажиглагдаж буй нэгэн үзэгдэл болох цалингийн зөрүү буюу тэгш бус байдлыг цаашид улам нэмэгдүүлэх нэгэн хувилбар байж болох юм. Цалингийн зөрүү нэмэгдэж байгааг шударга ёсны шаардлагын үүднээс авч үзвэл зөвтгөх үндэслэл бараг байхгүй. Бүтээмжийг нэмэгдүүлэх боломж хязгаарлагдмал байгаа нь ажиллагсдын бүтээмж доогуур байгаагаас бус харин тус салбарын хөдөлмөрийн онцлог шинж чанартай холбоотой. Цалингийн тэгш бус байдал нэмэгдэх эсхүл ажлын байр үгүй болох хоёр хувилбарын аль аль нь хүсээд байх шийдэл биш юм.

*Мэргэжлийн болон
дээд боловсрол
тавигдаж буй
шинэ шаардлагууд*

Зөвхөн мэргэжлийн өндөр ур чадвар шаарддаг ахуй үйлчилгээн дээр төвлөрөх гуравдагч хувилбар байж болох юм. Ахуй үйлчилгээний зарим салбарын ажлын байранд мэргэжлийн өндөр ур чадвар шаардагддаг учраас аж үйлдвэрлэлийн салбараас ахуй үйлчилгээнд шууд шилжин ажиллах боломжгүй. Уг хандлага нь өнөө ба ирээдүйд мэргэжлийн болон дээд боловсрол хөдөлмөрийн зах зээл дээр улам чухал үүрэг гүйцэтгэнэ гэдгийг харуулж байна.

*Хөдөлмөр
эрхлэлтийн
шинэ намтар
санхүүжилтийн
сонгодог бүтэц
дээр уулзаж
байна.*

Эдгээр хувьсал, өөрчлөлтүүдийн улмаас зөвхөн боловсрол бус бусад салбаруудын өмнө сорилтууд тулгарч байна. (Боловсрол хэмээх 7.5.-р бүлэгтэй харьцуулж үзнэ үү.) Нийгмийн бодлогын сонгодог салбарууд дээр нэгэн адил дарамт ирж байна. Учир нь ахуй үйлчилгээний салбарын олон ажлын байрууд зөвхөн хязгаарлагдмал хүрээнд хөдөлмөрийн сонгодог хэвийн нөхцөлийг хангаж байна. Хөдөлмөрийн хэвийн харилцаа нь удаан хугацааны хөдөлмөрийн гэрээн дээр суурилдаг, баталгаатай, бүрэн хөдөлмөр эрхлэлтийн ажлын цагийн загвар, тарифын гэрээгээр нормчлогдсон цалин эсхүл хөлс, нийгмийн даатгалын шимтгэл төлөх үүрэг, болон ажил олгогчийн зааварчилгаан доор ажиллах ба ажилтан ажлын цагаар ажил олгогчоос хувь хүний хувьд хараат байх зэрэг шаардлагууд тавигддаг. Гэтэл ахуй үйлчилгээний салбарын хөдөлмөр эрхлэлт эсрэгээрээ ихэвчлэн хагас өдрөөр, бие даасан байдал, эсхүл хугацаатай хөдөлмөрийн гэрээтэй байх нь олонтаа.

*Ур дагавар:
Нийгмийн
баталгаа туйлын
хангалтгүй.*

Нийгмийн хамгааллын олон системүүд урт хугацааны, аль болохоор тасралтгүй хөдөлмөр эрхлэлтийн намтар дээр суурилан зохион

байгуулагдсан байдаг тул (жишээ нь: тэтгэвэр ба ажилгүйдлийн даатгал) нийгмийн найдвартай хамгаалалд байх, тэтгэвэр, ажилгүйдлийн даатгал авах эрх нь хангалтгүй хэрэгжиж байгаа ажилтнуудын тоо нэмэгдсээр байна.

Дээрээс нь ахуй үйлчилгээний салбарын үйлдвэрчний эвлэлийн зохион байгуулалтын зэрэг бусад салбаруудаас доогуур-(салбарын бүх ажиллагсдын дунд үйлдвэрчний эвлэлийн гишүүдийн эзлэх хувь доогуур гэсэн үг) ажилчдын зөвлөл цөөн, олон ажил олгогчид ажил олгогчдын холбооны гишүүн бус байгаа нь нэмэлт хүндрэл үүсгэж байна. Үүний улмаас тарифын гэрээний хамрах хүрээ хязгаарлагдмал, зохих дүрэм журам мөрдөгдөж буй эсэхэд хяналт тавихад хүндрэлтэй байна.

Үйлдвэрчний эвлэлийн зохион байгуулалтын зэрэг буурч тарифын гэрээний хамрах хүрээ хумигдаж байна.

Бүтцийн хувьсалаас үүдэлтэй олон сорилтууд тулгарч байгаагаас боловсролд илүү өндөр шаардлага тавигдах, хөдөлмөр эрхлэлтийн намтар өөрчлөгдөх, улмаар цалингийн зөрүү нэмэгдэхэд нэрмээс болж байгааг нийтлэг сорилтууд хэмээн нэрлэж болно. Эдгээр хувьсал өөрчлөлтөд нийгмийн бодлогын нэн ялангуяа боловсрол, ажилгүйдэл, тэтгэврийн бодлогын салбар өртөж байна.

Бүтцийн хувьсалд юуны өмнө боловсрол, хөдөлмөр, тэтгэврийн салбар өртөж байна.

5.3. Хүн ам зүйн хувьсал

Нийгэм насжиж байгаа нь баярлууштай үр дагавруудыг авчирч байна. Өнөөгийн хүмүүс урт насалж байна. Шинээр төрсөн хүүхдийн дундаж наслалт хуучин холбооны улсуудад (баруун Германы нутаг дэвсгэр дээр) 1980-2002 оны хооронд эрэгтэйчүүдийнх 69.9-өөс 75.9 болж эмэгтэйчүүдийнх 76.6-аас 81.3 болж тус тус нэмэгдсэн байна.

Хүн амын дундаж наслалт нэмэгдэж байгаа нь баярлууштай үйл явдал:


Хоёрдох шалтгаан нь төрөлт буурсан. Нэн ялангуяа 1965-1975 оны хооронд төрөлт эрчимтэй буурсан. Төрөлт 1990 он хүртэл ялимгүй нэмэгдсэн ч үүний дараагаар 2007 он хүртэл тогтмол буурсаар байна. 2007 оны байдлаар Германд эмэгтэй тус бүрт дунджаар 1.37 хүүхэд ногдож байжээ.

Төрөлт буурсан:

Дээрх хоёр хөгжлийн хандлага давхацсаны улмаас эдийн засгийн идэвхтэй хүн ам ба тэтгэвэрт гарсан иргэдийн харьцаа ирэх жилүүдэд тогтмол буурах нь байна.

Үр дагавар: Насжилтын коэффициент нэмэгдэж байна:

Гүнзгийрүүлэн
унших эх
сурвалжууд:
Эрика Шүлц ба
Анке Ханнеманн,
2050 оныг хүртэлх
Германы хүн амын
хөгжил. Хүн амын
тооны ялимгүй
буурах уу? DIW Долоо
хоногийн тайлан №
47/2007,74



6-р зураг: Насжилтын коэффициентийн хөгжил (1960-2020 он)

Унших жишээ: 1965 онд Германд 20-59 насны 100 хүн тутамд 60-аас дээш насны 35 хүн ногдож байсан бол 2010 онд 60-аас дээш насны 45 хүн ногдож байжээ.

Хүн амын насны харьцааг илэрхийлдэг хэмжээ нь насжилтын коэффициент нь хөдөлмөр эрхлэгсэд ба тэтгэвэр авагсдын харьцааг илэрхийлдэг.

Насжилтын коэффициент нь 60-аас дээш насныхныг 20-59 насныханд харьцуулсан харьцааг илэрхийлдэг.

2005 он: 100
хөдөлмөр эрхлэгч
тутамд 44
тэтгэвэр авагч
ногдож байсан
бол 2020 онд
ойролцоогоор 53
болж өснө.

2005 оны тооцооллоор 100 хөдөлмөр эрхлэгч тутамд 44 тэтгэвэр авагч ногдож байсан бол 2020 он гэхэд энэ тоо 53 болж өснө. Герман улс тэтгэврийн хувиарлалтын тогтолцоотой тул санхүүжилтийн бэрхшээл зайлшгүй тулгарна. Өнөөгийн хөдөлмөр эрхлэгсдийн төлж буй шимтгэлээр улам бүр өсөн нэмэгдэж буй тэтгэвэр авагсдын өндөр насны баталгааг санхүүжүүлэх ёстой. Олон нийтийн дунд өрнөж буй хэлэлцүүлгүүд хөдөлмөр эрхлэгсдийн төлж буй шимтгэлийн хэмжээг нэмэгдүүлэх, тэтгэврийн хэмжээг бууруулах, эсхүл өрийн хэмжээг нэмэгдүүлэх зэрэг хувилбарын эргэн тойронд өрнөж байна.

Дээрх хувьсал, өөрчлөлтүүдийн улмаас хэр том сорилт тулгараад байгаа юм бэ? Насжилтийн коэффициентийн өсөлтийг хувь хэмжээгээр илэрхийлэх юм бол 2005-2020 оны хооронд буюу 15 жилийн хугацаанд 20%-иар нэмэгдэх болно. Жил тутамд 1.4%-иар нэмэгдэнэ. 1993-2008 оны хоорондох 15 жилд германы эдийн засгийн дундаж өсөлт 1,5%-тай тэнцэж байжээ.

Хэр том сорилт тулгараад байгаа юм бэ?

Ирэх 15 жилд ч эдийн засгийн жилийн дундаж өсөлт 1,5%-тай байна гэж үзвэл баялгаас олж буй ашгаасаа тэтгэврийн даатгалд хөрөнгө оруулалт хийх замаар тэтгэврийн хэмжээг бууруулахгүй байх боломжтой. Хэрэв энэ хувилбар биелэгдэх боломж төдийлөн баталгаатай бус гэж үзвэл эдгээр тоонууд тулгамдаад буй сорилтын цар хүрээг харуулж байна. Шинэчлэх шаардлага байгаа гэдэгт бол эргэлзэх хэрэггүй, тэтгэврийн хувиарлалтын тогтолцоо зайлсхийх боломжгүй хямралд орлоо гэж яривал хэт сүржигнэсэн хэрэг болно.

Дүгнэлт: Шинэчлэл шаардлагатай юу гэвэл шаардлагатай, гэхдээ хэт сүржигнэх хэрэггүй.

Нийгмийн насжилтын улмаас зөвхөн төрийн тэтгэврийн тогтолцоо хүндрэлд ороод байгаа юм биш, хүмүүс тэтгэвэрт гарсан хойноо урт насалж байгаа тул эрүүл мэндийн системийн ачаалал нэмэгдэж тэтгэврийн даатгалын нэгэн адил санхүүжилтийн хүндрэл үүсээд байгаа юм. Учир нь эрүүл мэндийн системийн санхүүжилтийн дийлэнх нь өнөөгийн хөдөлмөр эрхлэгсдийн төлж буй шимтгэлээс бүрддэг. Үүний нэгэн адил асрамжийн даатгалын хэмжээ ирээдүйд нэмэгдэх тул энэ нь мөн насжилтийн үйл явцаас гарч буй урьдчилан харах бололцоотой бас нэгэн үр дагавар юм.

Эрүүл мэнд ба асрамжийн системийн өмнө тулгамдаж буй сорилтууд:

2040 онд гэхэд германы хүн ам зүйн хөгжлөөс үүдэлтэй бэрхшээл дээд цэгтээ хүрнэ хэмээн судлаачид таамаглаж байна. Тухайн цаг үед хөдөлмөр эрхлэгчид ба тэтгэвэр авагчдын харьцаа хамгийн тааламжгүй хэмжээнд хүрэх аж. Үүний дараагаар уг харьцаа аажмаар сайжирч хүн амын тоо бүхэлдээ цөөрнө. Ирэх хэдэн арван жилд нэн ялангуяа тэтгэвэр, эрүүл мэндийн даатгал санхүүжилтийн томоохон хүндрэлд орох нь тодорхой болоод байна.

2040 онд уг хөгжил дээд цэгтээ хүрнэ.

Ард түмний орлогын нэмэгдлийн тодорхой хэсгээр нийгмийн системд хөрөнгө оруулалт хийхийн зэрэгцээ хүн амын ихээхэн хэсэг нь шимтгэлээ төлсөн нөхцөлд дээрх сорилтуудыг даван туулах бүрэн бололцоотой. 7.3 (Тэтгэвэр), 7.4 (Эрүүл мэнд) бүлгээс нийгмийн насжилтын улмаас тулгамдаж буй сорилтуудад хариу үйлдэл үзүүлэх боломжуудын талаар дэлгэрэнгүйг уншаарай.

Шийдэл: ард түмний орлогын нэмэгдлээр нийгмийн системд хөрөнгө оруулалт хийх-Нарийвчилсан мэдээллийг 7.3 ба 7.4 –р бүлгээс уншина уу.


5.4. Нийгмийн хувьсал

Амьдралын
төсөөлөл олон
талтай болж илүү
их эрх чөлөөтэй,
өөрийн хүслээр
амьдрах болжээ.

Гүнзгийрүүлэн унших
эх сурвалжууд:
Ульрих Век, Елизавет
Век-Гернхайм
(1994он) Эрсдэлтэй
эрх чөлөө, Орчин
үеийн нийгэм дэх
хувь хүмүүсийн бие
даасан байдал, Орчин
үеийн нийгэм сэтгүүл,
Франкфурт ам Майн
Томас Майер/Зиеген
(1992 он) Орчин
цагийн хувь хүмүүс:
Гэр бүлийн хамтын
амьдралын харилцан
адилгүй байдал
ба хувь хүмүүсийн
бие даасан байдал
Опладен

Дээр дурьдсан эдийн засгийн бүтцийн өөрчлөлтүүдийн зэрэгцээ өнгөрсөн хэдэн арван жилийн туршид явагдсан хүн амын насны бүтцийн өөрчлөлтийн улмаас хүмүүсийн үнэлэмж, амьдралыг үзэх үзэл өөрчлөгдсөн байна. Өнөөгийн амьдралын хэлбэр маяг, төсөөлөл 50,100 жилийн өмнөхөөс өөрчлөгджээ. Хүмүүсийн амьдралд нийгмийн конвенцууд төдийлөн нөлөө үзүүлэхээ байжээ. Хувь хүмүүсийн эрх чөлөө, өөрийн хүслээр амьдрах хандлага нэмэгдсэн байна. Эдгээр хувьсал өөрчлөлтүүд олон талтай бөгөөд эдгээрийг илүү их эрх чөлөө эдлэх боломж хэмээн нийгэм талархан хүлээн авч байна. Дээрх хувьсал, өөрчлөлтүүд амьдралын дадал заншилд хэрхэн нөлөөлж байгааг айл өрхийн гэр бүлийн гишүүдийн тооны хөгжлөөс тодорхой харж болно. 20-р зууны эхэн үед өрхийн стандарт тав ба түүнээс дээш гишүүнтэй байжээ. Нэг гишүүнтэй өрх эсрэгээрээ ховор тохиолдол байлаа. Харин 21-р зууны эхэн үед байдал эсрэгээрээ эргэж нийт айл өрхийн 40 орчим хувийг нэг гишүүнтэй өрх эзэлж байна. Нийт өрхийн дөрөв хүрэхгүй хувь нь дөрвөөс илүү гишүүнтэй байна. (7-р зургийг үзнэ үү.)

Эдгээр тоонуудын ард “өөрийн гэсэн дөрвөн хананы дунд амьдрах буюу өмчлөлийн байртай болох”-ыг илүүд үзэх хандлага огт нэмэгдэхгүй харин ч буурч байна. (Энд байдал эсрэгээрээ эргэжээ. 1972 онд 25 настангуудын ойролцоогоор 20% нь эцэг эхтэйгээ амьдарч байсан бол 2003 онд 30% нь эцэг эхтэйгээ амьдарч байжээ.) (Майер Сиеген 2006 он) Энэ нь төрөлтийн коэффициент буурсан, нөгөөтэйгүүр гэр бүл зэрэг уламжлалт бүтцүүд алдагдаж байгаатай холбоотой.



7-р зураг: 1900-2007 оны хоорондох германы өрхийн хэмжээ

Унших жишээ: 1900 онд бүх германчуудын ойролцоогоор 45% нь тав ба түүнээс дээш гишүүнтэй гэр бүлд, 17% нь дөрвөн гишүүнтэй гэр бүлд, ойролцоогоор 17% нь гурван гишүүнтэй гэр бүлд, 15% орчим нь 2 гишүүнтэй гэр бүлд, 7% орчим хувь нь ганцаараа аж төрж байжээ. Өнөөдөр германчуудын 40 орчим хувь нь ганцаараа аж төрж байна.

1960 оноос хойш гэрлэлтийн тоо тогтмол буурсаар байна. Өдгөө үр хүүхэдтэй олон хосууд албан ёсны гэрлэлтгүйгээр хамтран амьдарч байна. Өмнө нь хамтран амьдрагчдыг “зэрлэг гэр бүл” хэмээн дооглонгуй өнгө аястай тэднийг нэрлэдэг байлаа. Үүний зэрэгцээ 1960 оноос хойш гэр бүл салалтын тоо тогтмол нэмэгдсээр байна.

Гэрлэлтийн тоо буурч байна.

Гэрлэлт ба гэр бүл салалтын тоо (1960-2005 он)

Он	Гэрлэлт 1000 хүн ам тутамд	Гэр бүл салалт
1960	9,4	1,0
1970	7,4	1,3
1980	6,3	1,8
1990	6,5	1,9
1995	5,3	2,1
2000	5,1	2,4
2005	4,7	2,4
2010	4,7	2,3

Германы нийгмийн баримжаат төрийн олон салбар өрхийн тэргүүлэгч эр хүн гэр бүлээ тэжээнэ гэдэг гэр бүлийн уламжлалт загвар дээр суурилсан учраас дээр дурьдсан өөрчлөлтүүдэд хараахан бэлтгэлгүй байна. Ялангуяа тэтгэврийн даатгалын салбарт бэлтгэлгүй байна. Тэтгэврийн даатгалд тэтгэврийн хэмжээ ба төлсөн шимтгэлийн хэмжээ нь хоорондоо нягт холбоотой учраас хөдөлмөрийн насандаа тогтвортой ажил хөдөлмөр эрхлээгүй, тэтгэврийн насандаа ганцаараа амьдарч буй олон эмэгтэйчүүдийн тэтгэврийг олгоход бэлэн бус. Үүнээс гадна улам бүр тоо нь нэмэгдэж буй өрх толгойлсон, хүүхэдтэй эмэгтэйчүүдийн ядууралд өртөх магадлал нэмэгдсээр байна. 1996 оны байдлаар нэн ялангуяа 18-аас доош насны хүүхдүүдтэй гэр бүлийн зөвхөн 4,8% нь өрх толгойлсон

Бэрхшээл: Өрхийн тэргүүлэгч эр хүн гэр бүлээ тэжээнэ гэдэг логик дээр суурилсан

эцэг, эхийн гэр бүлд хүмүүжиж байсан бол 2007 онд энэ үзүүлэлт 7% болж өссөн байна. Өрх толгойлсон ганц бие өрхийн 90 орчим хувь нь өрх толгойлсон эмэгтэйчүүдийн гэр бүл байна. (өрх толгойлсон эцэг ба эхчүүдийн холбооны 2008 оны мэдээлэл)

Өрх толгойлсон эцэг, эхчүүдийн ядууралд өртөх магадлал хамгийн өндөр байна.

Өрх толгойлсон эцэг ба эхчүүдийн ядууралд өртөх магадлал хамгийн өндөр байна. Германд хүүхэдтэй гэр бүлийн ядууралд өртөх магадлал илүү өндөр бөгөөд өрх толгойлсон эцэг, эхчүүдийн хувьд илүү өндөр гэдгийг 8-р зургаас харж болно.

Ядууралд өртөж болзошгүй эмзэг байдлын квот нь хүн амын дундаж орлогын 60%-иас доош орлоготой хүмүүсийн квот юм. Энэ тохиолдолд дундаж орлого нь нийт орлогын дундаж бус харин дундаж орлогын дундаж үзүүлэлт юм. Өөрөөр хэлбэл дундаж орлогын дундаж хэмээх энэ үзүүлэлтийн дагуу хүн амын тэн хагас нь энэ үзүүлэлтээс дээгүүр, нөгөө хагас нь энэ үзүүлэлтээс доогуур орлоготой гэсэн үг.

Гэр бүл ба хөдөлмөр эрхлэлтийг хослуулах боломж, дэлгэрэнгүйг 7.5-р бүлгээс уншина уу.

Ядууралд өртөх эрсдэлийг бууруулахын тулд юуны өмнө гэр бүл, хөдөлмөр эрхлэлт ба хүүхдийн хүмүүжлийг хослуулах боломжийг сайжруулах нь нэгэн чухал шийдэл юм. Энэ асуултын хариултыг Боловсролын бодлого хэмээх 7.5-р бүлгээс уншина уу.


Ихэвчлэн ахимаг насныхан тэд дундаа эмэгтэйчүүд ядуу байна.

Нийгмийн хувьсал ахимаг настангуудын орлогын байдалд муугаар нөлөөлж байна. Нийт хүн амын дунд ганцаараа аж төрдөг хүмүүс ядууралд илүү өртөж байна. 2002 оны байдлаар 65-74 насны ганцаараа аж төрдөг иргэдийн 26,8% нь дундаж орлогын 60%-иас доогуур орлоготой байсан бөгөөд эмэгтэйчүүдийн квот 29,3%-тай байжээ. Өрх толгойлсон эмэгтэйчүүд, тэр дундаа ахимаг насны эмэгтэйчүүдийн орлогын байдал илүү хүнд байна.

Өндөр насны ядууралд өртөх эрсдэл

Настайчууд хоёр гишүүнтэй өрхөд амьдарч байгаа нөхцөлд нийт хүн амын дундаж орлоготой ойролцоо хэмжээний орлоготой байдаг. Татвараас санхүүжүүлдэг тэтгэврийн доод хэмжээг нэмэх замаар өндөр насны ядуурлаас сэргийлэх нэгэн боломж байж болох юм. Дэлгэрэнгүйг тэтгэвэр хэмээх 7.3-р бүлгээс уншина уу.

Унших жишээ: Хоёр насанд хүрэгчдийн гэр бүлд нэг хүүхэд амьдарч байгаа нөхцөлд ядууралд өртөх эмзэг байдлын квот нь ойролцоогоор 8% байдаг. Нэг насанд хүрэгч 3 хүүхэд хүмүүжүүлж байгаа нөхцөлд хүүхдүүдийн ядууралд өртөх эмзэг байдлын квот 42% хүртэл нэмэгддэг. Энэ тохиолдолд 100 хүүхэд тутмын 42 нь дундаж орлогын дунджийн 60%-иас бага орлогоор амьдрах ёстой гэсэн үг юм.



8-р зураг: 18-аас доош насны хүүхдүүд ба гэр бүлийн хэлбэрийн дагуу ядууралд өртөх эмзэг байдлын коэффициентийг харуулсан байдал, 2005 оны байдлаар

Энэ нь нийгмийн ардчилалд юу гэсэн үг бэ?

- Даяаршил, эдийн засаг ба хөдөлмөрийн салбарт явагдаж буй бүтцийн хувьсал, хүн ам зүйн хөгжил ба нийгмийн хувьсалын улмаас германы уламжлалт нийгмийн баримжаат төрд шинэ сорилтууд тулгарч байгаа боловч эдгээр сорилтуудыг даван туулах боломжтой юм.
- Германы нийгмийн баримжаат төрийн байгуулал нь өрхийн тэргүүлэгч эр хүн нь ганцаараа хөдөлмөр эрхэлж гэр бүлээ тэжээдэг уламжлалт консерватив гэр бүлийн загвар дээр суурилсан хэвээрээ, хоёрдугаарт санхүүжилт ба нийгмийн үйлчилгээ, тэтгэвэр тэтгэмжийн хэмжээ ихэвчлэн хөдөлмөр эрхлэлтийн статусыг хадгалахад чиглэдэг учраас эдгээр бэрхшээлүүд тулгарч байгаа юм.
- Олон төрлийн сорилтуудад нийтлэг бус харин сорилт тус бүрт тохирсон хариултыг өгөх шаардлагатай байгааг дараагийн бүлгүүдэд тайлбарлах болно. Тулгамдаж буй сорилтуудыг нийтэд нь авч үзвэл амжилтанд хүрсэн социалдемократ нийгмийн баримжаат төртэй орнуудаас үлгэр жишээ авч тэр чиглэлд шинэчлэлийг хийх нь зүйтэй мэт харагдаж байна. Энэ нь иргэдийн тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээг хөдөлмөр эрхлэлтийн статустай нь холбож өгөхийн оронд иргэнд илүү чиглүүлж шимтгэлээс санхүүждэг тогтолцооны татвараас санхүүждэг хэсгийг нэмэгдүүлэх замаар шинэчлэлийг хийнэ гэсэн үг юм.

6. УЛС ТӨРИЙН НАМУУДЫН НИЙГМИЙН БОДЛОГЫН ТАЛААР БАРИМТАЛЖ БУЙ БАЙР СУУРЬ

Товиас Гомберт

Энэхүү бүлэгт Бундестагт суудалтай улс төрийн намуудын хөтөлбөрийг:

- Намуудын нийгмийн бодлогын үндсэн зарчмуудыг харьцуулна.
- Нийтийн сайн сайхны төлөөх төрийн гурван үндсэн загварын дагуу эрэмбэлнэ.
- Намуудын хөтөлбөртөө үндэслэл болгон авсан шударга ёсны төсөөллийг танилцуулна.

*Намуудын
хөтөлбөр:
ирээдүйн амлалт*

Намуудын хөтөлбөр бол ирээдүйн өмнө авч буй амлалт юм. Намууд ирээдүйг ингэж төсөөлбөл иргэдээсээ хамгийн их дэмжлэг авна хэмээн үзсэн тодорхой төсөөллөө дэвшүүлж уг төсөөллөө биелүүлэхийн төлөө ажиллахаа амладаг. Эдгээр амлалтууд нь намуудын сонгогчиддоо хүлээн зөвшөөрөгдсөн итгэл үнэмшил, улс төрийн намуудын орон зайд тухайн намын эзэлж буй байр суурьтай нийцэж байж дэмжлэг авдаг. Намууд өнгөрсөн ба ирээдүйд дүн шинжилгээ хийж хүмүүсийн хүсэн хүлээж байгаа ирээдүйн сайн сайханд хүргэж чадах, биелэгдэх боломжтой хөгжлийн замыг итгэл үнэмшил төрүүлэхүйц тод томруунаар дүрсэлж чадсан тохиолдолд сонгогчдынхоо дэмжлэгийг авдаг. Намууд ард иргэдийн хүсэн тэмүүлж буй ирээдүйг, ирээдүйд хүргэх замынх нь хамт тод томруун зурж хүлээн зөвшөөрөгдөх хэмжээнд хөтөлбөрөө боловсруулж чадсан нөхцөлд хөтөлбөр нь тэдний зүгийг заагч луужин нь болдог.

*Харьцуулалтын
ямар масштабыг
хэрэглэх бэ?*

Нийгмийн бодлого ямар урьдчилсан нөхцөлүүдийг хангасан нөхцөлд хэрэгжих бэ? гэдгийг хэр тодорхойлж чадсан бэ? гэдгээр үнэлэгддэг. Юуны өмнө консерватив болон либерал намууд нийгмийн бодлогыг улс төрийн үйл ажиллагааны маш явцуу орон зайд тодорхойлж өөрийн буруугаас биш зөвхөн бусдын буруутай үйл ажиллагааны улмаас хүнд байдалд орсон хүмүүсийн баталгааг тодорхой цаг хугацаанд хангахад чиглүүлдэг бол зүүн төвийн намуудын нийгмийн бодлого нь нийгмийн нөөцийн дахин хувиарлалтаар дамжуулан (Боломж) тэгш байдлыг урт хугацаанд хангахад чиглэсэн өргөн хүрээт бодлогын шийдэл юм. Нийгмийн ардчиллын онолын үүднээс (Майер, Дортмунд 2006 ба Нийгмийн ардчиллын сурах бичгийн 1-р дэвтэр) улс төрийн намуудын нийгмийн бодлогын шийдлүүдийг

тайлбарлахын тулд эхлээд бодлогын арга хэрэгслүүдийн тухай ойлголтууд, масштабыг нэрлэх ёстой. Үүний тулд эхлээд тухайн нам нийгмийн баримжаат төрийн ямар төсөөллийн дагуу нийгмийн бодлогоо хэрэгжүүлэхийг хүсэж байгаа эсхүл нийгмийн баримжаат төрийг хэрхэн цаашид хөгжүүлэх хүсэлтэй байгааг нь тодорхойлохын тулд дүгнэлт хийх масштабыг товч нэрлэх хэрэгтэй.

Энэ тохиолдолд Эспринг-Андерсоны тодорхойлсон капитализмын гурван үндсэн хэв шинж, тэдгээрийн нийтийн сайн сайхны төлөөх төрийн онцлог, тэдгээрийн онцлог шинжийн илэрхийлэл болсон шударга ёсны ойлголтыг масштаб болгон хэрэглэсэн байдаг. Үүнд:

- Континентал буюу эх газрын европын консерватив хэв шинж
- Ангелсаксоний либерал хэв шинж
- Скандинавын социалдемократ хэв шинж

Капитализмын хэв шинжийн талаархи дэлгэрэнгүй тайлбар тэдгээрийн үндэслэл болгон авсан шударга ёсны төсөөллүүдийн талаар энэ номын 4-р бүлэгт байгаа.

Намуудын хөтөлбөрийг дараагийн бүлгүүдэд энэ загварын үндсэн дээр судалж үзэх бөгөөд улс төрийн намууд германы өнөөг хүртэл замнаж ирсэн “эх газрын европын-консерватив хэв шинжит нийтийн сайн сайхны төлөөх төрийн” хөгжлийн замналаар цаашид ямар хугацаанд замнахыг хүсэж байна?, уг замналыг эргэн харах, эсхүл өөрөөр хөгжүүлэхийг хүсэж байна уу? Ингэснээр улс төрийн намууд нийгмийн шударга ёсны талаархи ямар төсөөллийг хэрэгжүүлэхийг хүсэж байна гэдгийг судлах болно.

6.1. Германы хөгжлийн ерөнхий зарчмууд-Христосын Ардчилсан Холбоо Намын /ХАХН/-ын хөтөлбөр

ХАХН 2007 онд мөрийн хөтөлбөрөө шинэчлэн баталсан. Хөтөлбөрийн цөм нь “Нийгмийн баримжаат зах зээлийн эдийн засаг”-ийг амжилтанд хүргэх ирээдүйн хөгжлийн загвар хэмээн үзсэн бөгөөд “ХАХН нь нийгмийн баримжаат зах зээлийн эдийн засгийн төлөөх нам./.../ ХАХН коллективизмын социалист болон бусад хэлбэрүүдээс татгалзана. Манай эрин үеийн нийгмийн асуудлуудад хариулт өгөх чадамжгүй, зах зээлд бүхнийг даатгасан, хазааргүй капитализмаас нэгэн адил татгалзана. Нийгмийн баримжаат зах зээлийн эдийн

*Харьцуулалтын масштаб:
Нийгмийн баримжаат төрийн хэв шинжүүд, дэлгэрэнгүйг 4-р бүлэгт*

Хөгжлийн ямар зам, шударга ёсны ямар төсөөллийг үндэслэл болгон авсан бэ?

ХАХН “нийгмийн баримжаат зах зээлийн эдийн засаг”-ийг хэрхэн тайлбарлав?

засаг нь дахин нэгдсэн герман улсад , даяаршлын эрин үед бидний эрхэм зорилго хэвээрээ байх болно.” (46-р хуудас)¹²

Нийгмийн
баримжаат төр
биш харин
нийгмийн
баримжаат зах
зээлийн эдийн
засаг нь ХАХН-ын
үндсэн ойлголт
мөн.

Нийгмийн баримжаат төрийн тухай ойлголт нь “Нийгмийн баримжаат зах зээлийн эдийн засаг”-ийн ойлголттой нэгэн зэрэг хэлэгдэж байх болно. Нийгмийн баримжаат төр нь зах зээлийг тэнцвэржүүлэгч, засварлагч нь бөгөөд зах зээлийн эдийн засгийг нийгмийн баримжаат зах зээлийн эдийн засаг болгон хөгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэсэн билээ. “Нийгмийн баримжаат төр түүхэн үүргийг гүйцэтгэсэн. Нийгмийн баримжаат төрөөс татгалзах боломжгүй юм. Германы нийгмийн хамгааллын системүүдийг бүрдүүлэхэд ХАХН голлох үүргийг гүйцэтгэсэн. Эв санааны нэгдэлийн зарчим дээр суурилсан системээр амьдралын эрсдэлүүдээс хамгаалагдсанаар хүмүүсийн аюулгүй байдал хангагдсан. Нийгмийн аюулгүй байдал нь хангалуун чинээлэг амьдрал, нийгмийн энх тайван, оролцоог авчирсан. Нийгмийн хамгааллын системүүдийг ирээдүйд ч үүргээ гүйцэтгэх чадамжтай байлгахын тулд өөрчилж улам боловсронгуй болгох шаардлагатай. “Идэвхтэй” нийгмийн баримжаат төрийн зорилго нь хүн бүрийг өөрт байгаа боломжийнхоо хэрээр идэвх санаачилгатай байж өөрийнхөө өмнө хариуцлагаа хүлээх чадвартай болгоход чиглэгдэнэ. (60-р хуудас) Энэ утгаараа ХАХН-ын үндсэн ойлголт нь нийгмийн баримжаат төр бус харин нийгмийн баримжаат зах зээлийн эдийн засаг юм.

Сувсидар зарчим

“Коллективизм”-аас татгалзсаны дараагаар сувсидар зарчим (сувсидар зарчмын Христосын шашны үндэслэл: Штегман/Лангхорст 2005 он, 610-р тал)-ыг хэрэглэх болсон юм. “Эрх чөлөө хүмүүст өөрийн амьдралын өмнө хариуцлага хүлээх боломжийг олгодог, нөгөө талаас хүмүүс эрх чөлөөгөө эдэлнэ гэдэг нь өөрийн хүссэнээр амьдарна гэсэн үг. Ийм ч учраас нийгмийн амьдралыг сувсидар зарчмын дагуу эмхлэн байгуулах хэрэгтэй. Иргэн өөрөө, гэр бүлийнхээ хүрээнд, бусадтай сайн дурын харилцаан дээр хамтран илүү сайн хийж чадах зүйлийг иргэнд, иргэдэд өөрт нь үлдээх хэрэгтэй. Зөвхөн иргэд дангаараа эсхүл засаг захиргааны тухайн нэгж дангаараа гүйцэтгэж чадахгүй, хүчин хүрэлцэхгүй үүргийг л дээд шатны байгууллагууд гүйцэтгэх ёстой. Сувсидар ерөнхий зарчим нь нийгмийн жижиг болон том нэгжийн хооронд, эсхүл чөлөөт

12 Намуудын хөтөлбөрт өгөгдсөн хуудасны дугаар нь намын мөрийн хөтөлбөрийн эх бичгийн хуудасны дугаар юм.

эвсэл холбоод болон төрийн байгууллагуудын хооронд нэгэн адил мөрдөгдөх ёстой. Нийгмийн бодлогын шаардлагууд хувь хүмүүс болон нийгмийн жижиг нэгжүүдийн боломжоос давсан нөхцөлд нийгмийн томоохон нэгжүүд, мөн төрийн түвшин ажиллаж эхлэхийг сувсидар зарчим шаардаж байдаг. (7-р хуудас)

Сувсидар ерөнхий зарчим нь зөвхөн нийгмийн баримжаат зах зээлийн эдийн засагтай нийгэмд хэрэгжих боломжтой. "Нийгмийн баримжаат зах зээлийн эдийн засаг бол өрсөлдөөний байгуулал мөн. Нийгмийн баримжаат зах зээлийн эдийн засгийн бодлого бол байгууллын бодлого мөн. Нийгмийн баримжаат зах зээлийн эдийн засаг нь компаниудын бүтээмжийг дэмждэг, эрх чөлөөт орон зайг нээж өгч хүн амд нийгмийн үйлчилгээ болон ахуй үйлчилгээний өргөн сонголтыг бүрдүүлж өгдөг. Нийгмийн баримжаат зах зээлийн эдийн засаг хүн бүрт зах зээл дээр өөрийн хариуцлагаар үйл ажиллагаа эрхлэх боломжийг бүрдүүлж өгдөг. Өрсөлдөөний нөхцөлүүдийг баталгаатай байлгах чадамжтай төр нь иргэн бүртээ өөрийн хариуцлагын дор зах зээл дээр үйл ажиллагаа эрхэлж орлого олох боломжийг бүрдүүлж өгдөг. Мөн үйлдвэрлэл эрхлэх болон гэрээ байгуулах эрх чөлөө, зах зээлийн саад бэрхшээлээс хамгаалах хамгаалалт, зах зээлд ноёлж буй компаниуд эрх мэдлээ буруугаар ашиглахаас хамгаалах хамгаалалт, зах зээлийн ил тод, нээлттэй байдал зэрэг нь нийгмийн баримжаат зах зээлийн эдийн засгийн баталгаа нь болж өгдөг. Нийгмийн баримжаат зах зээлийн эдийн засагт өмчийн хамгаалал нь өмчийг олон нийтэд ашигтай байлгах, өмчид ногдсон нийгмийн үүргээ биелүүлэхэд баталгаа нь юм. (49-р хуудас)

Нийгмийн баримжаат зах зээлийн эдийн засаг нь бүтээмжийн шударга ёс дээр суурилдаг, бүтээмжийн зөрүүтэй байдал нь нийгмийн баялгийг бүрдүүлдэг мотор буюу хөдөлгөгч хүч нь гэж үздэг. (20,48-р хуудастай харьцуулан уншина уу.) Нийгмийн баримжаат зах зээлийн эдийн засгийн бодлого нь төр төвтэй бус харин хүн төвтэй эдийн засгийн байгуулал бөгөөд цаашид ч энэ хэвээрээ байх болно.

Бүтээмжийн шударга ёс ба хувийн хариуцлагыг үндэслэл болгон авсан учраас ХАХН нийгмийн даатгалын системийг хоёр чиглэлд өөрчлөн байгуулах зорилтыг дэвшүүлж байгаа юм. Нэг талаас бүтээмжийн шударга ёс ба хувийн хариуцлага нь нийгмийн хамгааллын орлогын эх үүсвэрийг бүрдүүлэгч хөдөлмөрөөс хараат байдлыг сулруулах,

Сувсидар зарчим нь бүтээмжийн шударга ёстой эерэг холбоотой.

нөгөө талаас төр үндсэн хангамжийг баталгаажуулахын зэрэгцээ хувь хүмүүсийн хувийн хариуцлагыг дээшлүүлэхийг шаардаж байдаг. (60-62-р хуудас)

Дээрх шаардлагын дагуу ажилчид нэмэгдэл үйлчилгээ авахын тулд түрийвчнийхээ хэмжээгээр хувийн даатгалд даатгуулах хэрэгтэй болж байгаа юм. Харин үндсэн хангамжаас давсан үйлчилгээ авахын тулд хувийн даатгалд даатгуулах ёстой гэж үзсэн тул ажил олгогчийн нийгмийн даатгалд төлдөг шимтгэл буурна гэсэн үг.

Ингэснээрээ ХАХН эх газрын Европын консерватив хэв шинжийн нийгмийн баримжаат төрийг либерал хэв шинжит нийгмийн баримжаат төрийн загвар луу өөрчлөн байгуулах оролдлогыг хийсэн байна.

Зах зээлийн эдийн засагтай харьцах төрийн үүргийг либерал ойлголтын үндсэн зарчмууд руу чиглүүлсэн ч христийн шашны үнэлэмжийн үүднээс зохицуулалтын зарим нэгэн бүрэлдэхүүн хэсгээс зууралдсан хэвээр байна.

ХАХН-ын өөрчлөлтийн саналууд:

- Хөдөлмөр/Эдийн засаг: Нийгмийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээг бууруулах замаар (зөвхөн ажил олгогчийн ачааллыг хөнгөвчлөх) цалингийн нэмэлт зардлуудыг бууруулах, ба ажилчид сайн дурын нэмэлт даатгалыг дангаараа төлөх (нийгмийн хамгааллын зардлыг ажилтнуудад дангаар нь үүрүүлэх)
- Эрүүл мэнд: Жишээ нь: Урамшууллын системийг нэвтрүүлэх
- Боловсрол: Бүтээмжийн шударга ёсны зарчим дээр түлхүү суурилсан байх
- Татварын (цалин)-гийн ачааллыг бууруулах, нийгмийн баримжаат төрийн үйлчилгээний зардлын санхүүжилтэд татварын санхүүжилтийг нэмэгдүүлэх

6.2. ЧАН-ын “Виесбадений ерөнхий зарчмууд”

ЧАН нь Бундестагт суудалтай улс төрийн таван намын дунд хамгийн хуучны мөрийн хөтөлбөртэй нам юм. ЧАН нь мөрийн хөтөлбөрөө 1997 онд “Виесбадений ерөнхий зарчмууд” нэртэйгээр баталсан. ЧАН-ын либерализмыг тууштайгаар үзэл онолын үндэслэл

болгосноороо бусад намуудаас онцлог. Ч.А.Н. гэдэг нь зохион байгуулалттай либерализмын нам гэсэн үг бөгөөд ухаалаг бодлого, олон талт байдал, өрсөлдөөнийг эрхэмлэдгээрээ бусад улс төрийн намуудаас ялгардаг, төрийг дээдлэх, төрийн оролцоог хэрэгжүүлэх замаар дэвшилд хүрэхийг зорьдог. (6-р хуудас).

ЧАН нь төрийн үүрэг ролийг хамгийн их шүүмжилдэг хэрнээ төрийн үүргийг бодлогын шийдлээ хэрэгжүүлэх үндсэн арга хэрэгсэл гэж үздэг. “Хүнд сурталтай төрийн эдийн засаг” (14-р хуудас) нь “хүнд суртлын аппарат”-аараа дамжуулан эдийн засаг ба нийгмийн чөлөөт, уян хатан хөгжил дэвшилд саад тотгор учруулдаг. “Либералчууд нийгэм ба экологийн хамгийн сайн зорилтод чиглэсэн төрийн эдийн засгийн оронд, нийгэм ба экологийн хамгийн сайн үр дүнг авчрах зах зээлийн эдийн засгийг байгуулахыг зорьж байна. (6-р хуудас) Либералчууд эхлээд эдийн засгийн бүтээмжийн чадавхийг (төрийн хөндлөнгийн оролцоо ба ашиг сонирхлын бүлгүүдийн эрх мэдлийн картелуудыг арилгах замаар) бүрдүүлчихээд дараагаар нь “нийгмийн бүтээмжийн чадавхийг” бүрдүүлнэ хэмээн үздэг. (14-р хуудас)

Өмч хөрөнгийг хувьчлах шаардлагыг үндсэн хуульд тусгаж улмаар бүх төрлийн сонгон шалгаруулалтад нийтийн болон хувийн компаниуд харьцуулж болохуйц санал өгсөн нөхцөлд хувийн эдийн засагт давуу эрхийг олгох санааг мөн хуульчлахыг шаардсан байна. (30-р хуудас) ЧАН-ын эрхэм зорилго нь “нийгэм ба экологийн баримжаатай зах зээлийн эдийн засаг”-ийг байгуулах явдал. Гэхдээ ЧАН эрхэм зорилгоо ХАХН, Хобоотон90/ Ногооны нам-аас өөрөөр тодорхойлсон байдаг. ЧАН юуны өмнө социалдемократуудтай илт сөргөлдөж эрс ухралтыг хийсэн байдаг. “Социалдемократ нийгмийн сайн сайхны төлөөх төр хүн бүрт бага багыг хүртээдэг бол либерал хэв шинжит нийгмийн баримжаат төр нь нийгмийн халамж үйлчилгээг зөвхөн ядуу иргэдэд чиглүүлнэ.” гэжээ. (21-р хуудас) Тэдний санал болгож буй уг бодлогын хувилбар яаж хэрэгжих, эмзэг байдлын үнэлгээг хэрхэн зохион байгуулах талаар үг цухуйлгаагүй орхисон байна.

ЧАН нь зах зээл төвтэй бодлогын шийдлийг санал болгосон ч харин нийгмийн баримжаат төрийг бүхэлд нь үгүйсгээгүй гэдгийг мөрийн хөтөлбөрийн “либерал хэв шинжит нийгмийн баримжаат төр” бүлгээс харж болно. Нийгмийн баримжаат төрийн бодлогыг

*Төрийн үүрэг:
Үндсэн шүүмжлэл
ба бодлогын
үндсэн шийдэл*

*“Төрийн
хөндлөнгийн
оролцоо”-ноос
татгалзах*

*Нийгмийн
баримжаат төрийн
үүргийг зовлон
нимгэлэхэд
чиглүүлнэ.*

зовлон зүдгүүрт өртсөн хүмүүсийн зовлонг нимгэлэхэд чиглүүлэх аж. “Материаллаг үндсэн баталгаа хангагдсан нөхцөлд л эрх чөлөө хэрэгждэг. Иргэдийн ойлголт, хариуцлага хичнээн дээшилсэн ч тодорхой хүмүүсийн амьжиргааны баталгаажих доод түвшнийг төр хангах хэрэгтэй гэдгийг либералчууд мэддэг” гэжээ. (20-р хуудас) Төр зөвхөн үнэхээр ядуу хүмүүсийн “амьжиргааны баталгаажих доод түвшнийг” хангах аж. (21-р хуудас)

ЧАН-ын нийгмийн бодлогын тулах цэг буюу хүндийн төв нь төрийн нийгмийн бодлогын бүх халамж, үйлчилгээ, тэтгэмжийг иргэний мөнгө болгон нэгтгэнэ. Үүний тулд татварын газар нийгмийн баримжаат төрийн болон татвараас санхүүждэг үйлчилгээг орлогын албан татвартай нэгтгэн тооцоод “орлогын албан татвар нь төрийн үйлчилгээний зардлаас давсан тохиолдолд” бонус олгох аж. Ажилтай байх сонирхлыг нэмэгдүүлэхийн тулд хөдөлмөрийн хөлсний нэгэн хэсгийг иргэний мөнгөнд оруулан тооцно. (21-р хуудас) Энэ нь бага цалинтай салбарт ажиллагсдад үзүүлж буй төрийн дэмжлэг болох аж.

Уг хөтөлбөрт бүтээмжийн шударга ёсыг бүтээмжийг дээшлүүлэх сонирхлыг тэтгэдэг, өндөр хэмжээнд либералчлагдсан нийгмийн баримжаат төртэй холбож өгсөн юм. Англо-Америкийн либерал хэв шинжит нийгмийн баримжаат төрийн загвар луу ХАХН-аас илүү хүчтэй чиглүүлсэн байдал ажиглагдаж байна.

ЧАН-ын өөрчлөлтийн саналууд:

- **Хөдөлмөр/Эдийн засаг:** Иргэний мөнгийг нэвтрүүлэх, бага цалинтай секторыг өргөтгөх, ядуурлын хяналт ба захиргааг сулруулах
- **Эрүүл мэнд:** Хөтөлбөрт тодорхой зүйл байхгүй.
- **Боловсрол:** Төр иргэдийнхээ сурч боловсрох үндсэн эрхийг хангана, хувийн сургалтын байгууллагууд өрсөлдөөнийг хүчтэй болгоно, дүрэм журмыг сулруулна.
- **Татвар:** Татварыг бууруулна, орлогын сөрөг албан татвар, иргэд өөрийнхөө төлөө өөрөө санаа тавьдаг байх ёстой.

6.3. Хамбургийн хөтөлбөр-Германы Социалдемократ Намын мөрийн хөтөлбөр

Германы Социалдемократ Нам (цаашид ГСДН хэмээн товчлох) 2007 онд “Хамбургийн хөтөлбөр” нэртэйгээр мөрийн хөтөлбөрөө баталсан. Уг хөтөлбөр нь өмнөх мөрийн хөтөлбөрүүдийн үргэлжлэл юм. ГСДН-ын Хамбургийн хөтөлбөрт нийгмийн баримжаат төр бол хүмүүсийн оролцоог хангах баталгаа хэмээн үзсэн. “Бүх хүмүүсийн эдийн засаг, соёл, нийгэм, улс төрийн хөгжилд оролцох оролцоог хангах нь социалдемократ бодлогын зорилт юм. Бүх хүмүүсийн оролцоо хангагдах үндсэн баталгаа нь сайн боловсрол, амьжиргааны баталгааг хангах хөдөлмөр ба эрүүл мэнд, мөн хангалуун чинээлэг амьдралын шударга хувиарлалт мөн. Нийгмийн баримжаат төрийн чанар нь мөнгөн тэтгэвэр тэтгэмжийн хэмжээгээр бус харин бүх хүмүүст эхнээсээ эхлээд шинэ эхлэл бүрийн өмнө нээлттэй байх ёстой амьдралын бодит боломжийн баталгаа хэр хангагдсан бэ? гэдгээр хэмжигдэнэ. (58-р хуудас)

Ийм ч учраас “ардчилсан социализм нь бидний хувьд эрх чөлөөтэй, эв санааны нэгдэлтэй нийгмийн алсын хараа бөгөөд ардчилсан социализмыг байгуулах нь бидний байнгын зорилт байсаар байх болно. Бидний үйл ажиллагааны зарчим бол нийгмийн ардчилал.” (16-р хуудас)

Энэ утгаараа нийгмийн баримжаат төр нь ардчилсан нийгмийн цөм нь юм. Нийгмийн баримжаат төр нь бүх хүмүүсийн оролцоог хангах баталгаа мөн. Төрийн хариуцлагыг хэрэгжүүлэхийн тулд төр, зах зээл, иргэний нийгмийн үүргийн хувиарлалтын үндсэн зарчим тодорхой байх ёстой. ГСДН ба ЧАН-ын үүрэг даалгаврын хувиарлалтын үндсэн зарчмуудын талаархи төсөөллийн хоорондоо эрс ялгаатай байна.

Зохицуулагч төртэй байх шаардлага ба төрийн зохицуулалтын хязгаар нь хоорондоо дараахи хоёр чухал хүчин зүйлсээр хязгаарлагдаж байдаг. Нэг талаас зохицуулалтгүй эсхүл хангалттай зохицуулалтгүй зах зээлийн гажуудлыг судалсан. Нөгөө талаас зөвхөн зохицуулагч төртэй идэвхтэй, ардчилсан нийгэмд хэрэгжих боломжтой ардчилсан социализмын зорилтод (16-р хуудас) хүрэхийг эрмэлзэнэ. Гажуудал болон зорилтуудыг нийлүүлээд харахад ГСДН-

Нийгмийн баримжаат төр бол оролцооны баталгаа

Нийгмийн баримжаат төр бол ардчилсан нийгмийн цөм юм.

Зах зээлийн гажуудал ба зохицуулагч төр

ын мөрийн хөтөлбөрийн нийгмийн бодлогын зорилтууд ба цоорхой тодорхой харагдана.

Нийгмийн баримжаат төр нь энэ утгаараа бүх хүмүүсийн иргэний, улс төрийн, эдийн засгийн эрхүүдийг бодит нөлөөтэй байлгах нэгэн арга хэрэгсэл юм. Иймээс нийгмийн баримжаат төр болон нийгмийн баримжаат төрийн тухай уг сэтгэлгээг Хамбургийн хөтөлбөрт улам боловсронгуй болгон хөгжүүлсэн бөгөөд нэг талаас хөдөлмөр ба эдийн засгийн цаашдын хөгжил нөгөө талаас үнэт зүйлсийн хэрэгжилтийн ерөнхий нөхцөлүүдийг хооронд нь байнга дэнслэн үзэж байх шаардлагатай.

Өнөөгийн нийгмийн өмнө тулгамдаж байгаа сорилтуудыг гарааны цэг болгон сонгон авсан. “Бидний хөдөлмөрийн нийгэмд гүнзгий хувьсал явагдаж байна. Инновацийн хурд болон хөдөлмөр эрхлэлтийн олон талт байдал нэмэгдэж байна. Боловсрол ба мэдлэг улам чухал болж шинэ хэлбэрийн бүтээлч мэргэжлүүд бий болж байна. Хугацаагүй хөдөлмөрийн гэрээтэй, тогтмол ажлын цагтай уламжлалт хөдөлмөрийн харилцааны ач холбогдол буурсаар байна. Хөдөлмөрчин хүмүүсийн амьдралд хараат хөдөлмөр эрхлэлт, ажилгүй байх, гэр бүлийн хөдөлмөр, хувиараа хөдөлмөр эрхлэлт зэрэг олон хэлбэрт үе шатууд ээлжилж байна. (9-р хуудас)

Ихэнхдээ албадлагын байдлаар ирдэг эдгээр өөрчлөлтүүд хүмүүсийн даах хэмжээнээс хэтэрч айлгаж байна. Олон хүмүүс бусдаас хараат болох, орхигдох, мартагдах бий гэдэг айдастайгаар аж төрж байна. Улс төрөөс ч мөн адилхан. Төдийлөн өндөр боловсрол эзэмшээгүй, жаахан нас ахисан л бол хүмүүс хөдөлмөрийн зах зээлээс хасагдаж байна. Эмэгтэйчүүд өндөр боловсролтой байсан ч мэргэжлээрээ ахиж дэвших, амьжиргааны баталгааг нь хангах ажилд орох боломжийн хувьд эрэгтэйчүүдээс дутмаг байна. Ажилтай хүмүүс ч байнгын дарамттай, илүү хатуу өрсөлдөөн болон дуудсан цагт нь бэлэн байх шаардлагын дор амьдарч амьдралын чанар нь доройтож байна. (9-р хуудас)

Улам бүр хувьсан өөрчлөгдөж, уян хатан болж буй эдийн засгаас хувь хүмүүст ирж буй дарамт, мөн боломжууд нэмэгдэж байна хэмээн Хамбургийн хөтөлбөр үзэж байна. Эдгээр нөхцөл байдлын дунд шударга нийгэмд эрх чөлөө, тэгш байдал, эв санааны нэгдэл

хэрэгжих ёстой юм бол эрхийг хэрэгжүүлэгч арга хэрэгсэл болох нийгмийн баримжаат төр мөн хувьсан өөрчлөгдөх ёстой. Эдгээр хувьсал өөрчлөлтөнд дасан зохицох шаардлагыг тус хөтөлбөрт “Нийгмийн асуудал үүсэхээс урьдчилан сэргийлэх чадамжтай төр” гэдэг ойлголтоор илэрхийлсэн байна.

Нийгмийн баримжаат төр бол хүчтэй ба хүчгүй, залуу ба хөгшин, эрүүл ба өвчтэй, ажилтай ба ажилгүй, хөгжлийн бэрхшээлтэй ба бэрхшээлгүй хүмүүсийн хоорондох зохион байгуулалттай эв санааны нэгдэл юм. Нийгмийн баримжаат төрийн суурь нь ирээдүйд ч төрөөс баталгаажуулсан нийгмийн аюулгүй байдал, оролцоо, нийгмийн үйлчилгээ хүртэх, тэтгэвэр тэтгэмж авах эрх болон ажилтнуудын эрх нь зөрчигдсөн нөхцөлд заргалдах боломж байсаар байх болно. Хөдөлмөр эрхлэлтийн хэлбэр илүү уян хатан, илүү баталгаазүй болохын хэрээр нийгмийн баримжаат төрийн үндсэн үүрэг илүү чухал болно. Хувьслын эрин үед аюулгүй байдлыг хангах... Асуудлыг урьдчилан харж асуудал үүсэхээс сэргийлэх чадамжтай нийгмийн бодлого амьжиргааны баталгаагаар хангах хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж хүүхдийн хүмүүжил, эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх арга хэмжээнд туслалцаа үзүүлнэ. Асуудлыг урьдчилан харж асуудал үүсэхээс урьдчилан сэргийлэх чадамжтай төр нь хүн ам зүйн хувьслын үр дагаварт зохих харуултыг өгч эмээтэйчүүд ба ахимаг насныхны хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ. Төр нийгмээс тусгаарлагдах байдлыг бууруулж ажил эрхлэх боломжийг нэмэгдүүлнэ. Төр хэнийг ч өөрийнхөө амьдралын өмнө хүлээх хувийн хариуцлагаас нь чөлөөлөхгүй. Асуудлыг урьдчилан харж асуудал үүсэхээс сэргийлэх чадамжтай төр нь боловсролыг нийгмийн бодлогын нэгэн үндсэн элемент гэж үздэг. Төрийн үүнээс илүү чухал үүрэг бол нийгмийн бүх гишүүдийн эв нэгдэлийг хангах. Иймээс нийгмийн асуудал үүсэхээс урьдчилан сэргийлэх чадамжтай нийгмийн баримжаат төр нь эдийн засаг-санхүү-хөдөлмөрийн зах зээл-боловсрол-эрүүл мэндийн бодлого, гэр бүл-хүйсийн тэгш байдлыг хангах бодлого эсхүл цагаач иргэдийг нийгэмдээ нэгтгэх бодлогын төрөл бүрийн үүргийг хооронд нь холбож өгдөг. (56-р хуудас)

“Асуудал үүссэн хойно шийдлийг хайдаг болон асуудлыг урьдчилан харж асуудал үүсэхээс урьдчилан сэргийлэх чадамжтай төр нь германы консерватив хэв шинжийн нийгмийн баримжаат төрийн нэгэн адил статусыг хадгалахад бус харин хүн бүрийн нийгмийн оролцоо, боломж, хүний дайтай амьдрах боломжийг бүрдүүлэх санхүүгийн баталгааг хангахыг зорьдог. Өөрөөр хэлбэл: Хамбургийн хөтөлбөр германы нийгмийн баримжаат төрийг скандинавын-социалдемократ хэв шинжит нийгмийн баримжаат төрийн замналаар цаашид хөгжүүлэхийг зорьж байна. Гэхдээ сонгон авсан хөгжлийн замналд нийцүүлэн өнөөг хүртэл хэрэглэгдэж ирсэн арга хэрэгслүүдийн уялдаа холбоог хангах замаар өөрчлөн байгуулах болно. Дараахи чухал зорилтуудыг товч дурьдвал:

- ГСДН нь ажилтан, ажил олгогчийн тэнцүү санхүүжилтээр санхүүждэг нийгмийн даатгалаар дамжуулан нийгмийн хамгааллын санхүүжилтийг баталгаажуулахыг эрмэлзэх болно.

(58-р хуудас) Гэхдээ нийгмийн даатгалын санхүүжилтийг татварын санхүүжилтээр нэмэгдүүлэх болно. Үүгээрээ ГСДН нь ХАХН, ЧАН-аас эрс ялгаатай. Орлогын бүх төрөл, хэлбэрийг хамруулах, мөн “хөдөлмөр эрхлэлтийн статус”-ыг хэвээр хадгалах бус харин “иргэн”-д чиглүүлэхийг шаардаж байна. (58-р хуудас)

- ГСДН нь эрүүл мэнд болон асрамжийн салбарт орлогын бүх хэлбэрийг хамруулсан, эв санааны нэгдэлийн зарчим дээр суурилсан иргэний даатгалын төлөө байна. (58-р хуудас) Жишээлбэл: Төрийн албан хаагч ба хувиараа хөдөлмөр эрхлэгсэд
- Орон нутгийн бодлогод амьдралын чанар чухал байр суурийг эзэлж байна. Нийгэмшүүлэх ба нийгмийн нэгдэлийг хангах төслүүд, хүүхдийн цэцэрлэг, сургууль, эрүүл мэнд ба спортын байгууллагууд, хотын хэсэгчлэн хөгжүүлэх төслүүдийг нэмэгдүүлэх шаардлагатай. (59-р хуудас)
- Гэр бүлийн бодлогын салбарт хүүхдийн “ амьдрах орчин ба асаргаа халамж”-ийн өмнө хүлээх эцэг ба эхийн тэгш эрхт хариуцлага (65-р хуудас), боловсрол нь хүйсийн тэгш байдал, нийгмийн давхарга хоорондын шилжилт, тэгш боломжийг нэмэгдүүлэх үндсэн ба дэмжигч бүрэлдэхүүн хэсэг мөн гэдгийг онцлон тэмдэглэсэн. (60-р хуудас) үүнтэй холбогдуулан өдөр өнжүүлэхтэй сургуулиудыг орон даяар нэвтрүүлэх, аль болох олон иргэний нийгмийн актёруудыг (хөгжил, соёлын сургууль, спортын холбоод)-ыг оролцуулах замаар бүх хүүхэд, залуучуудыг (эцэг эхийн түрийвчний том жижгээс үл хамааран) авъяас чадвараа хөгжүүлэх боломжоор хангана.
- ГСДН нь Европын Холбоог нийгмийн хатуу стандарт бүхий европын нийгмийн холбоо болгон өргөжүүлэхийг зорьж байна. Гэхдээ нийгмийн стандартуудыг гишүүн орнуудын сонгон авсан хөгжлийн замналдаа нийцүүлэн өөрийн орны онцлог нөхцөлд тулгуурлан хэрэгжүүлэх боломжийг хязгаарлахгүй байх хэмжээнд тогтоох ёстой. (28-р хуудас)

ГСДН-ын хөтөлбөр нь бүхэлдээ хүмүүний амьдралын туршид боломжийн тэгш байдлыг хангах, нийгмийн тэнцвэрт байдалд чиглэсэн асуудлыг үүссэн хойно нь шийдлийг хайдаг болон асуудлыг урьдчилан харж асуудал үүсэхээс урьдчилан сэргийлэх чадамжтай нийгмийн баримжаат төрийн загварыг танилцуулж байна. Германы эх газрын

европын, консерватив хэв шинжит нийгмийн баримжаат төрийг цаашид скандинавын социалдемократ хэв шинжит нийтийн сайн сайхны төлөөх төрийн чиглэлд хөгжүүлэх шаардлагатай хэмээн үзэж байна.

ГСДН-ын өөрчлөлтийн саналууд:

- Хөдөлмөр/Эдийн засаг: нийгмийн баримжаат төрийн уян хатан баталгаа бүхий хөдөлмөрийн даатгалыг¹³ нэвтрүүлэх, эв санааны нэгдэлийн зарчим дээр суурилсан даатгалын системд бүх нийтийг хамруулах
- Эрүүл мэнд: Иргэдийн даатгалыг нэвтрүүлэх, орон нутгийн оршихуйн нөхцөлийг сайжруулах
- Боловсрол: Сургуулийн сурагчдын хамтдаа суралцах хугацааг уртасгах, дунд сургууль-мэргэжлийн сургалт-их, дээд сургууль хооронд шат ахин дэвшин суралцах боломжийг дээшлүүлэх
- Татвар: Татварын санхүүжилтээр нийгмийн даатгалын санхүүжилтийг нэмэгдүүлэх, бүтээмжийн хэрээр, орлогын бүх хэлбэрийг хамруулах

6.4. “Ногоон ирээдүй”-Холбоотон 90/Ногоон намын мөрийн хөтөлбөр

Холбоотон90/Ногоон нам 2002 онд мөрийн хөтөлбөрөө баталсан. Зарим нэг завсрыг эс тооцвол харьцуулж буй улс төрийн намуудын дунд хамгийн урт хөтөлбөртэй нам юм. Үндсэн санаа нь: Нийгмийг нийгмийн болон экологийн баримжаатай зах зээлийн эдийн засгийн чиглэлд нарын энергийн эрин үеийн шаардлагад нийцүүлэн өөрчлөн байгуулах. Экологийн нөөцийг цөлмөж байгааг ирээдүйн хамгийн хүнд асуудал гэж үзсэн. Гэхдээ шаардагдах өөрчлөн байгуулалтыг төслийн хэлбэрээр боловсруулсан бөгөөд уг төслийг хэрэгжүүлэхэд зөвхөн байгаль орчны төдийгүй өргөн хүрээтэй нийгмийн бодлогын урьдчилсан нөхцөл хангагдсан байхыг шаардах бөгөөд байгаль орчин, нийгмийн бодлогын тодорхой үр дагавар гарах нь тодорхой харагдаж байна.

Нийгмийн бодлогын талаас нь авч үзвэл Холбоотон 90/Ногоон намын хөтөлбөр нь либерал үнэт зүйлс үнэнч үлдсэнээрээ (гэхдээ зах зээлийн либерал бус) бусад намуудаас ялгарч байгаа юм. “Иймээс өнөөг хүртэл хэрэгжүүлж ирсэн компаниудын ашгийг аль болох өндөр

Үндсэн асуудал:
нарны эрчим
хүчний эрин
үеийн нийгэм
ба экологийн
баримжаат зах
зээлийн эдийн
засаг

Либерал, гэхдээ
зах зээлийг
либералчлах
зорилтуудыг
тавиагүй.

13 “Хөдөлмөр эрхлэлтийн даатгал” сэдвийн дор хэлэлцүүлэг явагдаж байна. (102- хуудас)

байлгахад чиглэсэн нийгмийн баримжаат зах зээлийн эдийн засаг нь нийгмийн баримжаат гэдэг тодорхойлолтын хүрээнд тавигдаж буй шаардлагуудыг хангахгүй байгаа учраас нэн даруй хөгжүүлэх, улам боловсронгуй болгох шаардлагатай. Нийгмийн баримжаатай байх зорилтыг төр албан байгууллагуудын үүргийг гүйцэтгэдэг байх хэмжээнд бууруулж болохгүй. Нийгмийн хүчнүүдийн эрх чөлөөг хангахгүйгээр, иргэд өөрсдөө бие даан шийдвэр гаргахгүйгээр, сувсидар зарчмыг мөрдөхгүйгээр нийгмийн эв санааны нэгдэл хүнд сурталд живэх болно. Бид иргэний нийгмийг төрийн арга хэрэгслүүдээр дэмжихийн зэрэгцээ төрийн оролцоог хязгаарлах болно. Үүгээрээ манай намын хөтөлбөр төрийн социалист, консерватив болон зах зээлийн либерал бодлогын загваруудаас ялгаатай. (43-р хуудас). Ингэснээр Холбоотон90/Ногоонтнууд нь экологи, нийгэм, соёлын сонирхлууд нэгэн зэрэг хангагдаж байх “Дэглэмийн ерөнхий хүрээ”-г тогтоохыг шаардаж байгаа юм. (46-р хуудас)

“Оролцооны шударга ёс”-ыг өргөн хүрээнд тогтоож өгнө.

Дээрх зорилтоо дараа нь либерал, гэхдээ нийгмийн хариуцлагатай нийгмийн баримжаат төрийн тухай ойлголтод баттай суулгаж өгсөн байна. Үүнд: “Нийгмийн бодлого ба иргэдийн бие даан шийдвэр гаргах эрх. Нийгмийн баримжаат төрийн тухай ойлголтынхоо дагуу бид хүн төвтэй бодлогыг хэрэгжүүлэх болно. Шударга, нийгмийн баримжаатай иргэний нийгэмд төр нь хүн бүрт ур чадвар, унаган авъяасаа хөгжүүлэх ерөнхий нөхцөлийг бүрдүүлж өгнө.” (62-р хуудас)

“Оролцооны шударга ёс”-ыг өргөн хүрээнд тогтоож өгнө.

Мөрийн хөтөлбөрийнхөө ачаар Холбоотон90/Ногоонтнууд эвсэл улс төрийн намуудын орон зайд бие даасан байр суурийг эзэлж байгаа юм. Тэд нэг талаас либерал төсөөлөл, иргэний нийгэм, төрийн бус актёрууд дээр суурилсан, нөгөө талаас төрийн оролцоог хязгаарласан бодлогын төсөөлөл буюу мөрийн хөтөлбөрийг боловсруулсан бөгөөд эдгээр олон талт уламжлалыг бүхэлд нь “Оролцооны шударга ёс”-ны өргөн хүрээтэй төсөөлөл дор нэгтгэж: “Бидний нийгмийн шударга ёс болон эв санааны нэгдэлийн тухай төсөөлөл сонгодог дахин хувиарлалтын бодлогоос илүү өргөн хүрээтэй бөгөөд манай намын бодлогын хамгийн чухал зорилт бол ядуурал ба нийгмээс тусгаарлагдах байдлаас урьдчилан сэргийлэх, нийгмийн байдлын хувьд хамгийн хүнд байгаа иргэдийн аж байдлыг сайжруулахад оршино. Бид бүх иргэддээ нийгмийн хамгийн чухал салбарууд болох боловсрол, хөдөлмөр, улс төрийн оролцооны үүдийг нээж өгдөг оролцооны шударга ёсыг тогтоохыг зорьж байна. (61-р хуудас)

Холбоотон90/Ногоонтнууд эвслээс “оролцооны шударга ёс”-ыг хэрэгжүүлэхийн тулд цогц арга хэмжээ, арга хэрэгслүүдийг санал болгосон. Дараагийн хэсэгт саналуудыг бүхэлд нь биш, харин тодорхой саналуудыг танилцуулж байна. Эдгээр нь:

- Хэрэглээнд чиглэсэн, хавтгайруулсан, үндсэн баталгааг хангахын тулд нийгмийн тусламжийг (Уг хөтөлбөрийг батлагдаж байх үед тусламж хэмээн нэрлэдэг байв.) олгохоо болих хэрэгтэй. Үндсэн баталгаа нь тусламж хүртэгсдийн материаллаг үндсэн хангамжийг хангалттай хэмжээнд хангахын зэрэгцээ идэвхжүүлэх арга хэмжээг багтаасан байх шаардлагатай. (64,65-р хуудас) Идэвхжүүлэх арга хэмжээнд жишээлбэл: Ажилгүй хүмүүсийг дахин ажилтай болгохын тулд явуулж буй мэргэшүүлэх болон давтан сургалт багтдаг бөгөөд уг арга хэмжээнүүдийг төрийн болон иргэний нийгмийн актёруудын хамтын ажиллагааны хүрээнд авч хэрэгжүүлэх шаардлагатай. (Эвсэл холбоод, хотын хэсэг, дүүргүүд гэх мэт) (65-р хуудас)
- Холбоотон90/Ногоонтнууд нам нь ХАХН ба ЧАН-уудаас хөдөлмөрийн тухай ойлголтыг илүү өргөн хүрээнд тодорхойлсноороо онцлог юм. “Ирээдүйн экологийн болон нийгмийн баримжаатай зах зээлийн эдийн засаг нь хөдөлмөрийн бүх хэлбэрийг хүлээн зөвшөөрч үнэлэмжийг дээшлүүлж хүйсийн шударга хувиарлалтыг хангах ёстой. Гэрээсээ ажиллах, хүүхдийн хүмүүжил, хамтын амьдралын нэгжүүдийн сайн дурын санаачилгаар хийгдэж буй ажил, хөршүүд хоорондын туслалцаа зэрэг нь нийгмийн баримжаатай иргэний нийгмийн үндэс юм. Хөдөлмөрийн дээрх хэлбэрүүд байхгүй бол эв санааны нэгдэл ба нийгмийн сүлжээнүүд оршин тогтнох боломжгүй юм. (67- хуудас) Хөдөлмөрийн тухай эл өргөн хүрээт ойлголт нь Холбоотон90/Ногоонтнууд эвслийн нийгмийн бодлогын талаар баримталж буй байр суурийг ээдрээтэй болгож байгаа юм. Хөдөлмөрийн тухай өргөн хүрээт ойлголт нь нийгмийн баримжаат төрөөс нийгмийн шинэ талбаруудыг эрчимтэй бэхжүүлэхийг шаардаж байгаа юм. “Дээрээс нь төсвийн санхүүжилттэй, нийгэм ба экологийн хувьд ухаалаг, амьжиргааны баталгааг хангах ажлын байруудыг бий болгох шаардлагатай. Бид орон нутгийн эдийн засгийн бодлогын шийдлүүдийг цаашид хөгжүүлэхийн төлөө байна. Уг бодлогын шийдлийг бид: Амьжиргааны баталгааг

хангах ажилтай болох боломжийг шударга, нээлттэй болгох, ажил, амьдралын цагийн ухаалаг загваруудыг хөгжүүлэх, насан туршдаа суралцах, эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах, аливаа шалтгаанаар хохироодог байдлыг системтэйгээр арилгах, ахимаг насныхан ба цагаачдыг тээршаахын оронд нийгэмшүүлэх, нийгэмдээ нэгтгэхийн тулд санал болгож байна.

- Ногоонтнууд эрүүл мэнд, асрамж, өндөр насны даатгалын салбарт шимтгэлээс санхүүждэг иргэний даатгалыг нэвтрүүлэх саналыг дэвшүүлсэн нь ГСДН-тай төстэй байна. (80-р хуудас) Иргэний даатгал нь цаашдаа орлогын бүх хэлбэр ба бүх хүмүүсийг хамрах юм. Нийгмийн даатгалын хуримтлалын тогтолцоог хоршооллын загваруудтай хослуулах тухай санал дэвшүүлсэн ч хэрхэн хэрэгжүүлэх талаар системтэй тайлбар алга байна.
- Холбоотон90/Ногоонтнууд эвслийн хөтөлбөр зөвхөн санхүүжилтийн системийг авч үзээд зогсоогүй төрийн үйлчилгээний чанарын баталгааг үйлчилгээ хүртэгсдийн зүгээс харж саад бэрхшээлээс ангид байх шаардлага, эсхүл боловсролын тогтолцоонд дээд шатны сургуульд дэвшин суралцах боломжийг сайжруулах гэх мэт саналыг дэвшүүлснээрээ онцлог болжээ. (72-р хуудас)

Бүхэлд нь авч үзвэл ногоонтнууд Скандинавын, социалдемократ хэв шинжит нийтийн сайн сайхны төлөөх загвар луу чиглэсэн өөрчлөлтийг санал болгож буй нь тодорхой харагдаж байна. Либерал хэв шинжит нийгмийн баримжаат төрийн загвар луу чиглэсэн өөрчлөлтийг цухас дурьджээ.

Ногоон намын өөрчлөлтийн саналууд:

- **Хөдөлмөр/Эдийн засаг:** Хэрэглээнд чиглэсэн, хавтгайруулсан, тодорхой шаардлага, шалгуургүй үндсэн баталгааг хангах тогтолцоог нэвтрүүлэх, хөдөлмөрийн тухай ойлголтыг илүү өргөн хүрээнд томъёолох, хөдөлмөрийн бусад хэлбэрийг хүлээн зөвшөөрөх
- **Эрүүл мэнд:** Шимтгэлээс санхүүждэг иргэний даатгалыг нэвтрүүлэх, хуримтлалын тогтолцооноос санхүүжилтийн нэмэлт эх үүсвэрийг бүрдүүлэх
- **Боловсрол:** Хувийн хариуцлагыг дээшлүүлэх, өдөр өнжүүлэхтэй сургууль, олон нийтийн хариуцлагын буюу төсвийн

санхүүжилттэй мэргэжил дээшлүүлэх сургалтыг дэмжих

- Татвар: Бүтээмжийн хэрээр татвар ногдуулах, орлогын бүх хэлбэрийг оролцуулах

6.5. “Зүүний” намын хөтөлбөрийн үндсэн зорилтууд

Хуучин Ардчилсан Социализмын Нам (1898-2007 оны хооронд үйл ажиллагаа явуулж байсан) ба Хөдөлмөр ба Нийгмийн шударга ёсны төлөөх сонгуулийн холбоо (2005-2007 онд үйл ажиллагаа явуулж байсан) намаас эхтэй “Зүүний Нам” нь хараахан жинхэнэ мөрийн хөтөлбөртэй болж амжаагүй байна. Гэхдээ “Зүүний нам” ба Хөдөлмөр ба Нийгмийн шударга ёсны төлөөх сонгуулийн холбооны хамтарсан их хурлаас “Намын хөтөлбөрийг үндэслэх баримт бичиг”-ийг баталсан бөгөөд 2007 онд АСН-аас “Намын хөтөлбөрийг үндэслэх баримт бичиг”-ийг баталж уг баримт бичгийг формал байдлаар (намын хууль гэдэг утгаар нь) намын мөрийн хөтөлбөртэй адилтган үзэх тухай шийдвэрийг гаргасан юм. Агуулгын хувьд уг хөтөлбөр нь нэрлэгдсэн шигээ: “Хөтөлбөрийг үндэслэх баримт бичиг” биш бөгөөд нэгдсэн зорилтод хүрэхийн тулд “Зүүний нам”-ыг бүрдүүлэгч хоёр талын харилцан адилгүй байр суурийг нэгтгэж зорилтын нэгдсэн “Коридор”-ыг байгуулахад ашигласан байдаг.

“Хөтөлбөрийн үндсэн зорилтууд”-аас үүсгэн байгуулагч хоёр нам зорилт болон байр суурийн хувьд томоохон зөрчилтэй, эдгээр зөрчилдөөнтэй асуудлын шийдлийг жинхэнэ хөтөлбөртэй болтлоо хойш тавьсан, нэгдсэн зөвшилд хүрч чадаагүй нь харагдаж байна. Тодруулбал зохилтой олон асуудлууд байгаа ч зах зээлийн зохицуулалтыг хэр хэмжээнд хүртэл зөв гэж үзэх, төрийн оролцоог хэр хэмжээнд хүртэл зохистой гэж үзэх бэ? гэдэг асуултын хариулт хамгийн чухал юм. Чухам төрийн үүрэг ролийн тухай асуулт нь (актёр, зохицуулагч, компани, пионер аль нь гэж үзэх талаар) хэлэлцүүлэг, маргааны үндсэн талбар байх нь дамжиггүй.

“Зүүний Нам”-ын нийгмийн бодлогын талаар баримталж буй байр суурьт дээрх маргаан хоёр талт нөлөөг үзүүлж байна. Нийгмийн бодлогын олон шаардлагууд тавигдсан бөгөөд эдгээр нь ГСДН болон Холбоотон 90/Ногоонтнууд намуудын нэгэн адил чухал, мөн чухал байж болох асуудлууд юм.

Хөтөлбөрийг үндэслэх баримт бичиг, намын хөтөлбөр биш

Үндсэн асуудлууд нь шийдэгдээгүй.

Хоёр талт байр суурь

*Шүүмжлэлтэй,
гэхдээ төр ба зах
зээл хоорондын
харилцааг
нарийвчлан
тодорхойлоогүй*

*Тайлбар: төр,
эдийн засаг,
нийгэм хоорондын
харьцааг
өөрчлөхийн
тулд нийгмийн
баримжаат төрийн
зарчмуудыг
мөрдөх ёстой.*

Нийгэм болон экологийн талаар дэвшүүлсэн зорилтоо биелүүлэхийн тулд зах зээл ба эдийн засагт төрийн оролцоо хэр хэмжээнд байх, тэдний үндсэн бүтцэд ямар өөрчлөлт оруулах нь тодорхой бус зөвхөн дурьдаад орхисон, салбар тус бүрээр авч үзээгүй мэт харагдаж байна. Дээрх зорилтуудыг хэрэгжүүлэхийн тулд “Амьдралын бүх салбаруудыг өргөн хүрээнд ардчилах шаардлагатай гэжээ. Эдийн засгийн ардчилал нь өмчийн бүх хэлбэрийн засаглалыг нийгмийн масштабын дагуу тогтоохыг шаарддаг. (2-р хуудас)

Энэ утгаар нь авч үзвэл юуны өмнө “Зүүний Нам”-ын нийгмийн баримжаат төрийн зарчмуудын тухай тайлбар нь бусад намуудынхаас ялгаатай байгаа юм. Нийгмийн баримжаат эрх зүйт төрийн тухай ойлголт нь төр, эдийн засаг, нийгэм хоорондын харьцааг өөрчлөхөд чиглэгдэж байна. Нийгмийн баримжаат төрийн байгууллын тухай ойлголт нь эдийн засаг ба нийгмийн байгууллыг эрчимтэй, ардчилсан үйл явцын дунд нийгмийн баримжаат бодлогын шаардлагын дагуу шинэчлэх зорилгод чиглэгдэж байна. /.../ Нийгмийн баримжаат төрийн шаардлагыг нийгмийн шударга ёсны зарчмууд ба амьдралын чухал эрсдэлүүдийн үед төрийн хамгаалалтанд байх шаардлагын дагуу хэлбэрэлтгүйгээр тогтоож илүү тодорхой болгох шаардлагатай. Нийгмийн шударга ёсыг хангахад нийгмийн баялгийн шударга хувиарлалт чухал үүрэгтэй. Нийгмийн баримжаат төрийг хэрэгжүүлэхийн тулд нийгмийн үндсэн эрхүүдийг үндсэн хуулиар давхар баталгаажуулах хэрэгтэй гэжээ. (15-р хуудас)

“Зүүний Нам” өргөн хүрээтэй бодлого-баалсын харааны өөрчлөлтийн төлөө байх үүргийг өөртөө хүлээжээ. Харин “өөрчлөлт” аль хүртэл явагдах ёстой бэ? гэдэг талаар хөтөлбөрийг үндэслэх баримт бичигт тодорхой зүйл алга. Энэ нь тус намын дунд ямар жигүүр нь илүү хүчтэй байхаас хамаарах бололтой.

“Зүүний нам”-ын өөрчлөлтийн саналууд:

- Татвараас санхүүждэг, хэрэгцээнд чиглэсэн, аливаа дарамтаас ангид, нийгмийн үндсэн баталгааны тогтолцоог бүрдүүлэх
- Хөдөлмөр эрхлэгсдийн болон тэтгэврийн даатгалыг өөрчлөн байгуулах
- Эрүүл мэндийн салбарт эв санааны нэгдэлийн зарчим дээр суурилсан иргэдийн даатгалыг нэвтрүүлэх, шаардлагатай

тохиолдолд өртөг шингээсэн үйлдвэрлэлийн салбарын ажилтан ба ажил олгогчийн хувь, хэмжээ тэнцүү шимтгэлээр санхүүжүүлэх

- Нийгмийн даатгалын өөрийн удирдлагыг бэхжүүлэх
- Олон нийтийн буюу төсвийн санхүүжилттэй хөдөлмөр эрхлэлтийн салбар болон орон нутгийн оршихуйн баталгааг өргөтгөх
- Компаниудыг төрийн мэдэлд шилжүүлэх болон компаниудыг нийгмийн оролцоотой болгон өөрчлөх хэрэгтэй эсэхийг хянаж үзэх

6.6. Нэгдсэн дүгнэлт

Бундестагт суудалтай улс төрийн 5 намын мөрийн хөтөлбөр нь намууд улс төрийн эрх мэдэлд хүрсэн нөхцөлд германы нийгмийн систем ба нийтийн сайн сайхны төлөөх төрийг аль чиглэлд хөгжүүлэх бэ? гэдгээ тайлбарласан “Намуудын улс орны ирээдүйн хөгжлийн талаархи төсөөлөл” гэж үзэж болно.

Эцэст нь (үнэлэмжид хувь хүний үзэл бодол тодорхой нөлөө үзүүлсэн байхыг үгүйсгэхгүй) дараахи дүгнэлт гарч байна. Үүнд:

Улс төрийн намуудын нийгмийн бодлогын талаар баримталж буй байр суурийг авч үзвэл нэг талд ХАХН ба ЧАН-ын нөгөө талд ГСДН, Холбоотон 90/Ногоонтнууд эвсэл, “Зүүний Нам”-ын нийгмийн бодлогын талаар баримталж буй байр сууриудын хооронд тодорхой зааг тогтоож шугамын хоёр талд байршуулж болохоор эрс ялгаатай байна. ХАХН ба ЧАН нийгмийн баримжаат төрийг бусад намуудаас харьцангуй өндөр түвшинд либералчлах, бүтээмжийн шударга ёсонд илүү чиглүүлэх эрхэм зорилгын хүрээнд өөрчлөхийг эрмэлзэж байна. Тэд англосаксоний, либерал хэв шинжит нийтийн сайхны сайхны төрийн загвар дээр суурилан төсөөллөө боловсруулжээ. ХАХН зарим талаар сувсидар зарчим дээр суурилсан, нийгмийн баримжаат төрийн тусламж дээр түлхүү анхаарчээ.

ГСДН, Ногоон нам, “Зүүний Нам” хэрэгцээний шударга ёс ба боломжийн тэгш байдлын холимог зарчмуудын хэрэгжилтэд бусад намуудаас түлхүү анхаарчээ. Эдгээр холимог зарчмуудыг хэрэгжүүлснээр үндсэн эрхүүд өргөн хүрээнд хэрэгжиж, төр үндсэн эрхүүдийн хэрэгжилтийн баталгааг хангах боломжтой гэжээ. Гэхдээ намуудын үндсэн шаардлагуудаа хэрэгжүүлэх арга замын тухай төсөөлөл хоорондоо эрс ялгаатай байна.

Нийгмийн баримжаат төрийн тухай ойлголтууд нь хооронд нь тодорхой зааг тогтоож болох хэмжээнд зөрүүтэй.

- Холбоотон90/Ногоонтнууд нам төрийн баталгааны элементүүдийн зэрэгцээ либерал хүчин зүйлс, иргэний нийгмийн элементүүдийг хөтөлбөртөө түлхүү оруулсан байна.
- “Зүүний Нам” үндсэн эрхүүдийг хэрэгжүүлэхийн тулд нийгмийн баримжаат төрийн элементүүдийн зэрэгцээ ямар арга хэлбэрээр, хэр хэмжээнд гэдэг нь огт тодорхой бус нийгэмчлэх тухай (төрийн мэдэлд шилжүүлэх, хоршоолол, ажилтнуудын оролцоо, төсвөөс санхүүждэг хөдөлмөр эрхлэлтийн сектор гэх мэт) санааг дэвшүүлжээ.
- ГСДН хувьсан өөрчлөгдөж буй эдийн засгийн сорилтуудад дүн шинжилгээ хийсний үндсэн дээр скандинавын социалдемократ хэв шинжит нийтийн сайн сайхны төлөөх төрийн чиглэлд шинэчлэлийг хийж улам бүр уян хатан болж буй эдийн засгийн өнөөгийн нөхцөл дунд асуудлыг урьдчилан харж, асуудал үүсэхээс сэргийлэх чадамжтай нийгмийн баримжаат төрийг бэхжүүлэх ёстой гэдэг санааг дэвшүүлжээ. Иргэний нийгмийн, гэр бүлийн, төрийн элементүүдийг эн тэнцүү харгалзан үзэж цаашид хөгжүүлэх шаардлагатай гэжээ.

7. НИЙГМИЙН БАРИМЖААТ ТӨРИЙН ҮНДСЭН САЛБАРУУД

Өмнөх бүлгүүдэд нийгмийн ардчиллын хөтөлбөрийн масштаб болон нийгмийн бодлогын үндсэн асуудал, ойлголтуудыг тайлбарлалаа. Одоо эдгээр үндсэн асуудал ба ойлголтуудыг нийгмийн баримжаат төрийн бодлогын тодорхой салбаруудад хэрхэн хэрэглэх талаар ярилцъя. Дараагийн бүлгүүдэд Германы нийгмийн баримжаат төрийн системийн татвар, ажилгүйдэл, тэтгэвэр, эрүүл мэнд, боловсролын салбаруудад үндсэн асуудлыг хэрхэн тодорхойлж үндсэн ойлголтуудыг хэрхэн хэрэглэж байгааг тайлбарлаж үлгэр жишээ болохуйц бусад орнуудтай харьцуулах болно. Германы нийгмийн баримжаат төр нь шударга ёсны шаардлагуудыг олон хэмжээст хавтгай дээр хэрхэн хангаж байна? Тэндээс ямар сургамжийг авах ёстой бэ? гэдэг дээр гол анхаарлаа хандуулах болно.

Судалгаанд хамрагдсан орнуудын амьжиргааны өртөг харилцан адилгүй байна. Өгөгдсөн тоонуудыг илүү сайн эрэмбэлж ойлгомжтой болгохын тулд сонгон авсан орнуудын үнийн түвшинг 9-р зураг дээр харууллаа. Үнийн түвшин нь худалдан авах чадвар ба Европын Холбооны гишүүн 27 орны валютын хөрвөх ханшийн дунджид харьцуулсан харьцаа юм. Үнийн түвшин нь 100-аас дээш бол тухайн орны амьжиргааны өртөг харьцангуй өндөр, үнийн түвшин нь 100-аас доогуур бол тухайн оронд амьжиргааны өртөг харьцангуй хямд гэсэн үг. Өгөгдсөн бүх дүнг еврогоор илэрхийлсэн.



9-р зураг: Айл өрхийн үнийн түвшин 2006 оны байдлаар

Унших жишээ: Улс орнуудын харьцуулалтанд сонгон авсан бусад 4 оронтой харьцуулахад Данид амьжиргааны өртөг Европын Холбооны гишүүн 27 орны дунджаас ойролцоогоор 138% -аар дээгүүр байна. Энэ нь Европын Холбооны гишүүн орнуудын дунджаар нэг евро төлдөг амьжиргааны зардалд Даничууд 1,38 евро төлдөг гэсэн үг. Германд (103%) зөвхөн 1.03 евро төлнө гэсэн үг юм.

7.1. Татвар

Томас Риксен

Энэхүү бүлэгт:

- Татвар ногдуулахад баримталдаг чухал зарчмуудыг танилцуулна.
- Татварын төрөл бүрийн хэлбэрийг танилцуулж тэдний хувиарлалтанд үзүүлдэг нөлөөний талаар хэлэлцэнэ.
- Нийтийн сайн сайхны төлөөх төрийн загварын гурван үндсэн хэлбэр тус бүрийн татварын бүтцийг тухайн загварыг хэрэгжүүлж буй улс орнуудын эдийн засгийн бүтээмжийн чадамж, тэдгээрийн хувиарлалтад үзүүлж буй нөлөөтэй холбон танилцуулна.

Татварын гурван зорилго: орлого, дахин хувиарлалт, чиглүүлэх

Нийгмийн баримжаат төрийн хувьд татвар болон хураамж нь дараахи гурван шалтгааны улмаас маш чухал. Нэгдүгээрт: нийгмийн баримжаат төрийн нийгмийн бодлогын хөтөлбөрүүдийг санхүүжүүлэх эх үүсвэр нь татвар юм. Иймээс татвар нь нийгмийн бодлого болон бусад салбаруудыг мөн татвараас санхүүжүүлдэг. Хоёрдугаарт: хураамжийн хувь хэмжээ ба татварын бүтэц нь орлого, хөрөнгө, хүн амын хангалуун чинээлэг амьдралын хувиарлалтад нөлөөлдөг. (Дахин хувиарлалтын зорилгоор) Гуравдугаарт: татвар төлөгчдийн дунд тодорхой харьцааг төлөвшүүлэхэд татварыг чиглүүлэх норм болгон хэрэглэж болдог. Архи, тамхины онцгой татварыг эрүүл мэндийн бодлогоор зөвтгөдөг нь үүний нэг жишээ юм.

Татвар, хураамж, шимтгэлийн ялгаа

Явцуу утгаар нь авч үзвэл татвар нь албадлагаар төлдөг, төлснийхөө хариуг шууд хүртдэггүй зарлага юм. (Хураамжийн журам хэмээх 3-р бүлгийн 1-р хэсгийг үзнэ үү.) Төрийн үйлчилгээг санхүүжүүлдэг, өргөн утгаар нь авч үзвэл бас л татварт хамааруулж болох бусад зардлуудын хариуд хүмүүс үйлчилгээ тусламж хүртдэг. Хураамж бол тодорхой

Гүнзгийрүүлэн унших
эх сурвалжууд:
*Штефан Хомбург
(2000 он) Татварын
ерөнхий онол, Мюнхен
Жоел Слемрод, Жон
Вакижа (2004 он)
Татвар нь татварын
шинэчлэлийн
талаархи иргэдийн
дундах их маргааны
зам заагч нь мөн.*

зорилгын дагуу хураагддаг, хувь хүн үр ашгийг нь хүртдэг зардал. Үүний нэг жишээ бол хог хаягдлын хураамж. Шимтгэлийг мөн тодорхой зорилгын дагуу хураадаг, хувь хүн тус бүр биш ч тодорхой бүлгүүд үр ашгийг нь хүртдэг зардал юм. Жишээлбэл: ажилгүйдлийн даатгал нь ажилчдын тодорхой бүлгийг ажилгүйдлийн эрсдэлээс хамгаалах үүрэгтэй. Нийгмийн даатгалын бусад хэлбэрүүд үүнтэй төстэй зарчимтай.

Эхлээд татвар ногдуулахад баримталдаг хамгийн чухал ерөнхий зарчмууд ба татварын олон төрлүүдийн ялгааг тайлбарлана. Энэ үндсэн дээр татварын төрийн гурван хэв шинжийг тодорхойлж тэдгээрийн нийгмийн бодлогын чадавхийг хооронд нь харьцуулна.

7.1.1. Татвар ногдуулахад баримталдаг зарчмууд: шударга ёс ба эдийн засгийн үр өгөөж

Төр тодорхой зорилтуудыг дэвшүүлээд уг зорилтынхоо биелэлтийг хангах зорилгын дор татварын системээ бүрдүүлэх ёстой. Эдгээр зорилтуудаас шударга ёсыг хангах ба эдийн засгийн үр өгөөжийг дээшлүүлэх зорилтууд нь нийгмийн баримжаат төртэй шууд хамааралтай бөгөөд нийгмийн баримжаат төрийн бодлогын талаар харилцан адилгүй байр суурь баримтлагсдын дундах маргаан ч эдгээр хоёр зорилтын хүрээнд өрнөж байдаг.¹⁴ Дээрх хоёр зорилт нь хоёулаа эрхэмлэх ёстой зорилтууд бөгөөд хоорондоо зөрчилдөх боломжтой. Аль нь илүү чухал зорилго бэ? гэдэг асуултын эргэн тойронд улс төрийн хэрүүл маргаан өрнөж байдаг.

Шударга татвар ногдуулалт гэж юу бэ?

Татварын систем шударга байх ёстой. Гэхдээ татварыг хэрхэн шударгаар ногдуулах бэ? гэдэг нь өөрөө маргаантай асуудал. Улс төрийн эдийн засагчид ба философчид бүтээмжийн шударга ёс ба эквивалентын зарчмын дагуу татвар ногдуулах талаар олон жилийн туршид маргасаар ирсэн ч тодорхой үр дүнд хүрсэнгүй өнөөг хүрчээ. Эдгээр хоёр зарчим нь татварын шударга ёсны талаар бүтээлчээр сэтгэхэд тустай юм.

Бүтээмжийн чадавхийнх нь хэрээр татвар ногдуулах

Татвар төлөгчдөд хувь хүний бүтээмжийн чадамжийнх нь хэрээр татвар ногдуулах шаардлагыг бүр дээр үеийн Адам Смитийн үеэс

*Татвар
ногдуулахад
баримталдаг хоёр
зарчим: Шударга
ёс ба эдийн
засгийн үр өгөөж*

*Бүтээмжийн
шударга ёс ба
эквивалентийн
зарчим*

14 Татварын системийн өөр хоёр чухал шалгуур үзүүлэлтүүдийн талаар энд дурьдалгүй орхилоо. Эдгээр нь хэрэгжих боломж ба ил тод байдал юм.

Татвар ногдуулах төрөл бүрийн журмуудын хувиарлалтанд үзүүлэх нөлөөллийг тодорхойлох дүрэм

Орлого нэмэгдэхийн хэрээр ногдуулах татварыг бууруулах аргачлалыг регрессив аргачлал гэнэ. Регрессив татвар нь орлого ба хөрөнгийг дороос нь дээш хувиарладаг. Шударга ёсны шаардлагын дагуу татварын регрессив зарчмаас татгалзах ёстой. Хүн бүрт, нэгж бүрт орлогын хэмжээнээс нь үл хамааран тэнцүү хувь хэмжээгээр татвар ногдуулдаг зарчмыг хувь тэнцүүлсэн буюу пропорциональ аргачлал гэнэ. Орлого өсөхийн хэрээр татварын үнэмлэхүй ачаалал нэмэгдэнэ. Хувь тэнцүүлэх татварын дахин хувиарлалтын нөлөө нь тарифын дэвшилтэт буюу прогрессив аргачлалаас бага. Өндөр орлогод ногдуулж буй татварын ачааллын хувь хэмжээ нь бага орлогод ногдуулж буй хувь хэмжээнээс өндөр байх аргачлалыг прогрессив татвар гэнэ. Орлого нэмэгдэхийн хэрээр татварын харьцангуй ачаалал нэмэгдэж эцэст нь дахин хувиарлалтад үзүүлэх нөлөө нэмэгдэнэ.

тавьсаар иржээ. Хэрэв энэ зарчмыг бодлогын практикт хэрэгжүүлнэ гэвэл бүтээмжийн чадавхийг яаж хэмжих бэ? гэдэг асуулт тэр даруйдаа гараад ирнэ. (Энэ талаар 3-р бүлгийн хэлэлцүүлгийн талаар уншина уу.) Хэмжихэд хэцүү учраас ихэнхдээ хувь хүмүүсийн орлого бол бүтээмжийн чадавхийн илэрхийлэл хэмээн хялбарчилдаг.

*Бүтээмжийн
чадамжийн хэрээр
татвар ногдуулах*

Бүтээмжийн чадамжийн хэрээр татвар ногдуулах зарчмаас дараахи хоёр үр дагавар үүснэ. Үүнд: Ижил орлоготой татвар төлөгчид ижил хэмжээний татвар төлөх ёстой юу? (Хэвтээ хавтгай дээр шударга ёсыг хангах). Хоёрдугаарт: өндөр орлоготой хүмүүст бага орлоготой хүмүүсээс илүү татварын ачаалал үүрүүлэх ёстой юу? (Босоо хавтгай дээр шударга ёсыг хангах)

*Татвар
ногдуулах ямар
журмууд эдгээр
шаардлагуудыг
хангах бэ?*

Татвар ногдуулалтын ямар журам дээрх шаардлагуудыг хангаж чадах бэ? гэдэг асуудал маш их маргаан дагуулдаг. Регрессив татвар зарчимтайгаа зөрчилдөж байгаа нь тодорхой. Либертарчуудын нэгэн адил пропорциональ буюу хувь тэнцүүлсэн аргачлалаар татвар ногдуулчихвал бүтээмжийнх нь хэрээр татвар ногдуулах зарчимд нийцнэ гэчихээд сууж байх амархан. Жишээлбэл: Үндсэн хуулийн цэцийн гишүүн асан Кирххоф орлогын их, багаас үл хамааран бүгдээрэнд нь 25%-ийн нэгдсэн татварыг ногдуулах нь зөв гэдэг саналыг дэвшүүлж байжээ.

Татвар ногдуулах прогрессив буюу орлого нэмэгдэхийн хэрээр татварын хувь хэмжээг нэмэгдүүлэх аргачлалыг зөвтгөх нэгэн үндэслэл

Хэвтээ хавтгайд шударга ёсыг хангахын тулд орлого нэмэгдэхийн хэрээр татварын харьцангуй ачааллыг нэмэгдүүлэх нь зүйтэй гэдэг үндэслэл байж болно. Жишээлбэл: Жилдээ 100.000 еврогийн орлоготой татвар төлөгчийн хувьд орлогынхоо дөрөвний нэгтэй тэнцэх татварыг төлөх нь жилдээ 20.000 еврогийн орлоготой татвар төлөгч орлогынхоо дөрөвний нэгийг төлснөөс хамаагүй илүү хөнгөн тусна гэдэг үндэслэл байж болно. Жилдээ 100.000 еврогийн орлоготой татвар төлөгч 25.000 еврогийн татвар төлөх нөхцөлд магадгүй хоёрдох машинаа худалдан авахаа хойшлуулах, эсхүл гадаадад аялах гуравдах аяллаа хойшлуулах хэрэгтэй болно. Харин хоёрдох татвар төлөгчийн хувьд 5.000 еврогийн татвар төлөхийн тулд огт амралтанд явахгүй байх, эсхүл эрүүл хүнс худалдан авахаас

Орлогын ашгийн хязгаар: гэдэг нь эдийн засгийн ойлголт бөгөөд хэрэглэсэн сүүлчийн нэгжээс хүртэж буй хэрэглэгчийн ашгийн өсөлтийг илэрхийлдэг. Ихэнх бараа үйлчилгээний хувьд хэрэглээ өсөхийн хэрээр худалдан авч буй хэрэглэгчийн хувь хүний хувьд хүртэх ашиг нь буурдаг. (Жишээ нь: 9 шил дарс хэрэглэхсэн хүний хувьд 10 дахь шил дарсаа уулаа гээд тансаг хэрэглээнээс авах таашаал нь хэр хэмжээгээр нэмэгдэх бэ?)(Улс төрийн нэвтэрхий толь 2006 он: 128-129)

татгалзах хэрэгтэй болно. Эдгээр эргэцүүллийг эдийн засагчид орлогын хязгаар ашиг буурах гэдэг ойлголтоор илэрхийлдэг. Уг ойлголтыг татвар ногдуулах прогрессив аргачлалыг зөвтгөх үндэслэл болгодог. ГСДН прогрессив татварыг дэмждэг.

Орлогын хязгаар ашиг буурах:
Татвар ногдуулах прогрессив аргачлалыг зөвтгөх нэгэн үндэслэл

Төрийн зарлагын санхүүжилтэд компаниуд болон айл өрхүүд өөрсдийн бүтээмжийн хэрээр оролцдог. Энэ нь: ГСДН үр өгөөжтэй гэдэг нь батлагдсан татварын прогрессив аргачлалын төлөө байна гэсэн үг.

(ГСДН-ын Хамбургийн хөтөлбөр 2007 он 46-р тал)

Эквивалентын зарчим

Эквивалентын зарчим бол татвар ногдуулалтын шударга ёсны хоёрдох зарчим юм. Уг зарчмыг бүтээмжийн чадамжийн хэрээр татвар ногдуулах зарчмын эсрэг үйлчилдэг зарчим гэж үзэх нь олонтаа. Эквивалентын зарчмын дагуу татвар төлөгчийн төрөөс авч буй үйлчилгээний хэмжээтэй дүйцүүлэн төлөх татварын хэмжээг тогтоох хэрэгтэй болно. Үүний цаана татвар бол төрийн үйлчилгээг хүртсэнийхээ хариуд төлж буй үнэ гэдэг санаа агуулагдаж буй. Энэ утгаараа эквивалентийн зарчим нь нэгэн төрлийн солилцооны шударга ёс юм.

Эквивалентын зарчим: бол солилцооны шударга ёсны нэгэн хэлбэр

Асуудал: Тэгвэл
“үнийг” хэрхэн
зөв тогтоох бэ?

Гэхдээ төрийн үйлчилгээний хувь хүн тус бүрд ногдох үнийг тогтоох боломжгүй. бэ? Ихэнх тохиолдолд боломжгүй юм. Явцуу утгаар нь авч үзвэл татвараас санхүүждэг төрийн үйлчилгээ нь олон нийтийн (public) шинж чанартай¹⁵ учраас зах зээлийн механизм үйлчилдэггүй тул тухайн үйлчилгээнд тодорхой үнэ тогтоох боломжгүй. Харин хураамжийн хувьд бол тодорхой үнэ тогтоох боломжтой. Хураамжийн хэмжээг эквивалентын зарчмын дагуу тогтоодог. Шимтгэлийн хувь хэмжээг тогтоохдоо эквивалентийн зарчмыг зарчмыг ягштал мөрдөөд байдаггүй ч хэрэглэдэг. Мөн ажилгүйдлийн болон тэтгэврийн даатгалд төлсөн шимтгэл ба хүртэж буй тэтгэмжийн хоорондын эквивалентын зарчмыг ягштал мөрдөөд байдаггүй. Учир нь тухайн хүн тэтгэвэрт гартлаа тасралтгүй ажилтай байх, эсхүл ажилгүйдэлд өртөх эсэх, мөн тухайн мөнгөн тэтгэмжийг хэр удаан хугацаагаар авах нь тодорхой бус тул тэтгэвэрт гарсан, эсхүл ажилгүйдэлд өртсөн тохиолдолд олгох мөнгөний хэмжээг өмнө нь төлсөн шимтгэлийн хувьд хэмжээтэй уялдуулан тогтоодог.

Татвар төлсний
хариуд:
“Иргэншсэн
нийгэм”

Татварт эквивалентын зарчмыг явцуу утгаар нь ягштал хэрэглэх боломжгүй ч “зөөлөн” утгаараа шударга татварын системийн тухай эргэцүүлэлд тустай. Хэдийгээр төрөөс хүртэж буй үйлчилгээний үнийг хувь хүн тус бүрээр тооцох боломжгүй ч нийт татвар төлөгчид татвар төлснийхөө хариуд маш тодорхой хариу үйлчилгээ хүртдэг гэдэг нь бүгдэд ойлгомжтой. Эрх зүйн дэглэмийг тогтоох, дотоод болон гадаад аюулгүй байдлыг хангах, нийгмийн үйлчилгээ хүртэх, сургууль, гудамж талбай, ба нийтийн тээвэр зэрэг нь нийгмийн үйлчилгээнд багтана. Бүхэлд нь авч үзвэл:

“Татвар бол бидний иргэншсэн нийгэмд амьдарч байгаагийнхаа төлөө төлж буй төлөөс юм” (Оливер Вендел Холмес 1927 он, Америкийн үндсэн хуулийн цэцийн шүүгч Т.Р-ийн орчуулга)

Татварын
прогрессив
аргачлалын
үндэслэл: өмч
хөрөнгө ихтэй
байх тусмаа эрх
зүйн дэглэмийн
хамгааллыг илүү
их хүртдэг.

Татварын прогрессив аргачлалын эквивалентын онолын үндэслэл Уг эргэцүүллийг гүнзгийрүүлээд байх тусам эквивалентын зарчим ба бүтээмжийн чадамжийнх нь хэрээр татвар ногдуулах зарчим хоёрыг заавал хооронд нь сөргөлдүүлээд байх албагүй юм гэдэг нь илүү тодорхой харагддаг. Тэр ч байтугай эквивалентын зарчмыг татварын прогрессив аргачлалыг зөвтгөх үндэслэл болгох боломжтой. Үүнд:

15 Нийгмийн ардчиллын академийн сурах бичгийн 2-р дэвтэр “Эдийн засаг ба нийгмийн ардчилал”

татвар нь хувь хүний өмчийг хамгаалдаг, бүр тодорхой хэлбэл хувийн өмч гэж юу бэ? гэдэг тодорхойлолтыг гаргаж ирэх үндсийг бүрдүүлдэг эрх зүйн дэглэмийг байгуулах, хадгалах нөхцөл мөн. Ийм ч учраас илүү их орлоготой, хөрөнгөтэй хүмүүс төдийлөн чинээлэг бус хүмүүстэй харьцуулахад эрх зүйн болон өмчийн дэглэмээс илүү их хамгааллыг хүртдэг учраас тухайн дэглэмүүдийг хадгалахад шаардагдах зардлын санхүүжилтэд илүү их хувь нэмэр оруулахыг баян хүмүүсээс шаардах ёстой.¹⁶

Эдийн засгийн үр өгөөж

Татварын системд шударга ёсыг хангах суурь болгон хэрэглэдэг дээр дурьдсан зарчмуудын зэрэгцээ татварын систем нь эдийн засгийг тамирдуулах хэмжээнд татвар ногдуулахгүй байх ёстой гэдэг ерөнхий зарчим үйлчилдэг. Энэ зарчмыг төвийг сахисан байх зорилго гэж нэрлэдэг. Төвийг сахисан байдал нь нөөцийг үр өгөөжтэй зарцуулах боломжийг бүрдүүлж өсөлтийг дэмждэг учраас чухал зарчим мөн. Бэрхшээл нь: Бүх төрлийн татвар эдийн засгийн актёруудын шийдвэрийг хязгаарлаж байдаг. Харин хүн бүрт ижил хэмжээгээр ногдуулдаг хүн толгой бүрийн татвар нь татварын онцгой төрөл юм. Хэдийгээр хүн толгойн татварыг аль ч улсад хураадаггүй, улс төрийн хувьд хэрэгжүүлэх боломжгүй, хүсээд байх зүйл биш, дээр дурьдсан шударга ёсны зарчмуудтай зөрчилддөг ч гэсэн төвийг сахих зарчмын концепцийг илүү тодорхой тайлбарлахад тустай. Хэрвээ орлого олсон эсэх, ажилтай эсэхээс үл хамааран хүн толгой бүрт ижил хэмжээгээр ногдуулдаг хүн толгойн татвар гэж байдаг бол түүнийг төвийг сахисан татвар гэж нэрлэхээс өөрөөр юу гэж нэрлэх вэ? Хүн бүрт ижил хэмжээгээр татвар ногдуулдаг байсан бол эдийн засгийн байдлаа байнга дээшлүүлэх, ингэснээр эдийн засгийн өсөлтөнд хувь нэмрээ оруулах идэвх санаачилга хамгийн өндөр байхсан. Гэтэл орлого нь нэмэгдэхийн хэрээр татварын хувь хэмжээ нь нэмэгдээд байхад эдийн засгийн байдлаа байнга дээшлүүлэх урам зориг үгүй болдог. Татварын ачаалал прогрессив байх тусмаа эдийн засгийн байдлаа байнга дээшлүүлэх хувь хүмүүсийн урам зориг буурдаг.

Үр өгөөж ба шударга ёсны зорилтууд хоорондоо зөрчилддөг үү?

Татварын ачааллыг прогрессив ногдуулдаг учраас шударга ёсны шаардлагуудын дагуу шударга хэмээн үнэлэгддэг татварын тарифыг

*Төвийг сахисан байдал:
Эдийн засгийг тамирдуулж болохгүй.*

Өсөлт ба шударга ёсны хооронд ямар баланс байх ёстой бэ?

16 Нийгмийн ардчиллын сурах бичгийн 2-р дэвтэр "Эдийн засаг ба нийгмийн ардчилал" (132-137-р хуудас)

өсөлтөд саад тушаа болдог гэж үзэж болох талтай.

Энэ чиг хандлагаас нь авч үзвэл үр өгөөж ба шударга ёсны зорилтууд нь хоорондоо зөрчилддөг. Шударга ёсны зарчмаас яльгүй хазайвал өсөлтийг нэмэгдүүлэх, шударга ёсны зарчмыг ягштал баримталбал өсөлтийг хазаарлах боломжтой. Эдгээр хоёр зорилтуудын хоорондын балансыг хэрхэн тогтоох бэ? гэдэг асуудал нь тухайн нийгмийн үнэлэмжээс хамаардаг бөгөөд татварын бодлогын хэлэлцүүлгийн үндсэн сэдэв юм.

Бодит байдал дээр
хэр том зөрчил
үүсдэг бэ?

Улс орнууд өөр өөрийн хэмжүүрээр хэмжиж өөрийн орны онцлогт нийцсэн шийдвэрийг гаргасан байдаг талаар дараахи бүлэгт танилцуулах болно. Үүний зэрэгцээ үр өгөөж ба шударга ёсны солилцох харьцаа ямар байна бэ? Уг харьцаанд өөр бусад ямар хүчин зүйлс нөлөөлж байна? Яавал уг зөрчлийг эхлээд харагдсан шиг том биш байлгаж болох бэ?

7.1.2. Татварын төрөл бүрийн хэлбэрүүд

Төр бодит байдал дээр олон төрлийн зүйлс, үйл ажиллагаанд татвар ногдуулдаг. Татварыг төрөл бүрийн хэлбэрт хувааж болдог.

Шууд татвар

Шууд татварыг бүтээмжийн чадамжийн шалгуур үзүүлэлтүүдэд шууд харгалзуулан тогтоодог, өөрөөр хэлбэл орлого ба хөрөнгөнд шууд татвар ногдуулдаг. Орлогын татвар, хөрөнгийн нийгэмлэг буюу хуулийн этгээдийн, өв залгамжлал эсхүл хөрөнгийн татвар зэрэг нь шууд татварт багтдаг. Германд орлогын албан татварыг ногдуулахдаа (бусад ихэнх орнуудад) прогрессив аргачлалыг хэрэглэдэг. Прогрессив албан татварыг хувь хүмүүс, хувийн эрх зүйн зохион байгуулалттай компаниуд төлдөг. Харин хуулийн этгээдийн ашгаас төлөгддөг (жишээлбэл: Хувьцаат компани, Хязгаарлагдмал Хариуцлагатай Компани) нийгэмлэгийн татварыг хувь тэнцүүлэх аргачлалаар тогтоодог. Уг татварыг Германд саяхнаас 25% хүртэл бууруулаад байна. (Дээрээс нь орон нутгийн засаг захиргаанаас ногдуулдаг үйлдвэрлэлийн үйл ажиллагаа эрхэлсний татвар нэмэгддэг.)

Орлого ба
хөрөнгөнд шууд
татвар ногдуулдаг.

Нийгмийн
даатгалын шимтгэл
нь өргөн утгаар
нь авч үзвэл
татвар юм.

Нийгмийн даатгалын татварын эсхүл шимтгэлийн санхүүжилт
Өргөн агуулгаар нь авч үзвэл нийгмийн даатгалын шимтгэл нь

шууд татварын төрөлд хамаарна. Нийгмийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээг пропорциональ аргачлалаар ногдуулдаг. Үүнээс гадна ихэвчлэн шимтгэлийн хувь хэмжээг тооцох орлогын дээд хязгаарыг тогтоож өгдөг учраас өндөр орлогыг нийгмийн үйлчилгээний санхүүжилтэд бүрэн хэмжээгээр хамруулж чаддаггүй тул нийгмийн даатгалын зохицуулалт нь регрессив шинжтэй гэж хэлж болно. Гэхдээ тэтгэвэр болон эрүүл мэндийн даатгалд төрөөс татаас олгодог, уг татаасыг татвараас санхүүжүүлдэг. (явцуу утгаар нь) Нийгмийн даатгалын санхүүжилт нь регрессив шинж чанартай учраас ГСДН татвараас санхүүжүүлдэг хэсэг буюу төрийн татаасыг нэмэгдүүлэхийн төлөө байдаг. (Хамбургийн хөтөлбөр 2007 он 58-р тал)

Шууд бус татвар

Шууд бус татварт эдийн засгийн бүтээмжийн чадавхийг тойруу замаар тооцдог. Шууд бус татвар нь орлогын зарцуулалтад ачаалал ногдуулдаг. Германы олонд хамгийн их танигдсан, санхүүгийн хувьд хамгийн чухал татвар бол нэмүү өртөгийн албан татвар. Нэмүү өртөгийн албан татварыг хувь тэнцүүлсэн аргачлалаар 19%-иар тогтоодог. Харин өргөн хэрэглээний зарим бараа үйлчилгээнд 7% хүртэл бууруулсан нэмүү өртгийн татварыг ногдуулдаг. Нэн ялангуяа бага орлоготой иргэд орлогынхоо дийлэнх хувийг үндсэн хэрэгцээгээ хангахад зарцуулдаг учраас нэмүү өртөгийн албан татварыг регрессив үйлчилгээтэй гэж үзэж болно.

Үйлдвэрлэлийн хүчин зүйлст ногдох татварын ачаалал

Эцэст нь улс ардын аж ахуйн үйлдвэрлэлийн ямар хүчин зүйлст татвар ногдуулдаг бэ? хэмээн асууж болно. Ингэснээр хөрөнгө болон хөдөлмөрийн хүчин зүйлст ногдож буй татварын ачааллыг хооронд нь ялгах боломжтой.

7.1.3. Татварын төрийн гурван үндсэн хэв шинж

Дээрх категоруудын тусламжтайгаар өнөөгийн татварын системүүдэд дүн шинжилгээ хийх боломжтой. Нийгмийн баримжаат төрийн төрөл бүрийн хэв шинжүүд хоорондын ялгаатай байдал нь тэдгээрийн татварын бодлогын зохион байгуулалт дээр илүү тодорхой харагддаг. Англосаксоний, эх газрын, Скандинавын хэв шинжит нийгмийн баримжаат төрүүд нь хоорондоо татварын нийт ачаалал, татварын хувь хэмжээ, татварын төрлөөр ялгаатай байдаг.

Шууд бус татварыг орлогын зарцуулалтад ногдуулдаг. Жишээлбэл: нэмүү өртөгийн албан татвар

Хөрөнгө ба хөдөлмөрт ямар харьцаагаар татвар ногдуулдаг бэ?

Татварын төрийн гурван үндсэн хэв шинж: нийгмийн баримжаат төртэй төстэй харьцуулалтыг хийх нь

(Татварын холимог систем, татварын бүтэц) Ингэснээр татварын төрөл, хувь хэмжээ, бүтцээс хамааран хувиарлалтад үзүүлэх нөлөө нь харилцан адилгүй байдаг. (Вагшал 2001 он)

Татварын нийт ачаалал бага, нэн ялангуяа шууд татвар

Англосаксоний татварын төр: АНУ

Уг сурах бичигт Америкийн Нэгдсэн Улсыг англосаксоний татварын төрийн жишээ болгон авсан, нийтэд нь авч үзвэл татварын ачаалал бага байдаг. Татварын орлогын ихэнх хувийг шууд татвар эзэлдэг. Хувь хүмүүсийн орлогын татварын прогрессив ачаалал харьцангуй бага. Шууд бус татвар ба нийгмийн зардал бага.

Татварын нийт ачаалал дунд зэрэг, нийгмийн зардал буюу цалингийн нэмэлт зардал өндөр

Эх газрын татварын төр: Герман

Уг сурах бичигт Герман улсыг эх газрын татварын төрт орны жишээ болгон авсан. Татварын нийт ачаалал дунд зэрэг. Татварын нийт орлогод шууд татварын эзлэх хувь бага, харин нийгмийн зардал буюу нийгмийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээ өндөр байдаг. Үүний дагуу нийт зардлын квот ба явцуу утгаар нь авч үзвэл Дотоодын Нийт Бүтээгдэхүүнд-ДНБ-нд татварын эзлэх хувь хэмжээгээр илэрхийлэгддэг татварын квот хоёр нь хоорондоо эрс зөрүүтэй байдаг.

Гүнзгийрүүлэн унших эх сурвалжууд:
Герд Гроезингер (2007 он), Герман өндөр татвартай орон уу? Урт настай домог, хүндрэлтэй үр дагавар: Хөндлөнгийн оролцоо 4/1/, 28-39-р хуудас

Уламжлалын дагуу татварын нэрлэгдсэн хувь хэмжээ харьцангуй өндөр байдаг. Татварыг маш явцуу хэмжилтийн үндсэн дээр хураадаг. Гэхдээ орлогын албан татвар ба хуулийн этгээдийн албан татварын хувь хэмжээг 2000 оны татварын шинэчлэлийн хүрээнд бууруулсан. (Хэмжилтийн үндсийг харин эсрэгээр нь өргөтгөсөн.) Татварын шинэчлэлийн сүүлчийн шат 2005 оноос хүчин төгөлдөр болсон. Үүнээс хойш орлогын албан татварын дээд хувь хэмжээ 42% болоод байна. 1998 онд 53% байсан. Улс төрийн хэлэлцүүлэгт байнга нотолгоо болгоод байгаа Герман өндөр татвартай орон гэдэг яриа үндэслэлгүй юм. Гэхдээ нийгмийн даатгалын шимтгэлийн ачаалал олон улсын түвшинд харьцуулахад үнэхээр өндөр. Энэ нь хөдөлмөрийн зах зээл дээр сөрөг нөлөөтэй байж болох юм.

Скандинавын хэв шинжит татварын төр: Дани

Скандинавын хэв шинжит татварын төртэй орнуудад татварын нийт ачаалал өндөр. Орлогын албан татвар ба хэрэглээний албан татвар өндөр. Үүнээс гадна хувь хүмүүсийн орлогын албан татвар хүчтэй прогрессив үйлчилгээтэй. Нийгмийн ихэнх үйлчилгээ татварын системээс санхүүждэг тул нийгмийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээ болон цалингийн нэмэлт зардал доогуур.¹⁷

Татварын ачаалал бүхэлдээ өндөр: Орлогын болон хэрэглээний татвар өндөр

17 Скандинавын татварын төртэй орнуудын гэр бүлд багтдаг Швед улс мөн энэ чиглэлд явж байна.

	АНУ	Герман	Дани	ОЕСD-ийн гишүүн орнуудын дундаж
Зардлын нийт квот	28.0%	35.6%	49.1%	35.9%
Татварын квот	21.4%	21.8%	48.0%	26.8%
Орлогын албан татварын дээд хувь хэмжээ	35% 265.334- өөс дээш ¹⁸	42,0% 52.151-ээс дээш ¹⁹	59% 43.900- аас дээш ²⁰	
Босго татвар	10% ²¹	15%	5.48% ²²	
Татвараас чөлөөлөгдөх дүн	5.913	7.663	0 ²³	
Хөрөнгийн нийгэмлэгүүдийн татварын нэрлэгдсэн хувь хэмжээ ²⁴	39.88%	38.65% 29.83% 2008 он	25 %	
Хөрөнгийн нийгэмлэгүүдийн татварын үр өгөөжтэй хязгаар хувь хэмжээ (2008 он)	36.0%	27.3%	18,6%	
Нэмүү өртгийн татварын хувь хэмжээ	Н.а25	19.0%	25%	

18 Холбооны татвар. Муж улсуудын түвшинд тогтоогддог, холбооны түвшинд хураагддаг татварууд нэмэгддэг.

19 2007 онд баячуудын татварыг нэвтрүүлсэн. Үг журмын дагуу жилийн орлого нь 250,001 еврогоос дээш гарсан тохиолдолд 45%-ийн татвар ногдуулдаг.

20 Орлогын бүтцээс хамааран орлогын босгыг харилцан адилгүй тогтоодог.

21 Холбооны татвар

22 Нэгдсэн улсын татвар. Дээрээс нь хот, тосгоны татвар нэмэгддэг.

23 283 евро хүртэлх орлого татвараас чөлөөлөгддөг.

24 Нэгдсэн улсын болон орон нутгийн түвшинд хураагддаг хуулийн этгээдийн татвар, үйлдвэрлэл эрхэлсний татвар болон ижил төстэй бусад татварууд

25 Холбооны улсын түвшинд хувь хэмжээ нь өөрчлөгддөг, харьцангуй бага борлуулалтын татварууд

Татварын хувь хэмжээ, үзүүлэлтүүд юуг илэрхийлдэг бэ?

Зардлын квот нь ДНБ-нд бүх татвар ба зардлын эзэлж буй хувь хэмжээ юм. Татварын квот нь явцуу утгаар нь авч үзвэл татварын ДНБ-нд эзэлж буй нийт хувь хэмжээ юм.


Орлогын албан татварын дээд хувь хэмжээ нь орлого тодорхой хэмжээнээс дээш гарсан нөхцөлд ногдуулдаг татварын дээд хувь хэмжээ юм. Босго татвар нь татвараас чөлөөлөгдөх орлогын шугамаас дээш гарсан орлогод ногдох татварын хувь хэмжээ юм. Хуулиар тогтоосон орлогын дээд хэмжээнээс дээш олсон орлогын евро тус бүрт ногдох татварыг хязгаарын татварын хувь хэмжээ гэнэ. Бусад орлогод тухай бүрт мөрдөгдөж буй татварын хувь хэмжээ эсхүл татвараас чөлөөлөгдөх хууль үйлчилдэг. Хязгаарын орлогын татварын хувь хэмжээ ба татварын дундаж хувь хэмжээг хооронд нь ялгаж өгөх хэрэгтэй. Татварын дундаж хувь хэмжээ гэдэг нь дундаж орлогод ногдуулдаг хувь хэмжээ юм. Татварын прогрессив аргачлалыг хэрэглэдэг бол татварын дундаж хувь хэмжээнд хязгаарын татварын хувь хэмжээнээс доогуур байдаг.

Татварын нэрлэгдэх хувь хэмжээ нь хэмжилтийн тодорхой суурь дээр тооцсон хувь хэмжээ юм. Нэрлэгдэх хувь хэмжээ нь татварын үр өгөөжтэй хувь хэмжээнээс өөр. Үр өгөөжтэй хувь хэмжээ нь орлогын хэмжээ татварын хэмжилтийн сууриас давсан тохиолдолд орлогын ямар хэсэгт татвар ногдуулах бэ? гэдгийг тогтоодог. Энэ аргыг татвараас чөлөөлөгдөх орлогын хэмжээ, эсхүл татварын хөнгөлөлт эдлэх боломжтой үед хэрэглэдэг.

Хэлэлцүүлгийн сэдэв

Германд гэр бүл болсон эхнэр нөхөр хоёрын орлогыг нэгтгэж тооцоод татвар ногдуулдаг. Өөрөөр хэлбэл эхнэр, нөхрийн орлогыг хооронд нь нэмээд хоёр хуваагаад орлогын нийлбэрийн 50%-д зохих хувиар нэмэлт татвар ногдуулдаг. Энэ нь хувиарлалтад ямар нөлөө үзүүлэх бэ? Гэрлэсэн эхнэр нөхөр хоёрт орлогын татвар ногдуулснаар ямар үр дагаварт хүргэж болох бэ? Эсхүл бага орлоготой гэр бүлд ажил хийх сонирхол төрөх үү? Ер нь хувь хүний албан татвар дээр гэр бүлийн эхнэр нөхөр хоёрын орлогыг нэгтгэж тооцоод дахин татвар авахыг шударга гэж үзэж байна уу?

Дараахи графикт улс орнуудын татварын холимог системийг харуулж байна. Энэ графикаас төрийн татвараар бүрдүүлж буй нийт орлогын хэдэн хувь нь шууд татвараас, шууд бус татвараас, шимтгэлээс тус тус бүрдэж байгааг харуулж байна. Шууд татварт хамаардаг хөрөнгийн татварыг графикт тусад нь үзүүлсэн байна.




10-р зураг: 2006 оны татварын бүтэц

Хөрөнгө ба хөдөлмөрт ногдож буй ачаалал

Улсардынажахуйнүйлдвэрлэлийнхүчинзүйлстатварыначаалалхэрхэн хувиарлагдаж байгааг харахад англосаксоний орнуудад хөрөнгийн хүчин зүйл болон бусад үлдсэн хоёр хүчин зүйлс болох хөдөлмөр ба хэрэглээнд бараг тэнцүү татвар ногддог. Харин Скандинавын орнуудад хөдөлмөр ба хэрэглээнд хөрөнгөнөөс 50%-иар илүү татвар ногддог. Скандинавын орнуудын үйлчилгээний чадамж өндөртэй нийгмийн баримжаат төрийн зардлын санхүүжилтэд хөрөнгийн оролцоо маш бага байна. Мөн эх газрын нийгмийн баримжаат төртэй орнуудад хөдөлмөрийн ачаалал дэндүү өндөр байна. Нийгмийн баримжаат төртэй эх газрын ихэнх орнуудад хөрөнгө ба хөдөлмөрт ногдох татварын ачаалал германыхаас төдийлөн өндөр бус.

Германд: Хөрөнгө ба хөдөлмөрийн татварын ачаалал хэт тэнцвэргүй байна.



11-р зураг: Хөрөнгө ба хөдөлмөр+ хэрэглээнд ногдох татварын квот (1990-2000 оны дундаж үнэлгээ)

7.1.4. Татварын төрийн гурван хэв шинжид багтаж буй орнуудын амжилт ямар байна бэ?

Татварын төрөл бүрийн системүүд нь нийгмийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд ямар нөлөө үзүүлдэг юм бэ? Бид эхлээд хувиарлалтад үзүүлж буй нөлөөг дараа нь эдийн засгийн өсөлтийн амжилтыг харъя.

Англосаксоний орнуудын хувиарлалтын нөлөө

Англосаксоний татварын төр нь прогрессив аргачлалаар ногдуулдаг шууд татварууд дээр суурилдаг. Харин нийгэмлэгийн (ХК, ХХК) татварыг багаар бодоход хувь тэнцүүлэх аргачлалаар ногдуулдаг. Гэхдээ орлогын албан татварыг ногдуулж буй хувь хэмжээ нь харьцангуй жигд. Хөрөнгө ба үл хөдлөх хөрөнгийн татварын ачаалал нэгэн адил өндөр. Энэ нь эхлээд харахад гайхашрал төрүүлмээр боловч эцэстээ хувь хүмүүсийн статусыг биш харин хувь хүмүүсийн бүтээмжийг чухалчилдаг либерал үзэл санаандаа нийцэж байгааг харж болно. Гэхдээ татварын нийт ачааллын квот нь доогуур учраас төрд нь нийгмийн бодлогын арга хэмжээг хэрэгжүүлэх мөнгө бага байдаг. Тэгэхлээр англосаксоний татварын төртэй орнуудад хувиарлалт харьцангуй тэгш бус байх дүр зураг харагдаж байна.

Скандинавын орнуудын хувиарлалтын нөлөө

Скандинавын хэв шинжит нийгмийн баримжаат төр маш хүчтэй прогрессив аргачлалаар татвар ногдуулдаг, шууд татвар дээр суурилдаг тул татварын дахин хувиарлалтын нөлөө өндөр байдаг. Гэхдээ бусад онуудтай харьцуулахад үйлдвэрлэлийн хөрөнгийн хүчин зүйлд ногдох татварын ачаалал хөдөлмөрийн орлогод ногдох татварын ачааллаас бага. Дани улс дуал буюу хосолмол гэж нэрлэгддэг орлогын албан татварын системтэй. Уг аргачлалын дагуу хөрөнгийн орлогод хувь тэнцүүлсэн, бага хувь хэмжээгээр ногдуулж буй татвар нь хөдөлмөрийн орлогод ногдуулж буй татвараас доогуур байдаг. Өөрөөр хэлбэл хөрөнгийн татвар нь хөдөлмөрт прогрессив аргачлалаар ногдуулж буй татвараас доогуур. Мөн нийгмийн баримжаат төрийн санхүүжилтэд регрессив аргачлалаар ногдуулж буй шууд бус татварын эзлэх хувь хэмжээ өндөр. Хөрөнгийн албан татвар нь дунд зэрэг. Татварын нийт ачаалал өндөр тул маш сайн бэхэжсэн нийгмийн баримжаат төрийг санхүүжүүлэх боломжтой, төсвийн зарлагын тал дээр дахин хувиарлалтад нөлөө үзүүлэх хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх боломжтой. (4-р бүлэгтэй харьцуулна уу.) Бүхэлд нь авч үзвэл орлогын тэгш байдлыг өндөр хэмжээнд хангах боломжтой мэт дүр зураг харагдаж байна.

Хүлээлт: Тэгш
бус хувиарлалт
харьцангуй өндөр


Хүлээлт:
Харьцангуй тэгш
хувиарлалт

Эх газрын хэв шинжит нийгмийн баримжаат төрийн хувиарлалтын нөлөө

Эх газрын нийгмийн баримжаат төр нь шууд ба шууд бус татварын харьцангуй тэнцүү хувь хэмжээн дээр суурилдаг. Татварыг прогрессив аргачлалаар ногдуулдаг учраас дахин хувиарлалтын нөлөө нь өндөр байж таарна. Харин шууд бус татвар регрессив харин нийгмийн даатгалын шимтгэл хувь тэнцүүлсэн үйлчилгээтэй, гэхдээ эдгээр нөлөөг зориудаар бууруулах шаардлагагүй. Үүний нэгэн адил нийгмийн даатгалын шимтгэлийг хувь тэнцүүлсэн хувь хэмжээгээр ногдуулдаг практикийг өөрчлөх хэрэггүй. Гэхдээ хөрөнгийн татвар олон улсын түвшинд харьцуулахад маш бага, мөн үйлдвэрлэлийн хүчин зүйлс болох хөрөнгийн хүчин зүйлийн татварын ачаалал хөдөлмөрийн хүчин зүйлийн татварын ачаалалтай харьцуулахад бага. Татварын нийт хэмжээ дунд зэрэг. Эдгээр татвараас дахин хувиарлалтаас илүүтэйгээр хүмүүсийн статусыг хадгалахад чиглэгдсэн хөтөлбөрүүд хэрэгждэг. Тэгш бус байдлын хэмжээ дунд зэрэг үүгээрээ АНУ, Дани улсын дунд гэж ангилж болохоор дүр зураг харагдаж байна.

Хүлээлт: тэгш бус хувиарлалт дундаж өндөр хэмжээнд

Хэрвээ бид дээр дурьдсан гурван орны хувиарлалтын бодит үр дүнт аваад үзвэл бидний таамаглал зөв болох нь батлагдаж байна.



12-р зураг: 2000-аад оны дунд үе, хувиарлалтанд үзүүлж буй нөлөөлөл²⁶

26 Жини-коэффициент нь тэгш байдлын хэмжүүр юм. Жини коэффициент нь тэгш байдал бүрэн хангагдсан бол 0, тэгш бус байдал асар өндөр бол 1 гэсэн тоон утгатай байдаг. Тухайн улс орны олсон бүх орлогыг зөвхөн нэг хүн авдаг бол жини-коэффициент 1-тэй тэнцэнэ гэсэн үг.

Төсөөлөл батлагдаж байна: Дани улсын хувиарлалт хамгийн үр дүнтэй байна.


Унших жишээ: Дани улсын тэгш бус байдлыг илэрхийлдэг жини-коэффициент татвар, шилжүүлгийг хийхээс өмнө 0.39-тэй тэнцэж байна. Татвар төлж болон шилжүүлэг хийсний дараагаар жини-коэффициент нь 0.23-тай тэнцэж байна. Тэгш бус байдал нийгмийн халамж үйлчилгээ, мөнгөн тэтгэмжийг хувиарласны дараагаар 40.7%-иар буурсан байна.

Дани улсын орлогын хувиарлалт Германтай харьцуулахад “илүү тэгш” байгаад зогсохгүй татвар болон нийгмийн халамж үйлчилгээ, мөнгөн тэтгэмжийг олгосны дараагаар нөгөө хоёр улстай харьцуулахад илүү хүчтэй буурч байна. Анхдагч хувиарлалтын дараах жини-коэффициент өөрөөр хэлбэл татвар, нийгмийн халамж, үйлчилгээ, мөнгөн тэтгэлгийг олгохоос өмнөх зах зээлийн хувиарлалт татвар, нийгмийн халамж үйлчилгээ, мөнгөн тэтгэлгийг хувиарласны дараах бодит орлогыг хүртсэний дараа 40%-иар буурч байхад Германд 30%, АНУ-д зөвхөн 18%-иар буурч байна. (OECD 2008Б 109-р тал)

Зардлын квот өндөртэй татварын бодлоготой, татварын прогрессив аргачлалыг хэрэглэдэг, дахин хувиарлалтад чиглэсэн зарлагын бодлогыг хэрэгжүүлдэг орнуудад бодлогын зорилт биелэгдэж байгааг харуулж байна.

Тэгш байдлыг өндөр хэмжээнд хангасны төлөөсөнд эдийн засгийн өсөлт буурдаг уу?

Шударга ёс ба үр өгөөжийн зорилтууд хоорондын зөрчилдөөний тухай онолын дагуу засгийн газрууд тэгш хувиарлалтын зорилтыг хэрэгжүүлж чадсанахаа хариуд эдийн засгийн өсөлтөөс татгалзах хэрэгтэй болдог уу? гэсэн асуулт зайлшгүй гарч ирнэ.



13-р зураг: Зардлын квот ба эдийн засгийн өсөлт (1993-2006)

Унших жишээ: Швед улсын зардлын квот 1993-2006 онд дунджаар 49% байхад эдийн засгийн өсөлт нь 2,8%, Японы зардлын квот 27% хувьтай байхад эдийн засгийн өсөлт нь 1,2%-тай байжээ.

Зардлын квот ба эдийн засгийн өсөлтийн харьцаа

Зардлын квот ба эдийн засгийн өсөлтийн хооронд ямар нэгэн хамаарал байхгүй гэдгийг 13-р зураг харуулж байна. Бага татвартай орнуудын дунд эдийн засгийн өсөлт доогуур болон өндөртэй орнууд байна. Мөн өндөр зардалтай орнуудын дунд ч эдийн засгийн өсөлтийн хувь хэмжээ доогуур болон өндөр орнууд байна. Үр өгөөж ба шударга ёсны зорилтуудын хооронд энгийн зөрчил байгаа нь эмпирик судалгаагаар батлагдаагүй.

Гэхдээ энэ нь татвар эдийн засгийн өсөлтөд огт нөлөөлдөггүй гэсэн үг биш. Зардлын квотоос гадна бусад хүчин зүйлсийг харгалзан үзэх шаардлагатай. Нэг талаас татвар болон нийгмийн системийн өсөлтөд нөлөөлөх нөлөө татварыг юунд зарцуулж байгаагаас, нөгөө талаас татвараас санхүүжүүлж байгаа нийгмийн үйлчилгээ, мөнгөн тэтгэмж, халамж зэрэг нь эерэг бүтээлч үр дүнг авчирч байна уу? гэдгээс хамаардаг. (4-р бүлгээс харна уу) Өөр нэгэн тайлбар бол скандинавын өндөр татвартай орнуудын эдийн засгийн өсөлтийн хувь өндөр байгаа нь өсөлтөд ээлтэй хөрөнгө оруулалтын орчныг бүрдүүлж чадсан, хөрөнгийн хүчин зүйлд хөдөлмөрийн хүчин зүйлээс харьцангуй бага татвар ногдуулдагтай нь холбоотой байж болох юм.

Орлогын хосолмол албан татвар ба олон улсын татварын өрсөлдөөн

Аливаа улс оронд хөрөнгийн орлого, жишээлбэл компанийн ашигт бага татвар ногдуулбал ашигтай байх хоёр шалтгаан байна. Нэгдүгээрт: Хөрөнгө оруулалтанд ээлтэй орчин бүрдэж улмаар өсөлтөд эерэг үр дүн гарна. Хоёрдугаар шалтгаан бол татварын өрсөлдөөн юм. Үүнд: татварын ачааллыг бага хэмжээнд тогтоосноор бусад орнуудаас мовил буюу хөдөлгөөнт хөрөнгийг татаж чадна.

Дээрх хоёр шалтгааны улмаас скандинавын хэв шинжит улс орнууд хөрөнгийн татварын хувь хэмжээг хөдөлмөрийн буюу хөдөлмөр хийгээд олсон орлогод ногдох татвараас багаар тогтоодог орлогын хосолмол татварыг нэвтрүүлсэн юм. Гэхдээ олон хүмүүс иймэрхүү хэлбэрээр тэгш бус хандах нь бүтээмжийн чадамжийнх нь хэрээр татвар ногдуулах зарчмыг зөрчиж байна хэмээн шүүмжилдэг. Хөрөнгийн орлого нь эцэстээ бол хувь хүний бүтээмжийн чадавхийн нэгэн шалгуур үзүүлэлт юм. Иймээс нийгмийн баримжаат төрийг үйл ажиллагааг хангах болон хөрөнгийн орлогыг хүртэгсдийг нийгмийн баримжаат төрийн санхүүжилтийн зардалд зохистой хэмжээгээр оролцуулахыг хүсвэл татварын өрсөлдөөнийг олон улсын түвшинд зохицуулах шаардлагатай байна.

(5.1. Даяаршил бүлгээс харна уу)

*Судалгаанууд:
ямар нэгэн шууд
хамаарал байхгүй
гэдгийг харуулж
байна.*

*Нөлөөлөх хүчин
зүйлс: Мөнгийг
юунд зарцуулдаг
бэ?*

**Гүнзгийрүүлэн унших
эх сурвалжууд:**
*Штеффен Гангхоф
(2004 он), Татварын
бодлогыг хэн засагладаг
бэ? Олон улсын
өрсөлдөөн ба үндэсний
хувиарлалтын
зөрчилдөөний дүнд
хавчуулагдсан орлогын
албан татварын
шинэчлэл, Франкфурт
Ам Майн.*

*Суанне Уул, Томас
Риксен (2007 он),
Компанийн татварыг
европын холбооны
түвшинд нэгдсэн
системд оруулах
замаар гишүүн
орнуудын үйл
ажиллагааны орон зайг
тэлэх нь Фридрих-
Эбертийн Сангийн
захиалгаар хийсэн
үнэлгээ, Фридрих-
Эбертийн Сан, Бонн
хот*

Энэ нь нийгмийн ардчилалд юу гэсэн үг бэ?

- Нийгмийн зардлын санхүүжилтэд хүчтэй нь хүчгүйгээсээ илүү мөнгө төлдөг зарчмыг мөрдөх хэрэгтэй гэсэн үг.
- Орлого нэмэгдэхийн хэрээр татварын ачааллыг нэмэгдүүлдэг прогрессив аргачлалаар орлогын болон хөрөнгийн татварыг ногдуулах нь энэ зарчимд нийцнэ. Шууд бус татвар (Жишээлбэл нэмүү өртөгийн албан татвар) ба шимтгэлийн систем нь харин эсрэгээрээ регрессив аргачлалаар татвар, шимтгэлийг ногдуулдаг. Шууд бус татвар ба шимтгэл нь хүчгүйд нь илүү ачаа үүрүүлж байна.
- Гэхдээ татварын хувиарлалтад үзүүлэх нөлөө нь зөвхөн орлогын тал дээр прогрессив аргачлалыг хэрэглээд зогсохгүй мөнгөө юунд зарцуулж байгаагаас болон хичнээнийг зарцуулж байгаагаас хамаардаг.
- Социалдемократ хэв шинжит нийгмийн баримжаат төртэй орнууд татварын болон нийгмийн системүүдээрээ дамжуулан эдийн засгийн динамикийг сааруулахгүйгээр орлогыг харьцангуй тэгш хувиарладаг.
- Хэрвээ олон улсын хамтын ажиллагааны хүрээнд корпорациудын татварын өрсөлдөөнийг гааруулаад байдгаа больчихвол нийгмийн системүүдийн санхүүжилтэд хөрөнгийн хүчин зүйлсийн оролцоог сайжруулах боломжтой.

7.2. Хөдөлмөр

Энэхүү бүлэгт:

- Германы ажилгүйдлийн даатгалын тогтолцоог тодорхойлж Дани ба Их Британийн загвартай харьцуулна.
- Даатгалын системүүдийг шударга ёсны төрөл бүрийн цар хүрээний дагуу үнэлнэ.
- “Мэргэжлийн даатгал” шинэчлэлийн санаануудыг тайлбарлана.

Ажилгүйдэлд өртөх нь зөвхөн орлогоо алдаад зогсохгүй, их хохиролтой.

Ажилгүйдэлд өртсөн хүн зөвхөн ажил хийгээд олдог байсан орлогоо алдаж материаллаг хохиролд ороод зогсохгүй, өөртөө итгэх итгэлээ алдах, ямар ирээдүй угтаж байгаа бол? гэдэг айдаст автах зэрэг сэтгэл санааны сөрөг үр дагавруудтай байдаг. Урт хугацаанд ажилгүй байсан нөхцөлд нийгмийн үнэлэмж нь буурч улмаар эрүүл мэнд, сэтгэл санаагаар хохирдог.

Ажилгүйдлийн даатгалын үүсэл

19-р зуунд ажилгүйдлээс үүдэлтэй ядуурал ба зовлон зүдгүүр улам ноцтой асуудал болсоор байлаа. Хүн амын эрс өсөлт, хот руу чиглэсэн нүүдэл хүчээ авсантай холбоотойгоор тосгоны ахан дүүсийн болон хөршийн холбоо суларч ажилгүйдэлд өртөж орлогогүй болсон хүмүүс аж үйлдвэржилтийн өмнөх үетэй харьцуулбал илүү зовлонд зүдгүүрт автах болсон юм. 19-р зууны либералчлалын давалгаанд хамагдаж эрүүл саруул хэрнээ зовлон зүдгүүрт автсан хүмүүст залхуу, ажил хийх дургүй нэр зүүж ялгаварлан гадуурхаж, хууль дүрмээр далайлгаж байж ядууст үзүүлдэг тусламжид хамруулдаг байв. Ядууст үзүүлдэг тусламжийг авсныхаа хариуд иргэний эрхээ, нэн ялангуяа сонгох, сонгогдох эрхээ хасуулдаг байв.

Аж үйлдвэржилт ажилгүйдлийн асуудлыг хурцатгасан.

19-р зууны сүүлчээр европын олон оронд ажилчид нэгдэж улс төрийн нам байгуулж эхэлсэн юм. Ихэнх орнуудад ажилчин ангийнхны зүгээс үзүүлсэн нийгэм, улс төрийн шахалтын улмаас нийгмийн даатгалыг үүсгэн байгуулж нийгмийн даатгал нь аажмаар ядуусын тусламжийг халсан юм.

Ажилчин ангийн дарамт шахалтаар нийгмийн даатгал үүссэн.

Их Британид анхны ажилгүйдлийн даатгал үүсэн байгуулагдсан нь Ийнхүү анхны төрийн ажилгүйдлийн даатгал үүсгэн байгуулагдсан түүхтэй. 1911 онд Их Британи нь улс орон даяараа албан ёсны даатгал нэвтрүүлсэн анхны орон болсон юм. Ажилгүйдлийн даатгалын үйлчилгээ, тэтгэмжийн хэмжээ нь амьжиргааны баталгаажих доод түвшинг хангахад чиглэгдэж байлаа. Тэтгэмжийн хэмжээг доогуур тогтоох, тэтгэмж авах хугацааг хязгаарлах, хүлээлтийн хугацаа урт, ажил хайх үүргийг ногдуулах зэрэг арга хэмжээнүүд нь ажилгүйдлийн даатгалын тэтгэмжийг буруугаар ашиглахаас урьдчилан сэргийлэхэд чиглэгддэг.

1919 онд анхны ажилгүйдлийн даатгал байгуулагдсан.

Герман

Герман улс эрүүл мэнд болон гэнэтийн ослын даатгалыг үүсгэн байгуулахад бусад орнуудаас олон жилээр түрүүлж анхдагч байж чадсан ч (1883,1884) ажилгүйдлийн даатгалыг харьцангуй орой 1927 онд албан ёсны даатгал болгон нэвтрүүлсэн байдаг. 1927 оныг хүртэл томоохон хотуудад үйлдвэрчний эвлэлээс зохион байгуулдаг, хотоос санхүүгийн татаас авдаг даатгалын газрууд байжээ.

Герман: Ажилгүйдлийн даатгалыг харьцангуй орой нэвтрүүлсэн. (1927 он)

Ядуусын тэтгэмжийг халж улс орон даяар ажилгүйдлийн даатгалыг

нэвтрүүлснээр ажилгүй хүмүүс олдсон ажил болгоныг хийх дарамтаас ангижирсан байна. Германы ажил олгогчид орон даяар үйлдвэрчний эвлэлийн удирдлагатай ажилгүйдлийн даатгалыг байгуулах сонирхолгүй байсан тул эцэст нь ажил олгогч ба ажилтнуудын өөрийн удирдлагын дор ажилладаг ажилгүйдлийн даатгалыг байгуулах санаачилгыг өрнүүлсэн нь 1927 онд биеллээ олсон юм. Шинээр үүсгэн байгуулагдсан даатгалыг төр, үйлдвэрчний эвлэл, ажил олгогчдын гурван талын төлөөлөл удирдаж байлаа.

Дани

Дани:
Үйлдвэрчний
эвлэлээр
дамжуулан сайн
дурын даатгалыг
үүсгэн байгуулсан.

Албан ёсны буюу заавал даатгуулах төрийн даатгалын загвар бүх оронд байгуулагдаж чадаагүй. Данид ажилгүйдлийн даатгал нь өнөөдрийг хүртэл заавал даатгуулах даатгал биш. Үйлдвэрчний эвлэлүүд ажилгүйдлийн даатгалыг удирдаж тэр хэрээр ажилгүйдлийн тэтгэмж авах эрхтэй байхын тулд үйлдвэрчний эвлэлийн зохион байгуулсан ажилгүйдлийн даатгалын газруудын аль нэгэнд гишүүнчлэлтэй байх шаардлагатай.

Данийн ажилчдын
75-80% нь
үйлдвэрчний
эвлэлийн
гишүүн буюу
ажилгүйдлийн
даатгалд
хамрагдсан
байдаг.

Данийн ажилчдын 75-80% нь ажилгүйдлийн даатгалтай байдаг. Мөн ажилчдынх нь 75-80% нь үйлдвэрчний эвлэлийн гишүүн байдаг. Ажилгүйдлийн даатгал нь хэний удирдлагад байна бэ? гэдгээсээ гадна бусад онцлог шинжүүдтэй байдаг. Аж үйлдвэржсэн орнуудын ажилгүйдлийн даатгалууд хоорондоо ихээхэн ялгаатай гэдгийг Герман, Дани, Их Британийн харьцуулалтаас тодорхой харж болно.

Ажилгүйдлийн мөнгөний хэмжээ

Хэмжээ харилцан
адилгүй: Дани
90%, ХБНГУ 65-
67%

Харьцуулалтанд байнга хэрэглэдэг үзүүлэлтүүд бол ажилгүйдлийн мөнгөний хэмжээ ба олгох хугацаа. Германд ажилгүйдэлд өртсөн ажилтанд хүүхэдтэй бол өмнө нь авч байсан цэвэр орлогын 67 %, хүүхэдгүй бол 60%-ийг ажилгүйдлийн тэтгэмжийн мөнгө хэлбэрээр олгодог. Гэхдээ уг хэмжээг шимтгэлийн хувь хэмжээг шимтгэл тооцох дээд хязгаараас тооцдог. (Сар бүрийн нийт орлого баруунд 5.300- зүүнд 4.300 евро, 2008 оны байдлаар) Ажилгүйдлийн тэтгэмжийн мөнгийг хүүхэдгүй ажилтанд сар тутамд 1.600 евро хүртэл, гэрлэсэн, нэг хүүхэдтэй бол 1.800 евро хүртэл олгодог. Үүнтэй харьцуулахад Дани улсад өмнө нь авч байсан нийт цалингийн 90%-ийг ажилгүйдлийн тэтгэмжийн мөнгөнд олгодог. Ажилгүйдлийн тэтгэмжийн мөнгөний дээд хэмжээ сар бүр ойролцоогоор 1.700 евро байдаг. Үүнээс гадна Данид ажилгүйдлийн тэтгэмж авагсад

тэтгэмжээсээ татвар төлдөг. Бага орлоготой байгаад ажилгүй болсон Данийн иргэд Германы ижил төстэй ажилчдаас илүү өндөр тэтгэмж авдаг бол өндөр орлоготой байсан хүмүүс германыхаас бага тэтгэмж авдаг.

Их Британида ажилгүйдэлд өртсөн ажилтан бүр өмнө нь хэрхэмжээний орлоготой байснаас үл хамааран бүгд ижил хэмжээтэйгээр буюу долоо хоногтоо 60,50 фундыг ажилгүйдлийн тэтгэмжинд авдаг. Энэ нь фаундын хөрвөх ханшнаас хамаараад долоо хоног тутмын 60-90 евро гэсэн үг. Харин тэтгэмж авагч 25-аас доош настай бол тэтгэмжийн хэмжээ нь бага байдаг. Түрээсийн төлбөрт тусгай нэмэгдэл хүссэн өргөдөл гаргаж болно. Их Британийн ажилгүйдлийн даатгалаас олгож буй мөнгөн тэтгэмжийн хэмжээ нь германы суурь даатгалын мөнгөтэй ойролцоо хэмжээтэй байна. (Ажилгүйдлийн тэтгэмж-2, HARZ 4 хөтөлбөр)

Ажилгүйдлийн тэтгэмж олгох хугацаа

Тэтгэмж авах хугацаа нь мөнгөн тэтгэмжийн хэмжээнээс илүү их зөрүүтэй байдаг. Германд ажилгүйдлийн тэтгэмжийн мөнгө авах хугацааг даатгуулагчийн наснаас хамааран тогтоодог. 50-иас доош насны бүх даатгуулагчдын хувьд тэтгэмж олгох хугацаа нь дээд тал нь 1 жил байдаг бол 50 настанд 15 сар, 55 настанд 18 сар, 58 настанд дээд тал нь 2 жил үргэлжилдэг. Их Британид ажилгүйдлийн тэтгэмжийг дээд тал нь 26 долоо хоногийн турш олгодог, дараа нь хэмжээний хувьд ажилгүйдлийн тэтгэмжийн мөнгөтэй ижил, ажилгүйдлийн тусламж авах эрх нь үүсдэг. Харин ажилгүйдлийн тусламжийг илүү хатуу нөхцөлтэйгөөр олгодог. Харин Данид ажилгүйдлийн мөнгийг дөрөв хүртэлх жилийн хугацаанд олгодог.

Санхүүжилт

Мөн түүнчлэн улс орнууд ажилгүйдлийн мөнгийг өөр өөр арга замаар санхүүжүүлдэг. Германд цалингийн гурван хувьтай²⁷ тэнцэх шимтгэлийг ажилтан, ажил олгогч хоёр тэнцүү хувиар төлдөг бөгөөд мөн дээрхийн адил шимтгэлийн хувь хэмжээг тооцох хязгаарыг 5.300-4.500 еврогийн хооронд тогтоож өгсөн байдаг. Данид ажилтан дангаараа нийт цалингийнхаа 8%-тай тэнцэх мөнгийг ажилгүйдлийн

*Их Британи:
Долоо хоног
тутамд 50-60
фунд авдаг.*

*Олгох хугацаа
харилцан адилгүй,
хоорондоо асар
зөрүүтэй.*


*Санхүүжилт нь
хоорондоо асар
том зөрүүтэй.*

27 2009 оны 1-р сарын 1-нээс 2010 оны 6-р сарын 30-нийг хүртэл зөвхөн 2,8%-ийг төлнө.

даатгалд төлдөг бөгөөд шимтгэл тооцох орлогын дээд хязгаарыг тогтоодоггүй. Их Британид ажилгүйдлийн даатгалд тусгайлсан шимтгэл төлдөггүй. Британид нийт цалингийн 23,8%-тай тэнцэх (ажилтан 11%, ажил олгогч 12,8%) шимтгэлийг бүхэлд нь нийгмийн даатгалын шимтгэлд төлдөг. Бүхэлд нь төлсөн нийгмийн даатгалын шимтгэлээс ажилгүйдлийн мөнгөний зэрэгцээ, төрийн тэтгэвэр, эрүүл мэндийн систем, амаржихын өмнөх болон дараагийн мөнгө, хөдөлмөрийн чадвараа алдсаны мөнгө зэргийг санхүүжүүлдэг. Их Британид мөн орлогын дээд хэмжээг тогтоож өгдөг. (ойролцоогоор 4.500 евро) үүнээс дээгүүр орлоготой бол шимтгэл төлөх хувь хэмжээг 13.8% болгон бууруулдаг. (1% ажилтан, 12.8% ажил олгогч)

Хэмжээ, олгох хугацаа ба шударга ёс

Герман болон Дани улсад ажилгүйдлийн тэтгэмжид олгох мөнгөний хэмжээг ажилгүйдэлд өртөхөөс өмнөх орлогын хэмжээтэй уялдуулан тогтоодог. Барилгын энэхүү хийц буюу даатгалын бүтцээс бүтээмжийн шударга ёсны зарчмыг олж харж болно. Хэн ажилгүйдлийн даатгалд их мөнгө төлнөв? Тэр төлсөн мөнгөнийхээ хэмжээгээр илүү ихийг авах ёстой. Гэхдээ Данид энэ зарчим зөвхөн өмнөх орлого нь дундаж орлогын ойролцоогоор 70%-иас доош байсан хүмүүст үйлчилдэг. Харин дундаж орлогын 70%-иас дээш орлоготой байсан хүмүүсийн хувьд нэгдсэн хувь хэмжээгээр тэтгэмж авдаг. Үүгээр ч зогсохгүй, Данид Герман шиг шимтгэл тооцох орлогын дээд хязгаарыг тогтоодоггүй учраас өндөр орлоготой байсан хүмүүс ажилгүйдлийн даатгалд бага орлоготой хүмүүсээс илүү ихийг төлдөг. Данитай харьцуулахад Германд дахин хувиарлалт тун бага хэмжээгээр хийгддэг.



14-р зураг: Орлогыг орлох цэвэр орлогын хувь хэмжээг олон улсын түвшинд харьцуулсан байдал

Өнгөцхөн харахад Их Британид бусад хоёр оронтой харьцуулахад ажилгүйдлийн даатгалын мөнгөний хэмжээ бага мэт харагдаж байна. Энэ нь бага орлоготой хүмүүсийн хувьд ажилгүйдэлд өртөөд орлого нь багасдаг гэсэн үг биш. Орлого нь дундаж цалингаас доогуур байсан ажилгүй хүмүүст нэгдсэн тарифаар ажилгүйдлийн мөнгө олгодог. Уг хэмжээ нь германд дунджаас доогуур орлоготой ажил эрхэлж байгаад ажилгүйдэлд өртсөн даатгуулагчийн ажилгүйдлийн даатгалын мөнгөний хэмжээтэй ойролцоо байдаг. Их Британийн дундаж цалин ба түүнээс дээгүүр орлоготой байсан даатгуулагчид Герман болон Данийн ажилгүйчүүдтэй харьцуулахад харьцангуй бага мөнгө авдаг. Тэгэхлээр Британид дундаж ба түүнээс дээгүүр орлоготой даатгуулагчдын хүрээнд дахин хувиарлалтын нөлөө хүчтэй, бүтээмжийн шударга ёс ажилгүйдлийн мөнгөний хувьд хэрэглэгддэггүй. Бүтээмжийн шударга ёсны оронд тэгш байдлын зарчим (гэхдээ орлогын доогуур түвшинд) барилгын бүтцэд шийдвэрлэх үүргийг гүйцэтгэдэг.

Тэгш байдлын зарчим: Их Британи (доогуур түвшинд)

Энэ асуудал нь өөрөө шударга ёсны ямар зарчмуудыг үндэслэн ажилгүйдлийн мөнгөний хэмжээ, олгох хугацааг тогтоох юм бэ? гэдэг дараагийн асуултад хөтөлнө. HARZ-4 шинэчлэлийн хүрээнд өрнөсөн хэлэлцүүлгүүд хүмүүсийн дийлэнх нь “Шимтгэлийг удаан хугацаагаар төлсөн хүмүүс их тэтгэмж авах ёстой” гэдэг бодолтой байдаг гэдгийг харуулсан. Энэ нь даатгалын логиктой ямар ч хамааралгүй асуудал. Та пальтогоо яаруу тэвдүү өмсөж байхдаа хөршийнхөө коридортоо тавьсан үнэтэй ваарыг унагаагаад хагалж орхиж гэж бодъё. Хариуцлагын даатгалд та хичнээн удаан хугацаагаар мөнгө төлсөн байлаа ч даатгалаас танд мөнгө олгохгүй. Ваар хямд бол төлнө, үнэтэй бол төлөхгүй гэдэггүй, таныг хариуцлагын даатгалд хэр удаан мөнгө төлснөөс үл хамааран даатгалын газраас ваарны үнийг нөхөн олгодог. Ваарыг төлөхөд гаргасан зардлыг тань нөхөн олгоход таны өмнө нь авч байсан орлогын тодорхой хувийг буцаан олгох журам илүү шударга. Орлогыг орлох мөнгөний хэмжээнд даатгуулагч хэр удаан хугацаагаар шимтгэл төлсөн бэ? гэдэг нь шимтгэл төлсөн хугацааныхаа хэрээр нэмэгдэл авах үндэслэл болохгүй.

Тэтгэмжийн мөнгийг олгох хугацаа бол шалгуур биш

Германд удаан жилийн хугацаанд орлогын түвшин ажилгүйдэлд өртсөн тохиолдолд насан туршдаа ажилгүйдлийн даатгалаас тэтгэмж авахад хүрэлцдэг байлаа. Харин ажилгүйдлийн тусламж ба нийгмийн халамжийг нэгтгэж ажилгүйдлийн мөнгө 2 болгосны

дараагаар ажилгүй болсноос хойш 12 сар буюу нэг жилийн дараагаар зөвхөн суурь даатгалын мөнгийг (Ажилгүйдлийн мөнгө 2 эсхүл HARZ 4) олгодог болсон. Ахимаг настангуудын ажилгүйдлийн тэтгэмжийн мөнгө авах хугацааг 2006 оны 2-р сараас тусгайлан найман сараар сунгасан (Нийтдээ 24 сар хүртэл) байна. Энэ нь тэгш байдлын зарчимд нийцэхгүй ч боломжийн шударга ёсны зарчмаар зөвтгөх боломжтой. Учир нь ахимаг насныхны хөдөлмөрийн зах зээл дээр ажил олох боломж залуучуудаас илүү хязгаарлагдмал хэвээрээ байна. Ахимаг насныхны ийнхүү боломж муутай байгаа нь тэдний өөрсдийн буруу биш тул аргагүй байдлыг харгалзан үзэж тэтгэмж олгох хугацааг уртасгаж байгааг зөвтгөх үндэслэлтэй юм.

Тэтгэмжийн
хэмжээ 5 жилийн
дараа

Ажилгүйдэлд өртсөнөөс хойш нэг жилийн дараагаар ажилгүйдлийн тэтгэмжид авч буй мөнгөний хэмжээг харьцуулж үзвэл Герман, Их Британи, тодорхой ялгаа байхгүй, Данид мөнгөн тэтгэмжийн хэмжээ илүү өндөр байна. Учир нь тэнд ажилгүйдлийн мөнгийг дөрөв хүртэлх жилийн хугацаанд олгодог. (14-р зурагтай харьцуулна уу)

Эрх ба үүрэг

Шимтгэл төлсөн хугацаа нь хангалттай байх нөхцөлд Их Британид ажилгүйдлийн мөнгө авснаас хойш хагас жил өнгөрсний дараагаар (Ажилгүйдлийн мөнгөтэй ижил хэмжээний ажилгүйдлийн тусламжийг) авдаг. Германд ажилгүйдлийн мөнгийг (Хэрэв даатгуулагч 50-иас доош настай бол) нэг жилийн хугацаанд олгодог бол Данид 4 жилийн туршид ажилгүйдлийн мөнгийг олгодог. Эдгээр тоонууд харьцуулалтанд сонгон авсан бүх оронд ажилгүйдлийн мөнгийг олгоход тодорхой болзол шалгуур тавьдаг, эдгээрийг хэдэн жилийн өмнөөс "эрх ба үүрэг" эсхүл "хөдөлмөрийн зах зээлийн идэвхжүүлэгч бодлого" гэдэг ойлголтын дор нэгтгэж хэлэлцүүлэг өрнүүлдэг болжээ. Ажилгүйдлийн мөнгийг олгох үндсэн болзол нь: бүх оронд ажил идэвхтэй хайгч байх. Ажил хайгаад ч амжилт олоогүй нөхцөлд ажилгүйчүүдэд тодорхой цаг хугацаа өнгөрөх бүрт бусад арга хэмжээнд хамрагдах, оролцох үүргийг ногдуулдаг. Данид нэг жил өнгөрсний дараагаар, Их Британид 18 сар өнгөрсний дараагаар (залуу ажилгүй хүнд нэг жилийн дараагаар) тодорхой үүрэг ногдуулдаг. Германд хуулиар тогтоосон хатуу хугацаа байхгүй ч ажилгүйдлийн мөнгө олгох хугацаа дуусгавар болмогц (нэг жилийн дараагаар гэсэн үг) мөнгө олгох нөхцөлийг чангаруулдаг.

Тэтгэмж олгох
болзол

Ажилд дахин оруулах

Харьцуулалтад хамрагдсан бүх орнуудад ажилгүй хүмүүст 12-18 сарын дараагаас ажилд дахин боломжийг нь нэмэгдүүлэх зорилготой тусгай хөтөлбөрүүдэд хамрагдах үүргийг ногдуулдаг. Ажилгүй хүнд төрийн дарамт шахалтгүйгээр дахин ажилд олоход олгож буй хугацаа нь ойролцоо. Ажил хайлт амжилтанд хүрээгүй нөхцөлд хөдөлмөрийн бирж ажил хайгчид ажлын байртай болох боломжийг нь нэмэгдүүлэх тусгай хөтөлбөрт хамрагдахыг үүрэг болгодог. (Идэвхжүүлэх хөтөлбөрүүд) Эдгээр хөтөлбөрүүдийн агуулга нь орон бүрт харилцан адилгүй байдаг.

Төрөл бүрийн зорилтот хөтөлбөрүүд

Их Британид дээрх идэвхжүүлэх хөтөлбөрүүдийг “Шинэ үйлс” гэж нэрлэдэг. Эдгээр хөтөлбөрүүд ажилгүй хүнийг ажиллуулсныхаа хариуд татаас авдаг компанид зургаан сар ажиллах, дээд тал нь 12 сар үргэлжилдэг мэргэжил олгох-мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдах эсхүл нийтийн тусын төлөө ажилладаг байгууллагад 6 сар ажиллах үүргийг ногдуулдаг. Хэрвээ ажилгүй хүн хөдөлмөрийн биржээс санал болгож буй дээрх хөтөлбөрүүдийн аль нэгэнд нь хамрагдахгүй бол ажилгүйдлийн мөнгөний хэмжээг бууруулдаг.

Их Британийн “Шинэ үйлс” хөтөлбөр

Данид боловсрол төвтэй хөтөлбөрүүдийг санал болгодог. Эдгээр нь цаг хугацаа их шаарддаг, урт хугацаанд үргэлжилдэг хөтөлбөрүүд байдаг. Ингэснээр зөвхөн богино хугацааны хөтөлбөрүүд бус мэргэжил олгох сургалтыг “ердийн” боловсролын тогтолцооны хүрээнд санал болгодог. Данид ч нэгэн адил хөдөлмөр эрхлэлтийн сангаас татаас олгодог ажлын байрууд байдаг бөгөөд эдгээр хөтөлбөрүүдийг мэргэжил дээшлүүлэх хөтөлбөрүүдтэй холбож өгөх шаардлагатай. Мөн тодорхой хугацаагаар завсарлага авдаг, ротацийн ажлын байранд ажилладаг ажилчидтай ээлжлэн ажиллах боломжтой. Хөдөлмөрийн зах зээлийн хөтөлбөрүүдийн хүрээнд бага цалинтай секторыг онцгойлон дэмжихээс эрс татгалздаг. Хувь хүмүүсийн хөтөлбөрөөс сонголт хийх боломжтой ч заавал оролцох идэвхжүүлэлтийн хөтөлбөрийн төлөвлөгөөний дагуу сонголтоо хийхийг шаарддаг. Эдгээр идэвхжүүлэх хөтөлбөрт оролцох эсэх нь харин сайн дурын хэрэг биш харин ажилгүйдлийн мөнгийг үргэлжлүүлэн авах болзол нь болдог.

Дани: Боловсрол төвтэй хөтөлбөр

Германд Данийн нэгэн адил тохиролцоо буюу гэрээг хөдөлмөрийн бирж ба ажил идэвхтэй хайгч нарын хооронд байгуулагддаг.

Герман: Ажилд дахин оруулах тохиролцоонууд

Мөн HARZ-4 хөтөлбөрийн хүрээнд ажилгүйчүүдийн эрх ба үүргийг шинэчлэн тодорхойлох оролдлогыг хийсэн. Ингэснээр ажилгүйчүүдийн эрхийг нэмэгдүүлэх зорилгоор хөдөлмөрийн агентлагийн зүгээс идэвхжүүлэх хөтөлбөрүүдийг санал болгож байгаа ч нөгөө талаас уг хөтөлбөрүүд нь ажилгүйчүүдийн хөтөлбөрт заавал хамрагдах дарамтыг нэмэгдүүлэхэд чиглэгдэж байгаа юм. Сургалтын болон мэргэжил дээшлүүлэх хөтөлбөрүүдийг германд нэгэн адил санал болгодог бөгөөд эдгээр нь хөдөлмөрийн зах зээлийн идэвхтэй бодлогын цөмийг бүрдүүлж байдаг. Ажилгүй хүмүүсийг ажилд авсны нэмэгдэл, хувиараа хөдөлмөр эрхлэгсдэд олгодог компани аж ахуйн нэгж шинээр байгуулсны нэмэгдэл, эсхүл урт хугацаагаар ажилгүй байсан хүмүүст зориулсан нэг евроны жов хэмээн нэрлэгддэг хөтөлбөр буюу олон нийтийн тусын тулд хийгддэг тохиолдлын чанартай ажлын байр зэрэг ажилгүйчүүдийг хөдөлмөрийн зах зээлд нэгтгэх арга хэрэгслүүд илүү чухал байдаг. (Эдгээр ажлыг хийснийхээ хариуд ажилгүйдлийн мөнгө 2 дээр нэмээд ажил хийсэнтэй холбоотой гарсан нэмэлт зардлуудыг буцааж олгодог, санхүүжилтийг нь “нэг евроны ажил” нэрийн дор боловсруулсан хөтөлбөрөөс санхүүжүүлдэг.)

Хөдөлмөрийн зах зээлийн идэвхтэй бодлогын зардал

Ажилгүй хүн тутамд ногдох боловсрол/ сургалтын зардал еврогоор	Дани (2004* он)	Герман (2006 он)	Их Британи (2006 он)	Европын Холбооны гишүүн 15 улс (2006 он)
	6.649,12	1.859,47	228,06	1.650,09

Данийн талаар сүүлийн үеийн тоо баримт олдоогүй. (Эх сурвалж: Европын Холбооны статистик, хувийн тооцоо)

Мэргэжил олгох болон мэргэжил дээшлүүлэх сургалтын зардал

Герман улс Европын Холбооны гишүүн 15 орны дунд мэргэжил олгох болон мэргэжил дээшлүүлэх сургалтын зардлын үзүүлэлтээрээ дунджаас дээгүүрт ордог. Их Британиас харьцангуй их мөнгийг ажилгүйчүүдэд мэргэжил олгох, мэргэжил дээшлүүлэх сургалтад зарцуулдаг. Дани улстай харьцуулахад тун бага мөнгийг зарцуулдаг. Эдгээр дүгнэлтүүд өнгөцхөн харахад шударга ёсны зарчмуудтай

ямар нэгэн холбоогүй мэт харагдана. Харин ажилгүйдэлд өртсөн байдлыг боловсролын түвшинтэй нь харьцуулаад үзвэл шударга ёсны шаардлага илүү тодорхой харагдана. Баруун европын бусад орнуудтай харьцуулахад боловсролын түвшин доогуур байгаагаас болоод ажилгүйдэлд өртөх эрсдэл германд хамгийн өндөр.

Боловсролын түвшингээс хамааралтай ажилгүйдлийн квот (2007 оны байдлаар)

	Анхдагч шат I	Анхдагч шат II	Дээд сургууль
Герман	17,7	8,2	3,7
Дани	4,2	2,5	2,9
Их Британи	6,0	3,6	3,1
ЕХ-ны гишүүн 15 орны дундаж	8,8	5,8	3,7

Германд ажилгүйдэлд өртөх эрсдэл харилцан адилгүй хувиарлагддаг. Боловсролын түвшин доогуур бол ажилгүйдэлд өртөх, нас ахисан хойноо орлогын хомсдолд орох байнгын эрсдэлийг дагуулж байгаа нь үндсэндээ боломжийн тэгш байдлын зарчмыг зөрчиж байна. Иймээс ажилгүйчүүдийг хөдөлмөрийн зах зээлд нэгтгэх, ажилд дахин оруулах хөтөлбөрүүд юуны өмнө ажилгүйчүүдийн боловсролын байдлыг дээшлүүлэхэд чиглэгдэх ёстой. Боловсрол багатай ажилгүйчүүдийг ажилд зуучилсан ч дахин ажилгүйдэлд өртөх эрсдэл өндөр байдаг. Тогтвортой дэмжлэг үзүүлэхийн тулд учир шалтгаантай нь тэмцэх хэрэгтэй.

Боломжийн тэгш байдлын зарчим нь хөдөлмөрийн зах зээл дээр хамгийн боломж багатай хүмүүсийг онцгойлон дэмжихийг шаардаж байдаг. Нийгмийн зүгээс дэмжлэг үзүүлэх тэтгэмж үйлчилгээг буруугаар ашиглуулахгүй байх оролдлогыг хийж байдаг учраас “дэмжин шаардах” зарчимд нийцүүлэх хэрэгтэй болдог. Дэмжих ба шаардахын харьцаа өөр өөр байж болно гэдгийг сонгон авсан гурван орны туршлага харуулж байна. Их Британид хөтөлбөрүүд шаардахад түлхүү анхаардаг бол Данид үүрэг ногдуулах шинж чанар болон мөнгөний хэмжээг бууруулна шүү гэдэг байнгын дарамт нь ажилгүйчүүдэд аятай санагдахгүй нь мэдээж. Хөтөлбөрүүдийн чанар харилцан адилгүй байдаг. Харин боловсрол дээр төвлөрдөг хөтөлбөрүүд ажилгүйчүүдийн хөдөлмөрийн зах зээл дээрх

*Герман:
Ажилгүйдэлд
өртөх эрсдэл
туйлын харилцан
адилгүй.*

*Дэмжих ба
шаардах: Олон
арга зам бий.*

боломжийг урт хугацаанд сайжруулдаг. Германд сүүлийн жилүүдэд шаардахад илүү чиглэсэн шинэчлэлийн арга хэмжээнүүдийг хэрэгжүүлжээ. Дэмжлэгийг нэмэгдүүлэх оролдлогыг ч мөн хийж байна. Хэдийгээр германд бусад орнуудаас илүү чухал байгаа ч ажилгүйчүүдийн боловсролын байдлыг дээшлүүлэх тал дээр төдийлөн ахиц гараагүй байна.

Урьдчилан
сэргийлэх:
Хөдөлмөр
эрхлэлтийг даатгах
тухай санаа

Мэргэжил олгох болон мэргэжил дээшлүүлэх сургалтыг заавал ажлын байраа алдсан хойно нь эхлэх биш харин ажилтай байхад нь хөдөлмөрлөх чадварыг нь хэвээр хадгалах, ажилгүйдэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх зорилготойгоор явуулж байх ёстой. Ажилгүйдлийн даатгалыг цаашид улам боловсронгуй болгож хөдөлмөр эрхлэлтийн даатгал болгон хөгжүүлэх нь энэ чиглэлд хийх чухал алхам байж болох юм.

Хөдөлмөр эрхлэлтийг даатгах тухай санаа

Ажилгүйдэлд өртсөн хүн зөвхөн орлогын эрсдэлд ороод зогсохгүй харин эрсдэлтэй шилжилтийн үед ч нэгэн адил орлогын эрсдэлээс хамгаалагдсан байх ёстой. Зөвхөн хөдөлмөр бус шилжилтүүд ч ашигтай байх ёстой. Өндөр насны даатгалын хамгаалалтын системийг гурван бүрэлдэхүүн хэсэгт хуваасан нь үр өгөөжтэй гэдэг нь нотлогдсонтой нэгэн адил орчин үеийн хөдөлмөрийн харилцааны эрсдэлийг бууруулахын тулд хөдөлмөр эрхлэлтийн даатгалыг гурван бүрэлдэхүүн хэсэгт хуваах байдлаар өргөжүүлэх нь үр өгөөжтэй шийдэл байж болох юм.

Нэгдүгээрт:
түгээмэл буюу бүх
хүнд хүртээмжтэй
үндсэн хамгаалал

Нэгдүгээрт ажилгүйдлийн мөнгө 2-той тэнцүү хэмжээний үндсэн хамгааллын (тайлбарыг доор хийсэн) тогтолцоог бүрдүүлж ядуурлаас хамгаалах боломжтой, үндсэн хамгаалал нь зайлшгүй хэрэгцээтэй байх гэдгээс өөр нөхцөл болзол байхгүй, бүтээмжийн тодорхой нэгдсэн стандартыг хангасан, ажил хийж буй бүх хүмүүст нээлттэй тийм ч учраас татвараас санхүүждэг байх ёстой.

Хоёрдугаарт:
Цалингаас
хамаардаг орлогын
хамгаалалт

Хоёрдугаарт сайн дураараа бус харин аргагүй байдлын улмаас ажилгүй болсон хүмүүсийн орлогыг цалинтай нь уялдуулан хамгаалах, орлогын хамгааллын хэмжээ нь ажилгүйдлийн мөнгө 1-тэй хэмжээгээрээ ижил байх, гэхдээ үндсэн үүрэг функцийг нь бууруулах, нөгөө талаас бүх ажил эрхлэгсдийг хөдөлмөр эрхлэлтийн статусаас нь үл хамааран хамруулдаг байх ёстой.

Гуравдугаарт ажил эрхлэгсдийн намтарт нь чиглүүлсэн хөдөлмөрийн зах зээлийн бодлого нь өнөөгийн, идэвхтэй хөдөлмөрийн зах зээлийн бодлогоос гадна дараах гурван функцийг гүйцэтгэх ёстой. Эдгээр нь: Нэгдүгээрт төсвөөс санхүүждэг эсхүл төсвийн дэмжлэгтэй ажилд зуучлахаас гадна нийлүүлэлтийн тал дээр хөдөлмөрийн зах зээлийн үйлчилгээг үзүүлдэг, мэргэжлээрээ ахин дэвшихэд нь тогтвортой дэмжлэг үзүүлдэг, эрэлтийн тал дээр боловсон хүчний бодлого, нэн ялангуяа жижиг дунд үйлдвэрийг дэмждэг хөдөлмөрийн зах зээлийн тэнцэтгэлийн бодлого, хоёрдугаарт: мэргэжил дээшлүүлэх, цалингийн нэмэгдэл олгох, шилжилтийн хөдөлмөр эрхлэлтийн төрөл бүрийн хэлбэрээр дамжуулан ажлын байрыг шинээр бий болгох, хадгалахад чиглэсэн макро эдийн засгийн бодлогыг дэмждэг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлого гуравдугаарт: хувь хүнийг хөгжлийн данс ба хувийн нэмэлт эсхүл хамтын гэрээгээр олгогдсон нэмэлт хамгаалалт бүхий (мэргэжил дээшлүүлэх фонд, урт хугацааны эсхүл сургалтын конто), хөдөлмөрийн харилцаан дахь эрсдэлтэй шилжилтүүд болон хувийн амьдрал ба хөдөлмөр эрхлэлт хоорондын шилжилтийн эрсдэлээс хамгаалсан хөдөлмөрийн бодлого юм.

Үндсэн орлогын тухай санаа

Улс төрийн хэлэлцүүлэгт байнга хөндөгдөж байдаг нэгэн сэдэв бол үндсэн орлогыг хэрхэн хамгаалах тухай төрөл бүрийн саналууд юм. Үндсэн орлого бол орлогын баталгаажих доод түвшинг хамгаалах арга хэрэгсэл юм. Нийгмийн халамжаас ялгаатай нь бүх иргэд орлоготой эсэх, ажил хийдэг эсэх, бусад орлогын эх үүсвэрээс орлого олдог эсэхээс үл хамааран үндсэн орлогыг авах эрхтэй. Үндсэн орлогод ажлын бүтээмж ба ажилдаа ямагт бэлэн байх зэрэг нөхцөл болзол тавигдахгүй.

Үндсэн орлогыг хэрхэн зохион байгуулах бэ? гэдэг талаар олон санал байдаг. Саналууд үндсэн орлогын хэмжээ, санхүүжилтийн хэлбэр, нийгмийн халамжийн бусад хэлбэрүүдийг хэр хэмжээнд орлох юм? зэрэг олон зүйлсээр хоорондоо ялгаатай.

Төрөл бүрийн саналуудын ард өөр өөр зорилго, чиглэл бий. Жишээлбэл: неолиберал саналуудын ард үндсэн орлогыг амьжиргааны баталгаажих доод түвшингээс доогуур тогтоох эсхүл орлогын сөрөг албан татварыг бага цалинтай секторт ажиллах сонирхлыг дээшлүүлэхэд ашиглах болон цалингийн нэмэлт зардлыг бууруулах зорилго нуугдаж байдаг.

*Гуравдугаарт:
Амьдралын намтарт
нь чиглүүлэх*

*Гүнзгийрүүлэн унших
эх сурвалжууд:
Гюнтер Шмидт (2008
он) Ажилгүйдлийн
даатгалаас хөдөлмөр
эрхлэлтийн даатгал
руу
(ФЭС Бонн)*

*Байнга яригдаж
байдаг сэдэв*

Бусад саналууд нэн ялангуяа ажиллагсдын хараат бус байдлыг нэмэгдүүлэх, хөдөлмөрийг дахин хувиарлалтыг сайжруулахын тулд үндсэн орлогыг илүү өндөр тогтоохыг шаарддаг. Харин орлогын эх үүсвэрээ бүрдүүлэх ажилтай эсэхээс үл хамааран үндсэн орлоготой байх боломж энэ загвар дээр бодитойгоор байгаа. Нийгмээрээ бүхэлдээ ажилчдын эрх ашгийг хүчтэй хамгаалсан, ажлын хагас өдрийн горимд шилжих загвар нь зах зээлийн хүчнүүдийн оролцоог дэмжихэд чиглэгдэх аж. Дээрх хоёр экстрем буюу туйлширсан саналуудын хооронд бусад олон хувилбарууд байдаг.

“Үндсэн орлогын талаар та ямар байр суурь баримталдаг бэ?” гэдэг асуултад эхлээд “Тоо томшгүй олон саналуудаас чи алийг нь хэлж байна?” гэдэг асуултаар хариулах ёстой байх. Ямар ч тохиолдолд амьжиргааны баталгаажих доод түвшнээс дээгүүр тогтоогдох учиртай үндсэн орлого нь нийгмийн бодлогын бусад хөтөлбөрүүд татварын системд асар их үр дагаврыг дагуулах болно.

Мөн хөдөлмөрийн зах зээлийн бодлогод ч нэгэн адил томоохон үр дагаврыг авчрах болно. Өөрөөр хэлбэл: Эдийн засаг-нийгмийн системийн үндсэн салбарууд үүнтэй холбоотойгоор нийгмийн байгуулал далайцтай өөрчлөлтөд орох учиртай болно. Иймэрхүү өөрчлөлтүүдийг хийхийн өмнө нийгмийн өргөн хүрээтэй зөвшилцөлд хүрэх ёстой. Үндсэн орлогын талаархи саналын олон талт байдал нь дангаараа дээрх хэлбэрийн зөвшилцөлд хүрэх болоогүй гэдгийг харуулж байна.

Энэ нь нийгмийн ардчилалд юу гэсэн үг бэ?

- Хөдөлмөрийн зах зээлийн идэвхтэй бодлогыг бэхжүүлэх
- Мэргэжил олгох-мэргэжил дээшлүүлэх сургалтын санхүү ба чанарын үнэлгээг дээшлүүлэх
- Ажилгүйдлийн даатгалыг хөдөлмөр эрхлэлтийн даатгал болгон өргөжүүлэн хөгжүүлэх

Гүнзгийрүүлэн унших
эх сурвалжууд

Бжорн Вагнер (2009

он) үндсэн орлогын

тухай германы

хэлэлцүүлэг, Эрхэм

зорилго, ашиг

сонирхол ФЭС Бонн

Штефан Лессених

(2009 он) Нийгмийн

бодлогын

хэлэлцүүлэгт үндсэн

орлогын талаар

ФЭС Бонн

7.3. Тэтгэвэр

Энэхүү бүлэгт:

- Германы тэтгэврийн даатгалын системийг тодорхойлж Дани, Швед, Их Британийн загваруудтай харьцуулна.
- Даатгалын системүүдийг шударга ёсны төрөл бүрийн цар хүрээнд авч үзэж үнэлгээ өгнө.
- Хуримтлалын тогтолцоо зэрэг шинэчлэлийн загваруудыг танилцуулна.
- Хувиарлалтын зарчмаар санхүүждэг тэтгэврийн шинэчлэлийн санаануудыг хэлэлцүүлнэ.

Тэтгэврийн даатгал нь ажилгүйдлийн даатгалын нэгэн адил төрийн нийгмийн бодлогын үндсэн элементийн нэг юм. Аж үйлдвэржсэн орнуудад тэтгэврийн зардал нь нийгмийн даатгалын зардлын хамгийн том блок юм.

Тэтгэврийн даатгалын үүсэл

Герман улс 1889 онд төрийн тэтгэврийн даатгалыг нэвтрүүлснээрээ энэ салбартаа анхдагч орон болсон юм. 1920-иод оныг хүртэл аж үйлдвэржсэн ихэнх орнууд төрийн тэтгэврийн даатгалыг нэвтрүүлсэн юм. Тухайн үед германд нэвтрүүлж байсан тэтгэврийн даатгалыг өнөөдрийнхтэй харьцуулшгүй.

Өнөөгийн тэтгэврийн даатгалаас эрс зөрүүтэй: дундаж наслалт

Өнөөгийн системтэй харьцуулахад тэтгэвэрт гарах насны босго, дундаж наслалт эрс хол зөрүүтэй байжээ. Тухайн үед тэтгэвэрт гарах насны босгыг 70 насаар тогтоож байжээ. 1871-1880 онд шинээр төрсөн 100 хүүхэд тутмын 18 нь л 70 нас хүрч насалдаг байжээ. Харин тухайн үеийн 15 настнуудын дундаж наслалт 42,3 настай тэнцэж байжээ. Бодит байдал дээр тухайн үед хөдөлмөр эрхэлж байсан хүмүүсийн тун багахан хувь нь тэтгэврийн тогтолцооноос ашиг хүртдэг байжээ.

Хоёрдох том ялгаа бол тухайн үеийн тэтгэврийн даатгалын тогтолцоог өнөөдрийнх шиг хувиарлалтын зарчим дээр бус харин хуримтлалын зарчим дээр суурилан бүрдүүлж байжээ. Хуримтлалын зарчим дээр суурилсан германы тэтгэврийн тогтолцоо нь 1920-иод оны үед инфляци асар өндөр байсны улмаас үндсэндээ нуран

Герман: Анхны тэтгэврийн даатгал (1889 он)

Эхлээд тэтгэврийн даатгалыг хуримтлалын зарчмаар байгуулсан: 1920-иод онд болон дэлхийн хоёрдугаар дайны дараа түүхэндээ 2 удаа нуран унасан.

1957 оноос хойш
хувиарлалтын
тогтолцоонд
шилжсэн. (Үеүд
хоорондын гэрээ)

унасан. Мөн дэлхийн хоёрдугаар дайны дараа харьцангуй сүүлийн үеийн түүхэнд германы тэтгэврийн даатгалын тогтолцоо хоёрдох удаагаа нуран унасан.

Германы 1957 оны шинэчлэл

Хэдийгээр дэлхийн хоёрдугаар дайны дараагаар тэтгэврийн даатгалын зардлын томоохон хэсгийг Холбооны төсвөөс санхүүжүүлсээр байсан ч 1957 оныг хүртэл тэтгэврийн даатгалын хуучин буюу хуримтлалын тогтолцоог хэлбэр төдий хадгалсаар байлаа. 1957 онд германд хийгдсэн тэтгэврийн шинэчлэлээр өнөөг хүртэл хэрэгжүүлж байгаа хувиарлалтын тогтолцоонд шилжүүлсэн юм. Өнөөдрийн тэтгэвэр авагсдын тэтгэврийг өнөөдөр хөдөлмөр эрхэлж буй хүмүүсийн төлсөн шимтгэлээс санхүүжүүлдэг. (Үеүд хоорондын гэрээ) 1957 оны тэтгэврийн шинэчлэлийн бас нэгэн чухал алхам бол олгож буй тэтгэврийн хэмжээг орлогын ерөнхий (цалин ба эдийн засгийн хөгжилтэй уялдуулж өгсөн) хөгжилд нийцүүлсэн. Тэтгэврийн хэмжээг цалингийн хөгжилд уялдуулах аргачлалыг нэвтрүүлсэн. Эхлээд нийт буюу бохир цалинтай холбож өгсөн. Харин 1992 оноос өртөг зардлын өсөлтийн улмаас зөвхөн цэвэр цалинтай уялдуулан тогтоодог болсон. Эдийн засгийн өсөлтийн үрээр цалин нэмэгдсэн учраас цалинтай уялдуулан тогтоох аргачлалын дагуу тэд ч адилхан эдийн засгийн өсөлтийн үр өгөөжөөс хүртэж эхэлсэн.

Үеүд хоорондын гэрээ: Германы тэтгэврийн даатгалын

Германы хууль ёсны даатгалын ерөнхий зарчмын улс төрийн тодорхойлолтыг нь үеүд хоорондын гэрээ гэж нэрлэдэг. Уг гэрээний дагуу хүн амын байнгын ажилтай хэсгийн (бие даасан буюу хувиараа хөдөлмөр эрхэлдэггүй гэсэн үг) тэтгэврийн даатгалд төлсөн мөнгөөр ажил хийдэггүй хэсгийн тэтгэврийг нийтэд нь санхүүжүүлдэг гэсэн үг. Энэ нь ажил эрхэлж буй хүмүүсийн тэтгэврийн даатгалын шимтгэлд төлсөн мөнгө нь хуримтлагдаж хуримтлал үүсгээд тэр мөнгөнөөс нь хожим тэтгэвэрт гарахад нь тэтгэврийг нь төлдөггүй харин тэтгэврийн даатгалын шимтгэлийг төлснөөр хожим нь тэтгэвэр авах эрхээ баталгаажуулж байна гэсэн үг.²⁸ (Улс төрийн нэвтэрхий толь 2006 он, 119-р тал)

28 Бид Клайн Шуверт нарын 2006 онд хэвлүүлсэн “Улс төрийн нэвтэрхий толь” -иос төрөл бүрийн ойлголтуудыг сурах бичигт ашиглах боломжийг олгосон J.H.W. Dietz Nachf.Bonn хэвлэлийн газарт талархал илэрхийлж байна.

1960-аад оны сүүлчийг хүртэл нийтийн тэтгэврийн даатгалыг албан хаагчид, хувиараа хөдөлмөр эрхлэгсэд, гар урчуудаар алхам алхмаар өргөтгөсөн байна. 1972 оноос хойш гэрийн эзэгтэй нар, хувиараа хөдөлмөр эрхлэгсдэд сайн дураараа тэтгэврийн даатгалын шимтгэл төлөх, хожим нь тэтгэвэр авах эрхийг нь нээж өгсөн байна. 2003 оноос хойш тэтгэврийн орлого нь хүрэлцээгүй өндөр настангуудад үндсэн хамгаалалд орох боломжийг нь нээж өгснөөр өмнө нь нийгмийн халамж авч байсан хүмүүсийн орлогыг үндсэн орлогоор солих боломж нээгдсэн.

Хууль ёсны тэтгэврийн даатгалыг алхам алхмаар өргөтгөх

Риестерийн нэмэлт тэтгэврийг нэвтрүүлснээр 2009 оны 7-р сарын 1-нээс сар бүр 359 еврогийн нэмэгдэл олгох болсон. Риестерийн нэмэгдэл тэтгэвэр нь Холбооны сайд асан Вальтер Риестерийн нэрээр нэрлэгдсэн, хууль ёсны тэтгэврийн даатгалын, төрийн шууд дэмжлэгтэй хувийн, хуримтлалын зарчмаар санхүүждэг өндөр насны даатгалын багана юм. 2009 оныг хүртэл ойролцоогоор 12 сая Риестерийн нэмэлт тэтгэврийн гэрээ байгуулагдсан байна. Германы хувиарлалтын зарчим дээр суурилсан, төрийн тэтгэврийн даатгал нь өнөөдрийг хүртэл ихэнх хүмүүсийн өндөр насны баталгааны цөмийг бүрдүүлж байна.

2001 оноос хойш Риестерийн нэмэлт тэтгэвэр олгож эхэлсэн.

2004 онд тэтгэврийн хэмжээг тооцоолон тогтоодог томъёонд тэтгэвэр авагсдын тоо, тэтгэврийн хууль ёсны даатгалд шимтгэл төлөгсдийн тоог харгалзан үзсэн, тухайн цаг үеийн хүн ам зүйн хөгжлөөс хамаараад тэтгэврийг бага хэмжээгээр өсгөх эсхүл хэрвээ тогтвортой байдлын хүчин зүйлийн утга сөрөг гарсан нөхцөлд тэтгэврийг бууруулах арга хэмжээг авах болсон. Үлгэр жишээ тэтгэвэр авагсад хэмээн нэрлэгддэг 45 жилийн турш дундаж цалинтай тэнцэх орлогоос шимтгэлээ төлсөн, 2007 оны 7-р сарын 1-нээс тэтгэвэрт гарсан тэтгэвэр авагчид баруун германд 1.068,58 евро, зүүн германд 941,77 еврогийн тэтгэвэр тус тус авна. Хууль ёсны өндөр насны тэтгэврийн дундаж 2007 оны байдлаар баруун германд 970,27 евро, Зүүн Германд 1.044,50 евротой тэнцэж байжээ. Зүүн Германд дундаж тэтгэвэр барууныхаас өндөр байгаа нь хуучин Ардчилсан Герман Улсад ажилласан жил урт байгаатай холбоотой. Баруун Германд олон ажилчид компанийн тэтгэвэр авдаг учраас тэтгэврийн түвшин зүүн Германаас илүү өндөр байдаг.

2004 оноос хойш тогтвортой байдлын хүчин зүйл

Өндөр насны баталгааны гурван багана

Германы тэтгэврийн даатгалын эхний элемент бол төрийн үндсэн хангамж хэмээн нэрлэгддэг суурь тэтгэвэр, хоёрдогч багана нь

орлоготой уялдуулан тогтоодог, заавал даатгуулах тэтгэврийн даатгал юм. Гуравдагч багана нь сайн дурын, хувийн тэтгэврийн даатгал болон компанийн тэтгэвэр юм. Өндөр насны баталгаа нь ихэнх орнуудад эдгээр гурван баганаас бүрддэг, харин багана хоорондын жин харилцан адилгүй хувиарлагдсан байдаг.

Данийн ард түмний тэтгэвэр ба компанийн тэтгэвэр

Данид тэтгэвэр авагсдын орлогын эх үүсвэр нь ард түмний тэтгэвэр ("folkepension") юм. Сар тутмын суурь тэтгэвэр 660 евротой тэнцдэг бөгөөд татвараас зуун хувь санхүүжүүлдэг. 15-67 насны хооронд Дани улсад 3 жилээс доошгүй хугацаагаар оршин суусан, Дани улсын бүх иргэдийн өмнө ард түмний тэтгэвэр авах эрх нь нээлттэй. Харин гадаадын иргэдийн хувьд арваас доошгүй жил Дани улсад оршин суусан, түүнээс тэтгэвэрт гарахаас өмнөх сүүлийн таван жилд данид оршин суусан бол ард түмний тэтгэвэр авах эрх нь үүсдэг. Жил тутамд суурь тэтгэврийг дөч хуваасны нэг хувийг авах эрх үүснэ. Дани улсад 40 жил оршин суусан бол ард түмний тэтгэврийг бүрэн хэмжээгээр нь авах эрх үүсдэг. Суурь буюу ард түмний тэтгэврээс өөр тэтгэвэр авдаггүй өндөр настангуудын хувьд зайлшгүй хэрэгцээ байгаа эсэхийг нь хянаж үзсэний үндсэн дээр нэмэгдэл олгодог, уг нэмэгдэл нь 2008 оны байдлаар дээд тал нь 660 евротой тэнцэж байжээ.

Төрийн тэтгэврийн даатгалын хоёрдогч элемент нь АТР-хэмээн нэрлэгддэг нэмэлт тэтгэвэр юм. АТР-ийн тэтгэврийн дээд хэмжээ нь 2008 оны байдлаар сар тутамд ойролцоогоор 250 евротой тэнцэж байсан бөгөөд ажилласан жил, долоо хоног тутмын ажлын цагаас хамааран хэмжээг нь тогтоодог. Шимтгэлийн хэмжээг (долоо хоног тутмын ажлын цагийн нийлбэрээс хамааран үе шаттайгаар нэмэгдүүлдэг, сар бүр ойролцоогоор 35 еврог бүтэн цагаар ажиллагсад төлдөг) бөгөөд гуравны нэг орчим хувийг ажил олгогч, гуравны хоёр хүртэлх хувийг ажил олгогчид төлдөг. Эдгээр шимтгэлийг нийгмийн түншүүдийн хамтарсан өөрийн удирдлага бүхий фондод төвлөрүүлдэг. АТР-тэтгэвэр нь хуримтлалын зарчим дээр суурилсан тогтолцоо юм.

Данийн орлогоос хамааран хэмжээг нь тогтоодог тэтгэврийн багана нь компанийн тэтгэврээс бүрддэг бөгөөд нийт хөдөлмөр эрхлэгсдийн 90 орчин хувь нь компанийн тэтгэвэр авдаг. Энэ хооронд компанийн

Эхний элемент:
Татвараас
санхүүждэг үндсэн
эрхүүд

Хоёрдогч элемент:
АТР-тэтгэвэр
(хуримтлалын
зарчмаар)

Гуравдагч элемент:
Компанийн
тэтгэвэр
(Хөдөлмөр
эрхлэгсдийн 90
хүртэлх хувь нь
авдаг.)

тэтгэвэр нь байгуулагдаж буй бараг бүх тарифын гэрээний үндсэн бүрэлдэхүүн хэсэг болтлоо өргөжиж үндсэндээ заавал даатгуулах даатгалын түвшинд очоод байна. Шимтгэлийн гуравны нэг хувийг ажилтан, гуравны хоёр хувийг ажил олгогч төлдөг бөгөөд шимтгэлийн нийт хувь хэмжээ нь ойролцоогоор нийт цалингийн 15 хувьтай тэнцдэг, шимтгэлийг төрийн хяналтанд байдаг хөрөнгийн фондод төвлөрүүлдэг.

Шведийн тэтгэврийн систем

Шведэд мөн татвараас санхүүждэг суурь тэтгэврийн тогтолцоо байдаг, Шведэд оршин суудаг гэдэг нөхцөлөөр суурь тэтгэвэр авах эрх үүсдэг. Шведэд 40-өөс доошгүй жил оршин суусан, төрийн тэтгэврийн бусад сангаас тэтгэвэр авдаггүй (доор тайлбарлана) бол “баталгаат тэтгэврийг” бүтнээр авах эрхтэй бөгөөд тэтгэврийн хэмжээ 2007 оны байдлаар сар тутамд 670 евротой тэнцэж байжээ. (дээрээс нь орон сууцны түрээс, төлбөрийн мөнгө олгодог.) Хувийн эсхүл компанийн тэтгэврийн даатгалаас тэтгэвэр авдаг бол энэ нь баталгаат тэтгэврийн хэмжээг бууруулах шалтгаан болохгүй. Баталгаат тэтгэврээс харин зохих татварыг төлөх үүрэгтэй.

Шведийн тэтгэврийн даатгалын хоёрдох элемент нь хувиарлалтын зарчмаар санхүүждэг, орлогоос хамааралтай тэтгэвэр юм. Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нийт хувь хэмжээ нь 18.5% бөгөөд үүний 7%-ийг ажилчид, үлдсэн хувийг нь ажил олгогчид тэтгэврийн даатгалд төлдөг. Орлого нь шимтгэл тооцох орлогын дээд хэмжээнээс (2007 оны байдлаар жил тутамд 37.500 евро) давсан тохиолдолд ажилтан шимтгэлээс чөлөөлөгдөж ажил олгогч шимтгэлийн зөвхөн 50%-ийг төлдөг. Мөн шимтгэл тооцох орлогын дээд хэмжээнээс дээгүүр орлогод тэтгэвэр авах эрх үүсэхгүй. Хожим нь тэтгэвэр авах эрх үүсэхэд тэтгэврийн хэмжээг цалин ба инфляцийн хөгжилд нийцүүлэн тогтоодог. Дээрээс нь шимтгэл төлөгчдийн тоо ба тэтгэвэр авагчдын тооны харьцааг тэтгэвэр тооцох томъёонд оруулан тооцдог. Тэтгэвэр авагсдын тоо нэмэгдэхийн хэрээр Германтай нэгэн адил тогтвортой байдлын хүчин зүйлсийн дагуу тэтгэврийн хэмжээг автоматаар бууруулдаг.

Шведийн хууль ёсны тэтгэврийн даатгалын гуравдагч элемент нь урамшууллын тэтгэвэр хэмээн нэрлэгддэг тэтгэвэр юм. Тэтгэврийн даатгалын шимтгэлийн 18.5%-иас 2.5%-ийг төрийн зохицуулалт бүхий хуримтлалын зарчим дээр суурилсан тэтгэврийн фондод

*Анхдагч элемент:
Татвараас
санхүүждэг үндсэн
эрхүүд*

*Хоёрдогч элемент:
Орлоготой
уялдуулсан
хувиарлалтын
зарчим*

*Гуравдагч элемент:
хуримтлалын
зарчмаар (үүрэг
ногдуулааг)*

байршуулдаг. Ажилтнууд ямар фондыг сонгохоо өөрсдөө шийддэг. Германы Риестерийн нэмэлт тэтгэвэртэй харьцуулахад Шведийн ажилтнууд тэтгэврийн даатгалын шимтгэлийнхээ тодорхой (багахан) хувиар хуримтлалын зарчим дээр суурилсан тэтгэврийн баганад хөрөнгө оруулалт хийх үүрэг хүлээдэг.

Их тэтгэвэр

Тэтгэврийн системийн эхний багана нь хоёр хэсэгт хуваагдсан байдаг. Үндсэн баталгааны эхний хэсэг нь үндсэн баталгааны хэсэг нь төрийн суурь тэтгэвэр (basic state pension) юм. Төрийн суурь тэтгэврийг арваас доошгүй жил шимтгэл төлсөн бүх иргэд авах эрхтэй. Долоо хоног тутамд 90,70 фаундын суурь тэтгэврийг (2008/2009 онд сар тутамд 435 евротой тэнцэж байжээ.) 44 жил тасралтгүй шимтгэл төлсөн эрэгтэй, 39 жил тасралтгүй тэтгэврийн даатгалын шимтгэл эмэгтэй бүтнээр нь авах эрхтэй. 2010 оноос хойш суурь тэтгэврийг бүтнээр нь авах болзол болгодог тасралтгүй шимтгэл төлсөн байх ёстой ажилласан жилийн тоог эрэгтэй ба эмэгтэйчүүдэд тус бүр 30 жил болгон бууруулсан байна. Нийгмийн даатгалын шимтгэлийг тасралтгүй төлсөн байх жилийн тоо нь хангалтгүй өндөр настангуудад зайлшгүй шаардлагатай эсэхийг нь тогтоосны үндсэн дээр нийгмийн халамж олгохоос өөр арга зам байхгүй. Үндсэн хамгааллын энэхүү хоёрдох хэсгийг “тэтгэврийн зээл буюу pension credite” гэж нэрлэдэг, энэ хэсгээс тэтгэвэр авагч өрх толгойлсон эрэгтэй, эмэгтэйчүүдэд долоо хоног тутамд 124,05 фаунд, тэтгэвэрт гарсан хосуудад 189,35 фаундын орлогыг 2008/2009 байдлаар тус тус баталгаажуулдаг. Энэ нь еврод шилжүүлэн тооцоход сар бүрт 595 ба 909 евротой тэнцэх орлого юм.

Орлоготой уялдуулан хэмжээг нь тогтоодог хоёрдох багана нь төрийн, хувиарлалтын зарчмаар санхүүждэг тэтгэвэр эсхүл компанийн эсхүл хувийн тэтгэврээс бүрддэг. Төрийн тэтгэвэр (state second pension) орчуулах юм бол төрийн хоёрдогч тэтгэвэр нь жилийн орлого нь 4.524 фаундаас (ойролцоогоор 5.400 евро) дээш байх нөхцөлд нийгмийн даатгалын шимтгэлээс санхүүждэг. Хэмжээг нь 49 жил тасралтгүй мэргэжлээрээ ажиллахдаа олсон орлогыг үндэслэн тооцдог. Жилийн орлого нь 13.000 фаундаас дээш гарсан нөхцөлд (ойролцоогоор 15.600 евро) нэгдсэн хувь хэмжээгээр 3.390 фаундын (ойролцоогоор 4.000 еврогийн) хоёрдогч тэтгэвэр авах эрх үүсдэг. Жилийн орлогын хэмжээ нь 13.000-аас 29.952 фаунд

Эхний багана:
Төрийн суурь
тэтгэвэр

Хоёрдох багана:
Хувиарлалтын
зарчим (сайн
дурын)

бол (ойролцоогоор 15.600-35.900 евро) 3.390 фаунд дээр нэмээд орлогынхоо 10%-тай тэнцэх хэмжээний, орлогын дээд хэмжээ нь 13.000-34.840 фаунд бол (15.600-41.800 евро) орлогын 10-20%-тай тэнцэх хэмжээний хоёрдогч тэтгэврийг авдаг. 49 жил тасралтгүй ажилласан байх ёстой гэдэг болзлоос дутсан жил тутамд тэтгэврийн хэмжээ буурдаг.

Нэн ялангуяа 13.000 фаундаас бага орлоготой хүмүүс “хууль ёсны хоёрдогч тэтгэврийн” нэгдсэн хувь хэмжээгээр тэтгэвэр тооцох аргачлалаас хождог, харин өндөр орлоготой хүмүүсийн сонирхлыг төрийн тэтгэвэр төдийлөн татдаггүй.

Гэхдээ төрийн тэтгэврийн даатгалын хоёрдох багана нь заавал хамрагдах даатгал биш. Төрийн хоёрдогч даатгалд хамрагдах боломжтойгоос гадна хувийн эсхүл компанийн даатгалтай тэтгэврийн гэрээ байгуулах боломжтой. (“contracting out”) Хувийн эсхүл компанийн даатгалд даатгуулсан тохиолдолд шимтгэлийн хувь хэмжээ доогуур байдаг бөгөөд татварын хөнгөлөлт үзүүлэх замаар төрөөс дэмждэг. Хууль ёсны хоёрдогч тэтгэврийн хэмжээтэй багаар бодоход тэнцэх, түүнээс дээш хэмжээний тэтгэвэр өгөх баталгаа гаргасан тэтгэврийн фондод үйл ажиллагаа явуулах эрх олгодог. Өнөөгийн байдлаар тэтгэвэр авагсдын ойролцоогоор 56% нь хууль ёсны тэтгэврээс бус харин хувийн болон компанийн даатгалаас тэтгэврээ авдаг.

Тэтгэврийн системүүд ба шударга ёсны зарчмууд

Үндсэн хангамжийн тэтгэврийн даатгалын эхний багана нь хэрэглээний шударга ёсны зарчимд нийцэж байгаа юм. Эхний баганын хувьд улс орнууд хоорондоо бүх тэтгэвэр авагчдад түгээмэл хувь хэмжээгээр тэтгэвэр олгож байна уу? (Данид) эсхүл тэтгэвэр авагчдын тэтгэвэр хэтэрхий бага бол зайлшгүй хэрэгцээтэй гэдгийг нь тогтоосны дараагаар үндсэн хангамжийг баталгаажуулах зорилгоор олгож байна уу? (Их Британи, Герман, Швед) гэдгээрээ ялгаатай. Үүнээс гадна улс орнуудын үндсэн хангамжийн түвшин хоорондоо ялгаатай. Дани, Шведэд Германаас сар бүр 300 еврогоор илүү үндсэн хангамж буюу суурь тэтгэврийг олгож байна. Амьжиргааны өндөр зардлыг харгалзан үзвэл Шведэд түвшин харьцангуй өндөр байдаг. Энэ нь Шведэд дундаж орлогын 60%-иас доогуур орлоготой тэтгэвэр авагсдын тоо цөөн байгаатай холбоотой. Энэ тоо герман болон Шведэд илүү өндөр байдаг. Их Британид тэр ч байтугай 65-

*Альтернатив
хувилбарууд:
Хувийн эсхүл
компанийн
тэтгэвэр*

*Эхний багана:
Хэрэгцээний
шударга ёс*

аас дээш насныхны 30% нь харьцангуй ядууралд өртсөн байдаг.

Ядууралд өртөх эрсдэлийн квот: нь гар дээрээ авч байгаа орлого нь үндэсний дундаж орлогын 60%-иас доогуур хүмүүсийн эзэлж буй хувийг илэрхийлдэг.

65 –аас дээш насны хүмүүсийн ядууралд өртөх эрсдэлийн квот, 2007 оны байдлаар

Европын Холбооны гишүүн 25 орон	19%*
Дани	18%
Герман	17%*
Швед	11%
Их Британи	30%

Эх сурвалж: урьдчилсан тоон үзүүлэлтүүд /Европын статистик

Үндсэн хангамж буюу суурь тэтгэврийг бүх оронд ерөнхий татвараас санхүүжүүлдэг. Ингэснээр үндсэн хангамж нь дахин хувиарлалтад хүчтэй нөлөө үзүүлдэг, өндөр орлоготой хүмүүс илүү татвар төлдөг ч хариуд нь мөнгө авдаггүй (Герман ба Швед) эсхүл бусад бага орлоготой тэтгэвэр авагчидтай ижил хэмжээний тэтгэвэр авдаг. (Данид) Үүнээс гадна энд үеүд хооронд дахин хувиарлалт явагдаж байгааг ажиглаж болно. Дийлэнх нь хөдөлмөр эрхэлдэг татвар төлөгчдийн төлсөн татвараар тэтгэвэр авагсдын үндсэн баталгааг хангадаг.

Хоёрдогч багана:
Бүтээмжийн
шударга ёс


Тэтгэврийн даатгалын нь хоёрдогч багана нь орлогоос хамаардаг тэтгэвэр юм. Ингэснээр тэтгэврийн даатгалын хоёрдогч бага нь бүтээмжийн шударга ёсонд илүү нийцдэг. Бүтээмж нь юуны өмнө тухайн хүн хэр удаан жил ажилласан, орлого нь хэр өндөр байснаар хэмжигддэг. Герман болон Шведэд өндөр насны баталгааны энэ хэсгийг төрөөс зохион байгуулдаг, харин Данид энэ баганыг тарифын гэрээгээр үүрэг хүлээсэн компанийн тэтгэвэр орлодог. Их Британид төрийн ба компанийн тэтгэврийн даатгалын аль нэгийг нь сонгох боломжтой.

Орлогын төрөл бүрийн бүлгүүд хоорондын дахин хувиарлалт тэтгэврийн энэ баганад үндсэн хангамжтай харьцуулахад маш бага

хэмжээгээр явагддаг. Гэхдээ төрийн тэтгэврийн даатгалд хөдөлмөр эрхлээгүй, орлогогүй байх үеийг /(тухайн тасалдсан шалтгаан нь нийгмийн зүгээс зөв зүйтэй хэмээн үнэлэгдэж буй нөхцөлд) ажилласан жилд оруулан тооцох боломжтой. Жишээлбэл: Германд 2005 оныг хүртэл 17 наснаас хойш дунд сургууль болон дээд сургуульд суралцсан жилүүдийг ажилласан жилд тооцдог байжээ. Мөн гэр бүлийн гишүүдээ асарсны улмаас ажил хийх боломжгүй байсан жилүүдийн даатгалын шимтгэлийг тодорхой болзол хангагдсан нөхцөлд асрамжийн даатгалаас төлдөг. Өнөөдрийг хүртэл хүүхдээ асран хүмүүжүүлсэн 36 сар хүртэлх хугацаанд эхийн тэтгэврийн дансанд тэтгэврийн пунктыг даатгуулагчдын дундаж орлоготой тэнцэх орлогоос тооцон нэмдэг. үүгээрээ төрийн тэтгэврийн даатгал хөдөлмөрийн ах зээл дээр үнэлэгддэггүй хөлсгүй хөдөлмөрийн урамшуулах боломжтой юм. Дээрээс нь хууль ёсны тэтгэврийн даатгал нь хөдөлмөрийн чадвар буурсан, бэлэвсэрсэн хүмүүсийн тэтгэврээр дамжуулан амьдралын бусад эрсдэлүүдээс хамгаалах боломж бүрддэг байна.

Олон оронд тэтгэврийн даатгалын нэг ба хоёрдугаар баганыг хэрхэн зохион байгуулснаас хамааран өмнө нь олж байсан орлоготой харьцуулсан тэтгэврийн хэмжээнд хэрхэн нөлөөлж байгааг 15-р зургаас харж болно.

Тэтгэврийн
хэмжээг
харьцуулах нь



Эх сурвалж: OECD-ийн тоо баримт дээр тулгуурлан зохиогч боловсруулав. (2007 он, 39-р тал)

15-р зураг: Хөдөлмөр хийгээд олсон орлогод харьцуулсан тэтгэврийн хэмжээ

Унших жишээ: Данид (зураг дээр ногоон баганаар харуулсан) Дани өмнө нь дундаж цалингийн хагастай тэнцэх хэмжээний орлоготой байсан тэтгэвэр авагчид хамгийн сүүлд авсан дундаж цалингийнхаа ойролцоогоор 132%-тай тэнцэх цэвэр тэтгэврийг авдаг. Хэрэв тэтгэвэр авагчид дундаж цалинтай тэнцэх орлоготой байсан бол цалингийнхаа 86%-тай тэнцэх тэтгэвэр, дундаж цалинг хоёр дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний тэтгэвэр авч байсан бол цэвэр цалингийнхаа 72%-тай тэнцэх хэмжээний цэвэр тэтгэвэр авдаг.

*Тэтгэврийн хэмжээ:
Германы бага
цалинтай хүмүүс
бусад орны бага
цалинтай хүмүүстэй
харьцуулахад бага
тэтгэвэр авдаг.*

Дани болон Шведэд орлогын гурван бүлэгт хамрагдах даатгуулагчдын орлоготой харьцуулсан тэтгэврийн түвшин хамгийн өндөр байна. Мөн зөвхөн Германд дундаж цалингийн хагастай тэнцэх хэмжээний орлоготой даатгуулагчдын тэтгэврийн орлого дундаж орлоготой хүмүүсийн тэтгэврийн орлогоос доогуур байгаа нь анхаарал татаж байна. Бага орлоготой хүмүүсийн тэтгэвэр ба өмнө нь авч байсан орлогыг харьцаа тэр ч байтугай Их Британид Германаас илүү өндөр байна. Бүтээмжийн шударга ёсны зарчмыг зах зээлээс олж буй орлого гэдэг утгаар нь дангаар нь хэрэглэх юм бол дээрх харьцаа орлогын бүх бүлгүүдэд ижил байх учиртай.

*Тэтгэврийн
доод хэмжээг
нэмэгдүүлэх
замаар өндөр
насны ядуурлаас
сэргийлэх
боломжтой.*

Хэрэглээний шударга ёс дундаж болон өндөр орлоготой хүмүүсийн тэтгэврийн хэмжээтэй харьцуулахад бага орлоготой хүмүүсийн өндөр насны тэтгэврийн хэмжээг өмнө нь авч байсан цалингийнх нь ихэнх хэсгийг орлох хэмжээнд тогтоохыг шаарддаг. Дахин хувиарлалтыг хэр хэмжээнд хийвэл зохистой бэ? гэдгийг нарийвчлан тогтоох боломжгүй. Өндөр насны ядуурлаас урьдчилан сэргийлэхийн тулд Германы тэтгэврийн даатгалд бага орлоготой хүмүүсийн аж байдлыг сайжруулах шаардлага байгаа нь харагдаж байна. Орлогоос хамааралтай, хувиарлалтын зарчмаар санхүүждэг бүрэлдэхүүн хэсгүүдээс илүүтэйгээр суурь тэтгэврээр дамжуулан ядуурлаас сэргийлэх боломжтой.

*Хэлэлцүүлэг:
Хуримтлалын
зарчмыг хэр
хэмжээнд
хэрэглэвэл
зохилтой бэ?*

Сүүлийн жилүүдийн тэтгэврийн даатгалын хоёрдох баганыг хэрхэн зөв зүйтэй зохион байгуулах бэ? гэдэг асуудлын эргэн тойронд хэлэлцүүлэг өрнөж байна. Хэлэлцүүлэгт хуримтлалын зарчмаар санхүүждэг тэтгэврийг нэвтрүүлэх үү? Нэвтрүүлбэл хувиарлалтын зарчмаар санхүүждэг тэтгэврийг хэр хэмжээнд орлуулбал эсхүл нөхвөл зохилтой бэ? гэдэг асуудал зонхилж байна.

Хуримтлалын зарчим дээр суурилсан тэтгэврийн даатгалын давуу ба сул талууд

Өдгөө нийгмийн бүхий л зардал байнга тухайн үед ард түмний бүрдүүлж буй орлогоос санхүүждэг байх ёстой гэдэг энгийн бөгөөд тодорхой дүрэм үйлчилдэг. Нийгмийн зардлыг санхүүжүүлэх өөр ямар ч эх үүсвэр байхгүй, өмнө нь ч байгаагүй. Үеэс үеийн хооронд хуримтлалын фонд байгуулах, орлогын тодорхой хэсгийг шилжүүлэх, хувийн эдийн засгийн утгаар “хуримтлуулах” боломж ч байхгүй учраас тухайн үед бүрдэж буй ард түмний орлогоос өөр нийгмийн зардлыг санхүүжүүлэх өөр ямар ч эх үүсвэр байхгүй. Хөрөнгө хуримтлуулах аргачлал ба хувиарлалтын аргачлал нь агуулгын хувьд хоорондоо тийм ч их ялгаатай зүйл биш. (Макенрот 1952 он, 41-р тал)

Макенротын нотолгоо гэдэг нэрийн доор алдаршсан дээрх ишлэлтэй өнөөдрийг хүртэл хэн ч маргадаггүй. Уг санаа нь тэтгэврийнхний хэрэглээг зөвхөн хөдөлмөр эрхлэгсдийн хэрэглээнээсээ татгалзсан мөнгөөр хангагдах бөгөөд энэ нь тухайн сонгон авсан санхүүжилтийн загвараас үл хамаарна. Хуримтлалын зарчмаар санхүүждэг тэтгэврийн тогтолцоонд нэгэн адил хожим нь авах тэтгэвэр хүмүүсийн тэтгэвэртэй байх эсэх нь залуу үе нь тэтгэврийн үнэт цаасыг худалдан авах эсэхээс хамаардаг. Учир нь үнэт цааснаас олсон ашгаас тэтгэвэр авагчдын тэтгэврийг санхүүжүүлдэг юм. үнэт цаасыг (хувьцаа, зээлийн бичиг) худалдан авагч байхгүй бол зүгээр л ямар ч үнэ цэнэгүй цаас болж хувирна. Тэгэхлээр хуримтлалын зарчмаар санхүүждэг тэтгэврийн хэмжээ тухайн үед хөдөлмөр эрхлэгсдийн хүн ам зүйн болон эдийн засгийн нөхцөл байдлаас хамаардаг. Үүгээрээ хуримтлалын зарчмаар санхүүждэг тэтгэвэртэй ижил. Хуримтлалын зарчмаар санхүүждэг тэтгэврийн системд тэтгэврийн хэмжээ тухайн үеийн орлогын хэмжээнээс хамааралтай.

Хэрвээ шимтгэл төлөгчдийн тоо эсхүл цалин (эсхүл хоёулаа) буурвал хувиарлалтын зарчмаар санхүүждэг тэтгэврийн даатгалын орлого буурч улмаар тэтгэврийн хэмжээ буурдаг.

Эдийн засгийн зарим онол хуримтлал (хөрөнгө хуримтлуулах) үүсгэх замаар ирээдүйн эдийн засгийн өсөлтөд эерэгээр нөлөөлөх боломжтой гэдгийг харуулсан. Ингэснээр ахмадуудын үнэт цаасны цаасны үнэлэмж нэмэгддэг. Энэ нь өндөр насны баталгааг хуримтлалын зарчмаар санхүүжүүлдэг тэтгэврийн тогтолцоог нэмэгдүүлэхийг дэмжигчдийн нэгэн үндэслэл болдог. Учир нь хувиарлалтын зарчмаар санхүүждэг тэтгэврийн даатгалд юуг ч хуримтлуулдаггүй, учир нь залуу үеийн төлсөн шимтгэл шууд ахмадуудын тэтгэвэрт зарцуулагддаг. Үүнээс гадна дүн шинжилгээнүүд хуримтлалыг бий болгосон үеийнхний орлого хасан байж бий болгосон хөрөнгийн хуримтлалаас бий болсон өсөлтийн үр дүнг дараагийн үе нь хүртдэг гэдгийг харуулдаг. Дээрээс нь олон улсад хуримтлалын зарчмаар санхүүждэг тэтгэврийн даатгал нэмэгдэж байгаатай холбоотойгоор тэтгэврийн фондын өсөлт нэмэгдсэн ч сүүлийн жилүүдэд харин найдвартай хөрөнгө оруулах боломж хомсдож байна. Бүхэлд нь авч үзвэл хуримтлалын зарчмаар санхүүждэг тэтгэврийн даатгал ямар давуу талуудыг авчрах бэ? гэдэгт эргэлзээ ноёлж байна.

Хуримтлалын зарчмаар санхүүждэг тэтгэврийн даатгалын тогтолцоо нийт эдийн засагт ямар нөлөө үзүүлэх бэ? гэдэг талаар нэгдсэн байр суурьт хүрээгүй байгаагаас гадна хувь хүмүүст уг зарчмаас үүдэлтэй тодорхой эрсдэлүүд учирдаг. Бүхэлд нь авч үзвэл хуримтлалын тун багахан хэсгийг төрийн найдвартай бондыг худалдан авахад зарцуулдаг, төрийн өр эрчимтэй өсөх нь тодорхой тул төрийн өрийн бичгийг худалдан авахдаа ч болгоомжтой байх хэрэгтэй учраас зах зээлээс хувьцаа, бонд худалдан авахад хуримтлалын ихээхэн хувийг зарцуулдаг. Чухам энд зайлшгүй гарах олон эрсдэлүүд байна. Үүнд: Ханш буурах, (ханшийн эрсдэл), өртэй тал төлбөр хийхгүй байх (эргэн төлөгдөхгүй байх эрсдэл), инфляци нэмэгдсэний улмаас мөнгөн хөрөнгийн бодит үнэлгээ буурах (инфляцийн эрсдэл), гадаадын хөрөнгө оруулалтад валютын ханшийн зөрүү зэрэг олон эрсдэлүүд байна.

Хувиарлалтын зарчмын ашиг

Цалин нэмэгдэхийн хэрээр хувиарлалтын зарчмаар санхүүждэг тэтгэврийн ашиг нэмэгддэг. Энэ нь ажил эрхэлж буй хүмүүсийн төлж буй шимтгэлээс тэтгэврийг санхүүжүүлдэгтэй холбоотой. Ажил эрхлэгсдийн тоо нэмэгдэх, эсхүл цалин нэмэгдэх тохиолдолд тэтгэвэр авагсдын ажил эрхэлж байх үедээ төлсөн шимтгэлийн хэмжээнээс илүү их хэмжээний тэтгэвэр өгөх боломжтой. Ажил эрхлэгсдийн тоо буурвал бодит цалин буурна. Тэтгэвэр авагсдын тоо нэмэгдвэл тэтгэврийн хэмжээ буурна. Германы тэтгэврийн даатгалын тооцоогоор 2008 оны тэтгэврийн орлогын нэрлэгдэх ашиг ганц бие эрчүүдийн хувьд 3.5 %, эмэгтэйчүүд болон гэрлэсэн эрчүүдийн хувьд 4.1%-иар тус тус нэмэгдсэн байна. (45 жил тасралтгүй тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн, дундаж орлоготой, дундаж наслалтын хэмжээнд наслах тэтгэвэр авагчийн тэтгэврийн хэмжээ)

Нэрлэгдсэн ашиг: Төлсөн шимтгэлийн нийлбэрийг төлсөн тэтгэврийн нийлбэрт харьцуулсан харьцаа. 4.1%-ийн ашигтай гарна гэдэг нь шимтгэл төлөгчид 100 евро төлөөд 104.10 еврогийн тэтгэвэр авна гэсэн үг. Нэрлэгдсэн ашигт үнийн өсөлтийг харгалзаж үздэггүй. (хэрэв үнийн өсөлтийг харгалзан үзсэн бол ашиг нь бодит эсхүл үр өгөөжтэй ашиг байх байсан) Нэрлэгдсэн ашгийг зарлах нь хөрөнгийн хуримтлалын ашгийг тооцоолоход түгээмэл хэрэглэгддэг аргачлал юм.

2020, 2030, 2040 онд шинээр тэтгэвэрт гарах хүмүүсийн хувьд ашиг нь

буурах бөгөөд ганц бие эрэгтэйчүүдийнх 2.8%, эмэгтэйчүүд ба гэрлэсэн эрэгтэйчүүдийнх 3,3% байх урьдчилсан тооцоо гарчээ. Тэтгэврийн фондын ашигтай харьцуулахад олон улсын хувьцааны фондын нэрлэгдсэн ашиг өнгөрсөн 20 жилийн туршид дунджаар 6,5%-ийн нэрлэгдсэн ашгийг авчирчээ. (Врайер 2000, Германы тэтгэврийн даатгал 2009 он)

Дээрх тоо хуримтлалын зарчмаар санхүүждэг тэтгэврийн ашиг нь хувиарлалтын зарчмаар санхүүждэг тэтгэврээс илүү өндөр байх магадлалтай гэдгийг харуулж байна. Бид нэгэнт баталгаа биш магадлалын тухай ярьж байгаа болохоор ашиг нь илүү бага байх ч аюултай юм. Хувьцааны зах зээлийг урт хугацаагаар ажиглавал ашиг нь хасах руу орсон буюу алдагдалтай байх үечлэл давтагдаж байдаг. Эрсдэл учирсан тохиолдолд тэр ч байтугай хэмнэлт ямар ч үнэ цэнэгүй болдог. Мэдээж даатгалын мөнгийг эрсдэлээс хамгаалж давхар даатгадаг ч даатгуулсныхаа талаа урамшуулал төлдөг учраас хуримтлалын зарчмаар санхүүждэг даатгалын ашгийн давуу талыг бууруулдаг. Төрөөс батлан даалт гаргах өөр нэгэн хувилбар байж болох юм. Төрөөс батлан даалт гаргасан тохиолдолд бодит байдал дээр энэ нь хувиарлалтын зарчим бөгөөд тэтгэвэр авагчдад үзүүлж буй төрийн дэмжлэгийн дийлэнх хувийг хөдөлмөр эрхэлж буй хүмүүсийн төлж буй татвараас санхүүжүүлдэг.

Ашиг авчирна гэдэг найдвар тээж ашигтай гар гараас хөтлөлцөн орж ирэх эрсдэлийг үүрэх хэрэг байна уу? гэдэг асуулт гарч ирнэ. Энэ асуултын хариулт нь хуримтлалын зарчмаар санхүүждэг тэтгэвэр нийт тэтгэврийн хэдэн хувийг эзэлж байвал зохистой бэ? гэдгээс хамаарна гэдэгт эргэлзэх хэрэггүй. Шведэд тэтгэврийн шимтгэлийн 2.5%-иар хуримтлалын зарчмаар санхүүждэг тэтгэврийн фондод хөрөнгө оруулалт хийдэг. Хуримтлалын тэтгэврийн эзлэх хувь харьцангуй бага, дээрээс нь Шведийн тэтгэврийн хэмжээг олон улсад харьцуулахад харьцангуй өндөр. Мөн Германд нийт орлогын 4%-тай тэнцэх мөнгөөр хөрөнгө оруулалт хийж байж төрийн дэмжлэг авах эрхийг авдаг, энэ хувь хэмжээ нь өнгөцхөн харахад хүлцэж болох хувь хэмжээ мэт харагдаж байна.

Гэхдээ хуримтлалын зарчмаар санхүүждэг тэтгэврийн фондод хөрөнгө оруулалт хийх эсэх нь сайн дурын хэрэг байгаа нь хүндрэл учруулж байна. Учир нь нэмэлт хуримтлалыг нийт орлогынхоо 4%

*Хуримтлалын
зарчмаар
санхүүждэг
тэтгэврийн ашиг*

*Хуримтлалын
санхүүжилт хэр
хэмжээнд байвал
оновчтой бэ?*

*Асуудал нь: Сайн
дурынх байгаад
оршиж байна.*

тай тэнцэх хэмжээний хөрөнгө оруулалт хийхэд асуудалгүй өндөр орлоготой хүмүүс үүсгэж байна.

Энэ нь үндсэндээ төрийн дэмжлэгтэй, сайн дурын, тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэмэлт 4% -ийг төлснөөр орлого нь буурлаа гээд ажрахгүй, урт хугацаанд авч үзвэл төрийн тэтгэврийн даатгалын хэмжээ буурна гэдгийг ухамсарласан даатгуулагчдын нэмэлт даатгал болчихоод байна. Тэгэхлээр төрийн дэмжлэгээс дундаж болон өндөр орлоготой хүмүүс л ашиг хүртэнэ гэсэн үг.

Дүгнэлт:
хуримтлалын
зарчмаар
санхүүждэг
тэтгэврийг
хязгаарлах:
хязгаарлахгүй
бол цаашид
үүрэгжүүлэх

Хуримтлалын зарчмаар санхүүждэг Риестерийн тэтгэвэр нь хууль ёсны тэтгэврийн даатгалын түвшин буурч байгааг нөхөх зорилготой. Ойрын жилүүдэд шимтгэл төлөгчид ба тэтгэвэр авагчид хоёрын харьцаа муудах тул тэтгэврийн хэмжээ буурах нь тодорхой. Даатгуулагчдад тэгш хандах шаардлагын дагуу энэ баганыг заавал даатгуулах шинж чанартай болгон өөрчлөх, ард түмний зөвхөн тодорхой багахан хэсгийг хамруулдагаа болих шаардлагатай гэдэг нь харагдаж байна. Харин эрсдэлийг тооцож үзсэний үр дүнд хуримтлалын зарчмаар санхүүждэг тэтгэврийн шимтгэлийн хэмжээг 4%-иас нэмэгдүүлэхгүй байх нь зүйтэй. Энэ нотолгоо нь юуны өмнө үеүд хоорондын шударга ёсыг хангах шаардлагаас эхтэй. Хуримтлалын зарчмаар санхүүждэг тэтгэврийн хямралын үр дагаврыг эв санааны нэгдэлтэй нийгэмд татвар төлөгчид хамтдаа үүрэх ёстой, эрсдэлд орсон нөхцөлд шимтгэл төлж хуримтлалыг бүрдүүлж буй үеийнхэн татварын давхар ачаалал үүрэх хэрэгтэй болно.

Хувиарлалтын
зарчмыг хэрхэн
бэхжүүлэх бэ?

Нийгмийн хамгааллын үндсэн системд хувиарлалтын зарчмаар санхүүждэг тэтгэврийг үндсэн өндөр насны үндсэн баталгаа хэвээр нь үлдээсэн нөхцөлд хүн ам зүйн хөгжлийн улмаас тулгарч буй сорилтуудыг даван туулахын тулд ямар арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх боломжтой бэ? гэдэг асуулт зайлшгүй гарч ирнэ. (Хүн ам зүйн хувьсал 5.3-р бүлгээс уншина уу.) 2012-2029 оны хооронд тэтгэвэр гарах насны босгыг 67 болгон нэмэгдүүлэх, тэтгэврийн хэмжээг тооцоолон боддог томъёонд тогтвортой байдлын хүчин зүйлийг оруулах зэрэг эхний арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлээд байна.

Бодит болон хууль ёсны тэтгэвэрт гарах насны босго, 2002-2007 оны байдлаар

	Эрэгтэйчүүд		Эмэгтэйчүүд	
	Бодит	Хууль ёсны	Бодит	Хууль ёсны
Швед	65,7	65	62,9	65
Дани	63,5	65	61,3	65
Их Британи	63,2	65	61,9	60
Герман	62,1	65	61,0	65
OECD-дундаж	63,6	65,0	61,8	63,8

Эх сурвалж: OECD (2009 он)


Хүн ам зүйн хувьслаас үүдэлтэй тэтгэврийн цоорхойг багасгах бусад арга хэмжээнүүдийг юуны өмнө улс ардын аж ахуйн цалингийн нийлбэрийг нэмэгдүүлэхэд чиглүүлэх шаардлагатай. Энд дараахи хоёр арга хэмжээг авч хэрэгжүүлэх боломжтой мэт харагдаж байна. Үүнд: шимтгэл төлөгчдийн тоог нэмэгдүүлэх, цалинг нэмэгдүүлэх

Хөдөлмөр эрхлэгсдийн квотод сүүлийн жилүүдэд тодорхой ахиц гарч байгаа нь юуны өмнө эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлт нэмэгдсэнтэй холбоотой. Гэхдээ шимтгэл төлөгчдийн тоог нэмэгдүүлэх өөр арга зам бий. Ажил мэргэжил эрхэлж буй бүх хүмүүсийг тэтгэврийн даатгалд хамруулах (хувиараа хөдөлмөр эрхлэгсэд, албан хаагчид, улс төрчид гэх мэт) замаар тэтгэврийн даатгалын санхүүгийн үндсийг бэхжүүлэх боломжтой. Нөгөө талд тэтгэвэр авагсдын хүрээ өргөжих нь тодорхой. Хүн ам зүйн хувьслаас үүдэлтэй ачаалал 2040 онд дээд цэгтээ хүрэх тул ачааллыг аль болох урт хугацаанд харьцангуй жигд хувиарлаж зөөллөх шаардлагатай.

Бид урт хугацаанд хууль ёсны тэтгэврийн даатгалд нийт хөдөлмөр эрхлэгсдийг хамруулахыг зорьж байна. Үүний тулд хөдөлмөр эрхлээд олж буй орлого, хөдөлмөр эрхэлсэн хугацааг хэмжүүр болгон тэтгэврийн хэмжээг тогтоодог аргачлалыг хэвээр хадгалах болно. (Хамбургийн хөтөлбөр 2007 он, 59-р тал)

*Нэгдүгээрт:
Эмэгтэй шимтгэл
төлөгчид*

Хоёрдох шийдэл бол цалинг нэмэгдүүлэх. Нэгдүгээрт бүтээмжийг нэмэгдүүлэх замаар цалинг нэмэгдүүлэх боломжтой. Энэ хэтийн чиг хандлагыг удирдлага болговол хүн ам зүйн хувьслаас үүдэлтэй өөрчлөлтүүдийг хүндрэл багатай давахад боловсрол, мэргэжил олгох, мэргэжил дээшлүүлэх сургалтуудад хөрөнгө оруулалт хийх нь чухал арга хэрэгсэл юм. Гэхдээ 2000 оноос хойших цалингийн квот буюу бие даасан бус хараат хөдөлмөр эрхлэлтээс олсон нийт орлогын ард түмний нийт орлогод эзлэх хувь хэмжээ бүтээмж нэмэгдсэн хэрнээ буурсан байна. Энэ нь зарим талын батлаад байгаа шиг татвар, хураамжийн ачаалал нэмэгдсэнээс болоогүй. Цэвэр буюу нетто квот (өөрөөр хэлбэл нийт цалинд цэвэр цалингийн эзлэх хувь хэмжээ) ойролцоогоор 65% байна. Цалинд татвар, хураамж, шимтгэлийн эзлэх хувь ойролцоогоор 35%-тай тэнцэж байна. Харин компани-хөрөнгийн орлогын эзлэх хувь тогтмол өссөөр байна.



16-р зураг: Германы цалингийн квот болон цэвэр квот

Унших жишээ: 1999 онд цэвэр квот ойролцоогоор 64% байсан бол 2006 оныг хүртэл цэвэр квот ойролцоогоор 65% хүртэл нэмэгдсэн байна. Мөн энэ хугацаанд ард түмний орлогод цалингийн эзлэх хувь 72%-аас 66% боллоо буурсан байна. Цалинд татвар, хураамж, шимтгэлийн эзлэх хувь бараг өөрчлөгдөөгүй, хэвээр байхад цалингийн бусад орлоготой харьцуулсан харьцаа (хөрөнгийн орлого, компанийн орлого) буурсан байна.

Германы хувиарлалтын зарчмаар санхүүждэг тэтгэврийг нэмэгдүүлэхийн тулд цалинг нэмэгдүүлэх шаардлагатай. Европын бусад орнуудтай харьцуулахад юуны өмнө ахуй үйлчилгээний салбарт ажиллагсдын цалин бага байна. Салбарууд хоорондын цалингийн зөрүүг хэт нэмэгдүүлэхгүй байх, ирээдүйн тэтгэврийн баталгааг хангахад хувь нэмэр оруулахын тулд цалингийн доод хэмжээг хуулиар тогтоох нь бас нэгэн арга хэрэгсэл байж болох юм.

Бодлогын өөр нэг хувилбар бол сүүлийн жилүүдэд ихээхэн нэмэгдэж буй компаниуд болон хөрөнгийн орлогыг хууль ёсны тэтгэврийн даатгалын санхүүжилтэд урьдахаас илүү татан оролцуулах. Иймэрхүү хэлбэрийн татварын санхүүжилт нь тэтгэврийн доод хэмжээг нэмэгдүүлэх, ингэснээр тэтгэврийн орлогоос хамааралтай хэсгийн бууралт нэн ялангуяа дундаж болон бага орлоготой даатгуулагчдын орлогын алдагдлыг нөхөхөд ашиглах боломжтой.

Тэтгэвэрт гарах насны босгыг нэмэгдүүлэхийн зэрэгцээ хөдөлмөр эрхлэгсдийн аль болох удаан хугацаагаар хөдөлмөр эрхлэх боломжийг дээшлүүлэх хэрэгтэй. Олон салбарт тэтгэвэрт гарах насны босгыг нэмсэн хэмжээнд хүртэл ажиллах боломжоор хангахын тулд хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулах шаардлагатай. (Хөдөлмөрийн харилцааг илүү хүмүүнлэг болгох шаардлагатай.)

Хөрөнгийн орлого ба компанийн ашгийг тэтгэврийн санхүүжилтэд оролцуулах

Хөдөлмөрийн харилцааг илүү хүмүүнлэг болгох

Энэ нь нийгмийн ардчилалд юу гэсэн үг бэ?

- Өндөр насны баталгааг хангахын тулд татварын санхүүжилтээр тэтгэврийн доод хэмжээг нэмэгдүүлэх
- Хувиарлалтын зарчмаар санхүүждэг, хууль ёсны тэтгэврийн даатгалд шимтгэл төлөгчдийн хүрээг өргөтгөх
- өнөөгийн шимтгэлийн хувь хэмжээг нэмэгдүүлэхгүйгээр хуримтлалын зарчмаар санхүүждэг тэтгэврийн даатгалын баганыг үүрэгжүүлэх “Риестерийн үүрэг”
- Гэр бүл ба хөдөлмөр эрхлэлтийг хослуулах боломжийг дээшлүүлэх гэх мэт арга хэмжээгээр дамжуулан эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих
- Мэргэжил олгох, мэргэжил дээшлүүлэх сургалт, судалгаа, шинжлэх ухааныг дэмжих замаар бүтээмжийг нэмэгдүүлэх
- Хөдөлмөрийн харилцааг илүү хүмүүнлэг болгох

7.4. Эрүүл мэнд

Диана Огнянова, Александр Петринг

Энэхүү бүлэгт:

- Герман, Голланд, эрүүл мэндийн системийн үндсийг танилцуулна.
- Дээр дурьдсан гурван орны эрүүл мэндийн системийн хүчтэй болон сул талуудыг харуулна.
- Германы эрүүл мэндийн системийг шинэчлэх хувилбарууд, нэн ялангуяа санхүүжилтийн шинэчлэлийн талаар хэлэлцэнэ.

Хоёр загвар:
Төрийн
удирдлагатай
ба нийгмийн
даатгалаар
дамждаг.

Европ тивд эрүүл мэндийн өөр өөр загварууд үүсэж хөгжсөн түүхтэй. Зарчмын хувьд эдгээр загваруудыг төрийн удирдлагатай ба татвараас санхүүждэг (жишээ нь: Их үндэсний Эрүүл Мэндийн үйлчилгээ-National Health Service (NHS) болон нийгмийн даатгал дээр суурилдаг (Герман, Голландын эрүүл мэндийн даатгал) хэмээн хоёр хувааж болно.²⁹

Эрүүл мэндийн загваруудын зохион байгуулалтын хэлбэрүүд ба онцлог шинжүүд

Үндэсний эрүүл мэндийн алба	• Нийт хүн амд зориулсан төрийн хяналтанд байдаг эрүүл мэндийн байгууллагуудаар үнэ төлбөргүй үйлчлүүлнэ. • Зардлын дийлэнх хэсгийг татвараас санхүүжүүлдэг. • Ихэвчлэн төрийн байгууллагуудаар дамжуулан эрүүл мэндийн үйлчилгээг хүргэдэг.
Нийгмийн даатгалын загвар	• Өргөн хүрээг хамарсан заавал хамрагдах даатгал • Орлогоос хамааран ажил олгогч ба ажилтнуудын төлдөг шимтгэлээс ихэвчлэн санхүүждэг. • Төрийн болон хувийн эрүүл мэндийн даатгалын газруудтай • Төрийн болон хувийн байгууллагууд эрүүл мэндийн үйлчилгээг хүргэдэг.

²⁹ Европын зарим орон холимог тогтолцоотой байдаг. Жишээлбэл: Санхүүжилт нь татвар ба нийгмийн даатгалын шимтгэлээс бүрддэг.

Германы эрүүл мэндийн системийн загварын үүсгэн байгуулагдсан түүх 1883 оноос эхэлдэг. “Ажилчдын эрүүл мэндийн даатгалын тухай хууль”-ийн дагуу ажилчдад нийтээрээ эрүүл мэндийн даатгалд даатгуулах үүрэг ногдуулснаар орлогын тодорхой хэмжээнд хүртэл даатгалд даатгуулах үүрэг хүлээгч хүн бүр өөрийн ажил мэргэжлийн салбар тус бүрээр байгуулагдсан эрүүл мэндийн даатгалын гишүүн болсон.

1883: “Ажилчдын эрүүл мэндийн даатгалын тухай хууль батлагдсан.”

Өнөөгийн нийгмийн эрүүл мэндийн даатгалын систем нь төвлөрсөн бус, бүгд найрамдах улсын бүтцийн дагуу зохион байгуулагдсан. Төрөл бүрийн төрийн бус байгууллагууд (хамтын шийдвэр гаргадаг) хүчтэй байр суурь эзэлдэгээрээ онцлог. Ингэснээр эрүүл мэндийн даатгалын эмчилгээний үйлчилгээ хүргэгчдийн талд даатгалын эмч нарын холбоо, даатгалын шүдний эмч нарын холбоо нөгөө талд буюу зардлыг бүрдүүлэгч тал дээр эрүүл мэндийн даатгалын газрууд, тэдгээрийн холбоод нь эрүүл мэндийн даатгалын системийн үндсэн актёрууд юм.

Бүтэц: төвлөрсөн бус децентра, бүгд найрамдах улсын бүтцийн дагуу зохион байгуулагдсан, хүчирхэг төрийн бус байгууллагууд

Амбулаторийн эрүүл мэндийн хангамж нь хамтын шийдвэр хүчтэй нөлөөтэй байдаг сектор юм. (Бүссе/Риесберг 2005 он) Даатгалын эмч нарын холбоо өөрийн муж улсад үйл ажиллагаа явуулдаг даатгалын газруудтай үйлчилгээний үнийн дүнгийн талаар хэлэлцээр явуулдаг. Даатгалын газрууд нь холбооны улс даяар нийтлэг дагаж мөрддөг, гэхдээ бүс нутгийн онцлогт тохирсон дүрэм журмын дагуу үйлчилгээний үнийг өөр хоорондоо хувиарлаж авдаг. Ерөнхий мэргэжлийн болон нарийн мэргэжлийн эмч нар үзүүлсэн эрүүл мэндийн үйлчилгээний хэрээр хөлсөө авдаг. Үйлчилгээний хүрээнээс хамааран үнийн дээд хязгаарыг тогтоодог.

Амбулаторийн хангамж

Суурьшмал салбар нь хосолмол санхүүжилттэй байдаг: Хөрөнгө оруулалтыг холбооны улсуудаас төлөвлөж эцэст нь муж улсуудын болон Холбооны төсвөөс хамтарсан санхүүжилтийг хийдэг. Эрүүл мэндийн даатгалаас урсгал зардал, үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлдэг. 2004 онд Германд Австралийн оношлогооны системийг нэвтрүүлснээс хойш эмнэлгийн урсгал зардлуудыг уг системийн аргачлалаар тооцож гаргадаг болжээ. (ДЭМБ 2006 он)

Суурьшмал салбар

Хууль ёсны эрүүл мэндийн даатгал

Германы эрүүл мэндийн даатгалын систем нь хууль ёсны болон хувийн эрүүл мэндийн даатгалд хуваагддаг онцлогтой. Хууль ёсны

Эрүүл мэндийн даатгалыг хоёр хуваадаг.

эрүүл мэндийн даатгал нь эрүүл мэндийн даатгалын шимтгэлээс ихэвчлэн санхүүждэг. Эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг ажилтан ба ажил олгогчид тэнцүү хувиар хувааж төлдөг. 2005 онд ажилтнууд ба тэтгэврийнхний төлдөг шимтгэлийг 0.9%-иар нэмэгдүүлсэн. Хүүхдүүд болон ажил хийж орлого олдоггүй эхнэр эсхүл нөхрийг шимтгэл төлүүлэлгүйгээр хамтад нь даатгадаг, энэ нь хууль ёсны даатгалаар дамжуулан гэр бүлийн тусын тулд хийж буй дахин хувиарлалтын хэлбэр юм.

85% нь хууль
ёсны даатгалд
даатгуулсан
байдаг.

Хүн амын ойролцоогоор 85% нь хууль ёсны эрүүл мэндийн даатгалд даатгуулдаг. Эрүүл мэндийн даатгалын газарт гишүүнчлэлтэй байх нь жилийн орлого нь тодорхой мөнгөн дүнгээс дээш даваагүй (даатгуулах үүрэг хүлээх хязгаар) ажилчид, албан хаагчдын хувьд заавал даатгуулах үүрэг юм. 2009 оноос хойш заавал даатгуулах үүрэг ногдуулах орлогын дээд хэмжээг сар бүрийн нийт орлого нь 4.050 евро байхаар тогтоосон байна.

Эрүүл мэндийн
ямар даатгалд
даатгуулахаа
даатгуулагч өөрөө
сонгодог.

Өнөөгийн байдлаар ойролцоогоор 200 гаруй хууль ёсны даатгалын газар үйл ажиллагаа явуулж байна. (2009 оны 7-р сарын байдлаар) 1996 оноос хойш бараг бүх даатгуулагчдад эрүүл мэндийн ямар даатгалд даатгуулахаа өөрөө сонгох боломж нээлттэй байна. Даатгалын газар тус бүрийн гишүүнчлэлийн бүтэц шимтгэлийн орлого, тухайн ажил, мэргэжлийн бүлгийн өвчлөлийн бүтэц, давтамжийн бүтцээс хамааран өөр хоорондоо асар том ялгаатай байдаг.

Эрсдэлийн бүтцийг
тэнцвэржүүлэх
арга хэмжээ

Дээрх эрс ялгаатай байдлыг тэнцвэржүүлэхийн тулд 2009 оны 1-р сарын 1-нээс тухайн даатгалын газарт даатгуулсан ажил, мэргэжлийн бүлгийн өвчлөлийн бүтэц, давтамжид чиглэгдсэн эрсдэлийн бүтцийн тэнцвэржүүлэх арга хэмжээг нэвтрүүлсэн. Эрүүл мэндийн даатгалын газруудад даатгуулагч тутамд дундаж зардалтай тэнцэх хэмжээний мөнгийг олгодог. Хүн тус бүрт ногдох үндсэн зардалд даатгуулагчийн нас ба хүйсээс хамааран нэмэгдэл, хорогдлыг тооцдог. Дээрээс нь тодорхой удамшлын өвчтэй, эсхүл хүндэвтэр өвчтэй даатгуулагчдын зардал дунджаас нэлээд өндөр байдаг тул нэмэгдэл олгодог.

Даатгалын газрын даатгуулагчдын ажил мэргэжлийн өвчлөлийн бүтэц, давтамжаас үүдэлтэй эрсдэлийн бүтцийн тэнцэтгэл

Олон даатгуулагчид нь эмчилгээний зардал өндөртэй өвчнөөр өвчилсөн

даатгалын газруудын сөрөг тал буюу ачааллыг бууруулах зорилгоор даатгалын газруудад эрсдэлийг бууруулах зорилгоор мөнгө олгодог. Өвчлөлийн бүтэц давтамж буюу Morbidity гэдэг үг нь латин хэлний morbidus буюу өвчин гэдэг үнээс гаралтай. 2002 оныг хүртэл даатгалын газруудын хооронд үйлчилж байсан тэнцэтгэл нас, хүйс, хөдөлмөрийн чадвар алдалтыг харгалзан үздэг байсан. 2002 оноос хойш удамшлын өвчнөөр өвчлөгсдийг тусгай хөтөлбөрт хамруулах зардлыг тусгадаг болсон. Шинээр нэвтрүүлсэн тэнцэтгэлийн арга хэмжээ эмчилгээний өртөг зардал өндөртэй, удамшлын ба хүндэвтэр 80 төрлийн өвчнүүдийг сонгон авч эрүүл мэндийн даатгалын газарт нэмэгдэл олгодог.

Шинэчлэгдсэн эрсдэлийг тэнцэтгэх арга хэмжээ нь тухайн ажил мэргэжлийн бүлгийн өвчлөлийн бүтэц, давтамжийг тэнцэтгэх арга хэмжээний дагуу мөнгийг дахин хувиарладаг тул үнэхээр ноцтой эрсдэлүүдийг сонгох авах сонирхлыг бууруулдаг. Удамшлын өвчнөөр өвчилсөн өвчтөний өвчиг сонгон авсан 80 өвчний төрөлд багтаж буй нөхцөлд даатгуулсан эрүүл мэндийн даатгалын газар нь санхүүгийн өндөр эрсдэлд зайлшгүй өртөөд байдгаа больсон гэсэн үг.

Гурван жил дараалан орлого нь заавал даатгуулах дээд хэмжээнээс давсан хөдөлмөр эрхлэгч заавал даатгуулах үүргээс чөлөөлөгддөг. Мөн хувиараа хөдөлмөр эрхлэгчид хууль ёсны даатгалд заавал даатгуулах үүрэг хүлээдэггүй. Тэд өөрсдөө хүсвэл сайн дураараа хууль ёсны эрүүл мэндийн даатгал эсхүл эрүүл мэндийн хувийн даатгалд даатгуулж болно. 2007 онд хийгдсэн эрүүл мэндийн шинэчлэлийн дагуу 2009 оны 1-р сараас Германд оршин суудаг бүх иргэдэд эрүүл мэндийн даатгалд заавал даатгуулах үүргийг ногдуулсан.

Христосын Ардчилсан Холбоо/Христосын Нийгмийн Ардчилсан Холбоо ба Германы Социалдемократ Намын эвслээс 2007 онд хууль ёсны эрүүл мэндийн даатгалын газрууд хоорондын өрсөлдөөнийг дэмжих тухай хуулийг баталсан. Энэ хуулиар эрүүл мэндийн фондыг байгуулсан нь ГСДН-ын иргэний даатгалын тухай санаа, ХАХН хүн бүрт ногдох зардал гэдэг нэрээр олонд танигдсан эрүүл мэндийн урамшууллын концепцийн дундаас төрсөн, хоёр намын дунд харилцан буулт хийх замаар хүрсэн шийдэл байлаа.³⁰

2009 оноос хойш:
Заавал даатгуулах
үүрэг:

Эрүүл мэндийн
фонд

30 Номын 6-р бүлэгт тайлбарласан "Улс төрийн намуудын нийгмийн бодлогын талаар баримталж буй байр" болон "Нийгмийн ардчиллын үндэс" сурах бичгийн 47-49-р хуудастай харьцуулна уу.

Шинээр байгуулагдсан эрүүл мэндийн фондод хөдөлмөр эрхэлж буй даатгуулагчид, ажилтнууд, ажил олгогчдын үндсэн бүлгийн төлсөн шимтгэлийг нэгтгэдэг. Дээрээс нь жил тутамд 14 миллиард евро хүртэлх хэмжээний татварын нэмэгдлийг олгодог. Харин татвар ногдуулах аргачлал нь шимтгэлээс эсрэгээрээ прогрессив

тул дээр дурьдсан татварын нэмэгдэл нь хувиарлалтын шударга ёсыг сайжруулж эрүүл мэндийн даатгалын газруудын санхүүжилтийн суурийг өргөтгөдөг. (Гресс/Вазерн 2008 он, 7.1. Татвар бүлэгтэй харьцуулж үзнэ үү.)

ГСДН-ын дэвшүүлсэн иргэний даатгал байгуулах санаа нь эрүүл мэндийн даатгалын хувиарлалтын санхүүжилтийг хэвээр хадгалах, харин санхүүжилтийн суурийг өргөтгөх зорилготой. Эрүүл мэндийн хууль ёсны даатгалд заавал даатгуулах үүргийг бүх иргэдэд ногдуулна гэсэн үг. Өдийг хүртэл хууль ёсны даатгалд даатгуулдаггүй байсан хүн амын бүлгүүд жишээлбэл: хувиараа хөдөлмөр эрхлэгчид, албан хаагчдыг хамруулах. Харин хууль ёсны даатгалд заавал даатгуулах үүрэг ногдуулах орлогын дээд хязгаарыг үгүй болгоно. Харин шимтгэлийн суурийг түрээсийн орлого, хүүгийн орлого, хөрөнгийн орлого зэрэг орлогын бусад төрлүүдийг хамруулснаар өргөтгөнө. Өнөө мөрдөгдөж буй шимтгэл тооцох орлогын дээд хязгаарыг нэмэгдүүлэх шаардлагатай. Иргэний даатгалыг хууль ёсны болон хувийн даатгалын газрууд хэрэгжүүлнэ. Даатгуулагч өөрийн чөлөөт сонголтоор даатгалын газрыг сонгоно. Харин даатгуулагчдын бүтцээс хамааралтай ялгааг эрсдэлийн бүтцийг тэнцэтгэх арга хэмжээгээр дамжуулан тэнцэтгэнэ.

ХАХН/ХНАХ намуудын дэвшүүлсэн эрүүл мэндийн урамшууллын загвар нь хууль ёсны ба хувийн даатгалын газарт даатгуулагчдын ялгааг хэвээр үлдээнэ. Зөвхөн хууль ёсны эрүүл мэндийн даатгалын газруудад өөрчлөлт хийнэ. Хууль ёсны даатгалын газарт даатгуулагчид ирээдүйд бүгд ижил хэмжээний шимтгэл төлнө. Бага орлоготой иргэдэд эрүүл мэндийн урамшууллаа төлөхөд нь зориулж татвараас дэмжлэг үзүүлнэ. Уг загвар нь эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг хөдөлмөрийн зардал буюу цалингаас хамааралгүй болгон чөлөөлөх, харин нийгмийн тэнцвэрт байдлыг хангахад гарах зардлыг төрийн татвар ба нийгмийн халамж, үйлчилгээний салбарт үүрүүлэх зорилготой.

2009 оныг хүртэл эрүүл мэндийн даатгалын газрууд даатгуулагчид ба ажил ологчдоос шимтгэлээ шууд хураадаг байсан. Харин эрүүл мэндийн фондод хууль ёсны эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг төвлөрүүлдэг.³¹ Харин хууль ёсны даатгалын газрууд эрүүл мэндийн фондоос хүн тус бүрт ногдох эрүүл мэндийн үндсэн зардал дээр

31 Шилжилтийн үед шимтгэлийг урьдын адил эрүүл мэндийн даатгалын газрууд хурааж, хураасан мөнгөө эрүүл мэндийн фондод шилжүүлж байх зохицуулалтыг хийжээ.

даатгуулагч тус бүрийн нас, хүйс, эрсдэлийг тэнцэтгэсэн нэмэгдэл ба хасалтыг авдаг. Ингэснээр 1994 онд нэвтрүүлсэн эрсдэлийн бүтцийг тэнцэтгэх арга хэмжээг эрүүл мэндийн фондод нэгтгэж улам боловсронгуй болгосон.

Эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээг Холбооны засгийн газраас нэгдсэн журмаар тогтоодог. 2009 оны 7-р сараас шимтгэлийн хэмжээ даатгал төлөх үүрэг ногдох орлогын 14,9%-тай тэнцэж байжээ. Шимтгэл тооцох орлогын дээд хэмжээг сар бүр 3.675 еврогоор тогтоожээ. Даатгуулагчийн шимтгэл тооцох орлогын дээд хэмжээнээс давсан орлого шимтгэлээс чөлөөлөгддөг.

Шимтгэлийн хувь хэмжээг төвлөрсөн байдлаар , нэгдсэн журмаар тогтоодог.

Хууль ёсны даатгалын газруудад хувиарлагдсан мөнгө хүрэлцэхгүй байх тохиолдолд даатгуулагчдаасаа нэмэлт шимтгэл хурааж болно. Даатгалын газрууд сар тутамд 8 хүртэлх еврог даатгуулагчдынхаа санхүүгийн байдлыг хянаж үзэлгүйгээр нэмж хурааж болно. Нэмэлт шимтгэлийн хэмжээ 8 еврогоос давсан тохиолдолд шимтгэл тооцох орлогын 1%-иас хэтэрч болохгүй гэдэг хязгаарлалтыг тавьдаг. Тооцоо сайтай эрүүл мэндийн даатгалын газрууд шимтгэлийн тодорхой хувийг буцаан олгодог.

Шимтгэлийн хувь хэмжээг хязгаарлагдмал хүрээнд нэмэгдүүлэх боломжтой.

Даатгуулагчдын статус, шимтгэлийн хувь хэмжээ, даатгал төлсөн хугацаанаас үл хамааран хууль ёсны эрүүл мэндийн даатгалын гишүүдийн эрхэлсэн ажил, орлогогүй гэр бүлийн гишүүд хэрэгцээ шаардлага гарсан үед даатгуулагчтай ижил эрүүл мэндийн үйлчилгээ авах эрхтэй.

Хууль ёсны эрүүл мэндийн даатгал: үйлчилгээ авах тэгш эрхтэй.

Эрүүл мэндийн хувийн даатгал

Ард иргэдийн 9 орчим хувь нь эрүүл мэндээ хувийн даатгалын газруудад даатгуулдаг. Эрүүл мэндийн хувийн даатгалд даатгуулсан тохиолдолд гэрээгээр тохиролцсон эрүүл мэндийн үйлчилгээ, эрүүл мэндийн ерөнхий байдал, хүйс, даатгуулсан насны босго зэргийг харгалзан даатгалын урамшууллыг олгодог. Дээр дурьдсан ялгаатай байдлын дагуу эрүүл мэндийн хувийн даатгалын газрууд хувь хүмүүсийн даатгалын эрсдэлийг харгалзан үзсэний үндсэн дээр тодорхой тарифыг санал болгодог.

9% нь хувийн даатгалд даатгуулдаг.

Хувиарлалтын зарчмаар санхүүждэг хууль ёсны эрүүл мэндийн даатгалын газруудтай харьцуулахад (даатгалын үйлчилгээний

зардлыг тухайн жилд төлөгдсөн шимтгэлийн орлогоос санхүүжүүлдэг гэсэн үг) эрүүл мэндийн хувийн даатгалын газрууд даатгуулагчдын нас ахихын хэрээр хуримтлал үүсгэх үүрэг хүлээдэг. (хуримтлалын тогтолцоо). 2009

2009 оноос хууль ёсны даатгалаас хувийн даатгалд шилжсэн даатгуулагчдад хувийн даатгалын суурь тарифтай тэнцэх хэмжээний хуримтлалыг аваад явах боломжоор хангасан.

*Илүү сайн
үйлчилгээ нь: илүү
“том” эрсдэлийн
үр дагавар*

Эрүүл мэндийн хувийн даатгалын газруудын тариф нь эрүүл мэндийн хууль ёсны даатгалын газруудтай харьцуулахад хямд, даатгуулагчиддаа илүү сайн үйлчилгээ санал болгож чаддаг. Нэн ялангуяа залуус, эрүүл саруул эсхүл өндөр орлоготой ганц бие даатгуулагчдын төлөх шимтгэлийн хэмжээ эрүүл мэндийн хууль ёсны даатгалаас бага. Даатгуулагчид хувийн даатгалыг сонгож байгаагийн онцгой шалтгаан нь хууль ёсны ба хувийн эрүүл мэндийн даатгалын даатгуулагчдын бүтэц дэх тэгш бус нийгмийн хувиарлалт юм.

Эрүүл мэндийн хувийн даатгалд даатгуулагчид нь ихэвчлэн өндөр орлоготой, эрүүл мэндийн эрсдэл багатай даатгуулагчид байдаг учраас эрүүл мэндийн хувийн даатгалын газрууд хууль ёсны, эв санааны нэгдэлийн зарчим дээр суурилдаг даатгалын газруудын орлогоос хасаж сайн эрсдэлүүдээс зайлсхийгээд байгаа юм. Төрийн албан хаагчид, хувиараа хөдөлмөр эрхлэгсэд, өндөр орлоготой хүмүүс нь хувийн даатгалын даатгуулагчид тул эрүүл мэндийн хувийн даатгалын газруудад эдийн засгийн хувьд хямд төсөр, эрүүл мэндийн үйлчилгээг хэвийн үнээр тэр ч байтугай нэмэгдсэн үнээр буцааж төлөх боломжтой байдаг. Энэ нь эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэгсдийг урамшуулж хувийн даатгалын өвчтөнүүдийг онцгойлон халамжлахад хүргэдэг. (Балендизик 2009 он)

*Гэр бүлийн
гишүүд нэмэлт
даатгал төлөх
ёстой.*

Эрүүл мэндийн хууль ёсны даатгал даатгуулагчдынхаа ажил орлогогүй гэр бүлийн гишүүдийг зарчмын хувьд үнэ төлбөргүйгээр хамтад нь даатгадаг. Харин эрүүл мэндийн хувийн даатгал нь даатгуулагч бүрд тусад нь даатгалын урамшуулал төлөх ёстой. Хувийн даатгалд даатгуулагчид хүссэн үедээ хууль ёсны даатгал руу буцах боломжгүй. Хууль ёсны даатгал руу буцахыг хүсэгчид 55-аас доош настай, орлого нь шимтгэл тооцох доод хязгаараас бага болтлоо буурсан байх ёстой гэсэн шаардлагыг тавьдаг.

2009 оноос хувийн даатгалын газруудад үйлчилгээнийхээ багцад хууль ёсны даатгалын газруудын үйлчилгээний саналтай үнийн хувьд ижил суурь тарифыг нэвтрүүлэх үүргийг ногдуулсан. Уг тариф нь хууль ёсны даатгалын газруудын дундаж шимтгэлээс хэтрэхгүй байх ёстой. (2009 оны байдлаар сар тутамд ойролцоогоор 570 евро) Эрүүл мэндийн хувийн даатгалын газрууд болон сайн дураараа эрүүл мэндийн хууль ёсны даатгалд даатгуулагчид харин тодорхой нөхцөл болзол хангасан бол суурь тариф руу шилжиж болно. Эхлэн даатгуулагчид нас, хүйсээсээ хамааран элсэлтийн шимтгэл төлдөг.

*2009 оноос хойш:
Суурь тарифаар
шимтгэл төлөх
үүрэг хүлээлгэдэг.*

Голландын эрүүл мэндийн даатгалын систем

Голландын эрүүл мэндийн даатгалын систем нь Германыхтай ихээхэн төстэй. Эдгээр хоёр систем нь хоёулаа үндсэндээ орлоготой уялдуулан шимтгэлийн хэмжээг тогтоодог нийгмийн даатгалын систем бөгөөд даатгуулагч өөрөө даатгалын газраа чөлөөтэй сонгодог, хангамж үйлчилгээг ихэвчлэн хувийн зохион байгуулалттай гүйцэтгэгчид нийлүүлдэг, өргөн хүрээтэй, гэхдээ зарим хэсэг нь ойлгомжтой тодорхойлогдсон, үйлчилгээний багцуудыг даатгуулагчиддаа санал болгодог. Хоёр систем ямар учир шалтгаанаас болоод хоорондоо ийм төсөөтэй байгаа юм бэ? гэдгийг тайлбарлахад хялбар. 1941 онд нэвтрүүлсэн Голландын эрүүл мэндийн систем үндсэндээ германы системээс санаа авсан. (Гресс болон бусад зохиогчид 2006 он) Голланд улс эрүүл мэндийн системдээ хамгийн сүүлд 2006 онд гүнзгий шинэчлэл хийсэн.

*Германы
системтэй төстэй.*

Голландын эрүүл мэндийн систем гурван баганаас бүрддэг. Эхний багана нь (асрамж ба урт хугацааны даатгал) гуравдах (хувийн нэмэлт даатгалын) баганад 2006 оны эрүүл мэндийн даатгалын гүнзгий шинэчлэлийн хүрээнд үндсэндээ бараг өөрчлөлт оруулаагүй. Шинэчлэл үндсэндээ хоёрдох баганад хийгдсэн гэж хэлж болно. Шинэчлэлээс өмнө хоёрдох баганад заавал даатгуулах нийгмийн даатгал ба хувийн бүрэн даатгал багтдаг байсан. Орлогын дээд хязгаараас дээш орлоготой хөдөлмөр эрхлэгсэд болон хувиараа хөдөлмөр эрхлэгсэд заавал даатгуулах нийгмийн даатгалаас хасуулж хувийн бүрэн даатгалд даатгуулах ёстой байжээ.

*Эрүүл мэндийн
систем: гурван
баганатай.*

Харин шинэчлэлээс хойш эрүүл мэндийн даатгалын нэгдсэн систем бий болсон юм. Өмнө нь нийгмийн ба хувийн байсан даатгалын газрууд өдгөө даатгалын нэгдсэн системийн дотор хоорондоо

*1996 оноос хойш:
Эрүүл мэндийн
нэгдсэн системд
шилжүүлсэн*

өрсөлдөж байна. (фон Гиннекен болон бусад зохиогчид 2006 он)

Нийгмийн ба
хувийн даатгалын
газруудад
өрсөлдөөний
ерөнхий хүрээг
тогтоож өгсөн.

Хувийнх уу? нийгмийнх үү? гэдгээс үл хамааран эрүүл мэндийн даатгалын газруудад ижил нөхцөлийг бүрдүүлж өгсөн: Хоорондоо өрсөлдөх, даатгуулахыг хүсэгчдээс татгалзахгүй байх, эрсдэлээс хамааралтай урамшууллыг хураахгүй байх, үүргийг ногдуулсан бөгөөд хоорондоо эрсдэлийн бүтцийн тэнцэтгэлийн арга хэмжээнүүдээр холбогддог. Эрүүл мэндийн даатгалууд даатгуулагчдад харилцан адилгүй тарифыг санал болгох боломжтой. Гэхдээ бүх нийтээрээ даатгалд даатгуулах үүрэг хүлээдэг.

Санхүүжилтийн
дийлэнх хувийг
шимтгэлээс
бүрдүүлдэг.

Систем бүхэлдээ орлогоос хамааралтай болон орлогоос хамааралгүй шимтгэлээс санхүүждэг. Зардлын тодорхой хэсгийг төр даадаг. Төр хүүхдүүд, залуучууд, болон бага орлоготой хүмүүсийн эрүүл мэндийн нэмэгдлийг даадаг.

Шинэчлэлийн
нөлөө өндөр:
Таван даатгуулагч
тутмын нэг нь
даатгалын газраа
сольсон.

Шинэчлэл даатгуулагчдын даатгалын газраа солиход бэлэн байдалд эхлээд асар хүчтэй нөлөөлсөн. Ойролцоогоор таван даатгуулагч тутмын нэг нь шинэчлэлийн нөлөөгөөр даатгалын газраа сольсон. Голландын даатгуулагчид сонголтоо хийхдээ найдвартай байдлыг маш их эрхэмлэсэн. Даатгуулагчдад илүү ашигтай тарифыг даатгуулагчид ховорхон сонгож бүх даатгуулагчдын 95 % нь хувийн нэмэлт даатгалд даатгуулсан.

Голландын
шинэчлэл германд
үлгэр дууриалал
болох уу?

Хууль ёсны ба хувийн эрүүл мэндийн даатгалын хил хязгаарыг давж чадсан, өрсөлдөх чадвартай эрүүл мэндийн даатгалын систем германы эрүүл мэндийн даатгалын системийн дунд болон урт хугацааны үлгэр жишээ болж чадах уу? гэдэг сэдвийн дор хэлэлцүүлэг өрнөж байна.

Их Британи

Үндэсний
Эрүүл Мэндийн
үйлчилгээний
нэгдсэн
удирдлагын дор

Их хүн амын эрүүл мэндийн хангамж уламжлал ёсоор төрийн удирдлагад байдаг. Эрүүл мэндийн системийн ихэнх үүргийг 1948 оноос хойш үйл ажиллагаа явуулж буй үндэсний Эрүүл Мэндийн үйлчилгээний газраас төлөвлөж, удирдаж, зохицуулж байдаг. ҮЭМҮГ нь ихэвчлэн төсвөөс санхүүжиж төрийн удирдлагад байдаг. ҮЭМҮГ-т гишүүнээр элсэх үүргийг бүх иргэддээ ногдуулдаг.

Их Британид оршин суудаг бүх иргэд үндэс угсаа, орлогоос үл хамааран эрүүл мэндийн системээс үйлчилгээ авах эрхтэй. Бүх нийтэд нээлттэй үндсэн үйлчилгээнд ерөнхий-мэргэжлийн эмчийн-амбулаторийн-суурьшсан эмчилгээ, үйлчилгээ болон асрамжийн газарт асруулах үйлчилгээ багтдаг.

*Оршин суудаг
бүх иргэд эрүүл
мэндийн үйлчилгээ
авах эрхтэй.*

Эрүүл мэндийн системийн ихэнх зардлыг татвараас санхүүжүүлдэг, цаашилбал ихэвчлэн эмийн мөнгө болон шүдний эмчийн үйлчилгээний мөнгийг УЭМҮГ-аас төлдөг ард түмний даатгалын шимтгэл, хувиараа хөдөлмөр эрхлэгсэд, хараат хөдөлмөр эрхлэгсэд, ажил олгогчид төлдөг шимтгэлээс санхүүжүүлдэг. Харин өвчтөнүүд үндсэндээ эмнэлгээр үнэ төлбөргүй үйлчлүүлдэг.

Эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудын дунд Primary Care Trusts (PCTs) гол үүрэг гүйцэтгэдэг. PCTs нь ойролцоогоор 50 орчим өрхийн эмнэлгүүдийн сүлжээ юм. Нэг өрхийн эмнэлэгт 5.000-250.000 хүн ногддог. (PCTs) нь тухайн бүс нутгийн эрүүл мэндийн үйлчилгээний хэрэгцээг төлөвлөх ба эрүүл мэндийн үйлчилгээг найдвартай хүргэх үүргийг хүлээдэг. Тэд эрүүл мэндийн үйлчилгээний төсвийн 75%-иас дээш хувийг авч үйлчилгээг орон нутгийн асрамжийн байгууллагууд, УЭМҮГ, мөн түүнчлэн хөрш бүс нутгийн адил төстэй байгууллагууд, хувийн болон нийтийн тусын төлөө үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудтай гэрээ байгуулан хамтарч ажилладаг.

*Өрхийн эмч
нарын сүлжээ*

Эрүүл мэндийн үндсэн үйлчилгээг өрхийн эмч нар үзүүлдэг. Ихэвчлэн бие даасан өрхийн эмч нар (үүдний жижүүрийн үүрэг гүйцэтгэдэг –Gatekeeper)³² эрүүл мэндийн системийн өргөтгөсөн тусгай үйлчилгээг үзүүлэхэд онцгой чухал үүрэг гүйцэтгэдэг. Эмнэлгүүд тухайн үйлчилгээнээс хамаарсан, мөн гэрээгээр үнийн дүнг тохирсон төлбөрийг авдаг. Нэгдсэн төсөв нь тусгай үечлэлтэй, төрийн яамдын хүнд суртлын болон Англи, Валес, Шотланд, Хойд Ирландын эрүүл мэндийн яамдуудын удирдлагын дор үйл ажиллагаагаа явуулдаг.

*Өрхийн эмч нар:
үндсэн үйлчилгээ
ба дамжуулан
зуучлах*

Өвчтөнүүдийн сонголт хийх эрх чөлөө хязгаарлагдмал. Чөлөөт сонголт хийх боломж бүс нутгийн аль нэг дүүрэгт харъяалагддаг даатгалын газруудаар хязгаарлагддаг. Ингэснээр өвчтөнүүд өрхийн

*Өвчтөнүүдийн
сонголт хийх
эрх чөлөө
хязгаарлагдмал*

32 Англиар үүдний жижүүр гэсэн үг. Өвчтөнүүдийг тусгай мэргэжлийн эмч нарт жууцлах үүргийг хүлээдэг

эмчтэйгээ тохиролцсоны дагуу зөвхөн гэртээ ойрхон байршилтай олон эмнэлгүүдийн жагсаалт дундаас сонголт хийх боломжтой. Эмнэлгүүдээс сонголт хийх боломжийг нэмэгдүүлэх нь сонголт хүлээлгийн цагийг богиносгоход тустай.

*Их Британи:
Бусад орнуудтай
харьцуулахад
эрүүл мэндийн
зардал багатай.*

Их эрүүл мэндийн системийн хамгийн том асуудал бол санхүүжилт нь хангалтгүй, үүнээс үүдэлтэй хүлээлгийн хугацаа урт. ДНБ-нд эзлэх хувиар нь харвал Британи улс эрүүл мэндийн хангамжид харьцангуй бага мөнгийг зарцуулдаг. Герман улс 2007 оны байдлаар ДНБ-нийхээ 10.4%-тай тэнцэх мөнгөөр эрүүл мэндийн салбартаа хөрөнгө оруулалт хийсэн бол Их Британи ДНБ-нийхээ 8.4%-тай тэнцэх мөнгөөр эрүүл мэндийн салбартаа хөрөнгө оруулалт хийсэн нь тэр ч байтугай OECD-ийн гишүүн орнуудын дунджаас доогуур байгаа юм. (OECD 2008 он, д:1) Хатуу чанга төсвийн бодлого, үйлчилгээ, хангамжийн нэгдсэн зохицуулалт нэвтрүүлсний улмаас суурьшмал эмчилгээний салбарт хангамжийн хомсдол нүүрлээд байна.

*Шинэчлэлийн
зорилтууд
хангамжийн
хомсдолыг
арилгахад
чиглэгдэж байна.*

“ҮЭМҮГ-ний төлөвлөгөө-Хөрөнгө оруулалтын А төлөвлөгөөг- The NHS Plan-A Plan for Investment”, шинэчлэлийн А төлөвлөгөөг нэвтрүүлснээр 2000 онд асар өргөн хүрээтэй шинэчлэлийг эхлүүлсэн юм. 2010 он хүртэл шинэчлэлийг хэрэгжүүлсэн байх ёстой. Шинэчлэлийн хүрээнд жишээлбэл: эмнэлгийн орны тоог нэмэгдүүлэх, ерөнхий эмч нарын тоог нэмэгдүүлэх, өрхийн эмнэлэг, анагаахын оюутнуудын сургалтын орон тоог нэмэгдүүлэх гэх мэт зорилтуудыг дэвшүүлсэн. Цаашилбал хорт хавдараас урьдчилан сэргийлэх хөтөлбөрүүдийг өргөжүүлж ахмад настангуудын нийгмийн баталгааг үЭМҮГ-ний эрүүл мэндийн чекээр дамжуулан сайжруулах боломжийг бүрдүүлэх зорилтуудыг дэвшүүлжээ.

Эрүүл мэндийн системүүдийн харьцуулалт

Төрөл бүрийн системүүдийн сул ба давуу талуудыг үнэлэхийн тулд эрүүл мэндийн бодлогын зорилтуудыг авч үздэг. Аливаа эрүүл мэндийн системийн ерөнхий бүтээмжийн чадамжаас гадна юуны өмнө боломжийн тэгш байдал (эрүүл мэндийн үйлчилгээний нээлттэй байдал) ба бүх эрүүл мэндийн байгууллагууд суурилсан байх ёстой хэрэгцээний шударга ёс хэр хангагдсанаар нь үнэлдэг. Хүн бүр орлого, нийгмийн давхаргаас эрүүл мэндийн үйлчилгээ хүртэж чаддаг болсон нь 20-р зууны нийгмийн бодлогын томоохон амжилт хэмээн олон жилийн туршид бахархсаар ирсэн. Эрүүл байж

*Үндсэн зорилт:
Бүтээмжийн
чадавхийг
дээшлүүлэх,
Боломжийн
тэгш байдал
ба хэрэгцээний
шударга ёс*

хүмүүс хүний дайтай амьдарч чаддаг учраас эрүүл мэндийн хангамж үйлчилгээ бүх хүнд нээлттэй байх ёстой.

Анагаах ухаан-техникийн салбарт гарсан дэвшлүүдийн ачаар хэдэн жилийн өмнөхтэй харьцуулбал өдгөө олон өвчнийг амжилттайгаар эдгэрүүлж чаддаг болжээ. Энэ нь үнэ өртөг нэмэгдэх шалтгаан болж байна. Эрүүл мэндийн системийн үр өгөөж ба санхүүжүүлэх боломжийн асуудал зайлшгүй тулгардаг.

Европ-эрүүл мэндийн хэрэглэгчдийн индекс

Европын эрүүл мэндийн системүүдийг жил тутамд хооронд нь харьцуулдаг харьцуулалт нэн ялангуяа улс төрийн түвшинд хүчтэй нөлөөлдөг. 2005 оноос хойш Health Consumer Powerhouse гэдэг зөвлөх компани боловсруулан гаргасан Европ-Эрүүл мэндийн хэрэглэгчдийн индексийнхээ дагуу уг харьцуулсан судалгааг явуулж байна. Олон нийтэд нээлттэй статистик, (Холбооны улсууд, ДЭМБ, OECD) хуулийн текстүүд, баримт бичиг, санал асуулгуудыг үндэслэн тогтоосон индексүүдээр эрүүл мэндийн системүүдийг хэрэглэгчиддээ ээлтэй байдлыг үнэлдэг. Өөрөөр хэлбэл хэрэглэгчид судалгааны гол объект нь байдаг гэсэн үг.

Европын эрүүл мэндийн системүүдийг Европ-эрүүл мэндийн хэрэглэгчдийн индексийн дагуу 2008 онд үндсэн 6 үзүүлэлтүүдийн дагуу байр эзлүүлжээ. Эдгээр нь: өвчтөнүүдийн эрх, өвчтөнүүдийн мэдээлэл, Электрон-эрүүл мэнд³³, эмнэлгийн ор хүлээх хугацаа, эмчилгээний үр дүн, эрүүл мэндийн үйлчилгээ, эмийн хамрах хүрээ, хүртээмж, эмийн үйлчилгээ. Эдгээрийг бүтээмжийн 34 шалгуур үзүүлэлтүүдийн дагуу тогтоодог.

Үр өгөөж ба санхүүжүүлэх боломжийн асуудал

Эрүүл мэндийн хэрэглэгчдийн чадамжийн хаус-Health Consumer Powerhouse

Үндсэн зургаан үзүүлэлт

33 Электрон эрүүл мэнд үзүүлэлтээр эрүүл мэндийн системүүд мэдээлэл, харилцаагаа хэр хэмжээгээр компьютержүүлж эрүүл мэндийн мэдээллийг хурдан, найдвартай боловсруулж чаддаг бэ? гэдгийг тодорхойлдог.

Европ-Эрүүл мэндийн хэрэглэгчдийн индекс, 2008 оны байдлаар

	Герман	Голланд	Их Британи	Дээд оноо
Өвчтөнүүдийн эрх ба өвчтөнүүдийн мэдээлэл	100	125	94	150
Электрон-эрүүл мэнд	50	92	92	100
Эмнэлгийн ор хүлээх хугацаа	187	133	93	200
Эрүүл мэндийн үр дүн	190	214	155	250
Эрүүл мэндийн үйлчилгээний цар хүрээ ба хүртээмж	100	150	117	150
Эм	113	125	100	150
Нийт оноо	740	839	651	1,000
Эзэлсэн байр	6	1	13	

Эх сурвалж: Health Consumer Powerhouse (2008 он)

Герман: 31 орноос 6-р байр эзэлсэн.

2008 оны байдлаар Европ-эрүүл мэндийн хэрэглэгчдийн индексийн дагуу герман улс судалгаанд хамрагдсан 31 орноос 6-р байр эзэлсэн. Эндээс Герман улсад бага зэрэг буурах хандлага ажиглагдаж байна. Учир нь 2007 онд герман улс 5-р байр эзэлсэн бол 2005 онд 3-р байр эзэлж байжээ.

Эерэг: нээлттэй байдал дээшилж үйлчилгээний багцууд олширсон.

Health Consumer Powerhouse Германы системд практик дээр эмнэлгийн ор бараг хүлээдэггүй, мэргэжлийн эмчийн үйлчилгээг авахад ямар ч саадгүй, эмчилгээ, үйлчилгээний багцууд асар өргөн хүрээтэй гэдэг үзүүлэлтүүд дээр асар том нэмэх оноог өгсөн байна. Германы өвчтөнүүд хүссэн үедээ хоёрдогч этгээдийн зөвлөгөөг авах эрхтэй байгааг мөн эерэг үзүүлэлт хэмээн дүгнэгдсэн байна. 2007 онд германы эрүүл мэндийн үйлчилгээний чанар харьцангуй сайн хэмээн үнэлэгдсэн байдаг. Хүүхдийн нас баралт, хорт хавдараар өвчлөгсдийн таван жил амьдарсан хувь хэмжээ, эсхүл зүрхний шигдээсээр өвчилсний дараагаар өвчилж буй давтамж зэрэг үзүүлэлтүүдээр эмчилгээний чанарыг үнэлсэн байдаг.

Өвчтөнүүдийн эрх ба мэдээлэл үзүүлэлтээр Герман улс харьцангуй муу үнэлгээ авчээ. Өвчтөнийг хамгаалах тухай хууль байхгүй, германы эмч нар, эмнэлгүүдийн чанарын харьцуулалт ил тод бус байгаа нь оноо хасагдах шалтгаан болсон байна.

*Сөрөг:
Өвчтөнүүдийн эрх
ба өвчтөнүүдийн
мэдээлэл*

Голланд улс Европ-эрүүл мэндийн хэрэглэгчдийн индексийн дагуу хэрэглэгчиддээ хамгийн ээлтэй эрүүл мэндийн системтэй орноор шалгарч тэргүүн байрыг эзэлжээ. 2006, 2007 онд Голланд хоёрдугаар байрыг эзэлж байсан бол 2008 онд зэрэглэлийн жагсаалтад тэргүүн байрыг эзэлж Дани, Австри, Люксембург, Швед улс удаах байруудыг эзэлсэн байна.

*Голланд тэргүүн
байрыг эзэлжээ.*

Их Британи дунд хэрд байраа хадгалсаар байна. 2006 онд 15-р байр, 2007 онд 17-р байрыг тус тус эзэлжээ. 2008 онд байраа ахиулж 13-р байрт жагсжээ. Ийнхүү хойгуур жагсахад эмнэлгийн ор хүлээх хугацаа урт, эрүүл мэндийн хувийн болон төрийн үйлчилгээ хоорондоо чанарын асар том зөрүүтэй зэрэг үзүүлэлтүүд нөлөөлсөн бол Электрон эрүүл мэнд үзүүлэлтээр Голланд улстай нэгдүгээр байрыг хуваан эзэлсэн байна.

*Их Британи
дундуур*

Эрүүл мэндийн системүүдийг бүхэлд нь үнэлэх, харьцуулахаар сонгон авсан шалгуур үзүүлэлтүүд төлөөлөх чадвартай юу?34 гэдэг асуулт маргаан гарах үндэслэл болох нь эргэлзээгүй. Эрүүл мэндийн системүүдийг өөрчлөлт ба ахицыг судалгааны үндсэн асуудал болгосон хөдөлгөөнт ажиглалт зэрэглэл тогтоохоос илүү үр дүнтэй биш гэж үү? гэдэг асуулт зүй ёсоор тавигдаж байна. Мөн судалгаанд европын орнуудын харилцан адилгүй гарааны нөхцөлүүдийг харгалзан үзэхгүй байгаа нь шүүмжлэх үндэслэл болж байна.

Хэдийгээр дээр дурьдсан сул талууд байгаа, зарим нэг салбарт сайжруулах зүйлс байгаа ч энэ болон бусад судалгааны дүн бүтээмжийн чадавхи шийдвэрлэх гол асуудал биш гэдгийг харуулж байна. Жишээлбэл: урьдчилан сэргийлэх салбарын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж бусад орныг гүйцэх шаардлага байна. Энэ нь нийгмийн асуудлыг үүсэхээс урьдчилан сэргийлэх чадамжтай нийгмийн баримжаат төрийн тухай санаа ба эрүүл мэндийн дэд бүтцийг илүү боловсронгуй болгох, боловсролын асуудалтай ч холбоотой асуудал. (7.5.-р бүлгийг харна уу)

*Герман:
Бүтээмжийн
чадамж
ерөнхийдөө
өндөр-урьдчилан
сэргийлэх салбарт
бусад хоцрогдлыг
арилгах
шаардлагатай.*

34 Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага(2000 онд) ба Европын Холбооноос (Зохихцуулалтын нээлттэй аргачлалын дагуу) Јөргөн хүрээтэй тоон судалгаануудыг харьцуулалт хийх зорилгоор явуулсан.

Германы эрүүл мэндийн хэлэлцүүлэгт санхүүжилтийн асуудал чухал байр суурийг эзэлдэг. Зарлага ба орлогын тал дээр хоёуланд нь асуудал байгаа учраас санхүүжилтийн дарамт нэмэгдээд байгаа юм. Зарлага нэмэгдээд байгаагийн шалтгаан нь анагаах ухааны салбарт гарч буй дэвшил, насжиж буй ард түмний илүү өргөн хүрээтэй, илүү сайн эрүүл мэндийн үйлчилгээ авах хэрэгцээ, мөн эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын үр өгөөжийн цоорхой зэрэг юм. (Валендик 2009 он) Олон улсын түвшинд харьцуулахад герман эрүүл мэндийн үйлчилгээнд харьцангуй их мөнгө зарцуулдаг.


Эрүүл мэндийн зардал 2007 оны байдлаар

	Герман	Голланд	Их Британи
ДНБ-ний хувиар илэрхийлэгдсэн эрүүл мэндийн зардал	10,6	9,8	8,4
Хүн тутамд ногдох эрүүл мэндийн зардал	3.371	3.527	2.992

Эх сурвалж: Зардлыг доллараар тооцсон тул үнийн түвшингийн зөрүүний нөлөөг цэвэрлэсэн. (худалдан авах чадварын) OECD (2008:1)

Зардлын дээрх хувь хэмжээнээс үүдэн “Эрүүл мэндийн салбарын үнийн тэсрэлт”-ийн талаар ярьцгаадаг. Хэрэв шимтгэлийн хувь хэмжээ хэрхэн нэмэгдсэнийг харвал харин ч тун хязгаарлагдмал хэмжээнд нэмэгдсэн нь харагдана. 1991 онд 12.4%-иас 2009 онд 14.9% болгон нэмэгдүүлсэн байна. (Зураг 17-гаас харна уу)

Эрүүл мэндийн зардлыг ДНБ-ний хувиар илэрхийлснийг харахад 2003 оноос хойш тогтмол буурч ирснийг харж болно. Үнэ буурсан шалтгаан нь маш олон тооны орлого, зарлагын уялдааг хангахад чиглэгдсэн шинэчлэлийн арга хэмжээний үр дүн юм. (Вүссе/Риесберг 2005 он)



17-р зураг: Эрүүл мэндийн зардлын хөгжил(1998-2008 он)

Германы эрүүл мэндийн системийн орлогын тал дээр ноцтой асуудлууд тулгарч байна. Шимтгэл тооцох суурь нь тогтмол буурч байна. Орлого сайтай, харьцангуй эрүүл хүмүүс эв санааны нэгдэлийн зарчим дээр суурилсан (эв санааны нэгдэлтэйгээр эрсдэлийг туулах, орлогын хомдолыг эв санааны нэгдэлтэйгээр давах) хууль ёсны эрүүл мэндийн даатгалаас эрүүл мэндийн хувийн даатгалд даатгуулах замаар зайлсхийдэг.

Шимтгэл төлөх үүрэг ногдуулдаг орлогын өсөлт маш удаан. 1992 оноос хойш хүн амын дунд хөдөлмөр эрхэлдэг хүмүүсийн эзлэх хувь, нийт хөдөлмөр эрхлэгсдийн дунд хараат хөдөлмөр эрхлэгсдийн (хөдөлмөрийн гэрээгээр ажиллагсад гэсэн санаа) эзлэх хувь тогтмол буурсаар байна. (Вүссе/Риесберг 2005 он) Хараат хөдөлмөр эрхлэхээс бусад аргаар олж буй орлого (жишээлбэл: түрээсийн орлого) харин тогтмол нэмэгдсээр байна. Ингэснээр хууль ёсны эрүүл мэндийн даатгалын шимтгэл тогтоох суурь бүх хэлбэрийн орлогын өсөлтийг хамарч чадахгүй байна. Хууль ёсны эрүүл мэндийн даатгалын шимтгэл тогтоох суурь нь регрессив үйлчилгээтэй байна. Өөрөөр хэлбэл: Хууль ёсны эрүүл мэндийн даатгалын өндөр орлоготой гишүүд орлогынхоо өчүүхэн хувийг шимтгэлд төлдөг.

Хэрвээ эрүүл мэндийн даатгал ирээдүйд бүх иргэдэд аль болох ижил хэмжээгээр нээлттэй, хүртээмжтэй байх ёстой юм бол аль болох өргөн хүрээг хамарсан, эв санааны нэгдэлтэй санхүүжилттэй

Орлогын тал
дээр тулгарч буй
асуудлууд

байх ёстой. Онолын хувьд эрүүл мэндийн урамшууллын загвар шиг татварын санхүүгийн дэмжлэг үзүүлэх, эсхүл иргэдийн даатгал байгуулах замаар энэ асуудлыг шийдэх боломжтой. Дээр дурьдсан хоёр загварын дахин хувиарлалтын нөлөөг хэрхэн нэмэгдүүлэх бэ? гэдэг асуудал эцсийн эцэст татварын дэмжлэгийг хэрхэн хувиарлах бэ? эсхүл шимтгэл тооцох орлогын дээд хэмжээг хэрхэн тогтоосноос хамаарна. Татварын дэмжлэгийн систем зөвхөн бага орлоготой иргэдэд зориулагдах тул эрүүл мэндийн урамшууллын загвар нь иргэний даатгалтай харьцуулахад дунд орлоготой гэр бүлүүдэд илүү их дарамт болж очно. Харин өндөр орлоготой гэр бүлүүд энэ шинэчлэлээс хожих болно.

Германы эрүүл мэндийн системийн шударга, эв санааны нэгдэлтэй

Өвчтөн өөрийн гарал үүсэл, нас, хүйсээс үл хамааран эрүүл мэндийн үйлчилгээ, анагаах ухааны дэвшилээс тэгш хувь хүртэх эрхтэй. Бид хоёр ангит эрүүл мэндийн үйлчилгээг дэмжихгүй. Иймээс бид бүх хүмүүсийг хамруулсан, эв санааны нэгдэлтэй иргэдийн даатгалын төлөө байна.

(Хамбургийн хөтөлбөр 2007 он: 58-р хуудас)

**Гүнзгийрүүлэн унших
эх сурвалж:**

Хаген Күен,
Севастиан Клиное
нар (2007 он), Эв
санааны нэгдэлтэй
эрүүл мэндийн
даатгалын хэтийн
төлөө

Роверт Пакует,
Вольфганг
Шроедер (2009 он)
Акулын бассейнд.
"Туршилт хийгч
засаглалын" ирээдүй:
Эрүүл мэндийн
шинэчлэлийн
жишээн дээр 2007
он, Берлиний Бүгд
Найрамдах Улсад
2/2009 он, 56-63-р
хуудас

Штефан Гресс (2009
он) Эрүүл мэндийн
системд ижил
нөхцөлд шударга
өрсөлдөөний төлөө:
Германы эрүүл
мэндийн зах зээл дээр
өрсөлдөөний нэгдсэн
журамтай болох
шаардлага ВИСО
шууд, Фридрих-
Эбертийн сан, Бонн
хот

санхүүжилтийг бүрдүүлэхэд өнөөгийн хоёр ангит эрүүл мэндийн даатгалын (хууль ёсны болон хувийн) хоёр ангид хуваагдсан байдлыг арилгах хэрэгтэй. Голландын жишээ нийгмийн болон хувийн эрүүл мэндийн даатгалын даатгалын байгууллагууд хоорондын өрсөлдөөнийг даатгуулагчдын тусын тулд нэмэгдүүлж болдог гэдгийг харуулж байна. Үр өгөөжтэй шинэчлэл хийх үндэс нь нэгдмэл эрүүл мэндийн зах зээлийн санхүүжилтийн суурийг өргөтгөх, бүх иргэдэд заавал даатгуулах үүрэг ногдуулах гарц байх ёстой. Уг шинэчлэлд даатгалын байгууллагуудад хамтран ажиллах шаардлагыг тулгах, эрсдэлээс хамааралтайгаар шимтгэлийн хувь хэмжээг тогтоох, тухайн салбарын даатгуулагчдын өвчлөлийн бүтэц, давтамжийг үндэслэн тогтоосон эрсдэлийг тэнцэтгэх зэрэг арга хэмжээ багтана.

Энэ нь нийгмийн ардчилалд юу гэсэн үг бэ?

- Эрүүл мэндийн салбарт нийгмийн ардчилал бүтээмжийн чадавхи, хэрэгцээний шударга ёс, эв санааны нэгдэлийг (эрсдэл-ба орлогын эв санааны нэгдэл) эрхэм зорилгоо болгоно.
- Эрүүл мэндийн даатгалын санхүүжилтэд татвараас санхүүждэг нэмэлт санхүүжилтийн хэмжээг нэмэгдүүлэх эсхүл иргэдийн даатгалыг нэвтрүүлэх замаар эрүүл мэндийн системийн илүү

өргөн хүрээг хамарсан, илүү шударга санхүүжилтийг бүрдүүлнэ.

- Эрүүл мэндийн даатгалын газруудын хооронд (хууль ёсны болон хувийн) шударга өрсөлдөөнийг бий болгохын тулд төрөл бүрийн эрсдэлүүдийг тэнцэтгэж, шимтгэл төлөх орлогын дээд хязгаарыг үгүй болгож, даатгалын газрууд хоорондоо хамтран ажиллах дарамтыг бий болгох шаардлагатай.
- Урьдчилан сэргийлэх санал, арга хэмжээнүүдийг өргөжүүлэх шаардлагатай.

7.5. Боловсрол

Мариус Вүземайер

Энэхүү бүлэгт:

- Германы боловсролын системийг Швед, АНУ-ын боловсролын системтэй харьцуулна.
- Гурван системд шударга ёсны төрөл бүрийн цар хүрээнд, боловсролын бүтээмжийн байдлаар нь үнэлгээ өгнө.
- Германы боловсролын систем олон улсын харьцуулалтад хойгуур байр эзэлж байгаагийн шалтгаан болон шинэчлэлийн боломжуудын талаар хэлэлцэнэ.
- Боловсролын тэгш боломж ба нийгмийн ардчиллын суурь уялдаа холбоо сэдвийн дор санал солилцоно.

Германы боловсрол ба нийгмийн бодлого урт хугацааны туршид салангид явсаар ирсэн. Үүний шалтгаан нь улс төрийн түвшинд консерватив хэв шинжит нийгмийн баримжаат төр засгийн эрхэнд байсан, мөн нийгэм ба боловсролын байгууллагууд өөр өөр байгууллагад харъяалагдаж ирсэнтэй холбоотой. Германы Бүгд Найрамдах Улсын Байгуулалд боловсролын бодлогыг Муж улсууд болон Хот, тосгод хариуцдаг. Холбоо зөвхөн дээд сургуулийн бодлого, компанийн мэргэжлийн боловсрол, мэргэжил олгох сургалтыг хариуцдаг. Харин боловсролын бодлогыг Холбоо ба нийгмийн түншүүд дангаараа хариуцдаг. Иймээс боловсролын бодлогыг өнгөрсөн хугацаанд нийгмийн баримжаат төрийн нэгэн бүрэлдэхүүн хэсэг гэж үзсээр ирснээрээ бусад орнуудаас онцлог.

*Германд:
Нийгмийн болон
боловсролын
бодлого урт
хугацаанд
салангид явж
ирсэн.*

Олон улсад:
Нийгмийн-болон
боловсролын
бодлого нь
нэгдмэл байдаг.

Саяхнаас Герман улсад боломжийн-болон бүтээмжийн шударга ёсыг бэхжүүлэхэд хувь нэмэр оруулахын тулд, оруулах шаардлагатай учраас “Боловсролын бодлогыг хэр хэмжээнд нийгмийн бодлого” гэж ойлгох юм бэ? гэдэг асуулт тавигдаж эхэлсэн. Нийгмийн асуудал үүсэхээс урьдчилан сэргийлэх чадамжтай нийгмийн баримжаат төрийн хэтийн төлөвийн үүднээс (номын 4 ба 6-р бүлгээс харна уу.) нийгмийн баримжаат төрийн цаашдын хөгжлийн тухай эргэцүүлэлд боловсролын асуудал чухал байр эзэлдэг.

*Нийгмийн асуудал үүсэхээс урьдчилан сэргийлэх чадамжтай нийгмийн баримжаат төр нь боловсролын бодлогыг нийгмийн бодлогын үндсэн элемент гэж үздэг.
(Хамбургийн хөтөлбөр 2007 он:56-р хуудас)*

1717он: Прусын
эзэнт улсын
үед дунд
сургуульд заавал
суралцах үүргийг
ногдуулсан-бүтэц
нь өнөөдрийг
хүртэл хэвээр
хадгалагдсан.

Германы боловсролын систем-эхлэлүүд

Германд: Бүр тодруулж хэлбэл Прусууд нийгмийн даатгал болон боловсролын бодлогын суурийг тавьсан. 1717 онд Прусууд бүх хүүхдэд дунд сургуульд суралцах үүргийг ногдуулсан анхны орон болсон. Мөн олон улсын харьцуулалтад өөрийн гэсэн онцлогтой германы сургуулийн системийн олон салаа бүхий бүтэц нь тэр үеэс эхтэй.

Онцгой тохиолдол:
сургуулийн
хэлбэрийг эрт
хуваадаг.

Олон салаа бүтэц нь онцлог шинж

Аль муж улсад байгаагаас хамааран Германд сургуулийн сурагчдыг дөрөвдүгээр ангиа дүүргэснийх нь дараагаар эсхүл зургаадугаар ангиа төгссөнийх нь дараагаар (Берлин, Бранденбург муж улс) дараагийн дэвшин суралцах сургуульд нь чиглүүлдэг. Харин хожим нь үндсэн сургуулиас реал сургууль руу, эсхүл гимназид шилжих суралцах боломж тун хязгаарлагдмал. Австри, Швейцараас бусад OECD-ийн гишүүн 30 орны дунд сургуулийн сурагчдын боловсролын зам нь Герман шиг ийм эрт салдаг орон байхгүй. Дэлхийн хоёрдугаар дайны дараа бусад орнуудад мөн Германых шиг олон салаа бүтэцтэй орнууд байсан бөгөөд эрт орой хэзээ нэгэн цагт дунд сургуулийн нэгдсэн ба нийтлэг системд шилжүүлэн нэгтгэсэн байдаг. (Жишээлбэл: Шведэд 1958 онд)

Хагас өдрөөр хичээллэдэг.

Германд дунд сургуулиуд ихэвчлэн хагас өдрөөр хичээллэдэг. Бүх сурагчдын 20,9% нь 2007 онд холбооны улсын дунджаар авч үзвэл өдөр өнжүүлэхтэй сургуульд суралцаж байна. Муж улсууд хооронд ихээхэн ялгаатай, жишээлбэл Бавари (4%), Захсен (54,3%) Гэхдээ өдөр

Ихэвчлэн
хагас өдрөөр
хичээллэдэг.

өнжүүлэхтэй бүтэн өдрийн сургуулийн хөгжилд сүүлийн жилүүдэд нэлээд ахиц гарсан. 2003 онд Улаан-Ногооны эвсэл бүтэн өдрийн сургуулийн хөтөлбөрийг эхлүүлэхээс өмнө холбооны дунджаар бүх сурагчдын 10,8% нь өдөр өнжүүлэхтэй сургуульд суралцаж байжээ.

Компани дээр мэргэжлийн боловсрол олгодог хосолмол буюу дуал систем

Компани дээр мэргэжлийн боловсрол олгодог германы дуал буюу хосолмол мэргэжлийн боловсрол олгох сургалт нь урт хугацааны туршид олон улсад үлгэр жишээ болж байлаа. Уг систем нь сургуулийн мэргэжлийн боловсрол, мэргэжлийн ажил хоорондын шилжилтийг илүү хялбар болгож залуучуудын ажилгүйдлийг доогуур түвшинд байлгах, "практик авъяастай", сургуульд тааруухан дүнтэй суралцсан залуучуудыг хөдөлмөрийн зах зээл дээр нэгтгэхэд хялбар систем юм. Өөр ямар ч оронд компаниуд залуучууд анхны мэргэжлийг нь олгоход ингэж идэвхтэй оролцдоггүй.

Харин сүүлийн үед компани дээр мэргэжил олгодог сургалт дээр ирдэг дарамт тогтмол нэмэгдсээр байна. үйлдвэрчний эвлэлийнхэн юуны өмнө мэргэжил олгох сургалтын зах зээл дээр сургалтын орон тоо хомсдолтой байгааг шүүмжилж харин ажил олгогчид залуучууд "мэргэжлийн боловсрол"-д бэлтгэгдээгүй, түүхийгээрээ байна шүүмжилж байна.

Ихэнх залуучуудын хувьд хосолмол системээр мэргэжил олгох сургалтыг бусад сонголтуудаас илүүд үздэг хэвээрээ байна. Энэ нь зарим талаар сөрөг үр дагавартай. Нэгдүгээрт: их сургуульд суралцах хүсэлтэй залуучуудын тоо цөөрсөөр байна. Залуучууд мэргэжлийн боловсрол олсныхоо дараагаар мэргэжлийн ур чадвартай ажилчин болж чадаж байвал их сургуульд суралцах залуучуудын тоо цөөрч байгааг асуудал гэж үзэхгүй байж болно. Гэтэл мэргэжлийн боловсрол олоод хөдөлмөрийн зах зээл рүү шилжих шилжилт улам хэцүү болсоор байна. Үүнээс гадна мэргэжлийн боловсролын сургалтыг дүүргээд дээд сургуульд дэвшин суралцах боломж хязгаарлагдмал, авъяаслаг залуу насанд хүрэгчдийн мэргэжлийн сургалтыг дүүргээд дээд сургуульд элсэн орох асуудал хүндрэлтэй байна.

Германы боловсролын системд мэргэжлийн дуал систем хүчтэй байр суур эзэлж байгаагийн хоёр дахь сөрөг үр дагавар

Компани дээр мэргэжил олгодог мэргэжлийн боловсролын сургалт олон жил үлгэр жишээ болж байлаа.

Олон талт шүүмж

Дэвшин суралцах боломж хязгаарлагдмал

Эдийн засгийн өөрчлөлтөөс хараат байдал

нь мэргэжлийн сургалтын орон тооны эдийн засгийн өсөлт, бууралтын савлагаа болон бүтцийн өөрчлөлтөөс хараат байдал юм. Мэргэжлийн боловсролын зах зээлийн эдийн засгийн өсөлт, бууралтын савлагаанаас хараат байдал нь мэргэжлийн сургалтын дуал загварын олон жилийн өмнөөс танигдсан сул тал юм.

1970-аад болон 1980-аад онд эдийн засгийн савлагааны үеийг гар урчууд “зөөлөвч парлон”-ны үүрэг гүйцэтгэн тэнцэтгэж байсан учраас гайгүй давсан. Энэ нь эдийн засгийн савлагаа үүсмэгц гар урчууд өмнөхөөсөө олон дагалдан сурагчдыг ажилд авдаг байсан бөгөөд тэд нь эдийн засгийн нөхцөл байдал сайжирмагц аж үйлдвэрийн эсхүл ахуй үйлчилгээний салбар луу шилждэг байжээ. Харин эдийн засгийн бүтцийн өөрчлөлтийн улмаас (эдийн засгийн хувьслын улмаас ахуй үйлчилгээ ба мэдлэгийн нийгэм болон өөрчлөгдөж буй өөрчлөлт, үндэстэн дамнасан үйл ажиллагаа, улам бүр өсөн нэмэгдэж буй үнийн дарамт) энэ механизм өдгөө урьдын цаг шиг сайн үйлчилхээ байжээ. (Жаудас ба бусад зохиогчид 2004 он). Энэ нь эдийн засгийн бүтцийн хувьсал нь залуучуудын мэргэжил эзэмших болон мэргэжил дээшлүүлэх боломжийг эрэлт ихтэй мэргэжил сонгосон эсэхээ илүү хамаарах болжээ гэсэн үг.

Дээд сургуулийн систем

Германы дээд боловсролын систем улсын их сургуулиуд ба мэргэжлийн дээд сургуулиудаар тодорхойлогддог. Нийт суралцагчдын ойролцоогоор 2% нь хувийн дээд сургуулиудад суралцдаг. (Холбооны статистикийн газар 2005 он:10) Бавари, Баден-Вюрттемберг, Хамбург, Нордрейн-Вестфален, Саарланд, Нидерзахсен муж улсад семистер тутамд 500 еврогийн төлбөр авдаг. Германы дээд сургуульд суралцагсдын ойролцоогоор 18% нь Вафег дэмжлэг авдаг. (2007 онд хэвлэгдсэн Вафег-ийн 17-дахь илтгэл) дээд сургуульд суралцагсад, дээд сургуульд суралцаагүй үе тэнгийнхэнтэйгээ харьцуулсан харьцаа германд 36 орчим хувь байна. Байнга яригддаг нэгэн зорилт бол дээд сургуульд эхлэн суралцагсдын квотыг 40 хувь хүртэл нэмэгдүүлэх тодорхой зорилт дэвшүүлсэн боловч сүүлийн жилүүдэд нэмэгдэх нь байтугай буураад байна.

Гүнзгийрүүлэн унших эх сурвалж:

*Кристоф Хайне
болон бусад
зохиогчид (2008 он)
Суралцах эрх авсан
оюутнууд сургалтын
төлбөрийг юу гэж
үзэж байна? Ханновер*

Бага насны хүүхдийн боловсрол

Сүүлийн жилүүдэд сургуулийн өмнөх насанд нь хүүхдийг дэмжих нь хожим амжилттай суралцах суурийг нь тавьж өгдөг гэдэг мэдлэг өргөн тархаад байна. Гэтэл сургуулийн өмнөх насны хүүхдийн боловсролын асуудлаар герман бусад орнуудтай харьцуулахад ихээхэн хоцрогдолтой байна. өдөр өнжүүлэхтэй бүтэн өдрийн сургууль, сургуулийн өмнөх насны боловсролын байгууллагуудын тархалтын хувьд герман орон олон улсын тавцанд ихээхэн хоцрогдолтой явна. Нэн ялангуяа гурваас доош насны хүүхдийн боловсролын байгууллагын хувьд ихээхэн хоцрогдсон. Харин таван настнуудын хувьд хүүхдийн цэцэрлэгийн уламжлалын ачаар олон улсын харьцуулалтад дээгүүр байр эзэлдэг. Бүхэлд нь авч үзвэл бага насны хүүхдийн боловсролд төдийлөн ач холбогдол өгдөггүй хэвээр байна. Цэцэрлэгийн хүмүүжүүлэгч нарын цалин олон улсын түвшинд дэндүү доогуур байгаа нь үүний баталгаа юм. Олон улсын түвшинд ердийн зүйл болсон цэцэрлэгийн хүмүүжүүлэгч нарт дээд боловсрол эзэмшүүлдэг боловсролын байгууллага мөн байхгүйтэй адилхан байна.

Бага насны хүүхдийн боловсролын асуудал шийдэгдээгүй

Мэргэжил дээшлүүлэх сургалт

Нийтийн, нийтэд нээлттэй мэргэжил дээшлүүлэх сургалтын систем германд маш сул хөгжсөн. Германд 2003 онд 25-64 насны хүмүүсийн дөнгөж 12% нь мэргэжил дээшлүүлэх сургалтанд хамрагдсан нь үүний тодорхой жишээ юм. OECD-ийн гишүүн орнуудын дундаж 18%-тай байдаг. Финланд (36%), Швед (40%) зэрэг Скандинавын орнуудад мэргэжил дээшлүүлэх сургалтанд хамрагдагсдын эзлэх хувь өндөр байдаг. Удаан жилийн хугацаанд анхны мэргэжлийг олгох суурь сайтай, дуал мэргэжлийн боловсролын сургалт нь германы мэргэжил дээшлүүлэх сургалтын хоцрогдлыг нөхдөг гэдэг ойлголт байсаар ирсэн. өдгөө энэ ойлголт тийм ч зөв биш гэдгийг нийгэм ойлгох болсон.

Мэргэжил дээшлүүлэх сургалтын орон тоо хангалтгүй.

Бид өнөөгийн суралцагч нийгэмд мэргэжил дээшлүүлэх сургалтыг дөрөвдөгч багана болгон бэхжүүлэхийг зорьж байна. Мэргэжлийн сургалтын систем төрийн мэдэлд хэвээрээ байна. Бид мэргэжил дээшлүүлэх сургалтыг санхүүгийн хувьд болон ажлаас чөлөө авах эрхийг нь дэмжихийг зорьж байна. мэргэжил дээшлүүлэх сургалтад бид тарифын хэлэлцээрт оролцогсад болон компаниудыг татан оролцуулна.

(Хамбургийн хөтөлбөр 2007 он: 66-р хуудас)

АНУ ба
Финландтай
харьцуулах нь

Германыг олон улсын түвшинд харьцуулах нь

Писа-шок олон нийтийн анхаарлыг улс орнуудын хэтийн төлөвийн харьцуулалтанд хандуулж чадсан. Шокийн үр дагавраар германы боловсролын систем дараахи зарим нэг чухал үзүүлэлтүүдийн дагуу, шинэчлэлийн тухай хэлэлцүүлэгт үргэлж үлгэр жишээ болон дурьдагдаж байдаг АНУ ба ПИСА-судалгаагаар тэргүүн байранд шалгарсан Финландын боловсролын системүүдтэй харьцуулсан.

Финландын боловсролын систем

Сургуулийн өмнөх насны боловсролын тогтолцоо нь Финландад маш хүчтэй. Сургуулийн насанд хүрээгүй хүүхэд бүр бүтэн өдрийн цэцэрлэгээр хүмүүжих эрхтэй. Нэгээс хоёр настнуудын 27,5% таваас зургаан настнуудын 73% нь зургаагаас долоон настнуудын мөн ойролцоогоор 70-аад хувь нь сургуулийн өмнөх боловсролын байгууллагуудад хүмүүжиж байдаг. Бага насны дөрвөн хүүхэд тутамд зохих мэргэжлийг эзэмшсэн хүмүүжүүлэгч ногдож байдаг. Сургуулийн өмнөх боловсролд 13 хүүхэд тутамд нэг багш, нэг туслах багш тус тус ногддог. (OECD 2006 он:318-р хуудас)

Сургуулийн өмнөх
насны боловсрол
хүчтэй

Финланд хүүхдүүд 7 настайдаа сургуульд ордог бөгөөд хамтдаа есөн жил дунд сургуульд сурдаг. 9 жил суралцаад дунд сургуульд суралцах үүргээ биелүүлдэг. Дунд сургуулиа төгссөний дараагаар ахлах ангид дэвшин суралцах, ердийн сургуульд суралцах эсхүл мэргэжлийн боловсролын сургуульд суралцах боломж бий. Ердийн болон ахлах сургуулийн төгсөгчид дээд сургуульд суралцах боломжтой. (Еврибайсе 2008 он:4-р хуудас)

9 жил хамтдаа
суралцаг.

Финландад мэргэжлийн боловсролын сургалтыг ерөнхий боловсролын сургуульд нэгтгэсэн байдаг. Сурагчид мэргэжлийн боловсролын арвин сонголтоос сонголтоо хийж дунд сургуулиуд мэргэжлийн боловсролыг олгохдоо компаниудтай нягт хамтран ажилладаг. Мэргэжлийн боловсролоос дээд сургуульд дэвшин суралцах, анхдагч болон хоёрдогч сургуулиас дээд сургуульд дэвшин суралцах боломж Германтай харьцуулахад илүү хялбар. Мэргэжил дээшлүүлэх сургалт: Хөдөлмөрийн зах зээлийн идэвхтэй бодлогын нэгэн хэсэг.

Дунд сургууль
ба мэргэжлийн
боловсролыг
нэгтгэх

Эцэст нь Финландын мэргэжил дээшлүүлэх сургалт Скандинавын бусад орнуудын нэгэн адил хөдөлмөрийн зах зээлийн идэвхтэй

бодлогын нэгэн хэсэг нь байдаг. Хэдийгээр мэргэжлийн боловсрол олгох сургалтын байгууллагууд нь энд чухал үүрэг гүйцэтгэдэг ч Финландад сургалтын байр болон компаниудтай насанд хүрэгчдийн боловсролын мэргэжлийн сургалтын хөтөлбөрүүдээр дамжин холбогддог. Финландад германы нэгэн адил дээд сургуулиуд нь төрийн мэдлийнх байдаг тул төсвийн хөрөнгөөр санхүүждэг.

АНУ-ын боловсролын систем

АНУ-ын боловсролын систем нь төвлөрлийг эрчимтэй задалсан, децентрал бүтэцтэй, мөн хувийн сургуулиуд томоохон хувийг эзэлдэг. Ингэснээр бүхэлд нь авч үзвэл боловсрол эзэмших боломж их, сонголт арвин. Сургуулийн өмнөх боловсролын салбарт өргөн сонголт, боломжийг бүрдүүлсний үр дүнд гурваас таван настнуудын нийтдээ 64% нь сургуулийн өмнөх насны боловсролын байгууллагуудад хамрагддаг, тэдний тал хувь нь бүтэн өдрийн цэцэрлэгт хүмүүждэг. Таван настнуудын ихэнх нь улсын цэцэрлэгт явдаг.

АНУ-д сурагчид нийтдээ 12 жил дунд сургуульд суралцдаг. Холбооны аль улсад, сургуулийн ямар дүүрэгт оршин суудагсн хамааран суурь боловсролын сургалт зургаагаас найман жил үргэлжилдэг. Дунд сургуулийн сүүлийн дөрвөн жилийг ерөнхийдөө “high school” гэж нэрлэдэг.

“High school”-ийг залуус ихэвчлэн 17-18 насандаа төгсдөг. Холбооны ихэнх улсуудад 17-18 насанд дунд сургуульд суралцах үүрэгт хугацаа дуусдаг. Цааш нь дэвшин суралцах практикт чиглэгдсэн өргөн боломжууд байдаг. Сургалт нь хоёр жил үргэлжилдэг “community”, “junior college” –ийн аль нэгэнд элсэн суралцаад дараагаар нь дөрвөн жилийн сургалттай коллеж эсхүл их сургуульд дэвшин суралцдаг. (АНУ-ын боловсролын департамент-U.S. Department of Education 2005:13) Бүх суурь боловсролын болон болон дээд шатны сургуулиудын 24%-ийг хувийн сургуулиуд эзэлдэг. Эдгээр хувийн сургуульд суралцагсдын 10% нь суралцаж бүх багш нарын 12% нь багшилдаг. (АНУ-ын боловсролын департамент-U.S. Department of Education 2005:13) АНУ-ын “high school” ердийн болон мэргэжлийн сургалтын өргөн боломжийг олгодог. Дунд сургуулиа амжилттай төгссөн төгсөгч бүрт хувийн эсхүл улсын сургууль төгссөнөөс үл хамааран ижил үнэмлэх олгодог.

Шинэчлэлийн хэлэлцүүлэгт АНУ-ын дээд сургуулиудыг загвар

Боловсролын систем: хүчтэй хувьчлагдсан, төвлөрлийг задалсан.

Дунд сургуульд нийтдээ 12 жил суралцдаг.

Хувийн сургуулиуд өндөр хувийг эзэлдэг.

АНУ-ын дээд сургуулиуд үлгэр жишээ болох уу? харьцуулахад хялбар бус

болгон авах дуртай байдаг. Гэхдээ Америкийн дээд сургуулиудын хооронд чанар, сургалтын баазын асар том зөрүү байдаг гэдгийг мартаж болохгүй. “Community college” гэж нэрлэгддэг коллежууд нь жишээлбэл: мэргэжлийн боловсролын болон мэргэжил дээшлүүлэх сургалтууд байдаг. Суралцагсдын тун бага хувь нь үнэтэй хувийн сургуулиудад суралцдаг.

Чөлөөт зах
зээлээр дамжин
мэргэжил
дээшлүүлдэг.

Улсын болон хувийн мэргэжил дээшлүүлэх сургалтад дээрхтэй төстэй хөдөлмөрийн хувиарлалт хийгддэг. АНУ-ын сургуулиуд хоорондын хөдөлмөрийн хувиарлалт боловсролын чөлөөт зах зээлийн загварын дагуу хийгддэг. Энэ нь өргөн хүрээтэй, нэгдсэн, хуулиар зохицуулагддаг мэргэжил дээшлүүлэх сургалтын тогтолцоо байдаггүй харин “ажлын байран дээр сургах –training on the job” нэртэй хоорондоо холбоогүй, ихэвчлэн мэргэжил дээшлүүлэх сургалтанд хамрагдагсад өөрсдөө зардлаа төлдөг сургалтын орон тоо коллежуудийн дэргэд байдаг.

Боловсрол ба шударга ёсны зарчмууд

Шударга ёсны ямар зарчмуудын дагуу дээрх гурван өөр боловсролын системийг хооронд нь харьцуулах бэ? гэдэг асуулт гарч ирнэ. Энэ асуултад хариулахын өмнө түүхийг эргэн харвал тустай. Нийгмийн ардчиллын хэтийн төлөвөөс харахад боловсролын ач холбогдол улам бүр нэмэгддэг. 19 ба 20-р зууны ажилчны хөдөлгөөн хүн бүрийн оролцоог хангах, нийгмийг ардчилахад боловсрол шийдвэрлэх үүрэгтэй хэмээн ойлгож байсан. “Ард түмний боловсрол-Ард түмний чөлөөлөлт” гэдэг соён гэгээрүүлэх чухал уриаг дэвшүүлж байлаа. Боловсрол нь эрх мэдэл, эд хөрөнгө бүхий давхаргын давуу эрх байх ёсгүй.

Энэхүү эрхэд суурилсан шаардлага өнөөдөр ч хүчтэй хэвээрээ байгаа. Боловсролтой болох боломж хүмүүсийн гарал үүсэл, эсхүл орлогоос хамаардаг байж таарахгүй.

Нийгмийн ардчиллын шаардлагын үүднээс харахад боловсролын төрөл бүрийн системүүдийн үнэлгээнд шударга ёсны гурван хэмжүүр нийцэж байна. Боломжийн тэгш байдлын зарчим, бүтээмжийн шударга ёсны зарчим, хэрэгцээний шударга ёсны зарчим.

Боломжийн тэгш байдлыг нийгмийн ардчиллын шаардлагын

Ажилчны
хөдөлгөөн:
Ардчилал ба
оролцооны
түлхүүр нь
боловсрол юм.

Гурван зарчим:
Боломжийн тэгш
байдал, Бүтээмж,
Хэрэгцээ

Боломжийн тэгш
байдал

